
Ерөнхий Ассемблейн Жаран нэгдүгээр чуулган

Урьдчилсан жагсаалтын 60-р зүйл (а)

Эмэгтэйчүүдийн байдлыг сайжруулах: Эмэгтэйчүүдийн байдлыг сайжруулах

Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрийн талаарх гүнзгийрүүлсэн судалгаа

Ерөнхий нарийн бичгийн даргын тайлан

АГУУЛГА

	Зүйл	Хуудас
Талархал.....		6
I. Оршил	1- 21	8
А. Судалгааны хүрээ.....	8-17	9
Б. Судалгааны арга зүй.....	18-21	11
II. Ерөнхий тойм	22-64	12
А. Оршил.....	22	12
Б. Олон улсын хандлага: эмэгтэйчүүдийн хөдөлгөөн ба НҮБ.....	23-29	12
В. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл: Ялгаварлан гадуурхах хэлбэр ба хүний эрхийн зөрчил.....	30-37	14
Г. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлд хүний эрхийн талаас хандах, түүний үр дагавар.....	38-42	18
Д. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг устгах, нэгдмэл байдлыг хангах, үйл ажиллагааны хүрээг нэмэгдүүлэх.....	43-54	19
Е. Бэрхшээл, саад тотгорууд.....	55-64	23
III. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн нөхцөл, шалтгаан	65-103	28
А. Оршил.....	65-68	28
Б. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн хүрээ, үндсэн шалтгаанууд.....	69-91	29
1. Эцгийн эрхт ёс, бусад захирах, захирагдах харилцаа.....	69-77	29
2. Соёл ба эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл.....	78-85	31
3. Эдийн засгийн тэгш бус байдал ба эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл.....	86-91	33
В. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн шалтгаан, эрсдлийн хүчин зүйлс.....	92-100	34
1. Маргааныг шийдвэрлэхэд хүчирхийллийг ашиглах.....	93-94	34
2. Хувийн нууцын тухай үзэл баримтлалууд.....	95	35
3. Төрөөс арга хэмжээ авахгүй байх.....	96	35
4. Хүчирхийллийн эрсдлийн хүчин зүйлс.....	97-100	35
Г. Төр, Засгийн газар хоорондын ажиллагаанд нөлөөлөх нь.....	101-103	37
IV. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн хэлбэрүүд, үр дагавар, хор уршиг	104-181	38
А. Оршил.....	104-108	38
Б. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн хэлбэр, илрэх байдлууд.....	109 -155	39
1. Гэр бүл дэх эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл.....	111-125	39
(а) Бэлгийн хамтрагчийн хүчирхийлэл.....	112-117	40
(б) Зүй бус уламжлалт зан үйл.....	118-125	41
2. Нийгмийн тодорхой бүлгүүдээс эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэгддэг хүчирхийлэл.....	126-138	43
(а) Эмэгтэйчүүдийн амь насыг хөнөөх: Хүйсээр ялгаварлан эмэгтэйчүүдийг хөнөөх.....	127	43

(б) Бэлгийн хамтрагч бус этгээдээс үйлдэгддэг хүчирхийлэл	128-131	44
(в) Ажлын байр, боловсролын байгууллага, спортын байгууллагын орчин дахь бэлгийн дарамт, хүчирхийлэл	132-134	45
(г) Эмэгтэйчүүдийг хил дамнуулан худалдаалах	135-138	45
3. Төрийн зүгээс эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэгддэг хүчирхийлэл	139-142	46
(а) Албадан саатуулах ажиллагаан дахь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл	141	47
(б) Албадан үргүй болгох	142	47
4. Зэвсэгт мөргөлдөөний үеийн эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл.....	143-146	47
5. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл ба бүх хэлбэрээр ялгаварлан гадуурхах	147-154	49
6. Анхаарах шаардлагатай асуудлууд.....	155	50
V. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн үр дагавар	156-170	50
1. Эрүүл мэндэд учруулж буй үр дагавар.....	157-165	51
2. Нийгмийн болон шинэ, хуучин үеийн харилцаанд нөлөөлөх нь	166-170	52
Г. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн эдийн засгийн өртөг ..	171-181	53
V. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаар мэдээлэл цуглуулах нь.....	182-241	55
А. Оршил.....	182-186	55
Б. Хүн амд тулгуурласан судалгаанууд	187-200	56
1. Хүн амд тулгуурласан судалгааны тодорхойлолт	187-194	56
2. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаарх хүн амд тулгуурласан мэдээлэлд орхигддог зүйлүүд ба дутагдалууд.....	195-199	58
(а) Судлагдаж байгаа хүчирхийллийн хэлбэрүүд.....	196-198	58
(б) Ёс зүйн ба аюулгүй байдлын асуудлууд.....	199	58
3. Судалгааны төлөвлөлт ба хэрэгжүүлэлт	200	59
В. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаарх бусад мэдээ мэдээллүүд	201-220	59
1. Үйлчилгээнд тулгуурласан мэдээлэл	201-212	59
(а) Эрүүл мэндийн үйлчилгээ.....	205-207	60
(б) Эрүүгийн ба иргэний эрх зүй	208-210	61
(в) Бусад үйлчилгээ	211-212	61
2. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаарх үйлчилгээнд тулгуурласан мэдээлэлд орхигддог зүйлүүд ба дутагдалууд	213-215	62
3. Чанарын судалгааны мэдээлэл цуглуулах	216-219	62
4. Үнэлгээний судалгаа	220	63
Г. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн баримтжуулагдаагүй хэлбэрүүд.....	221-235	63
1. Эмэгтэйчүүдийн амь насыг хөнөөх	223-225	64
2. Зэвсэгт мөргөлдөөн, түүний дараах нөхцөл байдал дахь эмэгтэйчүүдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл	226-228	65
3. Охид, эмэгтэйчүүдийг хил дамнуулан худалдаалах	229-232	65
4. Ажлын байр, сургуулийн орчин дахь бэлгийн хүчирхийлэл	233-234	66
5. Албан байгууллага, засан хүмүүжүүлэх байгууллагын орчин дахь хүчирхийлэл.....	235	66
Д. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн үзүүлэлтүүд	236-239	67

Е. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаарх мэдээлэл цуглуулах ажлыг сайжруулах нь.....	240-241	68
VI. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх төрийн үүрэг	242-284	69
А. Оршил.....	242-253	69
Б. Төрийн үүрэг.....	254-260	71
В. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх асуудлууд	261-274	72
1. Хууль тогтоомж, бодлогын хүрээг тодорхойлох	262-265	73
2. Эрүүгийн эрх зүйн тогтолцоо.....	266-268	73
(а) Мөрдөн шалгах.....	266	73
(б) Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл үйлдэгчдэд ял шийтгэл оногдуулах.....	267-268	74
3. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн хохирогчдын хохирлыг барагдуулах	269	74
4. Дэмжих үйлчилгээ	270	75
5. Хандлага, ойлголтыг төлөвшүүлэх	271-272	75
6. Чадавхи бэхжүүлэлт, сургалт.....	273	75
7. Мэдээ мэдээлэл, статистик	274	76
Г. Олон улсын хэм хэмжээг үндэсний түвшинд хэрэгжүүлэхэд гарч буй бэрхшээлүүд	275-283	76
1. Хууль тогтоомж, түүний хэрэгжилт	276-279	76
2. Сургалт	280	77
3. Үйлчилгээний хүртээмж.....	281	77
4. Хандлага ба хэвшмэл хэв загвар	282	77
5. Мэдээ мэдээлэл, судалгаа	283	78
Д. Олон улсын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх төрийн үйл ажиллагаа.....	284	78
VII. Үр дүнтэй үйл ажиллагаа хэрэгжүүлэлтийн тэргүүн туршлага, бэрхшээлүүд	285-362	79
А. Оршил.....	285-291	79
Б. Хууль эрх зүйн орчны үр дүнтэй үйл ажиллагаа.....	292-318	81
1. Эрх зүй, хуулийн байгууллагын үйл ажиллагааны үндсэн зарчмууд.....	293	82
2. Хууль,] эрх зүйн тогтолцоо	294-303	82
(а) Хууль тогтоомжийг батлах.....	294	82
(б) Хуулийн хэрэгжилт	295-299	82
(в) Хууль тогтоомжид хяналт шинжилгээ хийх	300-301	84
(г) Хууль тогтоомжуудыг тогтмол хянан үзэж, шаардлагатай өөрчлөлтүүдийг хийх	302-303	84
3. Эрүүгийн хууль	304-309	85
(а) Гэмт хэрэгтэнд ял шийтгэл оногдуулах	304-306	85
(б) Хохирогчийн эрхийг хамгаалах	307-309	85
4. Иргэний эрх зүйн хамгаалалт.....	310-313	86
5. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх тусгай хууль тогтоомж	314-316	86
6. Эрх зүйн бусад асуудлууд	317	87
7. Олон улсын эрх зүйн хэм хэмжээг үндэсний шүүхэд хэрэглэх нь	318	88
В. Үйлчилгээ үзүүлэх тэргүүн туршлага.....	319-335	90
1. Үйлчилгээ үзүүлэх тэргүүн туршлагын зарчмууд	321	90
2. Үйлчилгээ үзүүлэх хэлбэрүүд	322-334	91
(а) Эрүүл мэндийн үйлчилгээ.....	322	91
(б) Бэлгийн хүчирхийллээс хамгаалах төвүүд	323	91
(в) Итгэлийн утас	324-325	92

(г) Хамгаалах байр.....	326-327	92
(д) Дэмжих бүлэг ба сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээ.....	328	93
(е) Эрх зүйн үйлчилгээ.....	329	93
(ё) Хүн хил дамнуулан худалдаалах гэмт хэргийн хохилогчдод үзүүлэх үйлчилгээ.....	330-333	94
(ж) Зэвсэгт мөргөлдөөн, түүний дараахь үед эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлд өртсөн хохилогчдод үзүүлэх үйлчилгээ.....	334	94
3. Зохицуулалт, байгууллага хоорондын ажиллагаа.....	335	95
Г. Урьдчилан сэргийлэх тэргүүн туршлага.....	336-354	95
1. Урьдчилан сэргийлэх тэргүүн туршлагын зарчмууд.....	338	96
2. Урьдчилан сэргийлэх стратеги.....	339-354	97
(а) Нөлөөллийн ажил, олон нийтийн аян.....	339-343	97
(б) Олон нийтийг дайчлан оролцуулах.....	344-345	98
(в) Эрчүүдтэй ажиллах.....	346-348	98
(г) Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, мэдээлэл технологийг ашиглах нь.....	349-351	99
(д) Нийгмийн аюулгүй байдлыг дэмжих нь.....	352	99
(е) Боловсрол, чадавхийг бэхжүүлэх нь.....	353	100
(ё) Урьдчилан сэргийлэх бусад стратегиуд.....	354	100
Д. Үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд тулгарч буй бэрхшээлүүд.....	355-362	100
1. Улс төрийн эрмэлзлийн дутмаг байдлыг илэрхийлэх тогтвортой бус үйл ажиллагаа, хөрөнгө нөөцийн хомсдол.....	357	101
2. Нэгдмэл үйл ажиллагааны дутагдал.....	358	101
3. Санхүүгийн дутагдалтай байдал.....	359	101
4. Хүчирхийлэл үйлдэгчдийн ял завших явдлыг зогсоох үр дүнгүй ажиллагаа.....	360	102
5. Ялгаварлан гадуурхах хэлбэрүүдийн хоорондын хамаарал.....	361	102
6. Үнэлгээний дутмаг байдал.....	362	102
VIII. Дүгнэлт, зөвлөмж.....	363-402	103
А. Дүгнэлт.....	363-373	103
Б. Ял завших, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх арга хэмжээ.....	374-402	105
1. Үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх зөвлөмжүүд.....	376-390	105
(а) Жендерийн тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүдийн хүний эрхийг хамгаалах.....	377-378	105
(б) Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх ажлыг манлайлах нь.....	379-380	106
(в) Олон улсын стандарт, үндэсний хууль тогтоомж, бодлогууд түүний хэрэгжилтийн явц дахь хийдлийг арилгах.....	381-382	107
(г) Бодлого боловсруулах ажлыг дэмжих зорилгоор эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрийн талаарх мэдээллийн санг сайжруулах.....	383-385	108
(д) Үндэсний, орон нутгийн зохицуулалттай салбар дундын стратегийг боловсруулж хэрэгжүүлэх нь.....	386-387	109
(е) Хөрөнгө нөөцийг оновчтой хуваарилах нь.....	388-390	109
2. Олон улсын хэмжээнд хэрэгжүүлэх зөвлөмжүүд.....	391-402	110
(а) Засгийн газар хоорондын хэмжээнд хэрэгжүүлэх зөвлөмжүүд.....	396-397	111
(б) НҮБ-ын системийн байгууллагын хэмжээнд хэрэгжүүлэх зөвлөмжүүд.....	398-402	112

Хүснэгтүүд

1. Зэвсэгт мөргөлдөөний үеийн эмэгтэйчүүдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн тохиолдол.....48
2. Бэлгийн хамтрагчийн зүгээс эмэгтэйчүүдэд учруулсан бие махбодийн хүчирхийллийн тохиолдлууд*

Хавсралт

- Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн хохирол:
хохирлын мөнгөн тооцоог гаргасан түүвэр судалгаа.....115

Жишээнүүд

1. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн тодорхойлолт16
2. Бээжингийн шийдвэр буюу үйл ажиллагааны хөтөлбөр17
3. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, түүнийг устгах тухай НҮБ-ын систем21
4. НҮБ-ын харъяа байгууллагууд, төрөлжсөн байгууллагуудын зүгээс эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаар гаргасан удирдамжууд23
5. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаарх хууль тогтоомж, бодлого, практикийн түүвэр26
6. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаарх олон орны судалгаанууд*
7. Тохиолдол ба хэргүүд*
8. Гэр бүл дэх эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаарх Дэлхийн Эрүүл Мэндийн байгууллагаас хийсэн судалгаанаас гаргасан үндэстний зан заншил ба аюулгүй байдлын тухай зөвлөмжүүд*
9. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн тоо баримтад нөлөөлж болох асуудлууд*
10. Олон улсын ба бүсийн түвшинд хуулиар шийдвэрлэгдсэн Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн жишээнүүд*
11. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаарх үндэсний хууль тогтоомж.....88
12. Нэг цэгийн үйлчилгээний төвүүд91
13. Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг олон нийтэд түшиглэсэн Дулутын загвар95

* Мэдээллийг <http://www.un.org/womenwatch/daw/vaw/index.htm> сайтаас олж авах боломжтой.

Талархал

Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаарх гүнзгийрүүлсэн судалгааг НҮБ-ын Ерөнхий Ассемблейн 58/185 дугаар тогтоолын дагуу НҮБ-ын Нарийн Бичгийн Дарга Нарын Газрын Нийгэм, Эдийн Засгийн асуудал эрхлэх газрын Эмэгтэйчүүдийн нөхцөл байдлыг сайжруулах хэлтсээс бэлтгэн гаргав.

Судалгаанд мэргэжилтнүүдийн хувь нэмэр, санал бодлыг тусгах зорилгоор Эмэгтэйчүүдийн нөхцөл байдлыг сайжруулах хэлтсээс хоёр уулзалтыг зохион байгуулсан байна. Статистик мэдээлэл болон тоо баримтын тухай эхний уулзалтыг Европын Холбооны Эдийн Засгийн Комисс болон Дэлхийн Эрүүл мэндийн байгууллагатай хамтран дараах нэр бүхий шинжээч мэргэжилтнүүдийн оролцоотой зохион байгууллаа: Элизабет Ардаифио-Шандорф (Гана); Асмита Басу (Энэтхэг); Мэри Элсберг (АНУ); Шэрмен А.Фароук (Бангладеш); Далиа Фароук (Йордан); Доминик Фожероллас-Швебел (Франц); Холли Жонсон (Канад); Ива Жосиах (Малайз); Сунита Кишор (Энэтхэг); Сами Невала (Финланд); Рут Ожиаambo Очиенг (Уганда); Ана Флавиа д' Оливера (Бразил); Патрика Тжаден (АНУ); Силвиа Уалби (Хойд Ирланд болон Их Британийн Нэгдсэн Вант Улс); Жен Уард (Кени/АНУ); илүү дэлгэрэнгүй мэдээллийг <http://www.un.org/womenwatch/daw/egm/vaw-stat-2005/index.html> сайтаас авч болно.

Шилдэг болон сайн практик ажиллагаа сэдэвт хоёр дахь уулзалтыг НҮБ-ын Мансууруулах Бодис болон Гэмт Хэргийн Эсрэг тэмцэх байгууллагатай хамтран дараах мэргэжилтнүүдийн хүрээнд явуулав: Заризана бинти Абдул Азиз (Малайз); Шарлотте Банч (АНУ); Ана Мария Карседо Кабанас (Коста Рика); Сэлли Фау Гоүлдфарб (АНУ); Клаудия Хермандорфер Акоста (Гондурас); Шеилла Кануангарара (Зимбабе); Элизабет Келли (Англи); Фатма Али Мостафа Кафаги (Египет); Бадху Кишвар (Энэтхэг); Роза Логар (Австри); Лори Макау (АНУ); Лепа Младенович (Серб); Сапана Прадхан-Малла (Непал); Леена Руусувуори (Финланд); Лиз-Анн Веттен (ӨАБНУ); уулзалтын талаарх мэдээллийг <http://www.un.org/womenwatch/daw/egm/vaw-gp-2005/index.html> сайтаас үзэж болно. Дээрх хоёр уулзалтанд НҮБ-ын төрөлжсөн хэд хэдэн байгууллагын төлөөлөгчид оролцсон билээ.

Шинжээчдийн мэргэжлийн саналын товчлолыг Алексис Ароновиц, Кристин Чинкин, Катрине МкКенна, Аудра Ваулес, Танис Дэй, Жорген Лоренцен болон Силвиа Уалви нар бэлтгэв.

Эмэгтэйчүүдийн Судалгааны Олон Улсын Төв (Ната Дюввиори, Карен Грөүн, Субадра Панчанадесуарэн, Катрин Уаланд), Эрүүл мэндийн салбарт орчин үеийн технологийг зохистой нэвтрүүлэх хөтөлбөр (Мэри Элсберг) болон Эмэгтэйчүүдийн нөхцөл байдлыг сайжруулах хэлтсийн ажилтнууд болон зөвлөх Элизабет Шнайдер, Донна Сюлливан нар судалгаанд өөрсдийн хувь нэмрийг оруулсан болно.

Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг устгах чиглэлээр туршлагатай, олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн, өндөр түвшний 10 шинжээчээс бүрдсэн зөвлөх хороо судалгааны агуулга, хүрээ, арга зүйн талаар заавар, санал бодлоо байнга илэрхийлж байсан бөгөөд судалгааны төслийг хянаж, саналаа тусган, стратегийн ач холбогдол бүхий багц зөвлөмжийг боловсруулсан байна. Зөвлөх хорооны гишүүдийг танилцуулбал: Шарлотте Банч, Эмэгтэйчүүдийн Глобал Манлайллын Төвийн гүйцэтгэх захирал (АНУ); Сюзанна Чиаротти, Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах Латин Америк болон Карибийн Хорооны бүсийн зохицуулагч асан (Аргентин); Доркас Кокер-Аппиах, Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг устгах Хорооны шинжээч (Гана); Радхика Коомарасуами, Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, түүний шалтгаан болон үр дагавар гэсэн сэдвээр НҮБ-ын Тусгай

Илтгэгч асан, Хүүхэд болон Зэвсэгт мөргөлдөөний асуудлаар НҮБ-ын Ерөнхий Нарийн Бичгийн Даргын Тусгай Төлөөлөгч (Шриланк); Якин Ертюрк, Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, түүний шалтгаан болон үр дагавар гэсэн сэдвээр НҮБ-ын Тусгай Илтгэгч (Турк); Алда Фасио, НҮБ-ын Латин Америкийн Хүрээлэнгийн Гэмт Хэргээс Урьдчилан Сэргийлэх болон Хүчирхийлэл Үйлдэгсдийн Зан Үйлийг Өөрчлөх байгууллагын Эмэгтэйчүүд, Хүйсийн Асуудал болон Шударга Ёс хөтөлбөрийн зохицуулагч асан (Коста Рика); Асма Кадер Иорданы Эмэгтэйчүүдийг дэмжих Глобал хүрээлэнгийн Ерөнхий зохицуулагч, Эмэгтэйчүүдийн Эсрэг Хүчирхийллийг Хязгаарлах Арабын байнгын шүүхийн эмэгтэйчүүдийн хүчирхийллийн эсрэг асуудлын консул асан (Иордан); Ирене Кан, Эмнести Олон Улсын байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга (Бангладеш), уулзалтанд Уинди Браун төлөөлж байсан; Анжелло Мело, Хүний болон Нийтийн Эрхийн Африкийн Комисс, Африк дахь Эмэгтэйчүүдийн Эрхийн Асуудлаар Тусгай Илтгэгч (Мозамбик); Найсоо Шин, Эмэгтэйчүүдийг Ялгаварлан Гадуурхах Бүх Хэлбэрийг Устгах Хорооны шинжээч (БНСУ) зэрэг хүмүүс ажиллалаа.

НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд болон төрийн бус байгууллагаас бүрдсэн ажлын баг судалгаанд өөрсдийн хүч чармайлтыг зориулж, мэдээлэл, санал бодол солилцох гүүр болж, энэ талаарх мэдлэгийг сайжруулахад чухал хувь нэмэр орууллаа. Ажлын багт Энх Тайвныг сахиулах ажиллагааны хэлтэс, Эмэгтэйчүүдийн байдлыг сайжруулах болон Хүйсийн Асуудал хариуцсан Тусгай Зөвлөхийн Газар, НҮБ-ын Статистикийн хэлтэс, НҮБ-ын Хүний Эрхийн Комиссариатын газар, Африкийн Эдийн засгийн комисс, Европын Эдийн засгийн комисс, Латин Америк болон Карибын Эдийн засгийн комисс, Ази болон Номхон далайн нийгэм, эдийн засгийн комисс, Баруун Азийн нийгэм, эдийн засгийн комисс, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, НҮБ-ын Эмэгтэйчүүдийн Сан, НҮБ-ын Дүрвэгсдийн Асуудал Эрхэлсэн Комиссариатын Газар, НҮБ-ын Хүн Амын Шилжин Суурьшлын Хөтөлбөр, ДОХ/ХДХВ-ын асуудлаарх НҮБ-ын Хамтарсан Хөтөлбөр, НҮБ-ын Хүүхдийн Сан, НҮБ-ын Хүн Амын Сан, Эмэгтэйчүүдийн нөхцөл байдлыг сайжруулах олон улсын сургалт, судалгааны хүрээлэн, НҮБ-ын Бүс Нутгийн Гэмт Хэрэг, Шударга Ёсны Судалгааны Институт, Олон Улсын хөдөлмөрийн Байгууллага, НҮБ-ын Боловсрол, Шинжлэх Ухаан болон Соёлын Асуудал эрхэлсэн Байгууллага, Дэлхийн Эрүүл мэндийн Байгууллага болон Дэлхийн Банк зэрэг НҮБ-ын нарийн бичгийн дарга нарын газрын байгууллага, НҮБ-ын сан, хөтөлбөр болон тусгай агентлагуудын төлөөлөл багтсан байна.

Ажлын багт мөн дараах ТББ-ууд оролцсон байна: Эмнести Интернэйшнл, Эмэгтэйчүүд, Хууль, Эрх зүй болон Хөгжлийн Азийн Форум, Нөхөн Үржихүйн Эрхийн Төв, Эмэгтэйчүүдийн Глобал Манлайллын Төв, Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах Латин Америк болон Карибийн Хороо, Тэгш Байдал NOW, Африкийн Эмэгтэйчүүдийн Хөгжил болон Харилцааны Сүлжээ, Хүчирхийллийн Эсрэг Европын Мэдээллийн Төв, Хүний Эрхийн Шинжээч (Эмэгтэйчүүдийн Эрхийн Хэлтэс), Олон Улсын Бэлгийн Ижил Баримжаатай Хүмүүсийн Эрхийн Комисс, Олон Улсын Уугуул Эмэгтэйчүүдийн Форум, Эмэгтэйчүүд, Энх Тайван болон Аюулгүй Байдлын асуудлаарх ТББ-ын Ажлын Хэсэг, Нээлттэй Нийгэм Хүрээлэн (Эмэгтэйчүүдийн Хөтөлбөрийн Сүлжээ), Африкийн Хууль болон Хөгжлийн асуудлаарх эмэгтэйчүүд байгууллага, Дүрвэгч Эмэгтэйчүүд болон Хүүхдийн Эмэгтэйчүүдийн Комисс.

Судалгааны талаарх ерөнхий мэдээллийг <http://www.un.org/womenwatch/daw/vaw/index.htm> сайтаас олж авах боломжтой болно.

I. Оршил

1. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл нь хүний эрхийн ноцтой зөрчил бөгөөд жендерийн тэгш эрхийг бүрэн хангахад гол саад учруулж, дэлхийн бүхий л оронд тохиолдож байна. Хүчирхийллийн аль ч хэлбэрийг бид хүлээн зөвшөөрөх ёсгүй. Тухайлбал, аюулгүй тайван үед гэр бүлийн болоод нийгмийн хүрээнд; зэвсэгт мөргөлдөөний үед гэр бүлийн болон бусад хүмүүс; мөн аливаа төрийн үйлчилгээний байгууллагуудын зүгээс гэх зэрэг эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэгдэж буй бүх төрлийн хүчирхийллийг хүлээн зөвшөөрөх ёсгүй. НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга "эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл үйлдэгдэх явдал үргэлжилсээр байгаа энэ үед тэгш эрх, улс үндэсний хөгжил болон энх тайван, аюулгүй байдлыг хангахад бид чухал ахиц дэвшилд хүрч байна гэж үзэх боломжгүй юм" хэмээн тэмдэглэн хэлжээ.
2. Тухайн Улс нь эмэгтэйчүүдийг хүчирхийллээс хамгаалах, хүчирхийлэл үйлдэгчдэд хариуцлага хүлээлгэх, хохирогчдод хууль эрх зүйн болон нийгмийн бүхий л төрлийн үйлчилгээг үзүүлэх үүрэг хүлээдэг. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг устгах нь бид бүхний энэ цаг үеийн томоохон бэрхшээлтэй асуудлуудын нэг болж байна. Сүүлийн арван жилд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, устгах чиглэлээр бий болгосон мэдлэг боловсрол, арга хэрэгслүүдийг эмэгтэйчүүдийн эсрэг бүхий л хэлбэрийн хүчирхийллийг устгахад илүү нарийн зохион байгуулалттай, илүү үр дүнтэй ашиглах ёстой. Энэ нь улс төрийн зүгээс уг асуудалд анхаарал хандуулах, нээлттэй хэлэлцэх, түүнчлэн төр, засгийн газрын удирдлагын зүгээс асуудлыг шийдвэрлэхэд хүчин чармайлт гаргахыг шаарддаг.
3. Эрэгтэйчүүдийн зүгээс эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэж байгаа хүчирхийллийг устгахын төлөө тухайн улс орнууд болон НҮБ-ын системийн байгууллагууд, ТББ-ууд, эмэгтэйчүүдийн бүлгүүд, сүлжээнүүд болон судлаачид нилээд чухал ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Янз бүрийн түвшинд янз бүрийн байгууллага, бүлгүүдийн авч хэрэгжүүлсэн томоохон арга хэмжээнүүд нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн мөн чанар, цар хүрээ, хүчирхийллийн эмэгтэйчүүдэд болон улс нийгэмд үзүүлэх нөлөөний талаарх ойлголтуудыг нилээд нэмэгдүүлсэн байна. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх олон улсын хууль эрх зүй, бодлогыг тодорхойлсон ба үүнд нийгмийн болон гэр бүлийн хүрээнд үйлдэгдэж байгаа хүчирхийллийн олон төрөл хэлбэрүүдийг багтаасан.
4. Гэсэн хэдий ч эмэгтэйчүүд жендерт суурилсан хүчирхийллээс ангид амьдрах аюулгүй орчныг бий болгохын тулд хийх зүйл маш их байна. Олон улсын хууль эрх зүйн хэм хэмжээ, стандарт, бодлого бий болгох зэрэг амжилт гарсан ч тэдгээрийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх ажил төдийлөн сайн хийгдэж ирсэнгүй. Энэ нь дэлхийн бүх оронд хангалттай бус байна. Үүний сацуу эмэгтэйчүүдийн эсрэг бүхий л төрлийн хүчирхийллийн хэлбэрүүд, тархалт ба мөн чанарын талаар мэдээлэл цуглуулах ажил сүүлийн жилүүдэд эрс нэмэгдсэн хэдий ч мэдээлэл нь хангалттай цогц, иж бүрэн байж чадахгүй байсаар байна. Улс төрийн зүгээс асуудалд анхаарал хандуулах явдал дутагдсанаас эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн асуудлыг шийдвэрлэхэд зарцуулагдах нөөц хөрөнгө хангалтгүй, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг үл тэвчих нийгэм улс төрийн орчныг бий болгох ажлууд хийгдээгүй байгаа нь нөлөөлж байна. Мөн эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, устгах, эрэгтэйчүүдийн хүчирхийлэл үйлдэх явдлыг өдөөж байгаа олон нийтийн хэвшмэл буруу ойлголт, хандлагыг өөрчлөх ажилд эрчүүдийг өргөнөөр татан оролцуулах шаардлагатай байна.

5. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх дэлхий нийтийн хүчин чармайлтанд Ерөнхий Ассемблей тэргүүлэх чухал үүргийг гүйцэтгэсэн. Ерөнхий Ассемблейн Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг устгах тухай Тунхаглал нь (48/104 шийдвэр) үндэсний болон олон улсын түвшинд авч хэрэгжүүлэх арга хэмжээний үндсэн хүрээг тодорхойлсон юм. Сүүлийн жилүүдэд Ерөнхий Ассемблей эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн асуудлыг ерөнхийд нь, түүнчлэн тодорхой хэлбэрүүдийг нь тусгайлан авч үзэж, шийдвэрлэж байна. Эдгээр асуудалд цагаач эмэгтэй ажилчид, эмэгтэйчүүд охидыг хил давуулан худалдаалах, эмэгтэйчүүд охидын эрүүл мэндэд хор уршиг учруулж байгаа уламжлал, зан заншилтай холбоотой үйлдлүүд, гэр бүлийн нэр төрийг хамгаалах нэрийдлээр эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэгдэж байгаа гэмт хэргүүд, гэр бүлийн хүчирхийлэл зэрэг багтаж байна.

6. 2003 оны 12 дугаар сард Ерөнхий Ассемблей 58/185 дугаар шийдвэрийн дагуу анх удаа эмэгтэйчүүдийн эсрэг бүхий л хэлбэрийн хүчирхийлэл, тэдгээрийн илрэлийн талаар дэлгэрэнгүй, гүнзгий судалгаа явуулах үүрэг хүлээсэн байна.

7. Энэхүү судалгаа дэлхийн бүх оронд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрийг үл тэвчих, эсэргүүцэх явдлыг онцлон тэмдэглэх, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, устгах бүх нийтийн хамтын хүчин зүтгэл болон улс төр, засгийн газрын амлалт, чармайлтыг бэхжүүлэх, улс орнууд эмэгтэйчүүдийн эсрэг бүх хэлбэрийн хүчирхийлэлтэй тэмцэх үүрэг хариуцлагаа биелүүлэх арга замуудыг тодорхойлох, хэрэгжилтийг илүү тогтвортой, үр дүнтэй болгох, улс орнуудын үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх замуудыг тус тус тодорхойлохыг зорьсон болно.

A. Судалгааны хүрээ

8. 58/185 дугаар шийдвэрийн дагуу энэ судалгаа эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн бүх төрөл, хэлбэрүүдийг хамран дараах асуудлуудыг багтаах ёстой. Үүнд:

а. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлд нарийн дүн шинжилгээ хийхийн хамт мэдээ, мэдээлэл цуглуулахад дутагдаж байгаа зүйлүүдийг тодорхойлох, асуудлын цар хүрээг тодорхойлох, санал боловсруулах зорилгоор эмэгтэйчүүдийн эсрэг бүх хэлбэрийн ерөнхий статистик тоо баримтыг гаргах

б. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн шалтгаан, үндсэн шалтгаан, нөлөөлж буй бусад хүчин зүйлүүд

в. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн дунд болон урт хугацааны үр дагавар

г. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн нийгэм, эрүүл мэнд болон эдийн засгийн өртөг зардал

д. Хамгийн шилдэг практик туршлагаудыг тодорхойлох: хууль эрх зүй, бодлого, хөтөлбөр, үр дүнтэй арга хэмжээнүүд ба эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг устгахын төлөө тэмцэх хамгийн сайн арга механизмуудын үр нөлөө

9. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн бүх төрөл, хэлбэрүүд, тэдгээрийн үйлдэгдэж байгаа илрэлүүдийн талаар дан ганц судалгаагаар дэлгэрэнгүй авч үзэх боломжгүй юм. Тиймээс энэ судалгаа нь 58/185 дугаар шийдвэрт дурдсан бэрхшээл, асуудлуудыг онцгойлон авч үзэж, үнэлгээ, дүгнэлт хийх, нэгтгэхийг зорьсон. Зарим асуудлуудыг Ерөнхий Нарийн бичгийн даргын бусад холбогдох судалгаануудаар өмнө нь авч үзсэн билээ. Зэвсэгт мөргөлдөөн, зөрчлийн үе дэх болон зөрчлийн дараах нөхцөл дэх эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн асуудлыг 2002 онд Аюулгүй

байдлын Зөвлөлийн 1325 дугаар шийдвэрийн дагуу "Эмэгтэйчүүд, энх тайван ба аюулгүй байдал" судалгаагаар дэлгэрэнгүй авч үзсэн. Хүүхдийн эсрэг хүчирхийллийн асуудлаар явуулах судалгааны бэлтгэл одоогоор хангагдаж байна.

10. Энэхүү судалгаа эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн асуудлыг нилээд өргөн агуулгаар, өргөн хүрээнд авч үзэж, түүний тархалт ба хэм хэмжээний талаар тоо баримтыг нэгтгэн дүгнэсэн болно. Түүнчлэн, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаарх мэдээ, тоо баримтуудын дутагдалтай болон бэрхшээлтэй асуудлууд, хүчирхийллийн тархалтыг үнэлэх арга барилуудын талаар гаргаж тавьсан. Үүнээс гадна судалгаа нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн шалтгаан, үр дагавар, өртөг зардлын талаарх мэдээ, мэдээллүүдийг нэгтгэсэн. Мөн эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд улс орнуудын хүлээх үүрэг хариуцлага, хүчирхийлэлтэй тэмцэх шилдэг үр дүнтэй, сайн практик туршлагауудыг судалгаагаар тодорхойлсон.

11. Судалгааны 2 дугаар бүлэгт эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн асуудлаар олон нийтийн ойлголт, ухамсрыг нэмэгдүүлэх, түүнтэй тэмцэх олон улсын арга хэмжээг бий болгосон түүхийн талаар товч авч үзсэн. Ингэхдээ эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг хүний эрхийн ноцтой зөрчил хэмээн тооцдог болоход хамгийн чухал үүрэг гүйцэтгэсэн арга хэмжээ, үйл ажиллагаануудын талаар авч үзсэн. Олон улсын ба бүсийн хууль, бодлогуудад тусгасан болон НҮБ-ын Дэлхийн Зөвлөлгөөнөөр баталсан Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх өнөөгийн хүрээний талаар дүгнэсэн. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаар олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх, түүнтэй тэмцэхийг уриалахад эмэгтэйчүүдийн хөдөлгөөний гүйцэтгэх үүрэгт анхаарлаа хандуулсан.

12. Судалгааны 3 дугаар бүлэгт эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэгдэж буй хүчирхийлэл, энэ явдал оршсоор байгаа түүхийн болон нийгэм, соёлын орчин нөхцлийн талаар авч үзсэн. Энэ бүлэг нь эрэгтэйчүүдийн зүгээс эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэгдэж байгаа хүчирхийллийн шалтгаанууд, ялангуяа ялгаварлан гадуурхах явдалд дүн шинжилгээ хийсэн. Уг дүн шинжилгээ нь эцгийн эрхт ёсны гүйцэтгэж байгаа үүрэг, эмэгтэйчүүдийн хүний эрхийг хүлээн зөвшөөрөхгүй байх, эмэгтэйчүүдийг захирах, хараа хяналт тогтоох зэрэг асуудлуудын талаар онцлон тэмдэглэсэн. Түүнчлэн эмэгтэйчүүдийг хүчирхийлэлд илүү өртөмтгий болгож байгаа эрсдэлийн хүчин зүйлүүд, хүчирхийлэлд өртсөн эмэгтэй бүрийн хувийн туршлагыг тодорхойлж буй хүчин зүйлс, тэдгээрийн ижил болон ялгаатай талуудын талаар онцлон авч үзсэн.

13. Судалгааны 4 дүгээр бүлэгт эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэгдэж байгаа хүчирхийллийн хэлбэрүүд, тэдгээрийн үр дагаврын талаар ерөнхий тоймыг харуулсан. Үүнд: эмэгтэйчүүд амьдралынхаа туршид янз бүрийн орчинд олон хэлбэрийн хүчирхийлэлд өртөж байгаа талаар үзүүлжээ. Дэлхийн янз бүрийн оронд эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэгдэж байгаа хүчирхийллийн янз бүрийн хэлбэрүүд, илрэлүүд, тэдгээрийн тархалт, тохиолдлын талаар бэлэн байгаа мэдээ, мэдээллийг мөн энэ хэсэгт танилцуулсан. Түүнчлэн, энэ бүлэгт эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн хохирогч, даван туулагсад, тэдгээрийн гэр бүл, олон нийт, нийгэм, улс үндэстэнд үзүүлэх сөрөг үр дагаврууд, эдийн засгийн зардалд дүн шинжилгээ хийсэн.

14. 5 дугаар бүлэгт эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаарх мэдээ, тоо баримт цуглуулахад тохиолдож байгаа өнөөгийн бэрхшээлүүд ба амжилтуудын талаар гарган харуулсан. Тусгай мэдээ, тоо баримтыг цуглуулах арга барил, мэдээ цуглуулахад энэхүү арга нь хэрхэн нийцэж буй талаар авч үзсэн. Мөн мэдээ цуглуулахад янз бүрийн талуудын гүйцэтгэх үүргийн талаар онцлон тэмдэглэсэн.

Эмэгтэйчүүдийн эсрэг бүх хэлбэрийн талаарх мэдлэгийг батжуулах, түүнчлэн бодлого, стратеги боловсруулахад шаардлагатай мэдээ, мэдээллээр хангахын тулд эмэгтэйчүүдийн эсрэг бүх хэлбэрийн хүчирхийллийн талаарх мэдээ, мэдээлэл цуглуулах явдлыг нэмэгдүүлэх нэн чухал шаардлагатай байгаа талаар онцолжээ.

15. 6 дугаар бүлэгт эмэгтэйчүүдийн эсрэг бүх хэлбэрийн хүчирхийллийг устгах, урьдчилан сэргийлэх, эмэгтэйчүүдийг хүчирхийллээс хамгаалах, хохирогчдод нийгмийн нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх чиглэлээр улс орнуудын хүлээх үүрэг хариуцлагын талаар чухалчлан авч үзсэн. Улс орнуудын үүрэг хариуцлагыг тодорхой болгоход холбогдох олон улсын хууль тогтоомжууд, стандарт ба хэм хэмжээтэй холбон авч үзсэн. Мөн улс орнууд үүрэг хариуцлагаа биелүүлэхийн тулд авч хэрэгжүүлэх ёстой үндсэн арга хэмжээнүүдийн талаар дурдсан.

16. 7 дугаар бүлэгт эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэхэд үр дүнтэй шилдэг практик туршлагауудыг хууль эрх зүй, үйлчилгээ ба урьдчилан сэргийлэх гэсэн 3 үндсэн чиглэлээр тодорхойлсон. Энэ бүлэгт дээрх 3 үндсэн чиглэлээр үр дүнтэй байгаа нь батлагдсан, хэрэгжүүлж болохуйц шилдэг практик туршлагауудын үндсэн зарчмууд ба тодорхой бодит жишээнүүдийг гарган харуулсан. Үүний зэрэгцээ эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаарх стандарт ба хэм хэмжээг хэрэгжүүлэхэд тулгарч буй бэрхшээлүүд, дутагдалтай байгаа асуудлуудыг тодорхойлсон.

17. 8 дугаар бүлэг нь ерөнхий дүгнэлт болон 7 үндсэн чиглэлээр холбогдох талуудын янз бүрийн түвшинд авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийн талаарх зөвлөмжийг дэвшүүлсэн.

Б. Судалгааны арга зүй

18. Энэ судалгааг бүс, дэлхий болон үндэсний хэмжээнд хийгдсэн судалгаанууд болон мэдээ, мэдлэг дээр үндэслэн явуулсан. Судалгаанд ашигласан олон мэдээ баримт, эх сурвалжуудын дотор гишүүн улс орнуудын тайлан, Бээжингийн Тунхаглал ба үйл ажиллагааны хэрэгжилтийг авч үзэх зорилго бүхий асуулгад гишүүн улс орнуудын өгсөн хариу /2003 ба 2004 онд хүлээн авсан/, Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүхий л хэлбэрийг устгах тухай Конвенцийн 18 дугаар зүйлийн дагуу гишүүн улс орнуудын явуулсан тайлангууд чухал ач холбогдол үзүүлсэн. Мөн судалгааг явуулахад НҮБ-ын системийн байгууллагууд, хүний эрхийн ба бүсийн байгууллагууд, ТББ-ууд ихээхэн туслалцаа үзүүлж хувь нэмрээ оруулсан. Түүнчлэн, интернет хэлэлцүүлэг явуулахад олон талууд оролцож хувь нэмрээ оруулсан. 2005, 2006 онд гишүүн орнууд ба бусад талуудын хамтран оролцсон хэд хэдэн хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Ерөнхий Ассемблейн 60 дахь удаагийн чуулган, Эмэгтэйчүүдийн нөхцөл байдлын талаарх Зөвлөлийн 50 дахь удаагийн чуулган мөн чухал хувь нэмэр оруулсан. Судалгааг явуулахад бүх бүсийн 10 мэргэжилтнээс бүрдсэн зөвлөх хорооны зөвлөмж, удирдамж чухал үүрэг гүйцэтгэсэн. Ерөнхий Нарийн бичгийн даргын Хүүхдийн эсрэг хүчирхийллийн асуудлаарх судалгааг удирдан явуулсан бие даасан зөвлөх Пауло Сержио Пинхейро ба Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн асуудлаарх Тусгай илтгэгчийн зүгээс өгсөн зөвлөмж, удирдамж мөн чухал үүрэг гүйцэтгэсэн.

19. Эмэгтэйчүүдийн нөхцөл байдлыг сайжруулах цахим мэдээллийн санд (вебсайт) дээр дурдсан эх сурвалжууд, бусад ашигласан мэдээ баримтын дэлгэрэнгүй жагсаалт, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн янз бүрийн хэлбэрийн талаарх хууль эрх зүйн илүү мэдээлэл багтсан байгаа болно. /10 дугаар хүснэгтийг үзнэ үү/

20. Энэ судалгаанд “эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл” хэмээх нэр томъёо нь эмэгтэй хүний эсрэг үйлдэгдэж байгаа буюу тэдэнд хамгийн ихээр нөлөөлж буй жендерт суурилсан хүчирхийллийн аливаа үйлдлийг илэрхийлж байгаа болно /1 дүгээр хүснэгтийг үзнэ үү/. Уг судалгаа нь жендерт суурилсан хүчирхийлэлд өртсөн эрэгтэйчүүдийн асуудлын талаар авч үзээгүй болно. Эмэгтэйчүүд гэсэн нэр томъёо нь бүх насны эмэгтэйчүүд, 18-аас доош насны бүх охидыг багтаасан болно.

21. Хүчирхийллийн “хохилогч”, “даван туулагч” гэсэн нэр томъёонуудыг ашиглах тал дээр үргэлж маргаантай байдаг. Зарим хүмүүс хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийг “хохилогч” хэмээн нэрлэх нь эмэгтэйчүүдийг сул дорой, эмзэг, чадваргүй гэх утгыг агуулдаг учраас эмэгтэйчүүдийн бие даасан байдал, чадварыг үгүйсгэдэг гэж үзэж, уг нэр томъёог хэрэглэхээс аль болох зайлсхийх хэрэгтэй гэдэг. Гэтэл “даван туулагч” хэмээн нэрлэх нь хүчирхийллийн гэмт хэрэгт өртсөн эмэгтэйн хүчирхийллийн улмаас болж хохирсон хохирлыг үгүйсгэх утга агуулгатай учраас хэрэглэх нь бас учир дутагдалтай хэмээн зарим хэсэг нь үздэг. Харин энэ судалгаанд “хохилогч” гэдгийг эрүүгийн хуулийн агуулгаар нь, “даван туулагч” гэдгийг нөлөөллийн утга агуулгаар тус тус ашигласан. Зарим тохиолдолд хохирогч, даван туулагч гэдгийг ижил утгаар ашигладаг.

II. Ерөнхий тойм

A. Оршил

22. АНУ-д эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл нь ялгаварлан гадуурхах явдлын нэг хэлбэр ба эмэгтэйчүүдийн хүний эрхийн зөрчилд тооцогдож, олон нийтийн анхаарлыг татсан асуудлын нэг болж эхэлсэн. Олон улсын хэмжээнд эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн хүний эрх ба нэр хүндийг хамгаалах талаар хэд хэдэн тунхаглал, гэрээ хэлэлцээрийг боловсруулан баталсан. Хэдийгээр эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг хүний эрхийн зөрчил хэмээн үзэх явдал нэмэгдсэн ч түүнийг бууруулах, устгах талаар төдийлөн хангалттай ажил хийгдэж чадаагүй хэвээр байна. Энэхүү судалгаа нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг бүх түвшинд, нэн тэргүүний асуудлын нэг болгон илүү ач холбогдол өгч, жинхэнэ ёсоор нь авч үзэж, хангалттай хөрөнгө, нөөц хуваарилж, асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна хэмээн дүгнэжээ. Судалгаа нь дэлхий дахинд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, шударга бус явдлыг шийдвэрлэхэд Засгийн газрууд, төрийн болон иргэний нийгмийн байгууллагуудад дэмжлэг, туслалцаа үзүүлэх зөвлөмжүүдээр хангахыг зорьжээ.

B. Олон улсын хандлага: эмэгтэйчүүдийн хөдөлгөөн ба НҮБ

23. Дэлхийн олон оронд эмэгтэйчүүдийн байгууллага, хөдөлгөөнүүдийн зүгээс явуулсан асар их ажлын үр дүнд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн асуудлыг ил гаргаж ирснээр нийгмийн анхаарлыг татах болсон. Эмэгтэйчүүд хэд хэдэн чиглэлээр өөрсдийн эрхийг хүлээн зөвшөөрүүлэх, тэгш эрхтэй байхын төлөө тэмцэж байх явцдаа эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл нь хэн нэгний санамсаргүй, зүй бус явдлын үр дүн биш, харин эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн хоорондын тэгш бус эрхийн харилцаатай гүн гүнзгий холбоотой гэж үзэн илүү анхаарлаа хандуулж эхэлжээ. /3 дугаар бүлгийг үзнэ үү/. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүчирхийлэлтэй тэмцэх, устгах талаар арга хэмжээ авахыг уриалахдаа эмэгтэйчүүд хүчирхийллийг ялгаварлан гадуурхах явдлын нэг хэлбэр, энэ нь хүчирхийллийг өдөөх механизм мөн хэмээн гарган тавьжээ. Энэ үйл явц нь эмэгтэйчүүдийн эсрэг бусад олон төрлийн

хүчирхийллийг тодорхойлох, тэдгээрийг үйлдэгдэж байгааг батлан харуулах /4 дүгээр бүлгийг үзнэ үү/, улмаар асуудлыг хувийн буюу гэр бүлийн хүрээнээс олон нийтийн анхаарал, улсын үүрэг хариуцлагын төвд гарган тавьж чаджээ.

24. Олон улсын түвшинд, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл нь НҮБ-ын байгууллагын хэмжээнд эмэгтэйчүүдийн хүний эрхийг хамгаалах гэсэн агуулгатайгаар авч үзэх асуудлын нэг болсон. Сүүлийн хэдэн арван жилийн хугацаанд дэлхий дахины эмэгтэйчүүдийн нөлөөллийн үйл ажиллагаа ба НҮБ-ын байгууллагын санаа, санаачлагын хоорондын уялдаа холбоо нь уг асуудалд анхаарал хандуулахад чухал хөдөлгөгч хүч болжээ. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн зарим нэг хэлбэртэй тэмцэх буюу жишээ нь, эмэгтэйчүүдийг албадан биеийг нь үнэлүүлэхийн тулд хил давуулан худалдаалахтай тэмцэх үйл ажиллагааг НҮБ-ыг байгуулагдахаас өмнө бас хийж байжээ. Гэхдээ эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн асуудалд өргөнөөр анхаарал хандуулах байдал нь Эмэгтэйчүүдийн төлөө НҮБ-ын 10 жилийн /1975-1985/ хугацаанд буюу олон арван эмэгтэйчүүдийн байгууллага эмэгтэйчүүдийн асуудлаарх олон улсын болон бүсийн хурал чуулганаар дамжуулан хүчирхийлэлтэй тэмцэхэд НҮБ-тэй нэгдсэнээр улам илүү хүчтэй болсон. Тэдгээрийн хүчин чармайлт нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэхэд чухал түлхэц болсон. Түүнчлэн олон улсын стандарт, хэм хэмжээ, хяналт шинжилгээ, тайлагнах механизмуудыг бий болгоход дэмжлэг үзүүлсэн.

25. Олон улсын түвшинд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх эхний санаа, санаачлагууд нь юуны түрүүн гэр бүлд гол анхаарлаа хандуулж байжээ. Эмэгтэйчүүдийн төлөө Дэлхийн Үйл ажиллагааны Төлөвлөгөө нь 1975 онд Мехико хотод зохион байгуулагдсан Олон улсын эмэгтэйчүүдийн дэлхийн чуулганаар батлагдсан. Уг төлөвлөгөө нь гэр бүл дэх зөрчлийг шийдвэрлэх, гэр бүлийн гишүүн бүрийн нэр хүнд, тэгш эрх, аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн ч хүчирхийлэл гэсэн утгаар нь төдийлэн авч үзээгүй. Гэхдээ Мехико хотод болсон ТББ-уудын хуралдаан, 1976 онд Брюссель хотноо зохион байгуулагдсан Эмэгтэйчүүдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх тухай олон улсын хуралдаанаар эмэгтэйчүүдийн эсрэг олон төрлийн хүчирхийллийн асуудлыг онцлон тэмдэглэсэн байжээ.

26. 1980 онд Копенгагенд болсон Эмэгтэйчүүдийн төлөө НҮБ-ын 10 жилийн дунд үеийн Дэлхийн Хоёрдугаар Чуулганаас гэр бүлийн хүчирхийллийн талаар шийдвэр гаргасан байна. Ингэхдээ гэр бүлийн хүчирхийллийг эрүүл мэндийн асуудлын хүрээнд авч үзэж, эмэгтэйчүүд, хүүхдийн эсрэг хүчирхийллийг устгах, эмэгтэйчүүдийг бие махбодийн болоод сэтгэл санааны хүчирхийллээс хамгаалах хөтөлбөрүүдийг боловсруулахыг уриалжээ. ТББ-дын зэрэгцээ чуулган дээр эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн асуудлыг авч хэлэлцсэн бөгөөд үндэсний хэмжээнд эмэгтэйчүүдийн хөдөлгөөний үндсэн асуудлуудад ач холбогдол өгөх явдал нэмэгдэж байгаа талаар онцлон тэмдэглэсэн байна.

27. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн асуудлаар эмэгтэйчүүдийн идэвхи зүтгэл, хөдөлгөөн 1980-аад оны эхэн үеэр нилээд нэмэгдсэн ба уг асуудлыг 1985 онд Найробид болсон Эмэгтэйчүүдийн Дэлхийн Гуравдугаар Чуулганаар чухалчлан авч үзсэн. Эмэгтэйчүүдийн хөгжил дэвшлийн төлөөх Найробын стратеги нь нийгэм дэх өдөр тутмын амьдралд тохиолдож буй эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн янз бүрийн төрлийг хүлээн зөвшөөрч, эдгээр хүчирхийллийн үйлдэгдэж байгааг батлан харуулахын зэрэгцээ, гэр бүлийнхээ хүрээнд хүчирхийлэлд өртөж байгаа эмэгтэйчүүд, хил давуулан худалдаалах, албадан биеийг нь үнэлүүлэх, дарамт шахалтад өртөж байгаа эмэгтэй хохирогчид, урьдчилан хорих төвд хоригдож

байгаа эмэгтэйчүүд болон цэрэг дайны зөрчилтэй нөхцөлд амьдарч байгаа эмэгтэйчүүдийн асуудалд тус тус анхаарлаа хандуулахыг уриалжээ. НҮБ-ын Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл ба бусад шийдвэрлэх асуудлуудын хоорондын уялдаа холбоо нь хүчирхийллийг Эмэгтэйчүүдийн төлөөх Арван жилийн зорилтууд буюу тэгш эрх, хөгжил, энх тайван байдлыг хангахад гол саад болж байна хэмээн тодорхойлжээ. Цаашдын Стратегиуд нь хүчирхийллийн эмэгтэй хохирогчдод цогц үйлчилгээ, дэмжлэг үзүүлэх, урьдчилан сэргийлэх, хууль эрх зүйн хариу арга хэмжээ авах үндэсний бүтэц, тогтолцоо, механизмыг бий болгохыг уриалжээ. Мөн эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг нийгмийн асуудал болох талаар олон нийтийн ойлголт, ухамсрыг дээшлүүлэхийн чухлыг онцлон тэмдэглэжээ.

28. Эмэгтэйчүүдийн төлөө Арван жилийн үйл ажиллагааны хамт НҮБ-ын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ба эрүүгийн хууль эрх зүйн асуудлаар ажилладаг байгууллагууд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, тэдгээрийн дотроос гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх ажил нилээд нэмэгдсэн. Энэ чиглэлийн үйл ажиллагаа дэлхийн олон оронд янз бүрийн нөхцөлд үйлдэгдэж байгаа хүчирхийлэл нь тэр бүр мэдээлэгдэхгүй байгаа явдлыг, түүнчлэн эмэгтэй хохирогчдыг дэмжих хууль болон хууль эрх зүйн орчныг бий болгох, үндэсний түвшинд хуулийг үр дүнтэй хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлагыг онцлон тэмдэглэжээ.

29. 1990-ээд оны эхээр эмэгтэйчүүдийн хөдөлгөөнүүдийн зүгээс эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг эмэгтэйчүүдийн хүний эрхийн зөрчил гэдгийг хүлээн зөвшөөрүүлэх явдал амжилтанд хүрсэн. 1993 оны Венийн Хүний Эрхийн бага хурлыг угтан эмэгтэйчүүдийн бүлгүүд нэгдэн, дэлхийн болон бүсийн хэмжээнд хүний эрхийн тухай хууль эмэгтэйчүүдийн эрхийн асуудлыг оруулах талаар нөлөөллийн ажлыг явуулжээ. Тэд бага хурал дээр эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг эмэгтэйчүүдийн хүний эрхийн зөрчил хэмээн үзэх ёстой гэсэн дэлхийн 128 гаруй орны хагас сая гаруй хүмүүсийн гарын үсэг бүхий шаардлагыг тавьж, улмаар эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн асуудлаар тусгай хуралдаан явуулсан зэргийн үр дүнд хүний эрхийн асуудал болгон хүлээн зөвшөөрүүлж чаджээ.

В. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл: Ялгаварлан гадуурхах хэлбэр ба хүний эрхийн зөрчил

30. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн хэлбэр, мөн чанарын талаар судлаачдын цуглуулсан дэлгэрэнгүй мэдээ, баримтууд нь нөлөөллийн компанит ажлуудтай нэгдсэнээр эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл нь эмэгтэйчүүд ба эрэгтэйчүүдийн хоорондын тэгш бус эрхийн харилцаа, эрхийн тэнцвэргүй байдлаас үүдэлтэй, дэлхийн асуудал болохыг хүлээн зөвшөөрүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл ба ялгаварлан гадуурхах явдлын хоорондын харилцааг тодорхойлсон нь хамгийн чухал алхам болсон юм.

31. Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах явдалтай тэмцэх Хороо 1982 онд Эмэгтэйчүүдийн эсрэг бүх хэлбэрийн ялгаварлан гадуурхах явдлыг устгах тухай конвенцийн хэрэгжилтэнд үнэлгээ, шинжилгээ хийх үүрэгтэйгээр байгуулагдсан эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг хүний эрхийн асуудал болохыг хүлээн зөвшөөрүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн. Конвенци нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн асуудлыг тодорхой заагаагүй ч, Хороо нь эмэгтэйчүүдийн эсрэг бүх хэлбэрийн хүчирхийлэл нь Конвенцид тодорхойлсон эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах гэсэн тодорхойлтонд хамаарах ёстой гэдгийг онцлон тэмдэглэсэн. Уг хороо гишүүн улс орнуудыг энэ төрлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр арга хэмжээ авахыг байнга уриалдаг. Хорооны 12 дугаар ерөнхий зөвлөмжид /1989/, Конвенцийн

хэд хэдэн зүйлийн дагуу эмэгтэйчүүдийг хүчирхийллээс хамгаалах гишүүн орнуудын үүргийн талаар тодорхой тусгаж, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн хэргүүд болон энэ чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээнийхээ талаар Хороонд илгээх тайландаа дурдаж байхыг даалгажээ. Хорооны 19 дүгээр ерөнхий зөвлөмжид /1992/ эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл ба ялгаварлан гадуурхах явдлын хоорондын харилцаа холбоог тодотгон, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл нь жендерт суурилсан ялгаварлан гадуурхалтын хэлбэрийг бий болгодог, ялгаварлан гадуурхалт нь энэ төрлийн хүчирхийллийн гол шалтгаан болж байна гэдгийг тэмдэглэсэн. Энэ дүн шинжилгээ нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн асуудлыг Конвенци болон хүйсээр ялгаварлан гадуурхахгүй байх тухай олон улсын хууль эрх зүйн хэм хэмжээнд тусгахад чухал нөлөө үзүүлсэн.

32. 1993 оны Венийн Хүний Эрхийн бага хурал эмэгтэйчүүдийн эрхийн асуудлыг хүний эрхийн асуудал гэдгийг хүлээн зөвшөөрүүлэхэд дэлхийн улс орнуудыг хэрхэн зохион байгуулалттайгаар дайчлан оролцуулж чадсаныг харуулсан юм. Бүх бүсүүдийн төрийн болон төрийн бус байгууллагуудын төлөөлөл болсон эмэгтэйчүүд хамтран ажиллаж, уг чуулганы бэлтгэл ажлыг зохион байгуулж, бүсийн болон дэлхийн хэмжээнд хүчтэй нөлөөллийн ажлуудыг явуулжээ. Ингэхдээ олон улсын хүний эрхийн асуудалд жендерийн үзэл баримтлалыг тусгах, эмэгтэйчүүдийн хүний эрхийн зөрчлүүдийг илрүүлэн гаргаж харуулах өргөн компаниг ажлуудыг чуулганыг угтан зохион байгуулжээ. Венийн Тунхаглал болон Үйл ажиллагааны хөтөлбөрт эмэгтэйчүүдийн эрхийг хүний эрхийн асуудал хэмээн үзэж, жендерт суурилсан хүчирхийллийг устгахыг уриалсан. Түүнээс гадна Венийн бага хурал тухайн оны эцэст Ерөнхий Ассемблейгаас Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг устгах тухай Тунхаглалыг батлан гаргахад чухал үүрэг гүйцэтгэсэн юм.

33. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг устгах тухай Тунхаглал эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл нь "эмэгтэйчүүд ба эрэгтэйчүүдийн хоорондын тэгш бус эрхийн харилцааны илрэл, улмаар эрэгтэйчүүдийн зүгээс эмэгтэйчүүдийг захирах, ялгаварлан гадуурхах байдлыг бий болгон, эмэгтэйчүүдийг бүрэн дүүрэн хөгжиж дэвшихэд саад болдог" хэмээн тодорхойлсон. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн үйлдэгдэж байгаа янз бүрийн орчин нөхцөлийг мөн онцлон тэмдэглэсэн. Үүнд: гэр бүлийн хүчирхийлэл, нийгэм олон нийтийн зүгээс эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэгдэж байгаа хүчирхийлэл, төрийн зүгээс эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэгдэж байгаа хүчирхийлэл гэх мэт. Мөн тунхаглал хүчирхийлэлд өртөх эрсдэл бүхий бүлгийн эмэгтэйчүүд, уугуул иргэд, үндэсний цөөнх, дүрвэгч, урьдчилан хорих газруудад хоригдож байгаа, хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, охидууд, ахмад насны эмэгтэйчүүд, зэвсэгт мөргөлдөөний нөхцөлд амьдарч байгаа эмэгтэйчүүд хүчирхийлэлд илүү өртөх эрсдэлтэй байгааг тодорхойлжээ. Тунхаглалд улс орнуудын зүгээс эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг устгах, урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх хэд хэдэн арга хэмжээг багтаасан. Үүний дагуу улс орнууд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг устгахад хүчирхийллийг өдөөж байгаа буруу зан заншил, уламжлал, шашин шүтлэгийг хориглох арга хэмжээ авахыг үүрэг болгосон.

Жишээ 1

**Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн тодорхойлолт
Ерөнхий зөвлөмж No. 19**

Эмэгтэйчүүдийн эсрэг жендерийн шинжтэй хүчирхийлэл нь “эмэгтэй хүнийх нь хувьд эмэгтэй хүний эсрэг чиглэсэн хүчирхийлэл буюу эмэгтэйчүүдэд зүйрлэшгүй хүндээр тусдаг хүчирхийлэл юм. Ийм хүчирхийлэлд бие махбодь, сэтгэл санаа, бэлгийн шаналалд хүргэдэг үйлдлүүд, тийм үйлдэл үйлдэхээр заналхийлэх, хүчээр тулгах болон бусад хэлбэрээр эрх чөлөөг нь эдлүүлэхгүй байх зэрэг үйлдлүүд орно.”

“Эмэгтэйчүүд олон улсын хууль, хүний эрхийн конвенцийн дагуу хүний эрхээ эдлэх байдалд нь хохирол учруулдаг буюу түүнийг огт үгүйсгэдэг жендерийн эсрэг хүчирхийлэл бол Конвенцийн 1 дүгээр зүйлд заасан ялгаварлан гадуурхалт юм.”^а

Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг устгах тунхаглал, 1 дүгээр зүйл

“Нийгмийн болон хувийн амьдралын алинд ч эмэгтэйчүүдэд бие махбодь, бэлгийн, сэтгэл санааны шаналал зовлонг бий болгох, бий болгож болзошгүй аливаа үйлдэл, мөн тийм үйлдэл үйлдэхээр заналхийлэх, хүчээр тулгах буюу эрх чөлөөг нь эдлүүлэхгүй байх” нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл юм.^б

**Эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийллийг устгах талаар
Ерөнхий Ассамблейн тогтоол**

Тогтоолд “эдийн засгийн эрх чөлөөг нь хасах, тусгаарлах зэрэг үйлдлүүд, мөн эмэгтэйчүүдийн аюулгүй байдал, эрүүл мэнд, сайн сайханд аюул, хор хөнөөл учруулж болох үйлдлүүд нь гэр бүлийн хүчирхийлэлд тооцогдоно”^в гэж тодорхойлсон.

а Эмэгтэйчүүдийн эсрэг ялгаварлан гадуурхалт устгах хорооны 19-р Ерөнхий зөвлөмжийн 7 дугаар зүйл

б Ерөнхий Ассамблейн тогтоол 48/104.

в Ерөнхий Ассамблейн тогтоол 58/147.

34. Венийн Бага Хурлын үр дүнгийн нэг нь 1994 онд Хүний эрхийн Комиссоос эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, түүний шалтгаан, үр дагаврын асуудлаарх Тусгай илтгэгчийг томилсон явдал байлаа. Тусгай илтгэгчийн эрх үүрэг, мандат нь дэлхийн хэмжээнд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн асуудлыг тогтмол, дэлгэрэнгүй, гүн гүнзгий судлах, тайлагнах бүтэц механизмыг бий болгосон. Энэхүү ажил нь олон улсын хүний эрхийн хэм хэмжээний дагуу хийгддэг бөгөөд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, түүний шалтгаан, сөрөг үр дагаврыг устгах талаар зөвлөмжүүдийг боловсруулах ажлыг ч багтаадаг. Тусгай илтгэгч асуудалд хийсэн дүн шинжилгээ, улс орнуудад хийсэн ажлын айлчлал, зөвлөмжүүд зэргээр дамжуулан эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн төрөл бүрийн хэлбэрийн талаар олон нийтийн ойлголт ухамсрыг нэмэгдүүлэх, энэ асуудлаарх олон улсын стандартуудын тухай ойлголтыг өргөжүүлсэн.

35. Бээжингийн Тунхаглал ба Үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг Бээжин хотноо 1995 онд зохион байгуулагдсан Эмэгтэйчүүдийн асуудлаарх Дэлхийн 4 дүгээр чуулга уулзалтан дээр 189 орон баталсан бөгөөд уг тунхаглал эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл нь эмэгтэйчүүдийн хүний эрхийн ноцтой зөрчил, эмэгтэйчүүдийг хүний бүх эрхийг бүрэн эдлэхэд саад болж байна хэмээн онцлон тэмдэглэсэн. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг устгах, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр улс орнуудын хүлээх үүрэг, хариуцлагаа биелүүлэхийг шаардаж эхэлсэн. Бээжингийн хурлын шийдвэр буюу үйл ажиллагааны хөтөлбөр нь тэгш эрх, энх тайван, аюулгүй байдлын зорилтуудыг хангахын төлөө яаралтай авч хэрэгжүүлбэл зохих 12 чухал асуудлыг дэвшүүлэн тавьсан ба эдгээр асуудлын нэг нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн асуудал байлаа. Энэ асуудлыг өөр хэд хэдэн асуудлын хүрээнд мөн авч үзэж шийдвэрлэх талаар заажээ.

Жишээ 2

Бээжингийн шийдвэр буюу үйл ажиллагааны хөтөлбөр

Бээжингийн шийдвэр буюу үйл ажиллагааны хөтөлбөрийн эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаарх асуудлаар дор дурдсан 3 үндсэн зорилтыг дэвшүүлжээ. Үүнд:

- Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг устгах, түүнээс урьдчилан сэргийлэх талаар уялдаа холбоо бүхий нэгдсэн арга хэмжээ авах
- Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн шалтгаан ба үр дагавар, үр дүнтэй хариу арга хэмжээнүүдийн талаар нарийн судлах
- Эмэгтэйчүүдийг хил давуулан худалдаалах явдлыг устгах, хүн худалдаалах, биеийг нь үнэлүүлэх, хүчирхийллийн улмаас хохирсон эмэгтэйчүүдэд дэмжлэг тусалцаа үзүүлэх

Эдгээр зорилтуудын дагуу, Бээжингийн шийдвэр буюу Үйл ажиллагааны хөтөлбөрт засгийн газруудын авч хэрэгжүүлбэл зохих арга хэмжээнүүдийг тусгасан бөгөөд үүнд олон улсын хүний эрхийн арга хэрэгслүүд, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн тухай хууль тогтоомжуудаа боловсронгуй болгож байх, хууль эрх зүйн үйлчилгээ хүртэх боломжийг нэмэгдүүлэх, хариу арга хэмжээ, үйлчилгээг үр дүнтэй болгох, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс эмэгтэйчүүдийг хамгаалах, хохирогч эмэгтэйчүүдэд дэмжлэг тусалцаа үзүүлэх, олон нийтийн мэдлэг, ухамсрыг дээшлүүлэх зэрэг хөтөлбөрүүдийг боловсруулан хэрэгжүүлэх талаар дурдсан.

36. Бээжингийн шийдвэр буюу үйл ажиллагааны хөтөлбөрийн 5 жилийн хугацааны хэрэгжилтийг 2000 онд авч үзэж дүгнэх үеэр Улс орнууд эмэгтэйчүүд, охидын эсрэг хүчирхийлэл нь гэр бүл, хувийн болон нийгмийн хүрээний алинд ч үйлдэгдсэн байсан хүний эрхийн зөрчлийн асуудал болохыг, мөн энэ чиглэлээр улс орнуудын хүлээх үүрэг, хариуцлагын талаар онцлон тэмдэглэсэн. Засгийн газруудыг эмэгтэйчүүдийг төр, байгууллага, хувь хүний зүгээс, хэн үйлдсэнийг нь үл харгалзан эмэгтэйчүүдийн эсрэг бүхий л хэлбэрийн хүчирхийлэл ба ялгаварлан гадуурхалтыг устгахын төлөө бүхий л арга хэмжээг авахыг хүссэн бөгөөд эмэгтэйчүүд, охидын эсрэг бүх хэлбэрийн хүчирхийллийг гэмт хэрэгт тооцон арга хэмжээ авах шаардлагатайг онцлон тэмдэглэсэн.

37. Аюулгүйн Зөвлөлийн 1325 дугаар /2000/ эмэгтэйчүүд, энх тайван ба аюулгүй байдлын талаарх шийдвэр нь цэрэг дайны зөрчилтэй үеийн нөхцөлдэх эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн асуудлыг шийдвэрлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн. Зэвсэгт

мөргөлдөөний зөрчлийн үед, түүний дараа үеийн нөхцөл байдалд эмэгтэйчүүд, охидын эрхийг хамгаалах тухай хуулийг бүрэн гүйцэд хэрэгжүүлэх хэрэгцээг хүлээн зөвшөөрч, зэвсэгт мөргөлдөөний нөхцөлд эмэгтэйчүүд, охидыг жендерт суурилсан хүчирхийллээс хамгаалах талаар тусгай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхийг уриалсан. Мөн энэ шийдвэр нь хүчирхийлэл үйлдэгчдийг ял шийтгэлгүй орхидог байдлыг зогсоох талаар улс орнууд арга хэмжээ авах тухай онцлон тэмдэглэсэн.

Г. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлд хүний эрхийн талаас хандах, түүний үр дагавар

38. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн асуудлаарх хамгийн анхны тусгай илтгэгч нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн эсрэг хөдөлгөөнүүдийг тодорхойлохдоо “эдгээр хөдөлгөөнүүд магадгүй хүний эрхийн тусгайлсан асуудлаар олон улсыг өргөнөөр татан оролцуулсан, улмаар олон улсын хэм хэмжээ ба стандартуудыг тогтоолгох, олон улсын бодлого, хөтөлбөрүүдийг боловсруулан хэрэгжүүлэхэд хүргэж чадсан хамгийн амжилттай түүхийн нэг байх” хэмээжээ.

39. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг хүний эрхийн асуудал болгон авч үзсэнээс үүдэн хэд хэдэн чухал үр дүн бий болдог. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг хүний эрхийн зөрчлийн асуудал болгон авч үзэх нь улс орнуудын энэ төрлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, түүнийг устгах, хүчирхийлэл үйлдэгчид хариуцлага тооцох талаарх үүргийг нь улам бүр тодотгож өгдөг. Улс орнууд эдгээр үүрэг хариуцлага нь хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах, дэмжих, эрхийг хангах чиглэлээр арга хэмжээ авах алхмуудаас эхлэх ёстой. Хүний эрхийн асуудлын хүрээ улс орнуудыг олон улсын болон бүсийн түвшинд хариуцлага хүлээх арга хэрэгсэл, механизмуудаар хангадаг. Эдгээрт хүний эрхийн тухай гэрээ, хэлэлцээрүүдэд нэгдэн орох, олон улсын эрүүгийн шүүхийн хурал, Африк, Европ болон Америк дундын хүний эрхийн системүүд зэрэг багтдаг /4 дүгээр бүлгийг үзнэ үү/.

40. Хүний эрх нь улс орнуудыг үүрэг, хариуцлагаа биелүүлж, олон улсын стандарт, хэм хэмжээг дагаж мөрдөж байгаа эсэх, ахиц амжилтыг хянаж дүн шинжилгээ хийх, зохицуулалт, тууштай байдлыг дэмжих нэгдсэн хэм хэмжээнүүдээр хангадаг. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг хүний эрхийн асуудал гэж авч үзэж шийдвэрлэх нь эмэгтэйчүүдийг чадавхжуулж, улмаар эмэгтэйчүүдийг зөвхөн хэн нэгний тусламжийг аваад зүгээр суух бус, харин өөрөө өөрсдийн эрхийн төлөө тэмцэгч байх байр сууринд аваачдаг. Энэ нь мөн хүний эрхийн төлөө бусад идэвхтэн тэмцэгчид, эрчүүд, хөвгүүдийг татан оролцуулах явдлыг нэмэгдүүлдэг бөгөөд эдгээр хүмүүс эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн асуудлыг хүний эрхийг хүндэтгэх асуудлын нэг болгон шийдвэрлэх явдалд хувь нэмрээ оруулагч, хамтран зүтгэгч нар болгодог.

41. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг хүний эрхийн асуудал хэмээн хүлээн зөвшөөрсөн нь хүний эрхийн талаарх хэлэлцүүлэг, практик туршлагад эмэгтэйчүүдийн хувийн туршлагыг нилээд ихээр багтаан оруулах боломжийг олгосон. Хэн нэгэн эмэгтэйд тохиолдсон явдал, туршлагыг ил гаргахгүй, мэдэгдэхгүй үлдээнэ гэдэг нь хүний эрхийн зөрчлийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, түүнийг засаж залруулах чиглэлээр арга хэмжээ авахад мэдээллээр хангах боломжийг үгүй болгодог. Тиймээс хүний эрхийн хэм хэмжээ нь эмэгтэйчүүдийн хувь хүний туршлагыг авч үзэж, асуудлыг нэгдсэн шинж чанартай болгох хэрэгтэй. Нэгдсэн буюу цогц хүний эрхийн тогтолцоо нь жендерийн үзэл баримтлалыг төдийгүй, эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэл, арьс өнгө, гарал

үүсэл, анги давхарга, нас, хүйс, бэлгийн чиг баримжаа, хөгжлийн бэрхшээл, яс үндэс, шашин шүтлэг, соёлтой холбоотой хувь хүний туршлагын шинж чанарыг бүрдүүлж, түүнд нөлөөлдөг янз бүрийн хүчин зүйлүүдийг бас авч үзэх хэрэгтэй болгоно.

42. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг хүний эрхийн асуудал хэмээн авч үзэх нь хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, боловсрол, эрүүл мэнд, хөгжил, эрүүгийн хууль эрх зүй зэрэг бусад арга замуудыг үгүйсгэсэн хэрэг биш юм. Харин ч асуудлыг салангид бус илүү цогцоор нь авч үзэж, бүх салбар хоорондын үйл ажиллагааг уялдаа холбоотой болгож, салбар дундын нэгдсэн хариу арга хэмжээ авах боломжийг бүрдүүлдэг. Ингэснээр, эрүүл мэнд, эрүүгийн эрх зүй, хөгжил, хүмүүнлэг, энх тайвныг сахиулах, аюулгүй байдлыг хангах гэх мэт бүх салбарт эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, арга хэмжээ авч хэрэгжүүлэх, санаа санаачлагуудыг бэхжүүлэх, хурдасгахыг уриалдаг.

Д. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг устгах, нэгдмэл байдлыг хангах, үйл ажиллагааны хүрээг нэмэгдүүлэх

43. 1990-ээд оны үеэр эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг хүний эрхийн асуудал хэмээн ойлгох ойлголт, хандлага гарч ирэхэд уг асуудал нь олон салбарт хамааралтай болох тухай ойлголт нэмэгдэж эхэлсэн. Үүний үр дүнд өнөөдөр эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн асуудлыг маш олон байгууллага, салбарууд өөрсдийн эрх, үүрэг, зорилгуудын хүрээнд авч үзэж шийдвэрлэх болсон. Үүний нэгэн адил, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн цар хүрээ, хэм хэмжээний талаарх ойлголтууд бодлого, практик туршлагаар дамжуулан шинээр нэмэгдэх явдал үргэлжилсээр байгаа бөгөөд энэ нь хүний эрхийг хамгаалах байгууллагууд, тусгай журмууд, олон улсын эрүүгийн шүүхийн үйл ажиллагаа, засгийн газар хоорондын байгууллагууд, бүсийн байгууллагууд болон НҮБ-ын байгууллагуудын үзэл баримтлалд тусгагдаж байна.

44. Эмэгтэйчүүдийн талаарх тусгай бодлого хөтөлбөрүүд нь НҮБ-ын эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаар авч үзэх асуудлуудыг чиглүүлэх явдал үргэлжилсээр байна. Үүний зэрэгцээ хүчирхийллээс ангид байх эмэгтэйчүүдийн эрхийг илүү цогцоор хамгаалахад анхаарал хандуулах явдал нэмэгдсэн. Хүний эрхийн байгууллагууд нь өөрсдийн ажлын хүрээг эмэгтэйчүүдийн үзэл баримтлал, чиг хандлага, туршлагатай уялдуулах явдал ихээр нэмэгдсэн ба өөрсдийн ажлын эрх, үүргийн хүрээнд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн асуудалд анхаарал хандуулах явдал маш их нэмэгдсэн. Жишээлбэл, Хүний Эрхийн Хороо ба Эдийн засаг, Нийгэм, Соёлын Эрхийн Хороо нь эрэгтэй эмэгтэй хүмүүс хүний эрхээ тэгш эдлэх эрхийн талаар ерөнхий тайлбарыг баталсан бөгөөд Арьсны өнгөөр ялгаварлан гадуурхах Хорооноос арьсны өнгөөр ялгаварлан гадуурхах явдлыг жендертэй холбоотой хэм хэмжээний талаар ерөнхий зөвлөмжийг тус тус баталсан. Эдгээр нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн мөн чанар, цар хүрээ, хэм хэмжээ, улс орнуудын хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, түүнийг устгах чиглэлээр хүлээх үүрэг, хариуцлагын талаар асуудлуудыг маш тодорхой авч үзсэн.

45. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн асуудлаарх тусгай илтгэгчээс гадна, Хүний эрхийн Хорооны бусад сэдэвчилсэн тусгай илтгэгчид хүчирхийлэлтэй холбоотой асуудлыг бас авч үздэг. Эдгээрт хүүхдийг худалдаалах, хүүхдийн бие үнэлэх явдал, хүүхдийг садар самуунд уруу татах асуудал, хүнийг ялангуяа эмэгтэйчүүд, хүүхдийг хил давуулан худалдаалах зэрэг асуудлаар ажилладаг тусгай илтгэгчид багтдаг. Тарчлаан зовоох, эрүүл мэнд, хоол хүнс, боловсрол, орон байр, өөрийн дуу хоолой, байр суурийг чөлөөтэй илэрхийлэх, шашин шүтлэгээ сонгох

тухай эрхийн асуудлаарх бусад тусгай илтгэгчид өөрсдийн эрх, үүргийн хүрээнд, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн тухай асуудлыг авч үзэж эхэлсэн. Гэр бүлийн нэр хүндийг хамгаалах нэрийдлээр эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэгдэж байгаа гэмт хэргийн талаарх асуудалд бие даасан шүүгчид, хуульчид тусгай илтгэгчид анхаарлаа хандуулан ажиллаж эхэлсэн.

46. Ерөнхий Ассемблей болон Эдийн засаг ба Нийгмийн зөвлөл нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн асуудалд байнга анхаарал хандуулсаар ирсэн. Ялангуяа, Эмэгтэйчүүдийн байдлын тухай Хороо, Хүний эрхийн хороо, Хүний эрхийг хамгаалах Дэд Хороо, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ба Эрүүгийн эрх зүйн Хорооноос эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн тодорхой нэг хэлбэрийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, түүнийг устгах чиглэлээр янз бүрийн байгууллага, талууд өөр өөр түвшинд ямар арга хэмжээ авч болох талаар зөвлөмж, чиглэл удирдамжаар хангасан шийдвэрүүдийг баталсан. Зарим шийдвэрүүд нь иргэний нийгмийн байгууллагуудын санаа, санаачлагуудыг бэхжүүлэхтэй холбогдсон. Жишээлбэл: Ерөнхий Ассемблей 1999 онд жил бүрийн 11 сарын 25-ны өдрийг Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг устгах Олон улсын өдөр болгох шийдвэрийг гаргасан.

47. Засгийн газар хоорондын бага хурал, чуулганууд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг устгах үүрэг амлалтыг улам бүр бэхжүүлсэн. Жишээ нь, 1994 онд Каир хотноо болсон Хүн ам ба хөгжлийн асуудлаарх олон улсын бага хурал эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг устгах нь эмэгтэйчүүдийг чадавхжуулахад чухал үүрэгтэй болохыг хүлээн зөвшөөрсөн. 2000 онд болсон Мянганы Бага Хурал дээр улс ба засгийн газрын тэргүүнүүд эмэгтэйчүүдийн эсрэг бүхий л хэлбэрийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай асуудлын талаар авч хэлэлцсэн. 2005 оны Дэлхийн Бага Хурал ба дээд хэмжээний уулзалтаар эмэгтэйчүүд охидын эсрэг бүхий л хэлбэрийн хүчирхийлэл ба ялгаварлан гадуурхах явдлыг нэн даруй устгахын чухлыг онцлон тэмдэглэж, Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжүүлэлттэй уялдуулан авч үзэх болсон.

48. Хуучин Югослав болон Руандагийн Олон улсын Эрүүгийн Шүүх хурал, Сиерра Леоны Тусгай Шүүх нь олон улсын эрүүгийн эрх зүйн системийн зэвсэгт мөргөлдөөн дэх эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл үйлдэгчдэд хариуцлага тооцох, ял шийтгэл хүлээлгэх үүргийг нэмэгдүүлсэн. Олон улсын эрүүгийн Шүүхийг байгуулах тухай 1998 оны Ромын тогтоол нь жендерт суурилсан эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн хэд хэдэн асуудлыг багтаасан.

49. НҮБ-ын бүх салбарын үйл ажиллагааг жендерийн үзэл баримтлалтай уялдуулах чиглэл удирдамжийн үр дүнд олон хөтөлбөр, бодлогууд өөрсдийн үйл ажиллагааныхаа эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдэд үзүүлэх үр нөлөөний тухай авч үзэхийг эрэлхийлэх болсон. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг устгах хөтөлбөрт оролцогч төрөл бүрийн байгууллагуудын тоо нилээд нэмэгдсэн. Эдгээр байгууллагууд судалгаа, бодлого боловсруулах, хүчирхийллийн хохирогч, даван туулагсдад үйлчилгээ, тусламж дэмжлэг үзүүлэх, олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх, нөлөөллийн үйл ажиллагаа явуулах, хөрөнгө босгох зэрэг олон чиглэлээр үйл ажиллагаа явуулахад оролцож байна. НҮБ-ын хэд хэдэн байгууллага эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг нэн тэргүүнд шийдвэрлэх асуудлуудынхаа нэг болгон тавьж байгаа нь сайшаалтай хэдий ч энэ чиглэлээр хөрөнгө нөөц, анхаарал тавих асуудал төдийлөн хангалттай бус байгаа бөгөөд үйл ажиллагааны сайн үр дүнтэй зохицуулалт дутагдаж байна.

Жишээ 3

Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, түүнийг устгах тухай НҮБ-ын систем

НҮБ-ын системийн хүрээнд хэд хэдэн байгууллага, агентлагууд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх тусгай хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байгаа болон зарим байгууллагуудын зорилго, зорилтууд, эрх үүрэг, мандатын хүрээнд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх хүчин чармайлтыг гарган ажиллаж байна. НҮБ-ын төрөлжсөн байгууллагуудын талаарх судалгаагаар НҮБ-ын 32 байгууллага дэлхийн, бүсийн болон үндэсний хэмжээнд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна гэсэн тоо гарчээ. Эдгээр байгууллагуудын үйл ажиллагаа нь гэр бүлийн хүчирхийллээс авахуулаад, зэвсэгт мөргөлдөөний үеийн, дараа үеийн нөхцөл дэх эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл гэх зэргээр маш өргөн хүрээг хамардаг. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн эсрэг НҮБ-ын явуулж буй бас нэг ажил нь НҮБ-ын байгууллага үйл ажиллагаа явуулж байгаа орон бүрт эмэгтэйчүүдийг хил давуулан худалдаалахыг устгах бэлгийн мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх чиглэлээрх хүчин чармайлт юм. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд эрэгтэйчүүд, хөвгүүдийн үүрэг, оролцоог чухал гэдэгт анхаарлаа хандуулах нь нэмэгдэж байна. Хөгжлийн зорилтуудыг хангахад эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл ихээр саад болж байгаад анхаарал хандуулах нь нэмэгдэж байна. Байгууллагууд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг ДОХ/ХДХВ зэрэг бусад асуудалтай холбоо хамааралтайгаар авч үзэж, хариу арга хэмжээ авч, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн янз бүрийн хэлбэр, тэдгээр нь хэрхэн үйлдэгдэж байгаа талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, мэдээлэл цуглуулах зэрэг чиглэлээр хувь нэмрээ оруулан ажиллаж байна.

Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэхэд учирч байгаа бэрхшээлүүд, дутагдлуудыг харгалзан үзэж эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх илүү цогц, нарийн зохицуулалт, зохион байгуулалттай хариу арга хэмжээ авахын төлөө зорьж ажиллах хэрэгтэй бөгөөд ялангуяа доорх асуудлууд чухал юм.

- НҮБ-ын төрөлжсөн байгууллагуудын зүгээс эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, түүнийг устгахын төлөө хүчин чармайлт, үйл ажиллагааг удирдан чиглүүлж байгаа хууль эрх зүй, бодлогын хэрэгжилт
 - Мэдээлэл цуглуулах ба судалгаа
 - Олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх, шилдэг практик туршлагуудыг түгээн дэлгэрүүлэх
 - үндэсний хэмжээнд зохион байгуулалттай хариу арга хэмжээ
 - хүч хөрөнгийг дайчлах, ашиглах
 - олон улсын хэмжээн дэх зохицуулалтын механизмууд

НҮБ-ын системийн эмэгтэйчүүд ба жендерийн тэгш эрхийн агентлаг хоорондын сүлжээ нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх хүчин чармайлтуудыг бэхжүүлэх, системийн хэмжээн дэх зохицуулалтыг сайжруулахын төлөө зорьж ажилладаг. НҮБ-ын Эмэгтэйчүүдийн Сангийн Итгэлийн Сан нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг устгахын төлөөх дэлхийн бүх орнуудын шинэ санаа, санаачлагууд, төслүүдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлдэг.

50. Бүсийн байгууллагууд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг устгах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Бүсийн хэмжээний гэрээ, хэлэлцээрүүдэд Эмэгтэйчүүдийн Эсрэг Хүчирхийллээс Урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай Америк Дундын Конвенци (Беле до Парагийн Конвенци), Эмэгтэйчүүд, хүүхдийг хил дамнуулан худалдаалах, бэлгийн мөлжлөгөд ашиглахаас урьдчилан сэргийлэх, тэмцэх тухай Зүүн өмнөд Азийн Бүсийн Хамтын ажиллагааны Конвенци зэрэг

багтаж байна. Африк тивийн хувьд бүсийн хэмжээн дэх санаа санаачлагуудад эмэгтэйчүүд ба хүүхдийн эсрэг бүхий л хэлбэрийн хүчирхийллийг таслан зогсоох тухай тусгай нэмэлтүүд (1998), 1997 оны Өмнөд Африкийн Хөгжлийн Олон нийтийн Эмэгтэйчүүд ба Хөгжил Тунхаглал, Европ тивийн хэмжээнд Европын Зөвлөлийн Хорооноос эмэгтэйчүүдийг хүчирхийллээс хамгаалах талаар гишүүн орнууддаа хандсан зөвлөмжийг баталсан.

51. Олон улсын стандартуудыг үйл ажиллагаандаа тусгасан бүсийн хэмжээний эдгээр санаа, санаачлагууд нь бүсийн хэмжээнд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хяналт шинжилгээ хийх бүсийн бүтэц механизмыг бий болгодог. Бүсийн зарим санаа санаачлагууд өнөөгийн стандартыг цааш нь өргөжүүлж байна. Жишээлбэл, Африкийн хүний эрхийг хамгаалах тухай протокол эмэгтэйчүүдийн эсрэг эдийн засгийн хүчирхийллийлэл, түүний хор уршгийн талаар нэмж оруулснаар Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг устгах тухай тунхаглалд тусгасан нэр томъёог өргөжүүлсэн. Беле До Пара-гийн Конвенци нь гэр бүлийн болон нийгмийн хүрээнд хүчирхийллээс ангид амьдрах эмэгтэйчүүдийн эрхийн талаар онцгойлон тусгаж, энэ чиглэлээр улс орнуудад хэд хэдэн үүргийг даалгасан. Түүнчлэн хүчирхийлэл ба эмэгтэйчүүдийн хүний эрхээ бүрэн эдлэх явдлын хоорондын уялдаа холбоог онцлон тэмдэглэсэн.

52. Олон улсын Парламентын холбоо бүх салбарт эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэхэд Парламентын гишүүдийн хүлээх үүрэг, хариуцлагын талаар чухалчлан үзсэн. Олон улс орнууд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр хууль баталж, бодлого, хөтөлбөрүүдийг боловсруулан ажиллаж байна. Зарим улс орнууд хүчирхийллийн хохирогч, даван туулагсдад дэмжлэг туслалцаа үзүүлэх, олон нийтийн ойлголт, ухамсрыг нэмэгдүүлэх, сургалт, чадавхийг бэхжүүлэх, хүчирхийлэл үйлдэгчдийг шийтгэх, хариуцлага ногдуулах, зан үйлийг нь засах зэрэг өргөн хүрээний асуудлыг хамруулсан үйл ажиллагааны үндэсний хөтөлбөрийг баталсан. Харамсалтай нь ахиц амжилт хангалтгүй байна. Ихэнх орнуудад хүчирхийлэлтэй тэмцэхэд эрүүгийн шүүх, эрүүл мэнд, хэвлэл мэдээлэл, боловсрол зэрэг бүх салбарыг хамарсан салбар дундын нэгдсэн зохицуулалт бүхий арга замууд дутагдаж байна.

53. Тухайн орон бүрт эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа янз бүрийн түвшний үйл ажиллагаанууд нь үндэсний хэмжээн дэх ерөнхий ахиц амжилтыг дүгнэхэд хүндрэлтэй болгож байна. Тухайн орны нийгэм, эдийн засаг, түүхийн өөр өөр нөхцөл байдлаас шалтгаалан эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэгдэж байгаа хүчирхийллийг танилцуулах, батлан харуулах явдлууд өөр өөр байдаг нь харьцуулалт хийхийг бүр ч илүү төвөгтэй болгодог. Гэсэн хэдий ч эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл оршиж байгаа гэдэг нь дэлхийн бүх орнуудад хөдөлшгүй үнэн нь батлагдаж байгаа болохоор ийм төрлийн хүчирхийллийг таслан зогсоохын тулд олон улсын болон бүсийн стандартуудыг хэрэгжүүлэх нь нэн тэргүүний, хойшлуулшгүй асуудал болж байна. Дэлхийн олон оронд хэрэгжүүлж туршаад үр дүнтэй, амжилттай болох нь батлагдсан, хэрэгжүүлж болохуйц шилдэг практик арга туршлагауд, бодлого, стратегиудаас шинэ бодлого, стратегиуд урган гарч байдаг (7 дугаар бүлгийг үзнэ үү).

54. Хүчирхийлэл нь эмэгтэйчүүдийн сонголт, чадварыг нь хязгаарласнаараа хөгжилд хувь нэмрээ оруулах, түүнээс үр шимийг нь хүртэх боломжийг үгүй болгодог. Үүнээс үүдэн гарч байгаа хор уршгийг Засгийн газрууд эдийн засгийн өсөлт, ядуурлыг бууруулах явдлын анхаарлын төвд байлгах ёстой. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл Мянганы хөгжлийн ядуурал, боловсрол, хүүхдийн эрүүл

мэнд, эхийн эндэгдэл, ДОХ/ХДХВ, бусад чиглэлээрх тогтвортой хөгжлийн зорилтуудын биелэлтэнд ихээхэн саад учруулж, ахиц амжилтыг хойш татаж байна. Мянганы Хөгжлийн Зорилтуудыг хэрэгжүүлэх бүх хөтөлбөр эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн асуудлыг шийдвэрлэх, урьдчилан сэргийлэхэд анхаарал хандуулахгүй бол хүчирхийлэл нь эдгээр санаачлагуудын үр дүн, үр шимийг мөн хязгаарлах болно. Ингэснээр Мянганы Хөгжлийн бүх зорилтуудад эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн асуудал тууштай хэрэгжих боломжгүй болно.

Жишээ 4

НҮБ-ын харьяа байгууллагууд, төрөлжсөн байгууллагуудын зүгээс эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаар гаргасан удирдамжууд

Байгууллага хоорондын байнгын хороо, Хүмүүнлэгийн байгууллагуудын хүрээнд жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх удирдамж: Онцгой нөхцөл байдлын үеийн эмэгтэйчүүдийн эсрэг бэлгийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах тухай (2006)

Бэлгийн мөлжлөг, бэлгийн хүчирхийллээс хамгаалах чиглэлээр тусгай арга хэмжээ, Ерөнхий нарийн бичгийн даргын мэдээлэл (2003)

Хүний Эрхийн Дээд Комиссарын Алба, Хүний эрх, Хүн хил давуулан худалдаалахтай холбоотой удирдамж ба зарчмууд (2002)

НҮБ, Аюулгүй хот хөтөлбөр, Аюулгүй байдлыг хянан шалгах удирдамж

Дүрвэгсдийн асуудлаарх НҮБ-ын Дээд Комиссар, Дүрвэгсэд, эх орондоо буцаж ирэгсэд, дотоодын дүрвэгсдийн эсрэг бэлгийн ба жендерт суурилсан хүчирхийллээс хамгаалах, урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээний удирдамж (2002)

Дүрвэгсдийн асуудлаарх НҮБ-ын Дээд Комиссар, дүрвэгсдийн нөхцөл байдалтай холбоотой 1967 дугаар Протокол, Конвенцийн 1 дүгээр бүлгийн 2 А зүйлийн дагуу жендертэй холбоотой гэмт хэргүүдийг шийдвэрлэх, олон улсын хамгаалалтын тухай удирдамж (2002)

Дэлхийн Хүнсний Хөтөлбөр, Бэлгийн мөлжлөг, бэлгийн хүчирхийллээс хамгаалах чиглэлээрх тусгай арга хэмжээ, Ерөнхий нарийн бичгийн даргын гаргасан мэдээллийг хэрэгжүүлэх тухай Гүйцэтгэх захирлын шийдвэр

Дэлхийн Эрүүл мэндийн байгууллага, бэлгийн хүчирхийллийн хохирогчдод эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх тухай удирдамж (2003)

Дэлхийн Эрүүл мэндийн байгууллага, Хил давуулан худалдаалах гэмт хэргийн хохирогч эмэгтэйчүүдээс мэдүүлэг авах аюулгүй байдлын болон ёс зүйн тухай удирдамж (2003)

Дэлхийн Эрүүл мэндийн байгууллага, Гэр бүлийн хүчирхийллийн асуудлаарх судалгаа хийх аюулгүй байдлын болон ёс зүйн тухай удирдамж (1999)

Е. Бэрхшээл, саад тотгорууд

55. Олон улс, бүсийн ба үндэсний дээд түвшинд нэн тэргүүний асуудлын нэг болгон авч үзэх улс төрийн хүсэл сонирхол, хүчин чармайлт, үүрэг амлалтгүйгээр эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох боломжгүй. Асуудалд анхаарлаа хандуулж байгаа эсэх улс төрийн хүсэл сонирхол нь хууль тогтоомж, үндэсний хөтөлбөр, хөрөнгө, нөөц хангалттай хуваарилах, дээд түвшинд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх механизмыг бүрдүүлэх, хүчирхийлэл үйлдэгчдийг ял завших явдлыг таслан зогсоох, хүчирхийллийг хүчтэй эсэргүүцэх, удирдлагын зүгээс тууштай дэмжлэг тусалцаа үзүүлэх гэх мэт маш олон төрлийн

арга замаар илэрдэг. Түүнчлэн энэ чиглэлээр ТББ-ууд үр дүнтэй үйл ажиллагаа явуулах таатай орчныг бүрдүүлэх, үйл ажиллагааг нь дэмжих, хамтран ажиллах зэрэг нь улс төрийн асуудалд анхаарлаа хандуулж байгаа хүсэл сонирхлын илрэл болж болно.

56. Эмэгтэйчүүдийн хүний эрхийг хамгаалах, дэмжих, эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хооронд тэгш эрхийн харилцааг бүрдүүлэх нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажлын гол цөм болох ёстой. Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хоорондын эрхийн тэнцвэргүй байдал, тэгш бус эрхийн харилцаа нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн шалтгаан, нөхцөл байдлын аль аль нь болж байна. Энэ судалгаа эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтыг зогсоохын төлөө тэмцэх нь бүх салбар дундын цогц, иж бүрэн, нарийн зохицуулалттай, тасралтгүй хүчин чармайлтыг шаардаж байгааг маш тодорхой гаргаж ирсэн. Энэхүү бүх салбарын цогц хариу арга хэмжээ нь хууль эрх зүй, эрүүгийн шүүх, эдийн засаг, нийгмийн бодлого, нийгмийн үйлчилгээ, олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх боловсрол зэрэг өргөн хүрээг хамарсан байх хэрэгтэй.

57. Арилгахад нилээд хүндрэлтэй байгаа асуудлуудын нэг нь эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхдаг нийгмийн хандлага, эдийн засгийн тэгш бус байдал нь эмэгтэйчүүдийг нийгэмд доогуур байр суурь эзлэх, бусдаас хараат, бусдад захирагдах байдалд оруулж байна. Дэлхийн өнцөг булан бүрт эрэгтэйчүүдийн зүгээс эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэгдэж байгаа хүчирхийлэл нийгэм, соёл, уламжлалын хандлагаас, ялангуяа эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн, бэлгийн амьдралд хяналт тогтоох, энэ чиглэлээр эмэгтэйчүүдийн өмнөөс шийдвэр гаргах эрхийн хэм хэмжээнээс үүдэн хөрөнгө, анги давхарга, хүчирхийллийн бусад хэлбэр, үндэстний зөрчлүүд зэрэг хүчин зүйлүүдтэй харилцан хамааралтай.

58. Дэлхийн олон оронд эмэгтэйчүүдийн байдлыг дээшлүүлэхэд тулгарч байгаа саад бэрхшээлүүд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг өдөөж байгаа нийгэм, соёлын уламжлалт буруу хандлагуудыг өөрчлөх ажлыг улам бүр хүндрүүлж байна. Зарим нөхцөлд зохион байгуулалттай улс төрийн хүч нь соёлын болон шашны ямар нэг үзэл баримтлал "фундаментализм" буюу аливаа нэгэн шашны сургаалыг чанд сахих үзлээс шалтгаалан зарим нэг улс орон, засгийн газрууд эмэгтэйчүүдийн эрхийг сайжруулах ажлыг хойш нь татах сөрөг нөлөө үзүүлж байна. Дэлхийн зарим оронд эмэгтэйчүүдийн өнөөдрийг хүртэл тэмцэж байж олсон ололт амжилтыг хөсөр хаяж, амжилтаас ухраан зарим тохиолдолд бүр айлган сүрдүүлж байна.

59. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоохыг эрэлхийлж байгаа талуудын дунд стратеги, арга замуудын талаар маргаан бий болж байна. Жишээлбэл, эмэгтэйчүүдийг хил давуулан худалдаалах хэргийг ямар арга замаар таслан зогсоох, биеэ үнэлэх явдал ямар тохиолдолд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл болдог, ер нь хүчирхийлэл гэж үзэх эсэх, эмэгтэйчүүдийн сонголт хийх эрх чөлөө, хохирогч болох явдлын хоорондын зааг ялгааг хэрхэн тогтоох талаар маргаантай байр суурийг илэрхийлж байна. Хэдийгээр иймэрхүү байдлын маргаан, санал нийлэхгүй асуудлууд хэцүү ярвигтай байгаа ч Засгийн газрууд аль ч нөхцөл байдалд эмэгтэйчүүдийн хүний эрх, хүчирхийллээс ангид амьдрах эрхийг хамгаалж байх үүрэгтэй гэдэг нь тодорхой юм (4 дүгээр бүлгийг үзнэ үү).

60. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн янз бүрийн хэлбэр, тэдгээр нь өөр өөр бүлгийн эмэгтэйчүүдэд ямар нөлөө үзүүлж буй талаар хангалтгүй, харилцан адилгүй мэдээ, мэдээлэл байгаа нь асуудлыг амжилттай шийдвэрлэхэд саад болж байна. Авч байгаа арга хэмжээнд үнэлгээ өгөх мэдээ, мэдээлэл хомс байгаа нь мэдээлэлд бүрэн дүн шинжилгээ хийх, улмаар хамгийн үр дүнтэй хариу арга хэмжээг бий болгох, сайн

бодлого, стратеги боловсруулахад хангалттай мэдээ, мэдээлэл өгөх боломжгүйд хүргэж байна. (4 дүгээр бүлгийг үзнэ үү).

61. Эдгээр хүндрэл бэрхшээлүүдийг шийдвэрлэхэд тууштай хүчин чармайлт, амлалт, хүч хөрөнгө шаардагдана. Зарим арга хэмжээ, жишээлбэл, шаардлагатай хууль тогтоомжийг батлахад төдийлэн их хүч, хөрөнгө шаардагдах албагүй. Иймд энэ төрлийн ч гэсэн алхмуудыг яагаад хийхгүй байна, ийм их хор уршиг учруулж байгаа асуудлыг шийдвэрлэхэд юуны учир бага хөрөнгө, нөөцийг зарцуулж байгаа юм гэх зэрэг асуултууд урган гарч ирнэ. Жишээлбэл, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх, таслан зогсоох НҮБ-ын Итгэлийн Сан байгуулагдсанаас хойш 10 жил болж байхад жилд дөнгөж 2 сая хүрэхгүй долларын хөрөнгөтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Засгийн газар, санхүүжүүлэгч байгууллагын аль алиных нь хувьд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл нэн тэргүүний асуудал байх ёстой.

62. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтыг өөгшүүлж байгаа нийгмийн хандлага, тогтолцоог өөрчлөхөд Засгийн газар, ТББ-ууд, бусад талуудын зүгээс зохион байгуулалттай, олон талт арга хэмжээг тууштай авч хэрэгжүүлэхийг шаардаж байна. Жендерийн тэгш эрхийг хангах, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг устгах, жендерийн асуудлыг бүх салбарын бодлого, стратегид нэгтгэх зэрэг санаа, санаачлага, арга хэмжээнүүдийг нэгтгэсэн, сайн зохицуулалт бүхий стратегийг бий болгох нь хамгаас чухал юм. Иймэрхүү хүчин зүтгэлийн зохицуулалтыг нэмэгдүүлэх, үйл ажиллагааны гол арга хэрэгсэл болох эмэгтэйчүүдийн асуудалд хамааралтай тусгай механизмуудаар дэмжиж өгөх хэрэгтэй.

63. Эмэгтэйчүүдийн хөдөлгөөн, хүний эрхийн байгууллагууд нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох чиглэлээр санаа санаачлагуудыг гаргах, ялангуяа, олон улсын стандарт, хэм хэмжээнүүдийг орон нутгийн түвшинд амьдрал дээр хэрэгжүүлэхэд чухал үүргийг гүйцэтгэх ёстой. Үндэсний хэмжээнд, эмэгтэйчүүдийн эрхийн төлөө тэмцэгчид, ТББ-ууд олон улсын стандарт, хэм хэмжээнүүдийг эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг устгахын төлөө нөлөөллийн ажлын арга хэрэгсэл болгон энэ чиглэлээр засгийн газрын үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөхдөө гол чиг болгон ашиглахаа үргэлжлүүлэх хэрэгтэй.

64. Хэдийгээр бэрхшээл, хүндрэлүүд тулгарсаар байгаа хэдий ч эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох, түүнтэй тэмцэх чиглэлээр ахиц амжилт гарч эхэлж байгаа ба цаашдаа улам батжуулан сайжруулахын төлөө санаа санаачлагууд, зөвлөмжүүдийг гаргасан. Нийгмийн түвшин бүрд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг устгахын төлөөх зоригтой алхмууд, манлайллууд нь улс төрийн хүчин зүтгэл, хүсэл сонирхол, хөрөнгө, нөөцийг хангалттай хуваарилах зэрэг явдалтай нэгдснээрээ энэ төрлийн хүчирхийллийг бууруулахад чухал хувь нэмэр болно.

Жишээ 5

Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаарх хууль тогтоомж, бодлого, практикийн түүвэр

Олон улсын гэрээ

Эмэгтэйчүүдийн эсрэг ялгаварлан гадуурхалтын бүх хэлбэрийг устгах тухай конвенц

Эмэгтэйчүүдийн эсрэг ялгаварлан гадуурхалтын бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн Сайн дураар биелүүлэх протокол

Иргэний болон улс төрийн эрхийн талаарх олон улсын конвенц, түүний Протокол

Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын конвенц

Арьсны өнгөөр ялгаварлан гадуурхах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц

Эрүүдэн шүүх болон бусад харгис, хүнлэг бус гутаан доромжилсон байдлаар харьцах буюу шийтгэхийн эсрэг конвенц

Хүүхдийн эрхийн тухай конвенц, түүний протоколууд

Цагаач ажилчид болон тэдний гэр бүлийн гишүүдийн эрхийг хамгаалах тухай олон улсын конвенц

НҮБ-ын Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх конвенцийн нэмэлт, Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхдийг худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэл оноох тухай протокол

Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын заалт

Дайны нөхцөл байдал дахь энгийн иргэдийг хамгаалах талаарх Женевийн конвенцийн заалт (4 дэх удаагийн)

Бүс нутгийн гэрээ

Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, түүнд шийтгэл оноох ба устгах тухай Америкийн орнуудын конвенц (Белун ду Парийн конвенц)

Африкийн хүний болон ард түмнүүдийн Харгин, Африкийн эмэгтэйчүүдийн эрхийн протокол

Эмэгтэйчүүд ба хүүхдийг биеийг нь үнэлүүлэх зорилгоор худалдаалахаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх бүс нутгийн хамтын ажиллагааны конвенцийн төлөө Өмнөд Азийн холбоо

Олон улсын бодлогын баримт бичиг

Дэлхийн хүний эрхийн Бага хурлаас баталсан Венийн тунхаглал ба үйл ажиллагааны хөтөлбөр

Хүн ам ба хөгжлийн олон улсын Бага хурлын үйл ажиллагааны хөтөлбөр

Дэлхийн эмэгтэйчүүдийн Бага хурлаас баталсан Бээжингийн тунхаглал ба үйл ажиллагааны хөтөлбөр

Ерөнхий ассамблейн 23 дугаар чуулганаас гаргасан “Эмэгтэйчүүд 2000: 21-р зууны төлөө жэндэрийн тэгш байдал, хөгжил дэвшил ба энх тайван” (Ерөнхий ассамблейн тогтоол S-23/3)

Ерөнхий ассамблейн сүүлийн үеийн тогтоолуудын түүвэр

Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг устгах тухай тунхаглал, тогтоол 48/104

Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг устгах талаар урьдчилан сэргийлэх болон хуулийн байгууллагаас авах арга хэмжээ, тогтоол 52/86

НҮБ-ийн мянганы тунхаглал 55/2^a

Эмэгтэйчүүд, охидын эрүүл мэндэд хор бүхий уламжлалт буюу ёс заншлын практикийн тухай, тогтоол 56/128

Эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийллийг устгах тухай тогтоол 58/147

Нэр төрөө хамгаалахын тулд эмэгтэйчүүд, охидын эсрэг үйлдсэн гэмт хэргийг устгахын төлөө ажиллах тухай тогтоол 59/165

Эмэгтэйчүүд, охидыг худалдаалахын эсрэг тогтоол 59/166

Цагаач эмэгтэй ажилчидын эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх тогтоол 60/139

2005 оны Дэлхийн дээд хэмжээний уулзалтын үр дүн, тогтоол 60/1^o

Аюулгүйн зөвлөлийн тогтоол

Эмэгтэйчүүд, энх тайван аюулгүй байдлын тухай тогтоол 1325 (2000)

Хүний эрхийн комиссын тогтоол

Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг устгах тухай тогтоол 2005/41

НҮБ-ийн гэрээний байгууллагууд

Эмэгтэйчүүдийн эсрэг ялгаварлан гадуурхлыг устгах тухай хороо: Ерөнхий зөвлөмж No 12, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаар

Эмэгтэйчүүдийн эсрэг ялгаварлан гадуурхалыг устгах тухай хороо: Ерөнхий зөвлөмж No 14, эмэгтэйчүүдийн бэлэг эрхтнийг зэрэмдэглэх

Эмэгтэйчүүдийн эсрэг ялгаварлан гадуурхлыг устгах тухай хороо: Ерөнхий зөвлөмж N. 19, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл

Арьсны өнгөөр ялгаварлан гадуурхлыг устгах хороо: Ерөнхий зөвлөмж No 25, арьсны өнгөөр ялгаварлан гадуурхал дахь хүйсийн ялгаварлалын байдал

Хүний эрхийн хороо: Ерөнхий тайлбар No 28, эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн эрхийн тэгш байдал (3-р зүйл)

Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хороо: Ерөнхий тайлбар No 14, дээд зэргээр эрүүл байх эрх

Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хороо: Ерөнхий тайлбар No 16, эдийн засаг, нийгэм, соёлын бүх эрхээ эдлэх, эрэгтэйчүүд ба эмэгтэйчүүдийн тэгш эрх

(3-р зүйл)

Олон улсын Парламентийн холбоо

Парламентын зүгээс бүх салбар дахь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх үр нөлөөтэй арга замыг дэмжих тухай 2006 оны 5 сарын 12-ны тогтоол

а 25-р заалт

б 58-р (д) заалт

в Ерөнхий ассамблейн 60/251-р тогтоолоор Хүний эрхийн зөвлөлийг байгуулсан. Уг тогтоолоор Хүний эрхийн комиссын бүрэн эрх, механизм, үүрэг, хариуцлагыг Зөвлөлд шилжүүлсэн. Уг тогтоолоор зөвлөлийн эдгээр бүрэн эрхийг 1 жилээр сунгасан ба энэ хугацаанд зөвлөл хянан үзэх ажлыг гүйцэтгэх

III. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн нөхцөл, шалтгаан

A. Оршил

65. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг ялгаварлан гадуурхалтын нэг хэлбэр, хүний эрхийн зөрчил гэдгийг хүлээн зөвшөөрөх нь энэ төрлийн хүчирхийлэл үйлдэгдэж байгаа өргөн хүрээний нөхцөл байдал, тэдгээртэй холбоотой эрсдлийн хүчин зүйлүүдийг илүү ойлгож таньж мэдэхийн эхлэл цэг болж байгаа юм. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг хүний эрхийн хүрээнд авч үзэж дүн шинжилгээ хийж байхын гол нь энэ төрлийн хүчирхийллийн тодорхой шалтгаанууд, хүчирхийлэл үйлдэгдэх эрсдлийг нэмэгдүүлэх гол хүчин зүйлүүд нь жендерг суурилсан эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, захиран дарангуйлахын бусад хэлбэрүүдийн маш өргөн нөхцлүүдээс үүдэлтэй байдаг. Энэ төрлийн хүчирхийлэл эрэгтэй эмэгтэй хүмүүсийн хоорондын тэгш бус эрхийн харилцааны хувийн, нийгмийн хүрээнд гарч байгаа илрэлүүд мөн. Хүний эрхэд тулгуурласан чиг хандлага нь эмэгтэйчүүдийн тэгш бус эрхийн хэм хэмжээ, эмэгтэйчүүдийн хүний эрхийн зөрчлүүдийн хоорондын уялдаа холбоо, эмэгтэйчүүдийн хүний эрх, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн холбоо хамаарлыг гарган харуулдаг. Түүнчлэн эмэгтэйчүүдийн эрхийн хэрэгжилт, эрхийн ялгаатай байдлыг арилгах хоорондын уялдаа холбоог ч тодотгож өгдөг. Хүчирхийлэлд өртөх эрсдэл нь хүний эрхийг үгүйсгэх, үл ойшоох нөхцлийг бий болгож байна.

66. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл нь зөвхөн тодорхой ганц бүс нутаг, соёл зан заншил, улс, нийгэм дэх тодорхой нэг бүлгийн эмэгтэйчүүдээр хязгаарлагдах асуудал биш юм. Хүчирхийллийн үйлдэгдэж байгаа янз бүрийн илрэлүүд, эмэгтэйчүүдийн туршлагыг эдийн засгийн байдал, арьс өнгө, үндэс угсаа, анги, нас, бэлгийн чиг баримжаа, хөгжлийн бэрхшээл, үндэстэн, шашин шүтлэг ба соёл уламжлал зэрэг олон хүчин зүйлүүд тодорхойлж байдаг. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэхийн тулд энэ төрлийн хүчирхийллийн суурь шалтгаанууд, эмэгтэйчүүдийн хараат, захирагдах байдлуудын харилцан хамаарал, нийгэм, соёл, эдийн засаг, улс төрд эмэгтэйчүүдийн захирагдах, хараат байлгах хэлбэрүүдийг илрүүлэн шийдвэрлэх шаардлагатай.

67. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн шалтгаануудыг феминизм, криминалистик, хөгжил, хүний эрх, нийгмийн эрүүл мэнд, социологи гэх зэрэг маш олон өнцгөөс авч үзэж байна. Ингэснээр хүчирхийллийн талаар онолын, практик туршлагын үүднээс янз бүрийн тайлбаруудыг гаргаж ирсэн. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг тайлбарлахдаа хувь хүний болон нийгмийн хүчин зүйлүүдэд өгч байгаа ач холбогдол нь янз бүр байгаа боловч бүх тайлбаруудын тодорхойлж байгаагаар эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг үүсгэж байгаа шалтгаан нь ганцаар хязгаарлагдах боломжгүй. Энэ төрлийн хүчирхийлэл хувь хүн, бүлэг хамт олон, үндэсний, дэлхийн зэрэг түвшинд оршиж байгаа эрхийн тэгш бус харилцаа, хүчин зүйлүүдээс үүдэн гарч байна.

68. Хүний эрхэд суурилсан үзэл хандлага нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх салбар дундын олон талт хариу арга хэмжээг бий болгохыг хөхиүлэн дэмждэг. Энэ хандлага эмэгтэйчүүдийн хүний эрхийн хоорондын харилцан хамаарал, эдгээр эрхийг үл ойшоох явдал нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл үүсэх нөхцлийг хэрхэн бүрдүүлж байгааг тал бүрээс нь авч үзэж ойлгох бололцоог олгодог. Хүний эрх нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг үүсгэж байгаа суурь шалтгаануудыг

шийдвэрлэх, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах улс орнуудын үүрэг, хариуцлагыг тогтоож, улс орныг эдгээр үүрэг, хариуцлагаа биелүүлэх хариуцлага тооцох механизмыг бий болгодог. Түүнчлэн хүний эрх нь нийгэмд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг үүсгэж, өөгшүүлж байгаа үнэлэмж, туршлагыг авч үзэж тэдгээрийг тууштай өөрчлөх зөвлөмж, удирдамжуудыг бий болгохыг дэмждэг.

Б. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн хүрээ, үндсэн шалтгаанууд

1. Эцгийн эрхт ёс, бусад захирах, захирагдах харилцаа

69. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл нэг талаас нийтлэг, нөгөө талаас тусгай өвөрмөц шинжийг агуулж байдаг. Өнөөдөр дэлхий дээр хүчирхийллээс ангид амьдрах эмэгтэйчүүдийн эрх чөлөөг бүрэн хангасан нэг ч бүс, улс, үндэстэн, соёл байхгүй байгаа нь асуудлыг дэлхийн хэмжээнд нийтлэг болгож байна. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл нь үндэстэн, соёл зан заншил, анги давхарга, шашны гэх мэт маш өргөн хүрээнд үйлдэгдэж, тархаж газар авсаар байгаагийн үндэс нь олон жил оршин тогтнож ирсэн эцгийн эрхт ёс, эмэгтэйчүүдийг эрэгтэйчүүдэд захирагдах, хараат байлгасаар ирсэн тогтолцоотой нягт холбоотой. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн хэлбэрүүд, тэдгээрийн илрэлүүд, эмэгтэйчүүдийн хүчирхийлэлтэй холбоотой хувь хүний өвөрмөц туршлагауд нь хүйсийн ялгаатай үнэлэмжүүд, жендерт суурилсан захирах, хараат байлгах явдлуудтай холбоотой.

70. Хүн төрөлхтний түүхэнд нийгэмд эмэгтэй, эрэгтэй хүйсийн хүлээх үүрэг хариуцлага нь эрэгтэйчүүд эмэгтэйчүүдийг захирах, эрх мэдэл, хараа хяналт тогтоох тогтолцоо, шатлал дараалалтай явж ирсэн. Эрэгтэйчүүдийн давамгайлал, эмэгтэйчүүдийн хараат байдал нь үзэл суртлын болоод бодит үндэслэлтэй, энэ чанарын аль алиныг нь агуулдаг. Эцгийн эрхт ёсны шинжүүд нь нийгэм, соёл уламжлалын хэм хэмжээ, итгэл үнэмшилд төдийгүй хууль эрх зүйн, улс төрийн бүтэц тогтолцоо, орон нутгийн, дэлхий эдийн засагт гүн шингэж, далд хэлбэрээр оршсоор байна. Эцгийн эрхт ёс нь эмэгтэйчүүдийн сонголтыг хязгаарлах боловч эмэгтэйчүүдийг ямар ч эрх мэдэлгүй болгож чадахгүй гэдгийг эрхийнхээ төлөө амжилттай тэмцэж байгаа эмэгтэйчүүдийн хөдөлгөөн батлан харуулж байна.

71. Эцгийн эрхт ёсны шинжүүд нь түүхийн явцад янз бүрийн байдлаар илэрч байгаа бөгөөд газар зүйн байршил, соёл уламжлал, улс төрийн тогтолцоо, нөхцлүүдээс шалтгаалан янз бүрийн нөлөө үзүүлсээр ирсэн. Энэ нь эмэгтэйчүүдийг захирах, хараат байлгах, гадуурхах бусад тогтолцоо ч холбоотой. Түүнчлэн эцгийн эрхт ёсны шинж чанарыг олон хүчин зүйлийн харилцан хамаарал, колоницлолын, түүний дараа үеийн ноёрхол, зэвсэгт мөргөлдөөн, дүрвэх, шилжин суурьших зэрэг асуудлууд бүрдүүлж байдаг. Түүний илрэлүүд нь эдийн засгийн үндэс, арьс өнгө, үндэс угсаа, анги, нас, бэлгийн чиг баримжаа, хөгжлийн бэрхшээл, шашин, соёлын байдлаар илэрхийлэгдэж байдаг. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг үүсгэж байгаа жендерийн тэгш бус харилцаа, хүйсийн ялгаатай үнэлэмжүүдэд дүн шинжилгээ хийх нь асуудлыг үр дүнтэй шийдвэрлэхэд тустай.

72. Эмэгтэйчүүдийн хараат, захирагдах, эрэгтэйчүүдийн захирах байдалд янз бүрийн нөхцөл оршин тогтносоор байгаа үндсэн хэлбэрүүдэд эмэгтэйчүүдийг нөхөн үржихүйн мөлжлөгөд ашиглах, нөхөн үржихүйн, бэлгийн амьдралд хяналт тавих, эмэгтэйчүүдийн эрх тэгш бус байдлыг өдөөж, өөгшүүлж байгаа зан заншил, соёл уламжлал, жендерийн тэгш бус байдлыг бий болгож байгаа улсын тогтолцоо, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл зэрэг нь багтана. Эмэгтэйчүүдийн эсрэг

хүчирхийлэл нэг талаас эмэгтэйчүүдийн хараат, захирагдах байдлыг өөгшүүлэх, нөгөө талаас тэрхүү хараат байдлын үр дагавар, хор уршиг болж байна.

73. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл нь эрэгтэйчүүдийн эрх мэдэл, хяналтыг тогтоон байлгах механизм болж үйлчилж байна. Эмэгтэйчүүдийн бэлгийн амьдрал, гэр бүлд гүйцэтгэх үүрэгтэй холбоотой нийгмийн хэм хэмжээг хэтрүүлдэг, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл зөвхөн хувь хүнд нөлөөлөөд зогсохгүй жендерийн хэм хэмжээ, ялгаатай үнэлэмжийг өдөөн өөгшүүлж байдаг. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн үйлдлүүдийг зөвхөн тухайн хүний сэтгэл зүйн хүчин зүйлүүд, нийгэм эдийн засгийн нөхцөл, жишээлбэл, ажилгүй байхаас үүдэлтэй хэмээн үзэх боломжгүй. Хүчирхийллийг үйлдэж байгааг тайлбарлахдаа юуны өмнө тухайн хүний зан үйл, зан авир, архи мансууруулах бодис хэрэглэдэг эсэх, өөрөө хүчирхийлэлд өртөж байсан эсэх зэрэг түүхтэй нь холбон авч үзэх хэрэгтэй. Энэ нь эмэгтэйчүүдийн хараат, захирагдах байдлын өргөн хүрээний нөлөөг олж харахад тусалдаг. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй холбоотой хүчин зүйлүүдийг нээж илрүүлэхдээ эрхийн харилцааны илүү өргөн хүрээнд авч үзэх хэрэгтэй.

74. Хүчирхийллийн шалтгааны талаарх олон нийтийн ойлголт эдгээр тогтолцооны хүчин зүйлүүдийг магадгүй агуулсан, үгүй бол огт бодолцож үзээгүй байж болно. 2005 онд хамтран амьдрагчийн зүгээс үйлдэгдэж байгаа хүчирхийллийн талаар явуулсан судалгаанаас харахад ихэнх эмэгтэйчүүд хүчирхийллийн шалтгааныг нийгмийн, соёл уламжлалын хэм хэмжээтэй холбон авч үзэж, олон эхнэртэй байх, эхнэрээ өвлөн дамжуулах, инж зэрэгтэй холбоотой буруу уламжлалын талаар дурдсан байхад, эрэгтэйчүүдийн дийлэнх нь хүчирхийллийг хүмүүс хоорондын янз бүрийн харилцаатай холбон тайлбарласан байна.

75. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл эрэгтэй, эмэгтэй хүйсийн гүйцэтгэх үүрэг хооронд ялгаа, зааг тогтоох механизм болж байна. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн үүргийг зохицуулж байдаг хэм хэмжээнүүд нь ёс зүйн дүрмүүд, нийгэм, олон нийтийн хүлээлтүүдэд бас тусгагдсан байж болно. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл ба ДОХ/ХДХВ-ын талаарх судалгаанаас харахад "эрэгтэйчүүд нь эмэгтэйчүүдийг уламжлалт үүрэг хариуцлага биелүүлэхгүй тохиолдолд шийтгэж, хүч хэрэглэдэг" хэмээн хариулжээ. Хамтран амьдрагчийн зүгээс үйлдэж байгаа хүчирхийлэл эмэгтэйчүүдийн хүлээх ёстой хэмээн үздэг тогтсон хатуу үүргүүд, эрэгтэйчүүдийн давамгайлал, хатуу чанга байдал, гэр бүлийн хүрээнд удирдан захирах эрх мэдэл зэрэгтэй маш нягт холбоотой.

76. Хүчирхийлэл үйлдэгчдийг ял шийтгэлгүй орхидог явдал нь энэ төрлийн хүчирхийллийг эмэгтэйчүүдийн эсрэг эрх мэдлийн хяналтын арга хэрэгсэл болгох байдлыг дэвэргэж байна. Засгийн газар хүчирхийлэл үйлдэгчид хариуцлага тооцож, ял шийтгэл хүлээлгэх үүргээ биелүүлэхгүй байх нь хүчирхийлэлд өртөж байгаа эмэгтэйчүүдийн эрх мэдэлгүй, хараат байдлыг улам нэмэгдүүлэхийн зэрэгцээ, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл жирийн, байх ёстой үзэгдэл гэж үзэх ойлголтыг нийгэмд бий болгодог. Ингэснээр хүчирхийллийн зан үйлийг хүлээн зөвшөөрүүлж амьдралын хэвийн нэгэн үзэгдэл мэт болгож байна.

77. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл ба эцгийн эрхт ёсны хоорондын харилцан холбооны талаар 1999 онд Өмнөд Африкийн Үндсэн Хуулийн Шүүхийн шийдвэрт тусгажээ. Шүүх нь Өмнөд Африкийн Үндсэн Хуулиар эмэгтэйчүүдийг хүчирхийллээс хамгаалах шууд үүргийг төрд хүлээлгэснийг олж тогтоожээ. Шүүх энэ эрхийг тэгш эрхийн болон ялгаварлан гадуурхах явдлаас ангид байх эрхтэй холбон тайлбарлажээ. Шүүгч Алби Сакс "жендерт суурилсан гэр бүлийн хүчирхийлэл нь эцгийн эрхт ёсны

ноёрхлын үр дүн, түүнийг өөгшүүлэгч хүчин зүйл болж байгаа бөгөөд энэ нь маш хэрцгий хэлбэрүүдээр үйлдэгдэж байна” хэмээн тайлбарлажээ.

2. Соёл ба эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл

78. Соёл уламжлалын зарим нэг хэм хэмжээ, ёс заншил нь эмэгтэйчүүдийн хүний эрхийг дээдэлсэн, эмэгтэйчүүдийг чадавхжуулдаг байхад, нөгөө талаас зарим ёс заншил, уламжлал, шашны үзэл баримтлал эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг зөвтгөх хэрэгслүүд болж байна. Соёл уламжлалын зарим нэг тогтсон хэм хэмжээ нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн шалтгаануудад тооцогддог бөгөөд үүнд: “уламжлалын хорт зуршлууд” (эм бэлэг эрхтнийг зэрэмдэглэх, хүүхдийг гэрлүүлэх, хүүг илүүд үзэх)-тай холбоотой итгэл үнэмшлүүд, шашны зан үйлийн дагуу эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах “нэр хүндийн” аллага, эмэгтэйчүүдийн гэрлэх эрхийг хязгаарлах зэрэг багтана. Гэхдээ бусад хэлбэрийн хүчирхийллийг үйлдэхэд соёл, зан заншлын үзүүлж байгаа нөлөөний талаар төдийлэн хангалттай судлагдаагүй байгаа, “соёл зан заншил” гэж юу болох, тэдгээрийг юу бүрдүүлдэг болох талаар явцуу хүрээнд асуудлыг бага боловч авч үздэг.

79. Хувь хүмүүс, хамт олны өдөр тутмын амьдралд гүн бат шингэсэн эрхийн харилцаа, итгэл үнэмшил, зан үйлүүд нь соёл зан заншлыг бүрдүүлж байдаг. Нийгмийн зан үйл нь тухайн нийгмийн соёл, зан заншлын илэрхийлэл байдаг ба дэлхийн бүх улсуудад хүчирхийллийн илрэлүүдэд соёл зан заншил нь нөлөөлж байна. Гэвч соёл, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл хоёрын хоорондын харилцааг түүхэн болон газар зүйн байрлал зэрэгтэй нь холбон авч үзэж байж илүү сайн тодорхойлох боломжтой. Орон нутгийн, дэлхийн хэмжээнд үзэл баримтлал өөрчлөгдөхийн хирээр соёл бүрдэж, дахин хэлбэрээ олж байдаг учраас ийм төрлийн буруу хорт зуршлыг багасгахын төлөө тэмцэх хэрэгтэй.

80. Соёл гэдэг нь нэг ижил төрлийн зүйл биш юм. Соёл янз бүрийн хоорондоо зөрчилтэй итгэл үнэмшлүүдээс бүрддэг. Улс төр, эдийн засаг, нийгмийн хөгжлүүд нь өөрсдийн санаа бодлоо эрх мэдэл, нөлөөтэй байр сууриар дамжуулан тодорхой итгэл үнэмшлийг бий болгож, хэм хэмжээг тогтоодог. Тухайн соёлоос ямар зүйлүүдийг авч үлдэх вэ гэдгийг тодорхойлох хүчин зүйлүүд цаг хугацааны явцад өөрчлөгдөж байдаг. Жишээ нь эрэгтэй удирдагчид соёлд хүчтэй нөлөө үзүүлэх технологийг нэвтрүүлэхийг хөхиүлэн дэмжсэн ч, эмэгтэйчүүдийн байдлыг сайжруулахыг хязгаарлах нь тухайн соёлд эмэгтэйчүүдийг уламжлалт байр сууринд үлдээх хандлагыг бий болгодог. Гэхдээ аливаа соёлыг бий болгоход эмэгтэйчүүд ч идэвхтэй үүрэг гүйцэтгэдэг. Жишээлбэл, тэд “соёлыг бий болгох, түүнд нөлөөлөх, эсэргүүцэн тэмцэж, өөрчлөх зэргээр оролцдог”. Эмэгтэйчүүдийн хувь хүний онцлог шинж нь тухайн орчны соёлыг бүрдүүлэхэд, соёл уламжлал, зан үйлд хэрхэн оролцоход нөлөөлдөг. Эмэгтэйчүүд тухайн амьдарч байгаа газар орныхоо соёлын сөрөг үр дагавруудаас хохирч байдаг боловч, нөгөө талаас эерэг соёл уламжлал, зан үйлээс үр шимийг хүртэж, амьдралд нь эерэг нөлөө үзүүлдэг.

81. Зарим орнууд, нийгмийн бүлгүүд нь эмэгтэйчүүдийн хүний эрхийг хязгаарлаж байгаа соёл, зан заншлаа зөвтгөхдөө уламжлал болсон соёлоо хамгаалахын төлөө хийж байгаа явдал мэтээр тайлбарладаг. Соёл уламжлалаа хамгаалах нэрийдлээр эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэгдэж байгаа хүчирхийллийг хаацайлах байдал ихэнхдээ улс төрийн, шашны удирдагуудын зүгээс гардаг бөгөөд тухайн соёл уламжлал өөрсдийнх нь эрхэд ямар ч нөлөө үзүүлээгүй байдаг. Эмэгтэйчүүдийн эрхийг хязгаарласан хууль тогтоомжууд, зан үйлийн талаар асуудлыг хөндснөөр соёл

уламжлалын асуудлыг орон нутгийн, олон улсын түвшинд хэлэлцүүлэх явдлыг нэмэгдүүлж байна. Янз бүрийн газар зүйн байрлал, шашны орчин нөхцлүүдэд соёлыг шашны “фундаментализм” хэлбэрээр улс төржүүлэх нь эмэгтэйчүүдийн хүний эрхийг хамгаалахад томоохон саад бэрхшээл учруулж байна.

82. Соёлын харьцангуй байдал, эмэгтэйчүүдийн хүний эрхийг (хүчирхийллээс ангид амьдрах эрхийг багтаасан) хүлээн зөвшөөрөх явдлын хоорондын зөрчил нь сүүлийн үед улс орнууд аюулгүй байдалдаа анхаарал хандуулах нь нэмэгдсэнээс үүдэн нилээн эрчимжиж байна.

83. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг хэрхэн бүрдүүлж, тодорхойлж байгаа замууд соёл өөрчлөгдөхийн хирээр мөн хувьсаж байдаг. Жишээ нь, “болзооны үеийн хүчин”, хоол унднаас гарах гэсэн нийгмийн үзэгдэл нь соёлын хэм хэмжээтэй нягт холбоотой боловч тэдгээрийг “соёлын үзэгдэл” гэж нэрлэдэггүй. АНУ-д эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл болзооны харилцаанд маш ихээр үйлдэгдэж байгааг судалгаа батлан харуулсан. Болзоо нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хоорондын нийгмийн харилцааны соёлын хэлбэр байдаг. Нэгэн байгууллагын мэдээлснээр 14-17 насны охидын 40% нь эрэгтэй найздаа зодуулж, хүчирхийлэлд нь өртдөг хэн нэгнийг танина гэсэн байхад, коллежийн эмэгтэй 5 оюутан тутмын нэг нь ямар нэг хэлбэрийн болзооны үеийн хүчирхийлэлд өртдөг хэмээн хариулжээ. Хоолоо сойх, өөрийгөө өлсгөх зэрэг нь ч мөн соёлын итгэл үнэмшилтэй холбоотой байдаг. Судалгаанаас харахад ялангуяа, охидын биеийн жин, гадна төрх, биеэ авч явах талаар тодорхой тогтсон хүлээлт, эцэг эх, найз нөхдийн нөлөө, тураах, биеийн жин барихад зориулсан хоол хүнс үйлдвэрлэгчдийн зар сурталчилгаа, хэвлэл мэдээллийн хэрэгслээр эмэгтэйчүүдийг хэрхэн харуулж байгаа зэргээс үүдэн бий болдог байна.

84. Эмэгтэйчүүдийн амийг хороох (эмэгтэй хүн учраас амийг нь хөнөөх) янз бүрийн үйлдлийн илрэлүүд нь соёлын хэм хэмжээ эмэгтэйчүүдийг захирахын тулд хүчирхийллийг ашиглаж буй хоорондын харилцан хамаарлыг харуулж байна. Эмэгтэйчүүдийн амийг хороох явдал янз бүрийн хүрээнд үйлдэгдэж байна. Үүнд: хамтран амьдрагчийн зүгээс үйлдэх хүчирхийлэл, зэвсэгт мөргөлдөөн, ажлын байран дахь бэлгийн дарамт, инжтэй холбоотой зөрчлүүд, гэр бүлийн “нэр төрийг” хамгаалах нэрийдлээр амь насыг нь хороох гэх мэт олон нөхцлүүд багтаж байна. Жишээлбэл, эмэгтэй хүнийг гэр бүлийн “нэр төрийг” гутаасан хэргээр аав, ах, нөхөр, хэн нэгэн эрэгтэй хамаатан амь насыг нь хороох хэргийг үйлдэж байгаа нь эмэгтэй хүний сонголт хийх, эрх чөлөөтэй байх зэрэг олон эрхэд халдаж, хяналт тогтоох, захирах аргаа болгож байна. Ихэнх тохиолдолд шийдвэрийг гэр бүлээрээ нийлж хамтран гаргадаг нь уг хэргийг нийтийн шинжтэй болгодог.

85. Зарим соёл уламжлал нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл үйлдэгдэх шалтгаан болж байгаа учраас соёлыг янз бүрийн нөхцөл байдалд нарийн судлах хэрэгтэй бөгөөд, өөр өөр нөхцөлд соёл гэсэн ойлголтыг хэрхэн ашиглаж байгааг авч үзэх нь чухал. Соёлыг зөвхөн тогтсон итгэл үнэмшил, зан үйл, заншил гэхээс илүү эрхийн харилцаа, нийгэм, эдийн засаг, улс төрийн үйл явцыг өөрчлөхөд чухал үүрэг гүйцэтгэдэг гэдгийг ойлгох нь чухал. Соёл нь өөрчлөмтгий шинж чанартай учраас эмэгтэйчүүдийг хараат байдал, захирагдах байдалд байлгаж байгаа соёлын хэм хэмжээг өөрчилж, хүний эрхийг дээдлэх соёлын итгэл үнэмшлийг бий болгохын төлөө тэмцэх нь чухал. Хүчирхийлэл үйлдэгдэхэд соёлын үзүүлж байгаа нөлөөг арилгахын төлөө тэмцэж байгаа хүчин зүтгэл нь янз бүрийн соёлын нөхцөл байдалд эрхийнхээ төлөө тэмцэж байгаа эмэгтэйчүүдтэй нэгдвэл илүү хүчтэй болох юм.

3. Эдийн засгийн тэгш бус байдал ба эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл

86. Эдийн засгийн тэгш бус байдал нь хувь хүний зүгээс авахуулаад эдийн засгийн өргөн хүрээний түвшинд үйлдэгдэж буй эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл үйлдэгдэх хүчин зүйлийн нэг болдог. Энэ төрлийн хүчирхийллийг үйлдэх нөхцлийг бий болгох төдийгүй нөхцөл байдлыг улам дордуулдаг. Эдийн засгийн тэгш бус байдал орон нутгийн, үндэсний, олон улсын түвшний алинд ч тохиолддог. Эмэгтэйчүүдийн эдийн засгийн тэгш бус байдал, ялгаварлан гадуурхалт нь хөдөлмөр эрхлэлт, ашиг орлого олох, эдийн засгийн бусад нөөцөөс хүртэх боломж, эдийн засгийн бие даасан байдал зэрэгт нөлөөлдөг ба эмэгтэйчүүдийн шийдвэр гаргах чадавхийг бууруулж, хүчирхийлэлд өртөх эрсдлийг нэмэгдүүлдэг.

87. Дэлхийн олон оронд эмэгтэйчүүдийн эдийн засгийн байдлыг дээшлүүлэх чиглэлээр нилээд амжилтанд хүрсэн ч, олон тооны эмэгтэйчүүд эдийн засгийн албан болон албан бус салбарт ялгаварлан гадуурхагдах, гэр бүлийн хүрээнд эдийн засгийн мөлжлөгт өртсөн хэвээр байна. Эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавхи сул байх нь газар, хувь хүний хөрөнгө, цалин, зээл гэх зэрэг эдийн засгийн нөөцийг хүртэх, тэдгээрийн зарцуулах, хяналт тавих зэрэгт мөн нөлөөлдөг ба энэ нь эмэгтэйчүүдийг хараат байдалд хүргэж, хүчирхийлэлд өртөх эрсдлийг нэмэгдүүлдэг. Үүнээс гадна эмэгтэйчүүдийн зүгээс өрхийн орлого зэрэг эдийн засгийн нөөцийг зарцуулах, хяналт тавих явдлыг хязгаарлах нь гэр бүлийн хүчирхийллийн нэг хэлбэр болж болно. Хэдийгээр эдийн засгийн бие даасан байдал эмэгтэйчүүдийг хүчирхийлэлд өртөхөөс бүрэн хамгаалж чадахгүй ч, эдийн засгийн бие даасан байдал, эдийн засгийн нөөцийг хүртэх, захиран зарцуулах боломж нь эмэгтэйчүүдэд сонголт хийх, хүчирхийллээс зугтаах, хамгаалуулах, нийгмийн үйлчилгээ үзүүлэх боломжуудыг хүртэх бололцоог нэмэгдүүлдэг.

88. Бүтцийн өөрчлөлт, эдийн засгийн зохицуулалт алдагдах, төрийн өмчийг хувьчлах зэрэг үйл явц нийт эмэгтэйчүүд, ялангуяа, нийгмийн эмзэг бүлгийн эмэгтэйчүүдийн эдийн засгийн ба нийгмийн тэгш бус байдлыг улам бүр нэмэгдүүлэх хандлагатай байдаг. Эдийн засгийн өөрчлөлт үндэсний олон засгийн газруудын эмэгтэйчүүдийн эрхийг төрийн салбарын хөтөлбөрүүд, нийгмийн зарцуулалтаар дамжуулан эмэгтэйчүүдийн эрхийг хангах, баталгаажуулах хүчин чадлыг нь бууруулсан.

89. Дэлхийн Эрүүл мэндийн Байгууллагаас өнөөгийн даяарчлал нийгмийн бүтэц, зохион байгуулалт, нийгэмд хүчирхийлэл өсөн нэмэгдэж байгаа явдалд нөлөөлж байгаа тухай мэдээлсэн. Тэдний мэдээлж байгаагаар “угаасаа эрхийн тэгш бус байдал газар авсан нийгэмд, даяарчлалаас үүдэн баян, ядуу хүмүүсийн хоорондын ялгаа асар их зөрүүтэй болж байгаа бөгөөд хүмүүс хоорондын хүчирхийллийг улам бүр өсгөн нэмэгдүүлэх хандлагатай” байна гэжээ. Дэлхийн даяарчлал янз бүрийн дарамт шахалтын хариу арга хэмжээ авч тухайн оронд нийгмийн хурдацтай өөрчлөлтүүд хийгдэж байгаа зарим өөрчлөлтүүд нь нийгэмд хүчирхийллийг нэмэгдүүлэх нөхцлийг бий болгож байна. Хуучин нийгэмд оршиж байсан нийгмийн хяналтын тогтолцоонууд нь эмэгтэйчүүдийн эсрэг төрөл бүрийн хүчирхийллийг үйлдэгдэх нөхцлийг бүрдүүлж байгаа ба даяарчлалаас үүдэн нийгэмд гарч байгаа өөрчлөлтүүд нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн шинэ хэлбэрийг бий болгох, оршин байгаа хэлбэрүүдийн нөхцлийг улам бүр дордуулах хандлагатай байна. Жишээ нь: дэлхийн түвшинд эмэгтэйчүүдийг хил давуулан худалдаалах хэргийг дурдаж болох юм.

90. Даяарчлалтай холбоотойгоор бий болж байгаа тэгш бус байдлын хэлбэрүүд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл үйлдэгдэх нөхцлүүдийг улам илүү хурцатгаж байна. Жишээ нь: нийгмийн баялгийг хүртэх, эрх мэдлийн хоорондын зөрүү ихсэж, орон нутгийн эдийн засгийг ядууруулж байгаа нь эмэгтэйчүүдийг зохицуулалт муутай үйлдвэрлэлийн орчинд хөдөлмөр эрхлэх, улмаар тэдний хөдөлмөрийг мөлжих хэлбэрийн хүчирхийлэлд өртөх хэлбэрийг бий болгож байна. Үүний зэрэгцээ, үйлдвэржүүлэлт, эдийн засгийн шилжилт эмэгтэйчүүдийн уламжлалт ажил үүргээс хол давсан ажлуудыг эрхлэхийг шаардаж байна. Эмэгтэйчүүдийн жендерийн үүргийн тогтворгүй байдал нь эмэгтэйчүүдийг захирах, хараат байлгах шинэ хэлбэрүүдтэй хамт оршин тогтнож, эмэгтэйчүүдийг хүйсээр тусгаарласан, цалин хөлс багатай хөдөлмөр эрхлэхэд хүргэж байна.

91. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн асуудлаарх өнөөгийн тусгай илтгэгч хөдөлмөр эрхлэх зорилготой эмэгтэйчүүдийн шилжин суурьших хөдөлгөөн нь эмэгтэйчүүдийг чадавхижуулах, олон улсын хүний эрхийн хуулийн үйлчилгээг шууд хүртэх боломжийг олгож байна” хэмээн тэмдэглэжээ. Зарим орон нутгийн, уламжлалт эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн хэлбэрүүд нь дэлхийн нийтлэг шинжтэй болохын зэрэгцээ эмэгтэйчүүдийг хил давуулан худалдаалах зэрэг хэлбэрийн хүчирхийлэл нэмэгдэж газар авч байна. Дэлхийн маш олон оронд хөдөлмөр эрхэлж байгаа цагаач эмэгтэйчүүд арьс өнгө, үндэс угсаа зэргээр ялгаварлан гадуурхалтанд өртөхийн сацуу нийгмийн үйлчилгээг хүртэх маш бага, огт боломжгүй, гэр бүлийн хүчирхийлэлд өртөх хандлага их байна. Бичиг баримтгүй, албан ёсны оршин суух, хөдөлмөр эрхлэх зөвшөөрөлгүй эмэгтэйчүүдэд нийгмийн үйлчилгээ хүртэх, хамгаалуулах боломж маш бага, огт байхгүй байна.

В. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн шалтгаан, эрсдлийн хүчин зүйлс

92. Эмэгтэйчүүдийн захирагдах байдлыг өргөн хүрээнд авч үзэхэд хүчирхийллийг үүсгэж байгаа хэд хэдэн тодорхой шалтгаант хүчин зүйлийг тодорхойлох боломжтой. Үүнд: тогтолцоотой холбоотой шийдвэрлэх, хувийн амьдралын асуудлаарх хоосон номлол зэрэг хамаарч байна. Эмэгтэйчүүдийг хүчирхийлэлд өртөх эрсдлийг нэмэгдүүлж байгаа хувь хүний болон гэр бүлийн хүмүүсийн зан авиртай холбоотой асуудлууд ч багтана (97-100 дугаар зүйлийг харна уу).

1. Маргааныг шийдвэрлэхэд хүчирхийллийг ашиглах

93. Хүчирхийллийг нийгмийн болон улс төрийн өргөн хүрээнд зөрчил маргааныг шийдвэрлэх арга хэрэгсэл болгон ашиглахыг хүлээн зөвшөөрөх байдал, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн хоорондын харилцан хамаарлыг хувь хүн, хамт олон, үндэсний хэмжээнд авч үзэж болно. Хувь хүний түвшинд, гэр бүлийн гишүүд болон эхнэр, нөхрийн хоорондын зөрчил маргааныг шийдвэрлэж байгаа арга замууд, харилцааны ур чадварууд нь хүчирхийллийг үүсгэж байгаа эсэхийг тодорхойлогч хүчин зүйлс болдог. Хамт олны түвшинд, гэр бүл, хамт олны дунд зөрчил маргааныг хэрхэн шийдвэрлэж байгааг зохицуулж байдаг нийгмийн хэм хэмжээ нь хүчирхийллийг өдөөсөн эсхүл эсэргүүцэх орчинг бий болгодог.

94. Үндэсний, олон улсын түвшинд улс төр, эдийн засгийн маргааныг шийдвэрлэхдээ хүч ашиглах нь зэвсэгт мөргөлдөөн дэх эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг үүсгэдэг. Хүч хэрэглэх явдлыг дайны арга хэрэгсэл болгон ашиглаж байгаа нь зэвсэгт мөргөлдөөний үеийн эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн хамгийн тод илрэл болно. Эмэгтэйчүүдийн бэлгийн амьдрал, нөхөн үржихүйд хяналт тогтоох, захирах

нь үндэстэнг устгах (цэвэрлэх) арга хэрэгсэл болон ашиглагдаж байна. Жишээ нь: 1999 оны үеэр Косовогийн зэвсэгт мөргөлдөөний үеэр хүчин, эмэгтэйчүүдийн эсрэг бэлгийн бусад хэлбэрийн хүчирхийллийг дайны зэвсэг, үндэстнийг устгах, цэвэрлэх арга хэрэгсэл болгон ашигласан. Хүчирхийллийг нийгмийн, улс төрийн өргөн хүрээнд зөрчил маргааныг шийдвэрлэх арга хэрэгсэл болгон ашиглахыг хүлээн зөвшөөрөх явдал, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл хоёрын хоорондын харилцааны талаар цаашид гүнзгийрүүлэн судлах чухал шаардлагатай байна.

2. Хувийн нууцын тухай үзэл баримтлалууд

95. Хувь хүний асуудлыг гэр бүлийн хүрээнд хамгаалах талаар хууль эрх зүйн хоосон номлолууд улс орнуудын хариу арга хэмжээ авахгүй байх, эмэгтэйчүүдийг гэр бүлийн хүрээнд хүчирхийлэлд өртсөн тохиолдолд нийгэм хөндлөнгөөс оролцож хохирогчийг хамгаалж, нийгмийн цогц үйлчилгээ үзүүлж чадахгүй байх зэрэг явдлуудыг зөвтгөхөд өргөнөөр ашиглагддаг. Хууль, практик дээр гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчдийг ял шийтгэлгүй өнгөрөөх төдийгүй, гэрийн үйлчлэгчдийн эсрэг хүчирхийлэл үйлдэгчид ч мөн ял завших явдлыг өдөөж байна. Сүүлийн 15 жилд олон улсын хууль тогтоомжуудыг бий болгосон нь гэр бүлийн хүрээнд хүний эрхийг хамгаалах улс орнуудын үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлсэн бөгөөд улс орнууд энэ үүргээ биелүүлэхийн тулд шаардлагатай хууль тогтоомж, бодлогуудыг баталж эхэлсэн (6 дугаар бүлгийг үзнэ үү). Гэвч эдгээр хууль тогтоомжуудын амьдрал дээрх хэрэгжилт хангалтгүй байгаа, нийгэмд тогтсон хэм хэмжээ нь гэр бүлийн хүрээнд эрэгтэйчүүд захирах, эмэгтэйчүүд захирагдах, гэр бүлийн хүрээний асуудал хувь хүний асуудал болон үлдэх явдлыг хаацархсан хэвээр байна.

3. Төрөөс арга хэмжээ авахгүй байх

96. Аливаа улс нь тухайн орны нөхцөлд жендерийн гүйцэтгэх үүрэг, эрхийн харилцааг бий болгох, өөрчлөх, түүнийг тогтоон барихад чухал үүрэг гүйцэтгэдэг. Асуудлыг шийдвэрлэхэд улс орны идэвхгүй, хариу арга хэмжээ авахгүй байгаа байдал нь эмэгтэйчүүдийн хүний эрхийг үл ойшоосон, эмэгтэйчүүдийг сул дорой байр сууринд байлгах хууль тогтоомж, бодлогуудыг амьдрал дээр үйлчилсээр байхад хүргэдэг. Улс орны зүгээс ямар нэгэн хариу арга хэмжээ авахгүй байгаа нь асуудлыг шийдвэрлэх, хариу арга хэмжээ авах, урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх зэрэг үүргийг ТББ-ууд болон иргэний нийгэм дэх бусад бүлгүүдэд тохон орхиж байна. Мөн энэ байдал нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл үйлдэгдсээр, оршин тогтносоор байх нөхцлийг бий болгож, эмэгтэйчүүдийг захирах, хараат байлгах явдлыг хүлээн зөвшөөрч байгаа хэлбэр болдог. Ялангуяа, улс орны зүгээс хүчирхийлэл үйлдэгчдийг шийтгэж, хариуцлага хүлээлгэх хуулийн тогтолцоог бий болгож, хариу арга хэмжээ авахгүй байгаа нь хүчирхийлэл үйлдэгчдийг өөгшүүлж, ял завших, улмаар хүчирхийллийг үргэлжлүүлэн үйлдэх, эмэгтэйчүүдийг хүчирхийлэлд өртсөөр байх, захирагдах байдлыг өдөөсөөр байна. Улс орны зүгээс эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн үндсэн шалтгаануудыг шийдвэрлэхгүй байх нь хүний эрхийг хангах олон улсын эрх үүргээ биелүүлэхгүй байгааг харуулж байна.

4. Хүчирхийллийн эрсдлийн хүчин зүйлс

97. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл үйлдэгдэхэд хүргэж байгаа гол шалтгаан нь бусад хүчин зүйлстэй нийлснээр эмэгтэйчүүдийн хүчирхийлэлд өртөх эрсдлийг нэмэгдүүлдэг. Нийгмийн эрүүл мэндийн судлаачид хүчирхийллийн тодорхой

хэлбэрүүд үйлдэгдэхэд нөлөөлж байгаа, уялдаа холбоо бүхий хэд хэдэн хүчин зүйлсийг тодорхойлсон. Эдгээр хүчин зүйлс хувь хүний, нийгэм, эдийн засгийн байдал, хүчирхийлэлд өртөж байсан эсэх, түүх, зан авирын төрөл хэлбэрүүд багтаж байна. Судалгааг ихэнхдээ хөгжиж байгаа орнуудад явуулсан бөгөөд юуны өмнө хамтран амьдрагчийн зүгээс үйлдэгдэх хүчирхийлэл, хүүхэд насандаа бэлгийн хүчирхийлэлд өртөж байсан эсэх, танихгүй хүмүүсийн зүгээс үйлдэх бэлгийн дарамт, хүчингийн хэргүүдийн талаар голлон авч үзжээ. Энэхүү судалгаагаар цуглуулсан мэдээ, мэдээлэл нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй холбоотой хэд хэдэн хүчин зүйлсийг илрүүлсэн. Гэхдээ тэдгээрийг хүчирхийлэл үйлдэгдэх шууд хүчин зүйлс гэж тодорхойлоогүй.

98. Маш олон судалгаа хүчирхийллийн эрсдлийг хувь хүн, гэр бүл, хамт олон, нийгэм, улсын түвшинд тодорхойлсон байдаг. Эдгээр эрсдлийг нийгмийн эрүүл мэндийн нэгэн загварт дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

а) Хувь хүний түвшинд: бага насандаа хүчирхийлэлд өртөж байсан эсэх, гэр бүлийн хүчирхийллийн гэрч болж байсан эсэх, архи мансууруулах бодисыг тогтмол хэтрүүлэн хэрэглэх, боловсролын, эдийн засгийн доогуур байдал, нийгмийн эмзэг бүлэгт харьяалагддаг эсэх зэрэг хүчин зүйлс. Эдгээр хүчин зүйлс нь хүчирхийлэл үйлдэгч, хохирогч хоёрын алинд нь ч хамааралтай.

б) Гэр бүл, эхнэр, нөхрийн харилцааны түвшинд: гэр бүлийн хүрээнд эрчүүд шийдвэр гаргах, эд хөрөнгийг захиран зарцуулах эрх эдлэх, эхнэр, нөхрийн хоорондын зөрчлийн түүх, эхнэр, нөхөр хоёрын хооронд эдийн засаг, боловсрол, хөдөлмөр эрхлэлтийн байдлын хир зөрүүтэй байдал зэрэг хүчин зүйлсийг хамааруулсан.

в) Олон нийтийн түвшинд: эмэгтэйчүүдийг ялгаварлах, эмэгтэйчүүдэд үзүүлэх нийгмийн дэмжлэг тусалцааны хязгаарлагдмал байдал, эрчүүдийн хүчирхийллийг хүлээн зөвшөөрч байгаа олон нийтийн хандлага, нийгэм эдийн засгийн байдал доогуур байх, ядуурал зэрэг хүчин зүйлсийг оруулжээ.

г) Нийгмийн түвшинд: эрэгтэйчүүдийн захирах, эмэгтэйчүүдийн захирагдах байдлыг өөгшүүлсээр байгаа жендерийн ялгаатай үнэлэмж, үүргүүд, хүчирхийллийг зөрчил маргааныг шийдвэрлэх хэрэгсэл болгон ашиглахыг хүлээн зөвшөөрөх явдлуудыг багтаасан.

д) Улс орны түвшинд: хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүчирхийлэл үйлдэгчдийг шийтгэх, хариуцлага хүлээлгэх хууль тогтоомж, бодлогуудын дутагдалтай байдал, хууль сахиулах байгууллага, шүүх, нийгмийн үйлчилгээний байгууллагын ажилтнуудын энэ талаарх ойлголт хангалтгүй, асуудалд мэдрэмжтэй хандах хандлага сул байгаа зэргийг авч үзжээ.

99. Дээр дурдсан дүн шинжилгээ ялгаварлан гадуурхалт ба тэгш бус эрхийн байдалд үндэслэсэн эрхийн ялгаатай байдлыг эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн гол тодорхойлогч болгон онцлон тэмдэглэжээ. Гэр бүлийн хүчирхийллийн талаарх судалгааны удирдагч “энэ төрлийн хүчирхийлэл нь хүний хамгийн ойр дотны хүмүүсийн хоорондын харилцаанд тохиолддог, ихэнх тохиолдолд хүчирхийллийг хэвийн зүйл мэтээр хүлээн авдаг бөгөөд хамгийн гол нь жендерийн ялгаатай үнэлэмж, жендерийн тэгш бус байдал, нийгэм дэх эмэгтэйчүүдийн эрчүүдтэй харьцуулахад доогуур байр суурь эзлэх байдлаас үүдэлтэй” хэмээн тодорхойлжээ. Дээр дурдсан хэд хэдэн хүчин зүйлс хүний эрхийг зөрчих явдалтай ч холбоотой. Жишээлбэл, Хүүхдийн Эрхийн Конвенциор баталгаажуулсан ч олон хэлбэрийн хүчирхийлэлд охид, эмэгтэйчүүд өртсөөр байна. Хүний эрхийг ийнхүү зөрчүүлэх нь хүчирхийллийн хэлбэрийг бий болгож, хүчирхийлэлд өртөх эрсдлийг нэмэгдүүлсээр байна.

100. Олон судлаачид ядуу эмэгтэйчүүд гэр бүлийн, бэлгийн, хүчин зэрэг хүчирхийллийн олон хэлбэрүүдэд өртөх илүү өндөр эрсдэлтэй болохыг удаа дараагийн судалгаагаар баталж байна. Гэхдээ ядуурал эмэгтэйчүүдийн хүчирхийлэлд өртөх эрсдлийн хүчин зүйл болж байгаа бол, ядуурлыг хүний эрхийн хэм хэмжээтэй холбон авч үзэхэд гол анхаарлаа хандуулах хэрэгтэй. Ядуурал ба эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн хоорондын уялдаа холбоо нь эмэгтэйчүүдийн эдийн засгийн, нийгмийн эрхийг хэрэгжүүлэх, хамгаалах, хүндэтгэх бодлого, практикт өөрчлөлт хийх шаардлагатай байгааг харуулж байгаа юм. Хүчирхийллийг шийдвэрлэх хөндлөнгийн оролцоо нь зөвхөн хувь хүмүүсийн түвшинд асуудалд арга хэмжээ аваад зогсохгүй, бусад түвшний тогтолцооны эмэгтэйчүүдийн нийгмийн, эдийн засгийн эрхийг үл ойшоох, үйлчилгээ, нийгмийн баялгийг хүртэхэд нөлөөлж байгаа жендерийн ялгаатай үнэлэмж, ялгаварлан гадуурхалт зэрэг хүчин зүйлсийг авч үзэж шийдвэрлэх нь чухал байна.

Г. Төр, Засгийн газар хоорондын ажиллагаанд нөлөөлөх нь

101. Ялгаварлан гадуурхалт ба эмэгтэйчүүдийг захирах, хараат байлгах явдал эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн үүсэх гол шалтгаан болж байгаа нь улс ба засгийн газар хоорондын байгууллагуудын зүгээс авах арга хэмжээнд тодорхой нөлөө үзүүлдэг. Улс орнууд хүний эрхийг хамгаалахтай холбоотой үүргээ биелүүлэхийн тулд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хоорондын эрхийн харилцааг зохицуулж буй нийгмийн болон соёлын хэм хэмжээг өөрчлөх явдал хэдий хүндрэлтэй ч арга хэмжээ авах ёстой. Улс нийгэмд өөрчлөлт хийх гол хөдөлгөгч хүч байх ёстой бөгөөд энэ үүргээ ТББ-ууд иргэний нийгмийн бусад бүлгүүдэд даатгаж орхих ёсгүй. Түүхийн үүднээс авч үзвэл аливаа улс орнууд нь өөрсдийн хууль тогтоомж, бодлогуудаараа дамжуулан өнөөдрийн жендерийн эрхийн харилцааг бий болгоход нөлөөлсөн нийгэм, соёлын хэм хэмжээнүүдийг бүрдүүлсэн. Тиймээс асуудал эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах нийгэм, соёлын хэм хэмжээг өөрчлөх үүргийг улс орон хүлээх эсэх бус харин түүнийг хэрхэн амжилттайгаар өөрчилж болох вэ гэдгээс хамаарна. Улс орны өөрчлөлтийг хөхиүлэн дэмжих, удирдан чиглүүлэх үүрэгтэй. Өнөөгийн нөхцөл байдлыг өөрчлөхөд шаардлагатай хууль тогтоомжийг батлах явдлыг хязгаарлах ёсгүй. Харин хуулийг өөрчлөлт хийх арга хэрэгсэл, нийгэмд шинэ ойлголт, хандлага, зан үйлийг бий болгох явдлыг өдөөгч гэдэг утгаар нь авч үзвэл зохино.

102. Эмэгтэйчүүдийн эсрэг жендерт суурилсан ялгаварлан гадуурхалттай тэмцэх Улс, засгийн газар хоорондын байгууллагууд, төрийн бус байгууллагуудын хамтын хичээл зүтгэл, хариу арга хэмжээ нь эмэгтэйчүүдийг удирдан манлайлах, бодлого, стратеги боловсруулахад өргөнөөр оролцуулахыг дэмжих хэрэгтэй. Энэ чиглэлээр улс ба засгийн газар дундын байгууллагууд иргэний нийгмийн байгууллагуудын санаа санаачлагуудыг дэмжиж, тэдгээрт үндэслэн олон нийтийн ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх, хандлагыг өөрчлөх, олон нийтийн хүчийг өргөнөөр дайчлан ажиллавал илүү үр дүнд хүрч чадна. Засгийн газар, иргэний нийгмийн байгууллагууд хоорондын ил тод хамтын ажиллагаа нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн эсрэг тэмцлийг илүү хүчтэй болгож чадна (7 дугаар бүлгийг үзнэ үү).

103. Үндэстэн дамнасан байгууллагуудын, тухайлбал, олон үндэсний корпорац, улс төрийн бүлэглэлүүд, гэмт хэрэгтнүүдийн сүлжээ зэргийн хүрээ өргөжиж, нөлөөлөл нэмэгдэж байгаа нь эмэгтэйчүүдийн эдийн засаг, нийгмийн эрхэд нилээд хүчтэй сөрөг нөлөө үзүүлж байна. Эдгээр нөлөөг шийдвэрлэхэд чиглэсэн дотоодын, тухайн үндэсний эрх зүйн орчин хангалтгүй байгаа учраас эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, түүний шалтгааныг хязгаарлах, үйлдэгсэдтэй хариуцлага тооцоход

хийдэл үүссэн хэвээр байна. Тиймээс хариуцлага тооцоход бэрхшээл үүсгэж байгаа хийдэлд тохирсон хариу арга хэмжээ авахын тулд улс болон засгийн газар хоорондын байгууллагууд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг үйлдэхэд эдгээр оролцогчдын үүрэг ямар байгааг нягтлан үзэх шаардлагатай байна.

IV. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн хэлбэрүүд, үр дагавар, хор уршиг

A. Оршил

104. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл нь янз бүрийн хэлбэртэй байх ба мөн чанарын хувьд харилцан адилгүй, нэгэн зүйл мэт харагдавч, хоорондоо хамааралтай, дахин давтагдах шинжтэй байдаг. Үүнд: Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлд бие махбодийн, бэлгийн, сэтгэл зүйн, сэтгэл санааны хүчирхийллээс гадна эдийн засгийн дарамт, мөлжлөг зэрэг багтдаг ба өнөөгийн даяарчлагдаж буй дэлхийд аль нэг үндэсний хил хязгаараас хальж, хувийн салбараас аваад нийгмийн бүхий л салбарт илэрдэг байна. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн хэлбэр, тэдгээрийн илрэх байдлыг нэрлэх нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таних, түүнд чиглэсэн арга хэмжээ авахад чухал алхам болох юм.

105. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн хэлбэр, илрэх байдал нийгэм, эдийн засаг, соёл, улс төрийн төлөв, орчноос хамаарч өөр өөр байдаг. Тухайн улс оронд хүн ам зүйн болон нийгэм, соёлын өөрчлөлт болох, эдийн засгийн шинэчлэл хийгдэх зэргээс хамаарч зарим төрлийн хүчирхийллийн хэлбэр багасч байхад, зарим төрлийн хүчирхийлэл үлэмж хэмжээгээр нэмэгдэж байдаг. Жишээ нь: шинэ техник технологи хүчирхийллийн шинэ хэлбэрийг бий болгодог, тухайлбал, Интернет, гар утасны мөрдөн мөшгөлтийг /ангуучлалыг бий болгох. Иймээс эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн хэлбэрийг бүрэн төгс тусгасан жагсаалт гэж байхгүй. Улс орнуудын Засгийн газрууд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн мөн чанар, хувьсан өөрчлөгдөж байдгийг хүлээн зөвшөөрч, хүчирхийллийн шинэ хэлбэрийг илрүүлэн таньж, эдгээрт чиглэсэн хариуг байнга эрэлхийлж, олж байх ёстой.

106. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл эмэгтэйчүүд, тэдний хүүхэд, нийгмийн тухайн давхарга, цаашилбал нийгэмд асар их үр дагаврыг бий болгодог. Хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд эрүүл мэндээр доройтох, амьдрал ахуйгаа дээшлүүлэх, нийгмийн амьдралд оролцох чадвар буурдаг байна. Эдгээр эмэгтэйчүүдийн хүүхэд бусад хүүхдүүдтэй харьцуулахад эрүүл мэндийн хувьд хохирох, зан байдал эвдрэх эрсдэлтэй нөхцөлд амьдарч байгаа бөгөөд сургуульд явах боломж муутай байх, сурлага муудах зэрэг асуудал үүсдэг байна.

107. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн өртөг хүний үнэ цэнийг эс тооцвол эдийн засгийн үйлдвэрлэл, хүний нөөц үлэмж буурах, нөгөө талаас үеэс үед дамжсан хүчирхийллийн улмаас улс төр, нийгмийн тогтворгүй байдал үүсэх, хүчирхийлэлд өртсөн хохирогчдод туслах хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүжилт зэрэг болно.

108. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн ихэнх тохиолдолд эмэгтэй хүн хохирч, хүчирхийллийг үйлдэгч нь эрэгтэй хүн байх боловч эмэгтэйчүүд мөн хүчирхийлэл үйлддэг. Эмэгтэйчүүд хамтран амьдрагчийнхаа эсрэг бага хэмжээний хүчирхийлэл үйлдсэн тохиолдолд тэд зүй бус уламжлалт зан үйлийн хүчирхийлэлд илүү их өртөх, цаашилбал хил давуулан худалдах гэмт хэргийн золиос болдог. Тэд мөн зэвсэгт мөргөлдөөний нөхцөлд хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн үйлдэлд хамгийн их өртдөг.

Б. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн хэлбэр, илрэх байдлууд

109. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн янз бүрийн хэлбэрийн талаарх судалгаа, тоо баримтыг цуглуулах явдлыг сайжруулахыг уриалсан Бээжингийн Үйл Ажиллагааны Хөтөлбөрийг баталснаас хойш арван жил өнгөрч, мэдэгдэхүйц ахиц, ялангуяа, хамтран амьдрагчийн зүгээс үйлдэж байгаа хүчирхийллийн (V-р бүлгийн харна уу) талаар гарсан хэдий ч хүчирхийллийн хэлбэрийн талаарх нотлох баримтын цуглуулах явдал жигд бус, зарим нь цаг хугацааны хувьд огт байхгүй байна. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн давтамжийн талаар цуглуулсан тоо, баримтыг сайтар нягтлан үзэхэд хүчирхийллийн зарим хэлбэрээр хязгаарлагдаж, бусад хэлбэрийн тухай алга байна. Харин эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн үйлдлийн тохиолдлыг сайн баримтжуулсан байна. Судалгааны материалаас гадна нягтлан үзсэн мэдээллийн эх үүсвэрт НҮБ-ын хэлэлцээрийн эрх бүхий байгууллага, бусад механизмын дагуу Засгийн газар, судлаачид, хэвлэл мэдээллийн байгууллагууд, ТББ-уудын ирүүлсэн тайланг оруулсан болно.

110. Эмэгтэйчүүдийн Эсрэг Хүчирхийллийн Бүх Хэлбэрийг Устгах Тунхаглал болон Бээжингийн Үйл Ажиллагааны Хөтөлбөр нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл үйлдэгдэж байгаа газар, орон зай, тухайлбал, гэр бүл, нийгмийн хүрээ, Төрийн зүгээс үйлдэж байгаа эсэх, ийм үйлдэлд Төрөөс ял шийтгэл үзүүлж хариуцлага тооцохгүй байгаа хандлага, механизмын эсрэг чиглэсэн билээ. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн олон хэлбэр янз бүрийн газруудад үйлдэгддэг: жишээ нь, хүчирхийллийг бий болгож байгаа зүй бус уламжлалт зан үйл, гэр бүл, нийгмийн тодорхой давхаргад үйлдэгдэж байдаг.

Хүнийг хил давуулан худалдах гэмт хэрэг гэр бүл, нийгмийн тодорхой бүлэг, Төрийн оролцоотойгоор эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэж байгаа хүчирхийллийн хэлбэр юм. Зөвхөн тухай орон бус олон улсын хилийг даван үйлдэгдэж байгаа хүчирхийлэл байдаг. Зэвсэгт мөргөлдөөний нөхцөл байдалд эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэж байгаа хүчирхийлэл янз бүрийн орон зайг хамарч байдаг. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн хэлбэрүүд хоорондоо харилцан холбоотой, эсхүл нэг нь нөгөөгөө бий болгож байдаг. Үүнээс гадна эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн ямар нэг хэлбэрийг эмэгтэйчүүд амсах, тэд хүчирхийлэлд өртөхөд олон төрлийн хүчин зүйлс нөлөөлдөг.

1. Гэр бүл дэх эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл

111. Энэ нь тухайн эмэгтэй гэр бүлийн хүрээнд төрсөн цагаасаа эхлэн өтлөх хүртлээ өөрийн амьдралын орчинд амсаж болох хүчирхийллийн хэлбэр юм. Эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийллийн хамгийн түгээмэл тохиолддог хэлбэрт: зодох, хамтран амьдрагчийн зүгээс хүчирхийлж байгаа бусад хэлбэр, хүчиндэх; бэлгийн хүчирхийлэл; инжтэй холбоотой хүчирхийлэл, эмэгтэйчүүд, нялхсын амь насыг бүрэлгэх, өрхийн эмэгтэй хүүхдийг хүчирхийлэх, эмэгтэйчүүдэд чиглэсэн зүй бус уламжлалт зан үйл, тухайлбал, эмэгтэйн бэлэг эрхтнийг зэрэмдэглэх; эрт гэрлүүлэх; богтлох; хамтран амьдрагч бус хүмүүсийн зүгээс үйлдэгдэх хүчирхийлэл; гэрийн үйлчлэгчээр ажиллагсдыг хүчирхийлэх; мөлжлөгийн бусад хэлбэр. Гэр бүлийн хүн, хамтран амьдрагчийн зүгээс үйлдэж байгаа хүчирхийлэл, зүй бус уламжлалт зан үйлтэй холбоотой хүчирхийллийн хэлбэрийн талаар, бусад хүчирхийллийн хэлбэр, илрэлтэй харьцуулбал илүү их судалгаа хийж, тоо, баримт цуглуулсан байна.

(а) Бэлгийн хамтрагчийн хүчирхийлэл

112. Дэлхий даяарх эмэгтэйчүүдийн эсрэг хамгийн түгээмэл хүчирхийллийн нэг хэлбэр нь хамтран амьдрагчийн зүгээс үйлдэж байгаа хүчирхийлэл юм. Нөхөр болон хамтран амьдрагчийн харилцааны явцад эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэгдэж байгаа хүчирхийллийн олон хэлбэрийг гэр бүлийн хүчирхийлэл; бэлгийн хамтрагчийн хүчирхийлэл хэмээн нэрлэж тогтсон байна. Зөвхөн албан ёсны гэр бүлийн харилцаанд үйлдэгдэж байгаа хүчирхийлэлээс гадна хамтран амьдрах явцад эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэгдэж байгаа хүчирхийллийг судлах чиг хандлага цаашид өсөх хандлагатай байна.

113. Хамтран амьдрагчийн зүгээс үйлдэж байгаа хүчирхийлэл насанд хүрсэн, өсвөр насны эмэгтэйчүүдийн эсрэг, тухайн эмэгтэйн санал, зөвшөөрөлгүй одоогийн, хуучин хамтран амьдрагчийн зүгээс үйлдэж байгаа бэлгийн, сэтгэл зүйн болон бие махбодийн янз бүрийн үйлдэл юм. Бие махбодийн хүчирхийлэл гэдэг нь өөрийн биеийн хүч, чадал, аливаа зэвсгийг ашиглан эмэгтэйн бие махбодид гэмтэл учруулах, гэмтээхийг хэлнэ. Бэлгийн хүчирхийлэл гэдэг нь бэлгийн харилцаанд албадах, эмэгтэйн зөвшөөрөлгүй, саналыг нь үл харгалзан бэлгийн харилцаанд оруулах, өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйг албадан бэлгийн харьцаанд оруулахыг завдсан, бэлгийн харьцаанд орсон, ингэхдээ дарамт учруулсан, согтууруулах ундаа, бусад мансууруулах бодисын нөлөөгөөр дээрх үйлдлийг хийсэн байхыг ойлгоно. Сэтгэл зүйн дарамтад эмэгтэйг хянах, түүнийг тусгаарлах, доромжлох, ичээх зэрэг үйлдлүүд орно. Эдийн засгийн хүчирхийлэлд өөрийн амьжиргааны эх үүсвэрт хяналт тавих, түүнээс хүртэх байдлыг хязгаарлах зэргээр илэрнэ.

114. Дэлхийн 71 орон хамтран амьдрагчийн зүгээс үйлдэж байгаа хүчирхийллийн давтамж, хүрээг баримтаар нотолж чадах, хүн амд тулгуурласан судалгааг хийсэн байна (2 дугаар хүснэгтийг харна уу). Дэлхийн Эрүүл Мэндийн байгууллагаас гэр бүлийн хүчирхийллийн талаар Бангладеш, Бразил, Этиопи, Япон, Намиби, Перу, Самао, хуучин Серб болон Монтенегро, Тайланд, Танзанийн Бүгд Найрамдах Улс зэрэг олон оронд судалгаа хийж, хамтран амьдрагчийн зүгээс үйлдэж байгаа бие махбодийн хүчирхийллийн амьдралын хугацаан дахь давтамж 13%-61%-н хооронд хэлбэлзэж байгааг харуулсан байна. Судалгаанд оролцсон газруудын ихэнхэд энэ хувь 23-49-н хооронд хэлбэлзсэн ажээ. Судалгаанаас үзэхэд хамтран амьдрагчийн зүгээс үйлдэж байгаа бэлгийн хүчирхийллийн амьдралын хугацаан дахь давтамж 6 хувиас 59 хувийн хооронд байна. Өмнө нь 36 орны хүн амд тулгуурласан 50 судалгаанд дүгнэлт хийж үзэхэд хамтран амьдрагчийн зүгээс үйлдэж байгаа бие махбодийн хүчирхийллийн амьдралын хугацаан дахь давтамж 10 хувиас 50 хувийн хооронд байжээ. Саяхан Арабын Бүгд Найрамдах Сиди Улсад хийсэн судалгаанаас эмэгтэйчүүдийн 21.8 хувь нь гэр бүлийн хүрээнд хүчирхийлэлд өртдөг, эдгээр эмэгтэйчүүдийн 48 хувь зодуулж байсан гэсэн дүн гарчээ (7 дугаар хүснэгтийг харна уу).

115. Хамтран амьдрагчийн зүгээс үйлдэж байгаа хүчирхийлэл маш их хурцдаж, даамжирсны улмаас үхэлд хүргэдэг байна. Австрали, Канад, Израйл, Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улс, Америкийн Нэгдсэн Улсад хийсэн амиа хорлосон эмэгтэйчүүдийн шалтгааныг тогтоох судалгаа хийхэд хүн амины хэргийн хохирогч эмэгтэйчүүдийн 40-өөс 70 хувь нь өөрийн нөхөр эсхүл найз залуугийнхаа гарт амиа алдсан байна. Америкийн Нэгдсэн Улсын судалгааны тоо баримтаас үзэхэд 15-18 насны охидын амь насаа алдах хоёр дахь гол шалтгаан амь насыг нь хөнөөх явдал хэмээн тогтоосон байна. Өөрийн гэрт амь насаа алдсан хохирогчдын 78 хувь нь өөрийн ойр дотны эсхүл хамтран амьдрагч хүмүүсийнхээ гарт амиа алдсан гэсэн дүн мөн судалгаанаас гарчээ. Колумб Улсад зургаан хоног тутам нэг эмэгтэй өөрийн хамтран амьдрагч эсхүл хуучин хамтран амьдрагчийн гарт амиа алддаг.

116. Жирэмсэн эмэгтэйчүүдийн эсрэг хамтран амьдрагчийн зүгээс үйлдэж байгаа хүчирхийллийн талаар 1963 оноос 1995 он хүртэл хийсэн судалгаанд дүн шинжилгээ хийж үзэхэд Америкийн Нэгдсэн Улсын жирэмсэн бүх эмэгтэйчүүдийн хүчирхийлэлд өртөх хувь 9-20.1 байна. 1996 онд Никарагуад хийсэн судалгаагаар эмэгтэйчүүдийн 31% зодуулж байсан гээд эдгээр эмэгтэйчүүд жирэмсэн байхдаа бие махбодийн хүчирхийлэлд өртөж байсан гэжээ. Хөгжиж буй хэд хэдэн оронд хийсэн судалгаанаас үзвэл эдгээр оронд эмэгтэйчүүдийн жирэмсэн байх үеийн хүчирхийлэл 4-32 хувь, жирэмсэн үед өртөх дунд зэргийн, хурц, бие махбодийн хүчирхийллийн давтамж 13 хувьтай байна.

117. Эмэгтэйчүүдийн эсрэг хамтран амьдрагчийн зүгээс үйлдэж буй хүчирхийллийн судалгаанд, түүний учруулж байгаа сэтгэл зүйн, сэтгэл санааны хүчирхийллийн талаар анхаарал бага хандуулж иржээ. Ийм хэлбэрийн хүчирхийллийг тодорхойлох, түүний хохирлыг хэмжихэд ихээхэн бэрхшээлтэй байдаг. Учир нь энэ хэлбэрийн хүчирхийлэл тухайн хүчирхийлэл үйлдэгчийн зан байдал, орчин, газраас хамааран өөрчлөгддөг. Сэтгэл санааны хүчирхийллийг бүрдүүлэгч үйлдэл, үйлдлийн нэгдэл, тэдгээрийн давтамж зэргийн талаар өнөөг хүртэл нэгдсэн ойлголтонд хүрч чадаагүй байна. Дэлхийн Эрүүл Мэндийн байгууллагаас гэр бүлийн хүчирхийллийн талаар олон оронд хийсэн судалгаанаас харахад судалгаанд оролцогчдын 20-75 хувь нь нэг буюу түүнээс дээш удаа сэтгэл санааны дарамт үзүүлэх үйлдэлд өртсөн гэжээ. Чили, Египет, Энэтхэг, Филиппин зэрэг улсад хийсэн олон орны хүн амд тулгуурласан судалгаанд хурц хэлбэрийн сэтгэл зүйн хүчирхийллийн давтамж Египетэд 10.5, Чилид 50.7 хувь хэмээжээ. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаар Францад үндэсний хэмжээнд анх удаа явуулсан судалгаанд оролцогч эмэгтэйчүүдийн 35 хувь сүүлийн 12 сарын турш хамтран амьдрагчийн үйлдсэн сэтгэл зүйн дарамтад өртсөн гэжээ. Сэтгэл зүйн хүчирхийллийн дарамтыг тодорхойлж байгаа үйлдэлд хэн нэгний үйл ажиллагааг хянах, захиргаадах, эсхүл үгүйсгэх, үл ойшоох, үл хүндэтгэх хандлагууд зэргийг багтааж ойлгоно. Судалгаанд оролцогчдын 4 хувь нь мөн хугацаанд сэтгэл санааны дайралт, эсхүл доромжлох, заналхийлэх хэл амаар дарамтлах үйлдлийн золиос болсон байна. Германд хийсэн судалгаанд оролцогчдын 42 хувь нь айлгах, заналхийлэх, доромжлох, зэрлэгээр хашгирах болон “сэтгэл зүйн дарамтанд” өртөж байсан гэж хариулжээ.

(б) Зүй бус уламжлалт зан үйл

118. Эмэгтэй нялхсын амь насыг бүрэлгэх, хүүхдийг төрөхөөс өмнө хүйсээр нь сонголт хийх, эрт гэрлүүлэх, инжтэй холбоотой хүчирхийлэл, эмэгтэйн бэлэг эрхтнийг зэрэмдэглэх, “нэр төрийг” хамгаалах нэрээр үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, бэлэвсэн эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах, тэднийг амиа хорлохыг тулгах зэрэг нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн хэлбэрүүд, зүй бус уламжлалт зан үйл гэж үзэх ба энэ хүчирхийлэл нь гэр бүл, нийгмийн хүрээнд үйлдэгддэг. Хэдийгээр зүй бус уламжлалт зан үйлийн талаар тоо баримтыг цуглуулж нэгтгэсэн ч энэ нь зүй бус зан үйлийн тодорхой жагсаалт болж чадахгүй юм. Зүй бус уламжлалт зан үйлийн тухай Засгийн Газар (жишээ нь: Хүний эрхийн хэлэлцээрийн эрх бүхий байгууллагад ирүүлж байгаа тайлан болон Бээжингийн Үйл Ажиллагааны Хөтөлбөрийг хэрэгжүүлэх дагалдах тайлан), Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн шалтгаан, үр дагаврын тухай мэдээлэх Тусгай илтгэгч, зүй бус уламжлалт зан үйлийн талаар Тусгай илтгэгч нар хөндөж тавьсан байна. Дээр дурдсан зүй бус зан үйлд охидыг сүмийн ёслолд тахин зориулах, хоёр дахь охины гэрлэх эрхийг хязгаарлах, жирэмсэн эмэгтэйчүүдийн хоолыг хязгаарлах, хүчээр нэмэгдэл тэжээл өгөх, хооллох (ёс

суртахууны хувьд хориглосон), нас барсан нөхрийнхөө ах/дүүтэй гэрлүүлэх зэрэг багтсан байна.

119. Судалгааны хамгийн их санаа зовоосон асуудал бол эмэгтэйн бэлэг эрхтнийг зэрэмдэглэх зан үйлийн асуудал юм. Судалгаанаас үзэхэд голдуу Африк болон Дундад Азийн орнуудын 130 гаруй сая охид, бүсгүйчүүд эмэгтэй бэлэг эрхтнийг зэрэмдэглэх зан үйлд өртсөн байна. Энэ зан үйл Европ, Хойд Америк болон Австралийн цагаачдын дунд элбэг тохиолддог. Судалгааны үр дүнгээс үзвэл энэ зан үйлийн газар зүйн байршлаас хамааран 19 оронд өөр тархалттай байна: Гвинейд 99 хувь, Египетэд 97 хувь, Этиопид 80 хувь, Бенинд 17 хувь, Гана болон Нигерт 5 хувь байна. Судалгааны дүн энэ зан үйлийн тархалт өндөр байдаг орнуудад эмэгтэйчүүдийн бүлгүүдийн хүчтэй эсэргүүцэл нэмэгдэж байгаа учраас буурах хандлага байгааг харуулж байгаа юм. Эмэгтэйчүүдийн дунд дээд боловсрол эзэмших байдал нэмэгдэх, эдийн засгийн эх үүсвэрийн хүртээмж сайжрах, хяналт тавих боломжтой болох, эмэгтэйн бэлэг эрхтэнийг зэрэмдэглэх зан үйл, угсаа байдлыг өөрчлөх асуудал эмэгтэйчүүдийн өөрсдийн эсэргүүцэл, ийм зорилготой үйл ажиллагааг дэмжихээс ихээхэн хамаарах юм.

120. Эрэгтэй хүйсийг илүүд үзэх үзэл эмэгтэй хүүхдийн амь насыг бүрэлгэх, хүүхдийг төрөхөөс өмнө хүйсээр сонгох, эмэгтэй хүйсийг зохион байгуулалттайгаар үгүйсгэх зэрэг хандлага, үйлдлээр илэрч, Зүүн Өмнөд Ази, Хойд Америк болон Дундад Азийн орнуудад эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа алдагдах, охидын эндэгдэл нэмэгдэх зэрэг үр дагаварт хүргэж байна. Энэтхэгт хийсэн судалгаагаар хүүхдийг төрөхийн өмнө хүйсээр сонгох, охин байвал амь насыг бүрэлгэх зэрэг үйлдлийн улмаас сүүлийн хорин жилийн дотор жилд хагас сая эмэгтэй хүйсийн ургийг устгасан байна гэж тооцоолжээ. Бүгд Найрамдах Солонгос Улсад жирэмсэн эхчүүдэд хүйс тодорхойлох тестийг хэрэглэж, хүү тээж байсан эхчүүдийн 90 хувь хэвийн төрж харин, охин ураг тээж байсан эхчүүдийн 30 хувь хэвийн төрж чадаагүй байна гэж Үндэсний Төрөлт Гэр Бүлийн Эрүүл Мэнд Судалгаанд дурдсан байна.

121. Эрт гэрлүүлэх гэдэг нь хүүхдийг албадан гэрлүүлэх, өөрөөр хэлбэл 18 нас хүрээгүй хүүхдийг гэрлүүлэх явдал юм. Нөхөн үржихүйн бойжилт гүйцэд явагдаагүй, өөрийн бэлгийн амьдралыг хянах, зохицуулах чадвар, мэдлэггүй бага насны охидыг гэрлүүлэх хандлага их. Ийм охид гэрлэж, хүүхэд төрүүлэх нь тэдний эрүүл мэндэд хортойгоор нөлөөлж, суралцах, боловсролтой болох боломжуудыг нь хязгаарлаж, эдийн засгийн бие даасан байдлыг бий болгох боломжгүй болгодог. Эрт гэрлүүлэх нь бэлгийн замын халдварт өвчинд өртөх эрсдлийг бий болгодог. Ийм гэрлэлт дэлхийн аль ч өнцөгт байдаг боловч ихэвчлэн охидын 30 хувь нь 15-19 насандаа гэрлэдэг Сахарын болон Өмнөд Африкийн оронд маш түгээмэл байна. Этиопид охидын 19 хувь нь 15 насандаа гэрлэдэг бөгөөд зарим бүс нутаг, тухайлбал, Амхарад энэ хувь 50 байна. Непалд охидын 7 хувь нь 10 нас хүрэхээс өмнө гэрлэдэг ба 40 хувь 15 нас хүрээд гэрлэдэг. НҮБ-ын Хүүхдийн Сангийн глобал үнэлгээний үр дүнд Латин Америк болон Карибын орнуудын 15-24 насны эмэгтэйчүүдийн 29 хувь 18 нас хүрэхээс өмнө гэрлэсэн байна.

122. Хүчээр гэрлүүлэх нь гэрлэж байгаа талуудын нэг талын хүчин төгөлдөр, чөлөөтэй зөвшөөрөл байхгүй гэрлэлт юм. Хүчээр гэрлүүлэх асуудал хурцдаж, нөгөө тал эсэргүүцсэн тохиолдолд заналхийлэх зан байдал, хорих, бие махбодийн хүчирхийлэл, хүчин болон зарим тохиолдолд амь насыг нь бүрэлгэх байдалд хүргэдэг. Энэ хэлбэрийн хүчирхийллийн талаар тун бага судалгаа хийгдсэн байна. Саяхан хийсэн Европын судалгаа Европын орнуудын Зөвлөлд тоон үзүүлэлтийг харуулсан судалгаа хангалтгүй байгааг дахин нотолсон байна. Киргизын 6 тосгоны 1,322 гэрлэлтийг хамарсан судалгаанд Киргиз угсааны гэрлэлтийн хагас нь бэрийг богтолсон, эдгээр

гэрлэлтийн гуравны хоёр нь гэрлэж байгаа хосууд харилцан тохиролцоогүйгээр гэрлэсэн байгааг харуулжээ. Умард Ирланд Их Британий Нэгдсэн Вант улсад Хүчээр Гэрлүүлэх Явдлыг таслан зогсоох Засгийн Газрын байгууллага жил бүр хүчээр гэрлүүлж байгаа 300 тохиолдолд хөндлөнгөөс оролцох хэрэгтэй болдог ажээ.

123. Инжтэй холбоотой хүчирхийлэл - инж нь сүйт бүсгүйн талаас сүйт залуугийн гэр бүлд төлж байгаа мөнгөн төлбөр эсхүл эд хөрөнгө, инжийн улмаас эмэгтэй амь насаа алдах байдалд хүргэдэг. Энэтхэгийн гэмт хэргийн албан ёсны статистикээс үзэхэд энэ хүчирхийллийн улмаас 2002 онд 6,822 бүсгүй амь насаа алджээ. Жижиг нийгмийн бүлгүүдийн дунд хийсэн судалгааны үр дүн ч гэсэн инж шаардах явдал бүсгүйг шатаах, амиа хорлосон гэж нэрлэж байгаа эмэгтэйчүүдийн үхэлд ихээхэн үүрэг гүйцэтгэдгийг харуулж байна.

124. “Нэр төр”-ийг хамгаалах нэрийн дор эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэж байгаа гэмт хэрэг нь гэр бүл, нийгмийн бүлгийн хүрээнд үйлдэгддэг. Эдгээр гэмт хэргүүд сүүлийн үед анхаарал ихээхэн татаж байгаа боловч, мэдээлэгддэггүй, нотлогдохгүй үлддэг хэвээр байна. Хамгийн хурц хэлбэрийн илрэл нь амь насыг хороох бөгөөд “ариун аллага” гэсэн нэртэй гэмт хэрэг юм. НҮБ-ын Хүн Амын Сангаас дэлхий дахинд жилд 5,000 гаруй эмэгтэйчүүд “ариун аллага” гэмт хэргийн золиос болж, гэр бүлийн гишүүдийн гарт амиа алдаж байна гэсэн судалгаа хийжээ. Засгийн Газрын илтгэлд 1998-2003 онд Пакистанд 4000 эрэгтэй, эмэгтэй хүмүүс “ариун аллага” зан үйлийн золиос болсон гэж мэдээлжээ. Энэ зан үйлийн улмаас амиа алдсан эмэгтэйчүүдийн тоо эрчүүдийн тооноос хоёр дахин их байна.

125. Дэлхийн олон оронд настай эмэгтэйчүүд, ялангуяа бэлэвсэн эмэгтэйчүүд гэр бүлийн болон нийгмийн тодорхой бүлгийн хүрээнд зүй бус уламжлалт зан үйлийн золиос болж байна. Хэвлэл мэдээллийн мэдээ, ярилцлага зэргийг ашиглан Гана Улсад судалгаа хийсэн бөгөөд ядуу, настай эмэгтэйчүүдийг чөтгөр, шулмас хэмээн дарамтлах байдал байгааг илрүүлсэн. Эдгээр эмэгтэйчүүдийг хамаатан, садангийн эрчүүд амь насыг нь хөнөөх бөгөөд хэрэв эндээс амь гарч чадвал бэлгийн, эдийн засгийн, бие махбодийн дарамт, хүчирхийлэл амсдаг байна. Бэлэвсэн эхнэрүүдийг бэлгийн дарамт хүчирхийлэлд оруулах, хадмын талын зүгээс эд хөрөнгөтэй холбоотой хүчирхийлэлд өртөж байгаа байдлыг дэлхийн олон орон, тухайлбал, Энэтхэгээс мэдээлж байгаа юм. Гэхдээ мэдээлэл хангалтгүй, энэ талаар бага мэдээлэгдэж байгаа хэвээр байна.

2. Нийгмийн тодорхой бүлгүүдээс эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэгддэг хүчирхийлэл

126. Эмэгтэйчүүд нийгэмд янз бүрийн хүчирхийлэлтэй нэлээд тулгардаг. Бие махбодийн, бэлгийн, сэтгэл зүйн хүчирхийлэл нь эмэгтэйчүүдийн хөршүүд, нийтийн тээвэр, ажлын байр, сургууль, спорт клуб, коллеж, эмнэлэг, шашны, нийгмийн байгууллагуудтай харилцах өдөр тутмын харилцаанд тохиолдож болох зүйл юм.

(а) Эмэгтэйчүүдийн амь насыг хөнөөх: Хүйсээр ялгаварлан эмэгтэйчүүдийг хөнөөх

127. Эмэгтэйчүүдийн амь насыг хороох хэрэг хаа сайгүй гардаг. Гэхдээ эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн энэ төрөл зарим орнууд, жишээлбэл Сиудад Жубрез, Мексик, Гватемалд ихээхэн анхаарал татах боллоо. Албаны эх сурвалжийн мэдээгээр Сиудад Жубрезд амь насаа алдсан 320 эмэгтэйн 1/3-ийг зэрлэгээр хүчирхийлж амь насыг нь хороосон байна. Гватемалын Үндэсний Цагдаагийн

Газраас 2001-2004 онд 1467 эмэгтэйн амийг хөнөөсөн гэмт хэрэг гарсныг мэдээлсэн. Харин бусад эх сурвалжийн мэдээлснээр дээрх тооноос 2070-аар олон буюу ихэнх нь 14-35 насны эмэгтэйчүүдийн амийг хороосон байна. Эмэгтэйчүүдийн амийг хороох гэмт хэрэг нь гадаадын компаниудын экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэлүүд төвлөрсөн татвараас чөлөөлөгдсөн бүс нутгуудад их тохиолдож байна. Ийм гэмт хэрэг үйлдэгсэд ял шийтгэлгүй өнгөрч байгаа нь дахин давтан гарах гол шалтгаан нь болж байна. Харин Гватемалын хувьд 1996 он хүртэл үргэлжилсэн дотоодын зэвсэгт мөргөлдөөний улмаас эмэгтэйчүүд олноор алагдахад хүргэжээ.

(б) Бэлгийн хамтрагч бус этгээдээс үйлдэгддэг хүчирхийлэл

128. Эмэгтэйчүүдийн хамтран амьдрагчийн зүгээс үйлдсэн хүчирхийлэлд өртөх эрсдэл ихтэй байдаг ч бэлгийн харилцаагүй, хамтрагч бус хүмүүсийн зүгээс бэлгийн хүчирхийлэлд өртөх явдал сүүлийн үед ихээхэн нэмэгдсээр байна. Бэлгийн хамтрагч бус хүмүүст төрөл садан, найз нөхөд, танил, хөрш, ажлын газрынхан, үл таних хүмүүс хамаарна. Бэлгийн хамтрагч бус хүмүүсийн зүгээс учруулсан хүчирхийллийн талаар тодорхой тоо, мэдээ гаргахад бэрхшээлтэй байдгийн учир нь ихэнх орнуудад бэлгийн хүчирхийлэлд өртөх нь эмэгтэйчүүд, тэдний гэр бүлд хамгийн ичгүүртэй зүйл гэж үздэгтэй холбоотой юм. Цагдаагийн байгууллагын статистик мэдээллээс харахад хүчингийн хэргийн ихэнх тохиолдол, бүртгэгдээгүй байдаг тул бүрэн мэдээлэл гаргах боломжгүй байдаг.

129. Бэлгийн хамтрагч бус хүмүүсийн зүгээс эмэгтэйчүүдэд учруулдаг бэлгийн хүчирхийллийн асуудлаар олон нийтийн дунд хэд хэдэн судалгаа хийгджээ. Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагаас гэр бүлийн хүчирхийллийн талаар олон улсын хэмжээнд явуулсан судалгаагаар бэлгийн хамтрагч бус хүмүүсийн хүчирхийлэлд өртсөн 15-аас дээш настай эмэгтэйчүүдийн тоо Этиоп, Бангладешд 1%-иас багагүй, Перу, Самао, Танзанид 10-12 хувьтай байжээ. Бусад орнууд ч үүнтэй адил үзүүлэлттэй байна. Жишээлбэл: Канадад эмэгтэйчүүдийн 11,6 хувь нь амьдралдаа бэлгийн хамтрагч бус хүний бэлгийн хүчирхийлэлд өртөж байсан гэж мэдэгдсэн бол, Шинэ Зеланд, Австралид эмэгтэйчүүдийн 10-12 хувь нь бэлгийн хамтрагч бус хүнтэй хүсээгүй бэлгийн харьцаанд орох, хүчиндэхийг оролдох, хүчиндүүлэх зэрэг янз бүрийн хэлбэрийн бэлгийн хүчирхийлэлд өртөж байсан гэж мэдээлжээ. Швейцарт явуулсан судалгааны урьдчилсан дүнгээр эмэгтэйчүүдийн 22,3 хувь нь амьдралдаа бэлгийн хамтрагч бус хүний хүчирхийлэлд автсан гэж мэдэгджээ.

130. Бэлгийн харьцаанд орохыг хүчээр тулгах нь бэлгийн хамтрагч бус хүмүүсийн зүгээс учруулдаг бэлгийн хүчирхийллийн нэг төрөл юм. Энэ төрлийн хүчирхийлэл нь хамтран амьдрагчдын хүрээнд ч бас тохиолддог. 2002 оны Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагаас гаргасан “Хүчирхийлэл ба Эрүүл Мэндийн Дэлхийн Мэдээнд бэлгийн харьцаанд орохыг хүчээр тулгах асуудлаар дэлхийн 6 орны хүн амын дунд явуулсан судалгааны үр дүнг мэдээлсэн. Энэ үзүүлэлтээр АНУ 9 хувь, Перуд 40 хувьтай байжээ. Дэлхийн бараг бүх оронд хөвгүүдтэй харьцуулахад илүү олон тооны охид бэлгийн хавьталд орохыг хүчээр тулгах байдалд өртөж байсан гэж мэдээлжээ.

131. Болзооны үеийн хүчирхийлэл бол бэлгийн хамтрагч бус хүмүүсээс охид бүсгүйчүүдэд учруулдаг бэлгийн хүчирхийллийн өөр нэг хэлбэр юм. Канадад жишээ нь: 15-19 насны охидын дунд явуулсан судалгаагаар тэдний 54 хувь нь болзооны үеийн хүчирхийлэлд өртөж байсан байна. АНУ-д 2000 онд хийсэн судалгаагаар болзооны хүчирхийлэлд өртөгсдийн 22 хувь нь дунд сургуулийн охид, 32 хувь нь коллежийн оюутнууд болох нь тогтоогджээ. Мөн АНУ-д явуулсан өөр нэг судалгаагаар эмэгтэйчүүдийн 8.3 хувь нь болзооны үеэр учруулсан бие махбодийн дарамт, хүчин,

хууран мэхлэлтэнд өртсөн, 20,6 хувь нь болзооны хүчирхийллийн ямар нэг хэлбэрт өртөж байсан гэжээ. Охид, бүсгүйчүүдийг хоол унд, сургалтын төлбөр, эсхүл ямар нэг бэлэг сэлт өгч хариуд нь бэлгийн харьцаанд татан оруулдаг. Охидыг хууран мэхлэх замаар бэлгийн харьцаанд уруу татдаг эдгээр хүмүүс охидыг ДОХ болон бэлгийн замын халдварт өвчнөөр халдварлах эрсдэлд оруулдаг. Африк, Азийн зарим орнуудад охидыг хүчиндэх хэрэг их гарч байгаа нь бэлгийн харьцаанд орж байгаагүй охидтой уг харьцаанд орвол ДОХ-ыг эдгээдэг гэдэг мухар сүжигтэй холбоотой ажээ.

(в) Ажлын байр, боловсролын байгууллага, спортын байгууллагын орчин дахь бэлгийн дарамт, хүчирхийлэл

132. Хууль тогтоох, хэрэгжүүлэх, нийгмийн бусад олон салбарт эмэгтэйчүүдийн оролцоо улам бүр нэмэгдэх болсноор ажлын байран дахь бэлгийн дарамт, хүчирхийлэл анхаарал татсан асуудлын нэг болсон. Европын Холбооны орнуудын эмэгтэйчүүдийн 40-50 хувь нь ажлын байран дахь аль нэг хэлбэрийн бэлгийн дарамт, хүчирхийлэлд өртсөн гэсэн өндөр үзүүлэлт гарсан байна. Ази, Номхон далайн орнуудад хийсэн зарим нэг жижиг судалгаанд хамрагдсан ажилчин, албан хаагч эмэгтэйчүүдийн 30-40 хувь нь үг ярианы, биеийн, бэлгийн харьцаа зэрэг бэлгийн хүчирхийллийн аль нэг хэлбэрт өртөж байсан гэсэн дүн гарчээ.

133. Сургууль, соёлын байгууллагад охид, бүсгүйчүүд бэлгийн дарамт, хүчирхийлэлд өртөх явдал ихээхэн анхаарал татах болсон байна. АНУ-д хийсэн судалгаагаар дунд сургуулийн 8-11 дүгээр ангийн охидын 83 хувь нь ямар нэг хэлбэрийн бэлгийн дарамтад өртдөг болохыг тогтоосон байна. Дэлхийн Банкны 2002 оны судалгаагаар Эквадорт сургууль, боловсролын газар охид бүсгүйчүүдийн 22 хувь нь бэлгийн дарамтын хохирогч болсон гэдгийг тотоожээ. Малавид дунд сургуулийн охидын хүрээнд явуулсан 2006 оны судалгаанд хамрагдагсдын 50 хувь нь багш, сурган хүмүүжүүлэгчид болон эрэгтэй сурагчдын зүгээс биед нь зөвшөөрөлгүйгээр хүрэх, оролдох байдалтай тулгарч байдаг гэсэн дүн гарчээ.

134. Спортоор хичээллэдэг охид, эмэгтэйчүүд бусад тамирчид, үзэгчид, дасгалжуулагчид, менежерүүд, гэр бүлийн гишүүд, олон нийтийн зүгээс учруулдаг жендерт суурилсан бэлгийн хүчирхийлэл, дарамтанд өртдөг. Судалгааны дүнгээс үзэхэд Канадад эмэгтэй тамирчдын 40-50 хувь, Австралид 27 хувь, Данид 18-аас доош насны эмэгтэй тамирчдын 25 хувь нь бэлгийн дарамтанд өөрөө өртсөн буюу эсхүл тийм дарамтанд орсон өөр хэн нэгнийг мэддэг, таньдаг гэжээ. Чех Улсад явуулсан судалгаагаар эмэгтэй тамирчдын 45 хувь нь спортын салбарын хэн нэгний бэлгийн дарамт, 27 хувь нь дасгалжуулагчийн бэлгийн дарамтанд өртсөн гэж мэдээлжээ.

(г) Эмэгтэйчүүдийг хил дамнаулан худалдаалах

135. Эмэгтэйчүүдийг хил давуулан худалдаалах нь эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэгдэж байгаа хүчирхийллийн нэг хэлбэр бөгөөд ихэвчлэн гэр бүл, зуучлагч, олон улсын гэмт хэргийн сүлжээ, цагаачлалын албаныхан гээд нилээд өргөн хүрээг хамарч олон улсын шинжтэй явагддаг. Хүн худалдаалах явдал тухайн улс орны дотоодод эсвэл 2 улсын хооронд явагддаг. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид нь ихэвчлэн эмэгтэйчүүд, хүүхдүүд байдаг бөгөөд ихэнхдээ биеийг нь үнэлүүлэх, бэлгийн мөлжлөгт ашиглах зорилгоор хил давуулан худалдаалдаг.

136. НҮБ-ын Үндэстэн Дамнасан Зохион Байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх Конвенцийн нэмэлт протоколд Хүн, ялангуяа, Хүүхэд, Эмэгтэйчүүдийг Худалдаалах Хэргээс Урьдчилан Сэргийлэх Протоколд “Хүн худалдаалах хэрэг нь айлган

сүрдүүлэх, хүч хэрэглэх буюу ямар нэг хэлбэрээр дарамтлан, залилан, хууран мэхлэх, хүчээр түрэмгийлэх, биеэ хамгаалах чадваргүйг далимдуулах, биеийг нь үнэлүүлэх зорилгоор өөр хэн нэгний мэдэлд өгч түүнийхээ хариуд мөнгө харамж авах зорилгоор тээвэрлэх, шилжүүлэхийг хэлнэ” гэж заасан. Хүч хөдөлмөрийг ашиглах гэдэг нь биеийг нь үнэлүүлэх, албадан хөдөлмөр эрхлүүлэх, мөлжих, мөлжлөгийн хөдөлмөр хийлгэх эсхүл эд эрхтнийг нь худалдаалах зэрэг орно.

137. Хүн худалдаалах хэргийн тархалтыг тогтооход хэцүү. /5 дугаар бүлгийг үзнэ үү/. Саяхан хүртэл хүн хил давуулан худалдах хэрэг гэж юу болох тухай, түүнийг яаж тодорхойлох нь ихээхэн зөрүүтэй байв. Харин Хүн хил давуулан худалдаалахыг хориглох тухай Протоколыг баталсан нь энэ асуудлыг шийдвэрлэхэд дөхөм болж байна. Хүн хил давуулан худалдаалсан тухай мэдээлэл цуглуулах ажил үндэсний, бүс нутгийн, олон улсын түвшинд хийгдэж байна. UNODC-ын мэдээллээс үзэхэд хүнийг хил давуулан худалдаалдаг 127, худалдан авдаг 137 улс байгаа ажээ. Төв ба Зүүн өмнөд Европ, Тусгаар Улсуудын Нэгдсэн Холбооны улсууд, Ази, Баруун Африк, Латин Америк, Карибын тэнгисийн орнууд хүн худалдаалах түлхэц газрууд, харин Баруун Европ, Ази, Хойд Америк хүн хил давуулан худалдаалж хүргэдэг хамгийн гол сувгууд болжээ.

138. Төрөл бүрийн эх сурвалжийн мэдээгээр жил бүр олон зуун мянган хүмүүсийг хил давуулан худалдаалах хэрэг гардаг боловч тэдний маш цөөхөн хувь нь л мэдээлэгдэж албаны хүмүүсийн анхааралд өртдөг байна. Жишээ нь: 2005 онд Португальд 506, Мексикт 412, Туркт 243 хүн хил давуулан худалдаалах хэргийн хохирогчийг олж тогтоожээ. Хүн хил давуулан худалдаалах гэмт хэрэгтнийг илрүүлэн ял шийтгэл тооцох явдал маш ховор байна. Жишээ нь: 2003 онд Литв 24 хүнд эрүүгийн хэрэг үүсгэсний зөвхөн 8 нь шийтгэгдсэн байна. Украинд 54 хүнээс зөвхөн 11-д нь л ял оноосон. 2004 онд АНУ-д 54 хүнээс 43-т нь ял шийтгэл оногдуулжээ.

3. Төрийн зүгээс эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэгддэг хүчирхийлэл

139. Төр, төрийн агентлагууд эсхүл төрийн, нийгмийн бодлогоор дамжин эмэгтэйчүүдийг биеийн, бэлгийн, сэтгэл санааны хүчирхийлэлд өртөхөд хүргэдэг. Төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэх эрх бүхий албан хаагчдын тоонд хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх засаглалын ажилтнууд, нийгмийн хамгааллын ажилтнууд, хорих газрын хамгаалагчид, хууль сахиулах байгууллагын ажилтнууд, цагаачлал, хил, цэрэг, аюулаас хамгаалах хүчинд ажиллагсад багтдаг.

140. Төрийн албан хаагчдын дотор гудамж замд ч, хорих саатуулах газруудад ч хүчин, бэлгийн дарамт зэрэг хүчирхийлэл үйлдэх тохиолдол бий. Зарим тохиолдолд зэрлэгээр тамлан зовоох, хүний ёсноос гадуур байдлаар тарчлаах ял шийтгэлийг хэтрүүлдэг тохиолдол ч бий. Төрийн зарим хууль, тогтоомж, бодлогоос болж эмэгтэйчүүд хүчирхийлэлд өртөх тохиолдол бий. Албадан үр хөндүүлэх, албадлагаар жирэмсэн болгох зэрэг нь төрийн бодлогоос улбаатай бөгөөд эмэгтэйчүүдийн бэлгийн хэвийн үйл ажиллагаа, нөхөн үржихүйд нь хяналт тогтоож хүчирхийлсэн хэрэг юм. Мөн эмэгтэйчүүдийн тусгаар байдал, хууль ёсны эрхийг үл тоомсорлох, төрөөс эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл үйлдэгчдэд ял шийтгэл завших боломж олгох нь төрийн бодлоготой холбоотой. Төрөөс эмэгтэйчүүдийн асуудалд нийцгүй хууль батлах, сайн хууль баталсан ч түүнийг зохих ёсоор хэрэгжүүлэхгүйгээс эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг нэмэгдүүлэх боломж олгодог.

(а) Албадан саатуулах ажиллагаан дахь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл

141 Цагдаагийн албадан саатуулах газар, хорих газар, нийгмийн хамгааллын байгууллагууд, цагдаагийн түр саатуулах газар болон бусад төрийн байгууллагуудад эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл үйлдэгддэг. Хорих газар үйлдэгдсэн хүчингийн хэрэг бараг хүний физиологийн хэрэгцээг хангасан үйлдэл шахуу тооцогддог. Янз бүрийн эх сурвалжуудаас авсан мэдээнд хорих газар байгаа эмэгтэйчүүд өртөж байгаа хүчирхийллийн олон хэлбэр байдаг. Үүнд: усанд оруулах, хувцсыг нь тайлуулах, эрэгтэй хүний хажууд биед нь үзлэг хийхийн зэрэгцээ үг хэлээр бэлгийн дарамт учруулдаг байна. Засан хүмүүжүүлэх газрын офицер, хянагч нар наад захын хэрэгцээний зүйлийн солилцоонд бэлгийн харилцаанд орохыг шаарддаг байна. Хэдийгээр хорих газарт эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл гардаг тухай дэлхийн бараг бүх орнуудад яригддаг боловч ийм төрлийн хүчирхийллийн тоон үзүүлэлтийг гаргахад хангалттай мэдээлэл байхгүй байна.

(б) Албадан үргүй болгох

142. Эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйг хянах зорилгоор албадан үргүй болгох арга хэрэглэн эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл үйлдэх тохиолдол байдаг. Тодорхой бүс нутгаар буюу улс орноор авч үзэхэд албадан үргүй болгож байгаа тохиолдлыг хянах боломжтой иж бүрэн мэдээлэл, судалгаа байдаггүй. Европын Ром, Америк, Канадад үндэстний цөөнхийн эмэгтэйчүүдийг албадан үргүй болгох хэрэг гардаг тухай мэдээлэл бий.

4. Зэвсэгт мөргөлдөөний үеийн эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл

143. Зэвсэгт мөргөлдөөн, цэрэг, дайны зөрчилдөөний үед эмэгтэйчүүд бие махбодийн, бэлгийн, сэтгэл санааны бүх хэлбэрийн хүчирхийлэлд өртдөг. Үүнд: эмэгтэйчүүдийн амь насыг хороох, тарчлаан зовоох, зэрлэг балмад авирлах, хүний ёсноос гажуудаар тарчлаан шийтгэх, тэднийг албадан цэрэг дайнд дайчлах, хүчиндэж бэлгийн мөлжлөгөнд оруулах, биеийг нь үнэлүүлэх, олон улсын хорих газарт хорих, хүчээр гэрлүүлэх, хүчээр садар самуунд татан оруулж биеийг нь үнэлүүлэх, албадан үр хөндөх, жирэмслүүлэх, үргүй болгох зэрэг орно.

144. Бэлгийн хүчирхийлэл нь зэвсэгт мөргөлдөөний үед олон шалтгааны улмаас тарчлаан зовоох, гэмтээж бэртээх, мэдээлэл авах дайсан, өрсөлдөгчөө доромжлох, оршин суугчдыг газар нутгаасаа дайжин орхиж явахад хүргэн, эсхүл зориудаар ДОХ тараах зорилгоор эмэгтэйчүүдийг хүчиндэх хэлбэрийг ашигладаг байна. Эмэгтэйчүүдийг албадан бэлгийн болон гэрийн зарц, боолын хөдөлмөр хийлгэж байна. Эмэгтэйчүүдийг бусдад шагналын журмаар эхнэр болгон өгч байна.

145. Зэвсэгт мөргөлдөөн цэрэг дайны зөрчилдөөн дэх эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл нь ихэвчлэн хүчингийн хэрэг зэргийг оролцуулсан голчлон бэлгийн хүчирхийлэл байдаг. Афганистан, Бурунди, Чад, Колумби, Зааны Ясан Эрэг, Конго, Либер, Перу, Руанда, Сиер Леон, Чечень /ОХУ/, Дарфур, Судан, Уганда, Югослав зэрэг одоо цэрэг дайны зөрчилдөөнтэй эсхүл өмнө нь байсан эдгээр орнуудад эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн хэрэг их гарч байсан.

146. 1 дүгээр хүснэгтэнд зэвсэгт мөргөлдөөний үеийн эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаар иргэд олон нийтийн дунд явуулсан 4 судалгааны мэдээг нэгтгэн харуулсан. 1994 оны үед үй олноор нь хоморголон устгалтын үед Руандад 250 мянгаас 500 мянган эмэгтэй, 1990-ээд оны эхэн үед Боснид 20 мянгаас 50 мянган

эмэгтэй, 1971 онд Бангладешд Зэвсэгт мөргөлдөөн, цэрэг дайны зөрчлийн үед 200 мянга орчим охид, эмэгтэйчүүд тус тус хүчиндүүлсэн гэсэн мэдээ байна.

Хүснэгт 1.

Зэвсэгт мөргөлдөөний үеийн эмэгтэйчүүдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн тохиолдол

Газрын нэр Зэвсэгт төргөлдөөний хугацаа	Судалгааны хэлбэр	Судалгааны үр дүн
Либер /1989-1994/	Монревид 15-79 насны 205 эмэгтэйн хүрээнд хийсэн судалгаа	Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн 49 хувь буюу 100 эмэгтэй ямар нэг хэлбэрийн хүчирхийлэлд өртсөн, 17 хувь нь зодуулж хүлүүлж, эсхүл зэвсэгт харуулаар мануулж хоригдсон. 33 хувь нь 1 буюу түүнээс олон удаа нүцгэлэн шалгах шалгалтанд өртөж, 15 хувь нь хүчиндүүлж, хүчиндэхийг завдсан бэлгийн дарамтанд өртсөн гэжээ. ^а
Уганда /1980-1986/	Н.А.Лоурто дүүрэг, Умард Уганда	Лоуэрто дүүргийн эмэгтэйчүүдийн 70 хувь нь цэргүүдэд хүчиндүүлсэн, нилээд их хувь нь 10 хүртэл цэргүүдэд бүлэглэн хүчиндүүлсэн гэж мэдээлжээ. ^б
Зүүн Тимор /1999/	288 эмэгтэйн дунд явуулсан олон нийтийн судалгаа	Эмэгтэйчүүдийн 24 хувь нь 1999 оны хямралын үед хүчирхийллийг хэрхэн гэрчилсэн тухай, өгүүлсний 96 хувь нь бэлгийн хүчирхийлэл, 92 хувь нь зэвсгээр айлган сүрдүүлж байгааг харсан гэжээ. ^в
Сиер Леон /1991-1999/	2001 онд дүрвэгсдийн 3 хуаран, 1 хотод олон нийтийн дунд хийсэн судалгаа 9.16 в гэр бүлийнхнээ төлөөлж 991 эмэгтэй мэдээлэл өгсөн	13 хувь буюу 1157 хүн дайнтай холбоотойгоор хүний эрх зөрчигдөж байгаа талаар, судалгаанд хамрагдагсдын 9 хувь, эмэгтэйчүүдийн 8 хувь нь зэвсэгт мөргөлдөөний үеэр гарч байгаа бэлгийн хүчирхийллийн талаар мэдээлжээ. ^г

^а С.Женнингс, П.Ж.Афис, Ж.В.Лиөрийн “Иргэний дайны үед эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл” Америкийн Эрүүл мэндийн холбоо / 279-р цуврал, дугаар 8 /1998 оны 2-р сар/ 625-629-р хуудас

^б В.Жиллерж, Бракен.П, Кабаганда.С “Угандын дайн ба хүчингийн хэрэг”, Лансет 337-р цуврал, дугаар 604 /1991 оны 7-р сар/

^в Хайнес.М, Уордж, Робертсон. К, Кроуз.С “Зүүн Тиморын зөрчлөөс шалтгаалан жондорт суурилсан хүчирхийлэл нэмэгдсэн талаар тодруулга”, “Гамшигууд” цуврал 28, дугаар 3, 2004 оны9 дүгээо сар, 294-321-р хуудас

^г Амовитз, Акинсулуре.Смит, “Сиер-Леоны дайн байлдааны зөрчилөөс үүдсэн хүний эрхийн зөрчил, бэлгийн хүчирхийлэл”, Америкийн Эрүүл мэндийн Холбооны сэтгүүл, цуврал 287, дугаар 4, /2002 оны 1-р сар /513-521-р хуудас/

5. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл ба бүх хэлбэрээр ялгаварлан гадуурхах

147. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн хэлбэрүүд нь нийгэм, соёлын хэм хэмжээ, эдийн засаг, улс төр, нийгмийн байгууллын тогтвортой байдлаас шалтгаалдаг. Эмэгтэйчүүдийн арьсны өнгө, үндэс угсаа, нийгмийн давхрага, анги, цагаач дүрвэгч байх, нас, шашин, бэлгийн чиг баримжаа, гэр бүлийн байдал, хөгжлийн бэрхшээл, ДОХ-оор халдварласан эсэх гээд маш олон хүчин зүйлүүдээс хамааран аль хэлбэрийн хүчирхийлэлд илүү өртөх эрсдэлтэй болох нь тодорхойлогдоно.

148. Зарим оронд тухайн тодорхой угсаатан, үндэстний бүлэгт харьяалагддаг эмэгтэйчүүд жендерт суурилсан хүчирхийлэл, арьс өнгөнөөсөө шалтгаалан хүчирхийлэлд өртдөг. Үндэстний цөөнхийн эмэгтэйчүүд бэлгийн хамтрагчийн зүгээс учруулдаг дарамт, цагдан хорихын хүчирхийллүүд, амь насаа алдах хүртэл олон төрлийн хүчирхийлэлд өртдөг нь үндэстний цөөнх биш эмэгтэйчүүдэд тохиолддоогоос илүү өндөр үзүүлэлттэй байдаг. 1996 оны Канадын Засгийн газрын статистик мэдээгээр адил насны эмэгтэйчүүдээсээ үндэстний цөөнхийн 25-44 насны эмэгтэйчүүд хүчирхийллээс болж нас барах нь илүү байна гэж дүгнэжээ. АНУ-д 1999 оны судалгаагаар үндэстний цөөнх эмэгтэйчүүд цагаан арьстан эмэгтэйчүүдээс 2 дахин илүү хүчирхийллийн гэмт хэргийн хохирогч болдогийг тогтоожээ.

2003 онд Австралийн уугуул үндэстэнд зодуулснаас гэмтэн бэртэж эмнэлэгт хүргэгдсэн тохиолдол үндэстний цөөнх биш эмэгтэйчүүдээс 28 дахин илүү байгааг олж тогтоосон.

149. Энэтхэгт нийгмийн анги давхрагын ялгаан дээр суурилсан буюу дээд давхаргын эрэгтэйчүүдийн зүгээс доод давхрагын эмэгтэйчүүдэд учруулсан хүчирхийллийн хэрэг хамгийн өндөр үзүүлэлттэй байдаг. Зарим алслагдсан бөглүү тосгонд бэлгийн харьцаанд орж байгаагүй охидын биед хүрэх нь тосгоны эзний эрх мэдлийн хэрэг байдаг ажээ.

150. Дэлхийн хүн амын томоохон хувийг эзэлж байгаа ахмад хүмүүсийн дотор ахмад насны эмэгтэйчүүд хүчирхийлэлд өртөх тохиолдол их байдаг. 60-65 насны, заримдаа 50-иас дээш насны эмэгтэйчүүдийн эрх зөрчигдөх явдал элбэг байдаг. Ахмад насны эмэгтэйчүүд бие махбодийн, бэлгийн, сэтгэл санааны дарамтанд орох, гэр бүлийн гишүүд, бусад асран хамгаалагчид нь үл хайхрах, эдийн засгийн хувьд хавчих зэргээр эрхийг нь зөрчдөг байна.

151. Эмэгтэйчүүд бэлгийн чиг баримжаанаасаа болж нийгмийн хандлага сэтгэхүйтэй холбоотойгоор янз бүрийн хүчирхийлэлд өртдөг. Бэлгийн чиг баримжаанаас нь буюу лесби (ижил хүйстэнтэйгээ бэлгийн харьцаанд орох) эмэгтэйчүүдэд учруулдаг бэлгийн хүчирхийллийн хэлбэрүүдэд бэлгийн хамтрагч бус хүмүүсийн бэлгийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөг, хүчээр гэрлүүлэх, амь насыг нь хороох зэрэг багтана. Жишээ нь: АНУ-д лесби эмэгтэйчүүд хорих газарт хүчингийн хэргийн золиос болох, цагдаа, гэр бүлийнхэн, олон нийтийн хүчирхийлэлд өртдөг. Лесби эмэгтэйчүүдийн дунд зодуулсан, хүсэл бодлыг нь үл харгалзан гэрлүүлсэн гэх мэт олон тооны хэргийн баримтууд байдаг. Мөн бэлгийн чиг баримжаанаас нь болж зарим лесби эмэгтэйчүүдийг сэтгэцийн эмнэлэгт албадан эмчилдэг.

152. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд гэртээ, ажлын байрандаа гэр бүлийн бусад гишүүд, асран хамгаалагчид, эсхүл үл таних хүмүүсээс учруулдаг дарамтад ихээр өртдөг. Европ, Хойд Америк, Австралид хийсэн судалгаагаар хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн хоёрны нэг нь жирийн эмэгтэйчүүдийн гуравны нэгтэй харьцуулахад илүү их бие махбодийн хүчирхийлэлд өртдөг байна.

153. Олон улсын цагаачдын бараг хагас хувийг эзэлдэг эмэгтэйчүүдээс 90 сая нь эх орноосоо хол харийн оронд ажиллаж амьдарч байна. Нэг талаар цагаач, бас эмэгтэй хүн болохын хувьд тэд үргэлж 2 дугаар зэргийн хүмүүст тооцогдон гадуурхагдаж аливаа дарамт, хүчирхийлэлд өртөх эрсдэл ихтэй байдаг. Цагаач эмэгтэйчүүдэд учруулдаг дарамт, хүчирхийлэлд олон цагаар хүнд хүчир ажил хийлгэх, цалин хөлсийг нь өгөхгүй ажилуулж хөдөлмөрийг нь мөлжих, өлсөх, цангах, зодуулах тэр ч бүү хэл хүчингийн золиос болох эсхүл албадан биеийг нь үнэлүүлэх зэрэг болно. Туршлага, ур чадвар доогуур ажилчид ихэвчлэн үйлчилгээний салбарт ажилладаг бөгөөд бусад эмэгтэйчүүдтэйгээ харьцуулахад илүү их, олон төрлийн хэлбэрийн хүчирхийлэлд өртдөг. Цагаач эмэгтэйчүүд бэлгийн хамтрагчийнхаа хүчирхийлэлд өртөх явдал ч элбэг байдаг. Учир нь цагаачилж, хууль бус амьдарч байгаагаасаа болоод тэдний боломж хязгаарлагдмал, мэдээлэл өгч, тусламж эрж чаддаггүй.

154. НҮБ-ын Хүний Эрхийн Комиссын анхаарлын төвд байгаа 10.9 сая хүн байгаагийн бараг хагас нь буюу 49 хувь нь эмэгтэйчүүд байна. Тэд орон гэр, асран хамгаалагчгүй байдлаасаа шалтгаалан олон хэлбэрийн хүчирхийлэл, дарамт, дайралтанд өртөх эрсдэлтэй байдаг. Үүнд: дүрвэгсдийн суурин, түр орогнож байгаа газартаа цэрэг армийн офицерууд, хилийн хамгаалалтынхан, эрэгтэй дүрвэгчид гэх мэт хүмүүсийн зүгээс үйлддэг бэлгийн хүчирхийллийн золиос болох явдал их байна.

6. Анхаарах шаардлагатай асуудлууд

155. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн ихэнх хэлбэрүүд ихээхэн анхаарал татаж байхад зарим нь огт хайхрагдахгүй анхаарлын гадуур орхигдох тохиолдол бий. Сэтгэл санааны хүчирхийлэл үйлдэгдэж буй нь тодорхой байдаг ч өөр ямар хэлбэрүүдээр илэрч буйг бид тэр бүр анзаардаггүй. Эмэгтэйчүүдийг гэр оронд нь цоожлох, найз нөхөд, бусад хүмүүстэй уулзуулахгүй тусгаарлах зэрэг үйлдлүүд бараг илэрдэггүй.

Сургууль, эмнэлэг, хорих газруудад эмэгтэйчүүдийн эсрэг гарч байгаа хүчирхийлэл бас л илрэхгүй үлдсээр байна. Эдийн засгийн мөлжлөгийн нэг хэлбэр болох цалин хөлсийг нь цаг тухайд нь олгохгүй удаах, тэднийг цалин хүчээр авах, амьдралын наад захын хэрэгцээгээ хангах боломжийг нь хязгаарлах зэрэг нь ихээхэн анхаарал шаардаж байгаа асуудлууд юм. Улам бүр нэмэгдэж байгаа хүн ам зүйн өөрчлөлтийг дагаад ахмад насны эмэгтэйчүүдийг дарамтлан мөлжих хандлага нэмэгдлээ.

Эмэгтэйчүүдийн амийг хороох хэрэг газар авч байгаа нь анхаарлын төвд байгаа ч ийм төрлийн хэргүүд ихэвчлэн жендерт суурилсан байдгийг тэр бүр анхаарахгүй хэвээр байна. Хүчирхийллийн шинээр бий болон бэхжиж байгаа олон төрлүүдэд компьютер, гар утас зэрэг техник технологийн дэвшлийг өргөн хэрэглэх боллоо. Ийнхүү шинээр гарч ирж байгаа хүчирхийллийн хэлбэрүүдэд тохирох нэр оноох шаардлага ч гарч байна.

В. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн үр дагавар

156. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл нь тэдний эрхийг зэрлэг балмадаар зөрчин, амьд явах, амь насаа хамгаалуулах, бие сэтгэл санааны хувьд эрүүл явах, боловсрох, ажил, орон байртай байх, нийгэм олон нийтийн үйл хэрэгт оролцох зэрэг үндсэн эрх чөлөөг нь бүдүүлгээр зөрчиж байна.

Ийм хүчирхийлэлд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн эрх мэдлийн хувьд тэгш бус байдал, ихэнхдээ хараат байдалтай байх явдал нь нөлөөлж байна. Үүнээс болж эмэгтэйчүүдийн эрүүл мэнд, сайн сайхан амьдрахад ноцтой хохирол учирч, эдийн засгийн зардал чирэгдэл их учруулж байна.

1. Эрүүл мэндэд учруулж буй үр дагавар

157. Хүчирхийлэл нь эмэгтэйчүүдийн биеийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндэд хортойгоор нөлөөлж байна. Хүчирхийллийн дарамтанд орсон эмэгтэйчүүдийн сэтгэл санааны эрүүл мэндийн байдал, нийгмийн үйл хэрэгт оролцох оролцоо мууддаг. Хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн ихэнх нь архи, мансууруулах бодисыг ихээр хэрэглэх, амиа хорлохоор завдах болон гэмтлийн дараах стресст орох, төв мэдрэлийн системийн өвчтэй болоход хүргэж байна.

158. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл нь ихэнхдээ үхэлд хүргэдэг. Эмэгтэйчүүдийн амийг хорлох, ДОХ-той холбоотой үхэл, төрөлтийн хүндрэлээс нас барах зэрэг нь ихэнхдээ эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс шалтгаалсан байдаг. ДОХ-ын халдвар, төрөлтийн хүндрэлээс нас барах нь хүчирхийлэлтэй шууд холбоотойг нотлох хангалттай мэдээлэл тэр бүр байдаггүй. Харин хэд хэдэн эмнэлгээс авсан судалгааны баримтад бэлгийн хамтрагчийн хүчирхийлэл, жирэмсэн үеийн нас баралт хоёрын хооронд шууд хамаарал байгааг нотолжээ. Жишээ нь: Баруун Энэтхэгийн 400 тосгон 7 эмнэлэгт явуулсан судалгаагаар жирэмсэн эмэгтэйчүүдийн 16 хувь нь хамтран амьдрагчийнхаа учруулсан хүчирхийллээс болж амь насаа алдсан байжээ. Үүнтэй адил тохиолдлууд АНУ, Бангладеш зэрэг орнуудад бас олон гарсан байдаг.

159. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс болж эмэгтэйчүүдийн бие махбодийн эрүүл мэндэд ноцтой хохирол учирдаг. Үүнд бие эрхтэн гэмтэх, гэдэс хэвлийн гэмтэл авах, ходоод гэдэсний архаг өвчтэй болоход хүргэдэг. Нөхөн үржихүйн эрүүл мэндэд учруулах уршгаас дурдвал: эмэгтэйчүүдийн өвчин, ДОХ, БЗХӨ, хүсээгүй жирэмслэлт, эмэгтэйчүүдийн өвчний хүндрэлүүдэд умайн хавдар, умайн цус алдалт, шээс бэлгийн замын өвчнүүд орно. АНУ-д хийсэн судалгаагаар хамтран амьдрагчийнхаа хүчирхийллийн хохирогч болсон эмэгтэйчүүд эмэгтэйчүүдийн өвчнөөр их өвчилдэг болохыг олж тодорхойлжээ.

160. Өнөөдөр дэлхий дээр олон мянган эмэгтэйчүүд ДОХ-ын халдвар авах эрсдэлтэй байна. Хүчирхийллээс айж эмээсэн эмэгтэйчүүд ДОХ-ын талаар мэдээлэл авах, шинжилгээ өгөхөөс айх, ДОХ-оор халдварласнаа нуух, ДОХ-ын халдвар нялх хүүхдэд халдахаас урьдчилан сэргийлэх зөвлөгөө авахаас үргэлж эмээж явдаг. Судалгаагаар ДОХ ба эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл хоёр хоорондоо харилцан холбоотой болох нь улам бүр нэмэгдэж байна. Учир нь ДОХ-ын халдвар авсан эмэгтэйчүүд хүчирхийллийн дарамтанд ихээр өртдөг. Нөгөө талаас хүчирхийллийн хохирогч болсон эмэгтэйчүүд ДОХ-ын халдвар авах өндөр эрсдэлд байдагтай холбоотой.

161. Хүсээгүй жирэмслэлт бол бэлгийн хүчирхийллийн бас нэг үр дагавар юм. Хүсээгүй жирэмслэлтийн эрсдэл нэмэгдэхэд хүчингийн хэрэг их нөлөөлдөг. Зэвсэгт мөргөлдөөний нөхцөлд байгаа орнуудад, жишээлбэл: Босни, Герцоговинд, Руандад эмэгтэйчүүдийг хүчээр жирэмслүүлэхийн тулд удаа дараа хүчирхийлж байсан нь үндэстнийг цэвэрлэх бодлогын нэг хэсэг байсан. Эмэгтэйчүүд нөхөр, хамтран амьдрагчийнхаа хүчирхийллээс айж эмээснээс болоод жирэмслэлтээс урьдчилан сэргийлэх арга хэрэглэж чаддаггүйн улмаас энэ нь хүсээгүй жирэмслэлтэд хүргэдэг байна. Колумбид явуулсан судалгаагаар хамтран амьдрагчийнхаа бэлгийн хүчирхийлэлд автсан эмэгтэйчүүд хүсээгүй жирэмслэх эрсдэл өндөртэй байдгийг тогтоожээ. Хүсээгүй жирэмслэлтээс болж баталгаагүй аюултай нөхцөлд үр хөндүүлэх, амиа хорлох, гэр бүлийнхээ гишүүд, ажлын хамт олноос нь дарамт учруулж нийгмээс тусгаарлах, тэр ч бүү хэл амь насыг нь хороох явдал гардаг.

162. Жирэмслэлтийн өмнө ба жирэмслэлтийн үеэр эмэгтэйчүүдэд учруулсан хүчирхийлэл эх хүүхдийн аль алиных нь эрүүл мэндэд ноцтой хохирол учруулдаг.

Жирэмсэн үеийн хүчирхийлэл нь ураг буруу хөгжих, зулбах, эсхүл дутуу төрөх, хүүхэд тураалтай гарах зэрэг олон хүндрэлүүдийг араасаа дагуулдаг. 2002 онд Никарагуад явуулсан судалгааны дүнгээс үзэхэд тураалтай хүүхэд төрж байгаа нь жирэмсний үед хамтран амьдрагчийн зүгээс учруулсан бие махбодийн дарамттай холбоотой болох нь тогтоогджээ.

163. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл нь тэдний бие, нөхөн үржихүйн эрүүл мэндийн аль алинд ноцтой хохирол учруулдаг. Үндэстэн дамнан худалдаалагдсан эмэгтэйчүүдэд архаг өвчин, хоол тэжээлийн дутагдал, эрүүл бус хооллолтоос шалтгаалан турах зэрэг эрүүл мэндийн асуудлууд тохиолддог. Мөн бэлгийн замын халдварт өвчин, бэлэг эрхтнийг нь зэрэмдэглэх, эх орон гэр бүлээсээ хол, хүчинд автсанаас байнгын сэтгэл санааны дарамттай амьдардаг. Эмэгтэй хүний бэлэг эрхтнийг зэрэмдэглэх нь ухаан алдах, хүчтэй өвдөх, идээт үрэвсэл, халдвар, хавдарт хүргэх ноцтой хүнд хэлбэрийн гэмтэл юм. Идээт үрэвсэл, халдвар үхэлд ч хүргэдэг. Мөн эх, нялхсын эндэгдэлийн эрсдлийг нэмэгдүүлэх, үргүйдүүлэх, сэтгэл зүйн хүнд дарамтанд оруулах хор уршигтай. Эмэгтэйчүүдийн бэлэг эрхтнийг зэрэмдэглэх нь эмэгтэйчүүд ДОХ-ын халдвар авах эрсдлийг нэмэгдүүлдэг.

164. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, тэдний сэтгэл санаанд учруулах хохирол нь бие махбодид учруулах дарамтын адил ноцтой байдаг. Депрес буюу сэтгэл санааны гүн хямрал нь эмэгтэйчүүдийн эсрэг бие махбодийн хүчирхийллийн улмаас гардаг уршиг юм. Хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд стресс, сэтгэл зовнилын өвчин, гэмтлийн дараах стресс, сэтгэл мэдрэлийн өвчин тусдаг. АНУ-ын Мичиган мужид явуулсан судалгаагаар жирийн эмэгтэйчүүдтэй харьцуулахад жилийн өмнө хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн 59 хувь нь сэтгэл санааны дарамтанд орсон байхыг олж тогтоосон. Бусад олон судалгаагаар хүчингийн хэрэг хүүхдийг бэлгийн дарамтанд оруулах, хамтран амьдрагчийн зүгээс учруулдаг хүчирхийлэл зэрэг нь эмэгтэйчүүдийн сэтгэл санааны хямралын үндсэн шалтгаан болдог. Судлаачид хүчирхийллийн золиос болсон хүний гэмтлийн синдромд айдас, депресс, тэр ч бүү хэл амиа хорлох явдлуудыг оруулж тооцжээ.

165. Сэтгэлийн гүн хямралд орох, амиа хорлохоор завдах нь хамтран амьдрагчийн хүчирхийлэлтэй салшгүй холбоотой. Мөн хүчингийн хэргийн золиос болсон, бэлгийн дарамтанд орсон охид бүсгүйчүүд амиа хорлох эрсдэл ихтэй байдаг. Гэмтлийн дараах стресс, сэтгэл санааны хямрал нь амиа хорлох явдлын гол хүчин зүйл болдог .

2. Нийгмийн болон шинэ, хуучин үеийн харилцаанд нөлөөлөх нь

166. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл нь нийгэм, эдийн засгийн амьдралд оролцоход нь тэдэнд саад болдог. Хүчирхийлэлд өртдөг эмэгтэйчүүдийн ихэнх нь ажилгүй эсхүл доогуур албан тушаалын ажилтай байх нь их байдаг. Үзэл бодолтой өөр нийгмийн тодорхой хүрээлэлд ажилладаг эмэгтэйчүүд бэлгийн хүчирхийлэлд орох магадлал ихтэй байдаг. Жишээ нь: Шри Ланкад удаан хугацаанд үргэлжилсэн зөрчил эцэст нь эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог хязгаарлан нэг төрлийн хүчирхийллийг бий болгожээ. Мексикт явуулсан судалгаагаар эрэгтэйчүүдийн заналхийлэл, дарамтаас болоод эмэгтэйчүүд нийгмийн үйл хэрэгт оролцохоо больсон болохыг тогтоосон.

167. Эмэгтэйчүүдийг хил дамнуулан худалдах хэргийн хорт үр дагавруудад эх хүүхдийг салгах, мэдлэг боловсрол олж авах боломжийг хязгаарлах, эмэгтэйчүүд ядуурч туйлдсанаас нийгмийн хамгааллын урт хугацааны дэмжлэг шаардах, гэмт хэрэг өсөхөд хүргэдэг.

168. Судалгааны дүнгээс үзэхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл,

нийгмийн хүчирхийлэл 2 хоорондоо салшгүй холбоотой. Гэр бүлийн хүчирхийлэл дунд байсан хүн цаашдаа нийгмийн харилцаанд орохдоо хүчирхийлэгч, дарангуйлагч болдог ажээ.

169. Гэр бүлийн хүчирхийлэл дунд өссөн хүүхдийн ааш авир нь төлөвшихөд ихээхэн бэрхшээл тулгарна. Судалгаагаар гэр бүлийн хүчирхийлэл хүүхдэд муугаар нөлөөлөх 3 хэлбэр байдаг. 1/ эрүүл мэндийн, 2/ сурлагын 3/ хүмүүжлийн. Гэр бүлийн хүчирхийлэлтэй орчинд өссөн хүүхэд аймхай, нийгэм хамт олны эсрэг хандлагатай байдаг. Мөн бусад хүүхэдтэй харьцуулахад сэтгэл санааны хямралд орсон, ууртай, цухалдуу, хэцүү зан авиртай болдог. Түүнчлэн тэд зэрлэг, балмад авир гаргаж эхэлдэг. Байнгын хүчирхийлэлтэй орчинд өссөн хүүхдүүдийн оюуны хөгжил саардаг учраас сурлагаар байнга хоцордог. Никарагуад явуулсан судалгаагаар хүчирхийллийн хохирогч охидууд жирийн хүүхдүүдтэй харьцуулахад 4 жилийн өмнө сургуулиас завсардах нь олонтаа тохиолддог болох нь ажиглагджээ. Түүгээр ч барахгүй хүчирхийлэл дарамтыг амсаж, мэдэрч өссөн хүүхдүүд ихэнхдээ энэ хүчирхийллийн зан авирыг өвлөн авч, өөрсдөө хүчирхийлэл үйлдэгч болж өсөх нь элбэг байдаг. Гэхдээ хүүхэд бүхэн хүчирхийлэгч болдоггүй гэдгийг анхаарах хэрэгтэй.

170. Эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн болон хамтран амьдрагчийн зүгээс учруулдаг хүчирхийлэл хүүхдийн амь насанд ч заналхийлэх тохиолдол бий. Никарагуад явуулсан судалгаагаар хамтран амьдрагчийнхаа зүгээс хүчирхийлэлд өртдөг эмэгтэйчүүдийн хүүхдүүд голдуу 5 хүрэлгүй нас бардаг болох нь ажиглагджээ.

Г. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн эдийн засгийн өртөг

171. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн улмаас эмэгтэйчүүд, хүүхдүүд, гэр бүл, цаашлаад нийгэм, улс үндэстнийг ядууралд хүргэх аюултай. Учир нь хүчирхийллийн хохирогч болсон хүмүүсийн зүгээс гэр бүл, нийгэм, эдийн засаг, улс орны амьдралд оруулах хувь нэмэр, хөдөлмөрийн бүтээмж буурч улмаар нийгмийн халамж үйлчилгээ, шүүх цагдаа, эрүүл мэндийн байгууллагуудын оролцоог нэмэгдүүлнэ. Тэдний мэдлэг боловсрол, бүтээлч шинийг санаачлах идэвх буурах төдийгүй тэдний үр хүүхдүүд ч тэдэнтэй адил байдалд ордог.

172. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн эдийн засагт учруулах хор уршиг, өртөг зардалд дүн шинжилгээ хийх нь энэ асуудлын хор нөлөө, нийгэмд учруулах сөрөг үр дагаврыг ойлгоход тусална. Хүчирхийллийн хор нөлөөг ойлгосноор энэ нь ганц нэг хувь хүний асуудал бус харин нийгэм, олон нийтийн эмзэг асуудал болохыг ухамсарлаж ойлгоход тус дөхөм болно. Ийнхүү дүн шинжилгээ хийснээр эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажилд хангалттай хөрөнгө, нөөцийг улсын төсөвт тусгахад чухал нөлөө үзүүлнэ. Хүчирхийллийг гарсан хойно нь бус харин гарахаас нь өмнө урьдчилан сэргийлэхийн төлөө аль болохоор зохих хөрөнгийг зарцуулан тэмцэх нь хүчирхийллийн үйлдэгдсэн хойно нь арга хэмжээ авснаас хавьгүй илүү болох нь тодорхой.

173. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэхэд гарах хэд хэдэн төрлийн зардал багтдаг. Үүнд: 1/ эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэхтэй холбоотой үйл ажиллагааны шууд зардал

2/ ажлаас гарах, хөдөлмөрийн бүтээмж буурахаас үүдсэн шууд бус зардал

3/ хүмүүст учрах өвчин, түүнээс үүдэх зардал орно.

174. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй холбоотой гарах шууд зардалд хувь хүмүүсээс гарч байгаа бодит зардлууд ч бас орно. Хүчирхийллийн хохирогчдод засгийн газар, бизнес, нийгмийн халамж үйлчилгээний байгууллагаас анхаарал

тавьж хүчирхийлэл үйлдэгчийг хууль шүүхийн байгууллагад шилжүүлэхэд дэмжлэг үзүүлдэг. Үүнд: шүүх цагдаа хуулийн /шүүх, прокурор, хорих газар, ял шийтгэл оногдуулах, хохирогчийг хамгаалах/, эрүүл мэндийн /эмнэлгийн анхан шатны яаралтай тусламж үзүүлэх, бие, сэтгэл санааны хохирлыг эмчлэх/ түр хамгаалах байраар хангах /нийгмийн үйлчилгээ/ ялангуяа хүүхдийг асран хамгаалахад/, санхүүгийн болон бусад тусламж үйлчилгээ /бэлгийн/хүчингийн хэргээс учирсан хохирлыг арилгахад туслах, зөвлөгөө өгөх утас ажиллуулах/, иргэний, хуулийн үйлчилгээний зардлуудыг төлөх /хүчирхийлэл үйлдэгчийг гэр орноос тусгаарлах, гэр бул цуцлуулахад гарах зардлуудыг төлөх/ гэх мэт.

175. Эдгээр үйлчилгээний зардлыг төр олон нийтийн байгууллагууд хариуцдаг. Шүүх, цагдаа, хуулийн байгууллагын зардлыг бараг бүх оронд төр хариуцдаг. Харин зарим орнуудад халамжийн үйлчилгээ, дүрвэгсдийн асуудалтай холбоотой зардлыг сайн дурынхан эсхүл олон нийтийн байгууллагууд хариуцдаг. Зарим орны төр олон, нийтийн байгууллагууд нь шууд эсхүл төрийн сангаар дамжүүлэн санхүүжүүлдэг. Эрүүл мэндийн халамж үйлчилгээг төрөөс шууд хариуцах буюу хувь хүний даатгалаас төлдөг.

176. Зардалтай холбоотой 2 дахь хэлбэр нь ажлын бүтээмж буурах ажил таслах, ажлаас гарахаас үүдэлтэй. Эмэгтэйчүүд гэмтэл бэртэл авах, сэтгэл санааны дарамтаас болоод ажлаа хийж чадахгүй болох буюу ажлын үр дүн, бүтээмж нь буурдаг. Цаашлаад ажлын бүтээмж буурсан, олон удаа ажил тасалсанаас болж эмэгтэйг ажлаас халагддаг. Ажилтан, ажил олгогч ч хохирол амсана. Эмэгтэйчүүд ажил орлогүй болдог бол харин ажил олгогч тэдний өвчтэй чөлөөтэй байсан үеийн алдалдал амсдаг.

177. 3 дахь хэлбэр нь хохирогчдын амсах гарз хохиролтой холбоотой гардаг зардлууд юм. Энэ нь засгийн газраас зардал ашгийн дүн шинжилгээ хийхдээ аливаа үйлдлийн учруулсан “гарз хохирлын” үнэлгээг оруулах болсонтой холбоотой. Жишээ нь: замын шинэ төсөл боловсруулах үед автын осол, гэмт хэргийн улмаас учирсан хор уршиг зардал, гэмт хэрэгтэй холбоотой гарах үр дагаврыг тооцоходоо гэх зэргээр уг зардлыг авч үзэж байна.

178. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн улмаас гарах зардлыг тооцоход хэцүү байдаг. Ийм зардал хохирлын нэг нь хүчирхийллийн гэрч болсон хүүхдийн сэтгэл санаанд учирсан хохирлыг арилгах сэтгэл зүйч, сэтгэл засалчдад төлөх зардал, сурлагаар хоцорсны улмаас гарах урт хугацааны зардлууд орно.

179. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн улмаас гарах зардлуудыг тодорхой хэлбэрүүдэд хувааж үздэг. Зардлаас гадна алдагдсан орлогын тооцоо, “зовлон зүдгүүрийн” зардлыг сүүлийн үед оруулах болсон. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн улмаас гарах зардлын судалгааг анх 1988 онд Австралид хийсэн. Судалгааны ихэнхийг хөгжиж буй орнуудад явуулсан. Шинэ судалгааг Болгар, Фижи, Өмнөд Африк, Угандад явуулж байгаа. 1994 оноос ДБ гэр бүлийн хүчирхийллийн зардлыг тооцсон.

180. Эдгээр судалгаанд хамрагдсан зардлууд арга зүйн хувьд өөр өөр байдгаас ялгаатай байдаг. Канадад эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй холбоотой гарсан жилийн дундаж шууд зардлыг тооцоход 684 сая доллар шүүхэд, 187 сая нь цагдаад, 294 саяыг сургалт, зөвлөлгөөнд, нийтдээ 1 тэрбум доллар зарцуулжээ. Их Британи Умард Ирландын Нэгдсэн вант Улсад хууль, эрүүл мэнд, нийгмийн халамж, орон байр, алдагдсан орлого болон бусад зардлуудыг нь тооцоход 23 тэрбум фунтстерлинг буюу нэг хүнд 440 фунт стерлинг ноогдох хэмжээний зардал гаргажээ. 1998 онд Финляндад

эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн асуудалтай холбоотой зардлыг тооцож үзэхэд нийтдээ 101 сая буюу нэг хүнд ойролцоогоор 20 евро ноогдох хэмжээний зардал гарчээ. Дэлхийн банкны судалгаагаар гэр бүлийн хүчирхийлэл ба хүчингийн хэрэг нь хөгжиж буй орнуудын 15-45 насны эмэгтэйчүүдийн нийт өвчлөлтийн 5 хувь, хөгжингүй орнуудын эмэгтэйчүүдийн 19 хувийг эзэлж байна гэсэн тооцоо гарчээ.

181. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн зардал асар өндөр байна. Энэ нь зөвхөн хувь хүмүүст төдийгүй гэр бүл, нийгэм, улсад ихээхэн хохирол учруулж эдийн засгийн хөгжлийг сааруулж байна. Судалгааг хэдийгээр өргөн хүрээнд хийсэн ч зарим нэг зардал гүйцэд тооцогдохгүй байгаа нь тодорхой. Гэлээ ч энэ бүхэн эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл эдийн засагт ноцтой хохирол учруулдагыг харуулж, түүнээс урьдчилан сэргийлэх байнгын арга хэмжээ авч байх шаардлагатай болохыг харуулж байна.

V. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаар мэдээлэл цуглуулах нь

A. Оршил

182. Эмэгтэйчүүдийн эсрэг янз бүрийн хэлбэрийн хүчирхийлэл, ялангуяа хамтран амьдрагчийн зүгээс үйлдсэн хүчирхийллийн талаар хийгдсэн судалгааны тоо 1990-ээд оны 2 дугаар хагасаас нилээд хэмжээгээр нэмэгдсэн. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаар судалгаа 71 оронд нэгээс доошгүй удаа явагдсан бол, 41 улсад үндэсний хэмжээний судалгаа нэгээс доошгүй удаа хийгдсэнийг 2006 оны НҮБ-ын тайланд дурдсан байна.

183. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаарх судалгааг төрийн яамд, статистикийн газрууд, их дээд сургуулиуд, төрийн агентлаг, ТББ, эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах гэх мэт олон төрлийн байгууллагууд хийсэн байна. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл нь дэлхий нийтээр хүний эрхийн зөрчлийн ноцтой, нийтлэг шинжийг олж буй хэлбэр бөгөөд үүний үр дүнд эмэгтэйчүүд, хүүхдийн эрүүл мэнд, сайн сайхан оршихуйд маш их хор уршиг тарьж байдгийг эдгээр судалгаа баримтаар тогтоосон.

184. Бодлого, стратегийг боловсруулахын тулд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрийн талаар баримт, ойлголттой болох ажил сүүлийн жилүүдэд нилээд урагштай байгаа боловч энэ талаар хийх ажил их байна. Олон улс оронд энэ чиглэлийн найдвартай мэдээ, мэдээлэл байхгүй тул тэдгээрийг харьцуулж дүгнэлт гаргах судлахад хангалтгүй байна. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаар цаашид цаг хугацааны туршид шинэчлэн нэгтгэх боломжтой мэдээ, мэдээллийг тогтмол цуглуулж байгаа цөөхөн улс орон байдаг. Хүчирхийллийн олон хэлбэрүүд нийгэм дэх эмэгтэйчүүдийн өөр өөр бүлгүүдэд ямар сөрөг нөлөөлөл үзүүлж байдгийг тогтоохын тулд илүү их мэдээ, мэдээлэл яаралтай цуглуулах, тэдгээрийг нас, үндэстэн ястны гэх мэт бүлгээр нь задлан ангилж үзэх шаардлагатай. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх талаар авч байгаа арга хэмжээ, түүний үр дүнгийн талаар мэдээлэл хомс байна.

185. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаар олон улсын хэмжээнд тогтсон шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулахыг бодлого боловсруулагчид, хүний эрхийн хөдөлгөөний идэвхитнүүд ч уриалж байна. Олон улсын ийм шалгуур үзүүлэлтүүд нь улс орнуудын түвшинд хүчирхийллийг тодорхойлж, хэмжих харьцуулсан арга барилыг ашиглан цуглуулсан, нийтлэг ашиглах боломжтой найдвартай мэдээ,

мэдээлэл дээр үндэслэж гарна.

186. Үндэсний түвшний бодлого, хөтөлбөрт зориулсан удирдамж гаргах, хүчирхийллийн эсрэг үйл ажиллагаанд улс орнуудын гаргаж байгаа ахиц, дэвшилд хяналт тавихын тулд илүү их, чанартай мэдээ мэдээлэл чухал. Мэдээ, мэдээллийг цуглуулах замаар хангалттай мэдлэгийн санг бий болгох нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх талаар улс орнуудын хүлээсэн үүргийн нэг хэсэг юм. Төрөөс албан ёсны статистикийн хүрээнд ТББ, эрдэмтэд, оролцогч бусад талуудтай хамтран системтэйгээр мэдээ, мэдээлэл цуглуулах тэдгээрийг олон нийтэд хүргэж байх үүрэг хүлээх нь зүйтэй.

Мэдээ, мэдээлэл хангалтгүй, олдохгүй байна гээд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, түүнийг устгах талаар төрийн хүлээсэн үүрэг хариуцлага багасах учиргүй.

Б. Хүн амд тулгуурласан судалгаанууд

1. Хүн амд тулгуурласан судалгааны тодорхойлолт

187. Хүчирхийллийн талаарх эмэгтэйчүүдийн өөрсдөд нь тохиолдсон зовлон бэрхшээлийг судалдаг хүн амын дундах буюу өрхийн судалгаа нь хүн амын дунд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаар мэдээлэл олж авах хамгийн сайн арга гэж үздэг. Хүн амын дундах судалгааг тохиолдлын, түүвэрлэсэн хүмүүсээс авдаг учир ийм судалгааны үр дүн нь томоохон бүлэг хүмүүсийн дундах бодит байдлын төлөөлөл болж чаддаг. Хүн амын дундах судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүд хуулийн байгууллагад мэдээлээгүй, өөрсдөдөө тохиолдсон хүчирхийллийн талаар хариулт өгдөг учир ийм судалгаа нь төрийн байгууллагад байгаа мэдээллээс ч илүү нарийн бодит байдлыг тусгаж чаддаг. Иймд энэ төрлийн судалгаа нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн бодит нөхцөл байдлыг тогтоох, цаашдын хандлагыг тодорхойлох, олон нийтэд мэдлэг олгох, бодлого боловсруулахад чухал шаардлагатай. Өөр улс орнуудад явж буй судалгаа хүчирхийллийн нөхцөл байдлыг тодорхойлох ойролцоо арга барилыг хэрэглэвэл эмэгтэйчүүдэд тулгарч байдаг хүчирхийллийн нийтлэг эрсдлүүдийг харьцуулан үзэх, өөр орчин дахь адил төстэй болон ялгаатай талуудыг ойлгож мэдэхэд тустай.

188. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаар хүн амд суурилсан мэдээлэл цуглуулах 2 гол аргачлал байдаг. Эхнийх нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн янз бүрийн хэлбэрүүдийн талаар нарийвчилсан мэдээлэл цуглуулах “тусгай” судалгаа. Нөгөө нь ядуурал, гэмт хэрэг, нөхөн үржихүйн эрүүл мэнд гэх мэт өргөн хүрээтэй асуудлаар мэдээлэл цуглуулахад чиглэгдсэн том хэмжээний судалгааны хүрээнд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг судлахын тулд боловсруулсан асуултууд, жишиг загварууд юм.

189. 1993 онд Канадын Статистикийн газраас явуулсан Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн судалгаа үндэсний хэмжээнд хийгдсэн анхны тусгай судалгааны нэг байв. Түүнээс хойш ижил төстэй судалгааг Австрали, Финланд, Франц, Герман, Шинэ Зеланд, Швед, АНУ-д явуулсан.

190. Судалгааны аргачлал ч илүү боловсронгуй болж ирлээ. ДЭМБ-аас судалгааны олон талт аргачлалыг боловсруулан гаргасан бөгөөд энэ аргачлалыг буурай хөгжилтэй 12 оронд явуулсан гэр бүлийн хүчирхийллийн талаархи судалгаандаа ашиглажээ. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаар судалгаа явуулах стандартчилсан аргачлалыг боловсруулж одоогийн байдлаар 11 (өндөр хөгжилтэй) оронд судалгаа

хийгдсэн байна. Судалгааны аргачлалыг боловсруулан адил бус нөхцөл байдалт улс оронд ашигласан нь олон улс орнуудад эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаар найдвартай, үнэн зөв, харьцуулж судалж болохуйц мэдээ, мэдээллийг гаргах чадавхийг ихээхэн нэмэгдүүлж байна. Гэвч албан ёсны стратегийн хүрээнд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаар судалгаа хийх стандарт арга барил олон улсын болон бүс нутгийн түвшинд хараахан боловсрогдоогүй байна.

191. Тусгай судалгаа эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн өөр өөр хэлбэрүүдийн гаралтыг тодорхойлохоос гадна хүчирхийллийн хамрах хүрээ, түүний шалтгаан, хүчирхийлэгчдийн талаарх нарийвчилсан мэдээллийг цуглуулах боломжтой байдаг. Эдгээр судалгаанд хүчирхийлэл гардаг нөхцөл байдал, хор уршиг, хүчирхийллийн эсрэг эмэгтэйчүүдийн тэмцэл, хохирогчдод үзүүлж болох үйлчилгээг хамруулан судалдаг. Тусгай судалгаа нь судалгаа хийхээс илүү сургалт явуулахад анхаарлаа чиглүүлж эмэгтэйчүүдийн аюулгүй байдал, мэдээллийн нууцлалд бүх талаар анхаардаг. Хүчирхийллийн гаралтын тооны талаар тусгай судалгааны гаргасан тооцоо ерөнхий судалгааны үр дүнгээс ихээхэн илүү байдаг. Тусгай судалгааг явуулах нь ихээхэн өндөр өртөгтэй ажил учир ийм судалгааг тогтмол явуулахад бэрхшээл үүсгэдэг.

192. Мэдээ, мэдээлэл цуглуулах 2 дахь арга барил болох ерөнхий судалгаанд тусгай загвар оруулж өгөх нь мэдээллийн эх үүсвэр хангалттай бус нөхцөлд хэрэглэхэд тохиромжтой. Камбож, Колумб, Доминикан, Египт, Гаити, Энэтхэг, Никарагуа, Перу, Замби гэх мэт нилээд улсад эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаарх асуултзагваруудыг хүн ам зүй, эрүүл мэнд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн судалгааны дотор оруулж судалсан байдаг. Зарим улсын Засгийн газраас эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн мэдээллийг оруулсан хүн амын дундах гэмт хэргийн судалгааг тогтсон хугацаанд явуулдаг. АНУ 1960-аад оноос Үндэсний хэмжээний гэмт хэргийн хохирогчдын судалгааг (урьд нь Үндэсний гэмт хэргийн судалгаа гэдэг байсан) явуулж ирсэн бол, Нэгдсэн Вант Улсад Британий гэмт хэргийн судалгааг 1982 оноос эхлэн явуулж байна. Канадын Статистикийн газар 1993 оноос Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн судалгааны багц асуултуудыг боловсруулж 5 жилд нэг удаа хийгддэг Хохирогчдын талаарх нийгмийн судалгаанд оруулан явуулж байна.

193. Нөхөн үржихүйн эрүүл мэнд, хүүхдийн эрүүл мэнд гэх мэт өргөн хүрээтэй асуудлын талаар мэдээ, мэдээлэл цуглуулж болдог нь ерөнхий судалгааны давуу тал бөгөөд үүгээрээ эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн эрсдлийн хүчин зүйлс, түүнээс гарах эрүүл мэндийн, бусад хор уршгийн талаарх ойлголтыг гүнзгийрүүлж өгдөг ач холбогдолтой. Түүнчилэн ийм судалгааг тогтмол явуулдаг учир тодорхой цаг хугацааны дараа эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн түвшин, хүчирхийллээс үүдэн урт хугацаанд гарах хор уршгийн талаар мэдээлэл авах боломж олгодог. Гэхдээ ерөнхий судалгааны дотор багтаж буй асуултуудын тоо хязгаарлагдмал байдаг. Түүнчилэн, ийм судалгаа нь хүчирхийллийн талаар тусгай тайлан гаргадаггүй учир эмэгтэйчүүд судалгаанд өөрсдөд тохиолдсон хүчирхийллийн талаар мэдээлэх сонирхол багатай байдаг.

194. Тусгай ба ерөнхий судалгааны аль аль нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлийг боловсруулах үнэ цэнэтэй мэдээ, мэдээлэл учир улс орнууд өөрийн хэрэгцээ чадавхид илүү тохирох арга барилыг сонгож хэрэглэх нь зүйтэй.

2. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаарх хүн амд тулгуурласан мэдээлэлд орхигддог зүйлүүд ба дутагдалууд

195. Ойрноос эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрүүдийн талаар мэдээ, мэдээлэл цуглуулах ажилд ахиц дэвшил гарч байгаа ч судалгааны ажилд харьцуулалт хийж болохуйц ижил төстэй аргачлал баримтлах шаардлага зайлшгүй гарч байгаа юм. Жишээ нь: хүчирхийллийг тодорхойлох, хэмжих арга зүйн ялгаатай байдлаас болж хамтран амьдрагчийн зүгээс үйлдэгддэг хүчирхийллийн гаралтын тоог харьцуулан судлах боломжгүй болдог. Түүнчилэн газар зүйн хамрах хүрээ, хамрагдах хүн амын бүлгүүд, хүчирхийллийн хэлбэрүүд дээр их зөрөөтэй, дутагдалтай талууд байдаг.

(а) Судлагдаж байгаа хүчирхийллийн хэлбэрүүд

196. Хүн амын дундах судалгаа нь ерөнхийдөө хамтран амьдрагчийн зүгээс үйлдэгдсэн хүчирхийлэл, бэлгийн хүчирхийлэл, эмэгтэй хүний бэлэг эрхтнийг зэрэмдэглэх, хүүхдийн эсрэг бэлгийн, сэтгэл санааны мөлжлөг зэрэг хүчирхийллийн олон хэлбэрийг судалдаг. Судалгааны олонхи нь хамтран амьдрагчийн зүгээс үйлдэх хүчирхийлэл, бэлгийн хүчирхийлэл гэх мэт ганц төрлийн нийтлэг хэлбэрийг онцгойлон үзэх хандлага байдаг. Бэлгийн хамтрагчийн зүгээс үйлдсэн хүчирхийллийн талаархи судалгаа нь бие, бэлгийн, сэтгэл санааны эсрэг хүчирхийллийг авч үздэг. Эмэгтэй хүн өөрийн бий болгосон орлогыг оруулсан гэр бүлийн санхүүг захиран зарцуулахыг нөхрийн зүгээс эс зөвшөөрөн өөрийн эрхшээлийг бий болгох, эдийн засгийн хувьд дарамтлах, нөхөр нь эхнэрээ цохиод авч байгаа нь байдаг л зүйл гэж үзэж байгаа зэрэг нь хүчирхийлэлд хандаж байгаа хандлага зэргийг зарим судалгаагаар дүгнэж хэмжиж байдаг.

197. Хүн ам зүйн болон эрүүл мэндийн судалгаа, түүнчилэн ЮНИСЕФ-ийн судалгаанууд дотор эмэгтэйчүүдийн бэлэг эрхтнийг зэрэмдэглэх байдлын талаар тусгай асуултын загваруудыг оруулж өгснөөр, энэ хэлбэрийн хүчирхийллийг баримтжуулах ажилд ихээхэн ахиц гарч байна. Эмэгтэйчүүдийн бэлэг эрхтнийг зэрэмдэглэх хүчирхийллийн талаар судалгаа нь 20 гаруй орноос мэдээ мэдээлэл цуглуулаад байна. Ийм судалгаа нь эмэгтэйчүүдийн бэлэг эрхтнийг зэрэмдэглэх байдлын бүс нутаг болон тухайн үндэстний түвшинд гарах гаралт, бэлэг эрхтэнд ажилбар хийж байгаа хэлбэрүүд, ийм зан үйлийг хийж байгаа хүмүүс, цаашид ийм зан үйл үргэлжлэх нь зохистой эсэх талаар олон нийтийн санаа бодол зэрэг олон төрлийн мэдээллүүдийг багтааж байна.

198. Харин Бээжингийн Үйл ажиллагааны чиглэлд заасан хүчирхийллийн өөр хэлбэрүүдийг баримтжуулах ажил ийм түвшинд хүртэл хийгдэж чадаагүй байна. Эдгээр хүчирхийллийн бусад олон хэлбэрүүд харьцангуй цөөн тоогоор гардаг, эсхүл тухайн хүн амын бүлэг дотор гардаг зэргээс шалтгаалж хүн амын дундах судалгаагаар судлан гаргаж ирэх боломжгүй учир эдгээрийг судлах өөр аргачлал, арга барил боловсруулах шаардлагатай.

(б) Ёс зүйн ба аюулгүй байдлын асуудлууд

199. Хүчирхийллийн сэдэв нь их эмзэг асуудал боловч эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаар мэдээ мэдээлэл цуглуулах боломжтой байдаг. Ингэхдээ судалгаанд хамрагдсан болон авч буй хүмүүсийн аюулгүй байдлыг хангах тусгай зарчим байх ёстой. ДЭМБ-аас гэр бүлийн доторхи хүчирхийлэл, хүн худалдаалах талаар судалгаа хийхдээ баримтлах аюулгүй байдал, ёс зүйн удирдамжийг боловсруулсан. Энэхүү удирдамжид судалгаа хийгч судалгаанд хамрагдагчийн аюулгүй байдлыг хангах, судалгааны ярилцлагын нууцлалыг хангах, ярилцлага

авагчид зориулж жендерийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн асуудлаар тусгай сургалт хийх, эрсдэлтэй нөхцөл байдалд байгаа ярилцлага өгөгчид хэнд хэрхэн хандах талаар туслах мэдээлэл өгөх, ярилцлага өгөгчид сэтгэл санаа, арга зүйн дэмжлэг үзүүлэх зэрэг асуудлуудыг хамарсан байдаг. Эдгээр арга хэмжээг авч хэрэгжүүлээгүйгээс мэдээ, мэдээллийн чанарт сөргөөр нөлөөлөх, ярилцлага авагч, хариулагч бие сэтгэлийн хувьд аюултай байдалд орох зэрэг сөрөг нөлөө гарч болно.

3. Судалгааны төлөвлөлт ба хэрэгжүүлэлт

200. Хүн амын дундах судалгаанд хүчирхийлэл гэж юуг хэлэх тухай тодорхойлолт, гарах байдлыг нь хэрхэн дүгнэж хэмжих арга зам нь маш олон янз байна. Зарим судалгаа нь тухайн улсын эрүүгийн хуулийн тодорхойлолтонд үндэслэсэн байхад, зарим нь судалгаанд оролцогчид өөрсдийгөө хүчирхийллийн хохирогч болсныг тодорхойлох боломж олгож байдаг. Зарим судалгаа “Та хүнд зодуулж байсан уу?” гэсэн ганц шууд асуулттай байхад, зарим нь “Та алгадуулж, өшиглүүлж, цохиулж байсан уу” гэх мэт илүү тухайлсан олон асуултуудыг тавьдаг. Эмэгтэйчүүдэд бусдын авир үйлдлийн талаар тухайлсан хэд хэдэн асуултад хариу өгөх боломжтой байдлаар асуулт тавих нь тэдний зүгээс хүчирхийллийн талаар илүү үнэн бодит байдлыг дэлгэн тавихад дөхөмтэй байдаг учир хүчирхийллийн бодит байдлыг дүгнэж цэгнэхэд ганц асуулт ашиглах нь учир дутагдалтай. Цөөн хэдэн асуулт бүхий судалгаа нь ерөнхийдөө хүчирхийллийн талаар хамгийн бага мэдээлэл гаргаж ирдэг. Судалгааг хэрхэн явуулах, судалгаанд хамруулах хүн амын бүлгийг яаж сонгох зэрэг нь судалгааны үр дүнд ихээхэн нөлөөтэй.

В. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаарх бусад мэдээ мэдээллүүд

1. Үйлчилгээнд тулгуурласан мэдээлэл

201. Хүчирхийллээс хохирсон эмэгтэйчүүдтэй харьцаж уулзаж байдаг төрийн, хувийн байгууллагуудаар дамжуулан тогтмол байдлаар авах мэдээллийг үйлчилгээнд үндэслэсэн мэдээлэл гэдэг. Үүнд: эрүүл мэндийн төвүүд, цагдаагийн байгууллага, нийгмийн халамжийн үйлчилгээ, хоргодох байрны зэрэг хүчирхийллийн хохирогчдод тусламж үзүүлэх үйлчилгээний мэдээллүүд орно. Дэмжлэгийн бусад үйлчилгээнд эмэгтэй хуульчдын холбоо, эрх зүйн туслалцаа өгөх газрууд, иргэний нийгмийн төлөө байгууллагууд орно. Ихэнхи тохиолдолд маш цөөн эмэгтэйчүүд, эсхүл хүндээр гэмтэж бэртсэн тохиолдолд л цагдаа, бусад дэмжих байгууллагуудад ханддаг учир үйлчилгээнд үндэслэсэн мэдээ, мэдээллүүдээс нийгэм дэх хүчирхийллийн гаралт, хэмжээ, далайцыг тодорхойлох боломжгүй. Харин үйлчилгээнд үндэслэсэн мэдээ, мэдээлэл нь тухайн салбарт хүчирхийлэлтэй хэрхэн тэмцэж байгаа, тэдгээр салбарт эмэгтэйчүүдийн хэрэгцээ шаардлагыг хэрхэн хангаж буй, талаар ойлголт авахад тус нэмэртэй.

202. Янз бүрийн байгууллагад хэдэн эмэгтэй хандаж тусламж хүсэв, тухайн хүн амын бүлэгт хүчирхийллээс хохирсон хэдэн эмэгтэй дэмжлэг, тухайлбал, эмнэлгийн үйлчилгээ авав гэдэг мэдээлэл, ойлголтыг үйлчилгээнд үндэслэсэн мэдээ, мэдээллээс авч болно. Хүчирхийллээс хохирсон эмэгтэйчүүд тухайлсан ямар үйлчилгээг авч байгаа талаарх мэдээлэл авснаар, ийм төрлийн үйлчилгээний хэрэгцээ, шаардлага, үнэ өртгийн талаар тооцоо хийх боломжтой болдог. Түүнчилэн ийм мэдээллийг ашиглан эрүүл мэндийн болон хууль хяналтын байгууллагууд

зэрэг үйлчилгээ үзүүлэгчдэд хэдэн удаагийн сургалт явуулах хэрэгцээ, шаардлага байгааг тоон үзүүлэлтээр гаргаж болдог. Эмэгтэйчүүд тусламж хүсэн хандаж байдаг байгууллагуудын үйлчилгээний хандлагыг үнэлж, цэгнэхэд үйлчилгээнд үндэслэсэн мэдээ, мэдээлэл чухал үүрэгтэй. Эмэгтэй хүн хүчирхийллийн талаар мэдээлж байхад, жишээ нь: цагдаагийн байгууллага ямар арга хэмжээ авав, хэргийг шалгав уу, сэжигтэн этгээдийг баривчлав уу, хэргийг цаашид шүүхийн байгууллагад шилжих хүртэл мөрдөн байцаалт явуулж уу? гэдгийг мэдэж байх нь чухал юм. Хүчирхийллийн эсрэг арга хэмжээний талаар хууль тогтоомж, бодлого, арга ажиллагаанд үнэлгээ хийх, тэдгээрийг боловсруулах зэрэгт цагдаа, шүүхээс авдаг мэдээ мэдээллүүд шаардлагатай.

204. Хүчирхийллээс хохирсон эмэгтэйчүүдийг дэмжих, байрлуулах байр, түр хоргодох газар зэрэг бусад үйлчилгээний хүртээмж, бололцоо ямар байгааг судлах нь уг асуудалд нийгмийн зүгээс хандах хандлага, арга хэмжээнд үнэлэлт, дүгнэлт өгөхөд ач тустай. Тусламж хүсэн хандаж буй эмэгтэйчүүдийн тооны талаар дүн шинжилгээ хийхэд ч энэ мэдээлэл хэрэгтэй. Жишээ нь: үйлчилгээний бололцоо, хүртээмж өссөн нь ийм үйлчилгээг хүсэж хандсан эмэгтэйчүүдийн тоон өсөлтийн тусгал байж болно. Нөгөө талаар ийм үйлчилгээ өгөх газрууд цөөн байдаг орон нутагт, хоргодох байрны болон бусад үйлчилгээг хүссэн эмэгтэйчүүдийн тоо цөөн байгаа нь, ийм үйлчилгээний хэрэгцээ шаардлага бага байгааг харуулж буй үзүүлэлт биш. Харин ч тус дэм хүссэн эмэгтэйчүүдэд үйлчилгээ хийх ажилд бэрхшээл саад учирч байдгийг харуулж буй хэрэг.

(а) Эрүүл мэндийн үйлчилгээ

205. Зарим эмэгтэйчүүд эрүүл мэндийн байгууллагын эмчилгээ туслалцаа, үйлчилгээг хүсэн хандах үед тэдний хүчирхийллээс хохирсон гэдэг нь мэдэгддэг. Эмнэлэгт ирэх учир шалтгаан нь хүчирхийллээс үүдэн гарсан байлаа ч эмэгтэйчүүд ихэнхдээ хүчирхийллийн золиос болсон байдлаа нууж байдаг. Хүчирхийллийн талаар тогтмол лавлагаа явуулах нь ийм хэргийг илрүүлэх байдал сайжрах арга замын нэг юм. Гэхдээ тогтмол лавлагаа явуулахын зэрэгцээ, эрүүл мэндийн үйлчилгээ зүй зохистой арга хэмжээ авах, зөвлөх, мэдээллийг бүртгэх, дүн шинжилгээ хийх тайлагнах чадавхитай байх ёстой.

206. Эмчлүүлэгч нь хүчирхийллийн золиос болжээ гэдгийг мэдсэн эмнэлгийн ажилтан энэ тухай хуулийн байгууллагад мэдэгдэх үүрэгтэй (заавал мэдэгдэх үүрэг) эсэх талаар томоохон маргаан байдаг. Энэ нь хувь хүний нууцыг задалсан хэрэг бөгөөд, ингэснээр цаашид ийм төрлийн хэрэг илрэхэд муугаар нөлөөлөхөөс гадна эмэгтэйчүүдийн эрсдлийг нэмэгдүүлж болзошгүй гэж эмнэлгийн ажилтнууд үздэг. Эрүүл мэндийн систем өөрөө зохистой арга хэмжээ авах бололцоогүй атал, эмэгтэйчүүдийг хүчирхийллийн золиос болсон эсэхийг мэдэж байх арга хэмжээг тогтмол явуулах нь ёс зүйн хувьд хир зохимжтой талаар ч эрүүл мэндийн ажилтнууд санал бодлоо илэрхийлдэг.

207. Хүчирхийллээс үүдэн хүний эрүүл мэндэд гэмтэл бэртэл, амиа алдах зэрэг ямар хор уршиг учирдаг талаар мэдээ, мэдээллийг тогтмол цаг хугацаанд цуглуулах нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, ялангуяа, хамтран амьдрагчийн зүгээс үйлдэж байгаа хүчирхийлэл, хамтран амьдрагчийн болон бусдын зүгээс үйлдэж байгаа бэлгийн хүчирхийллийн шинж байдал, чиг хандлагыг тодорхойлох боломж олгодог.

(б) Эрүүгийн ба иргэний эрх зүй

208. Бусад салбартай харьцуулахад эрүүгийн болон иргэний хуулийн салбарт статистик мэдээллийг илүү системтэй байдлаар авч үзэж болдог. Хамтран амьдрагч амь насыг нь хохироох, эмэгтэй хүний амь насыг хохироосон бусад хэргийн тухай мэдээллийн анхдагч эх үүсвэр нь цагдаагийн газар байх нь олонтоо. Хохирогч гэм буруутны талаар болон хохирогчийг давтан хохироох, давтан түрэмгийлэх зэргийн талаар мэдээлэл цуглуулах боломж, бололцоо хуулийн байгууллагуудад байдаг. Эдгээр байгууллагууд нь хуулийн дагуу үүргээ гүйцэтгэж байдаг учир эрүүгийн хуулийн зүйл, анги бүрээр мэдээллийн сан үүсгэх боломжтой. Статистик нь хохирогчдыг хүйсээр нь, хохирогч нь гэм буруутай этгээдтэй ямар холбоотой талаар тус тусад нь мэдээ гаргадаггүй учир, ихэнхи орны хувьд статистикийн мэдээллээс эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн хэмжээ далайцын талаар бүрэн дүүрэн ойлголт авах бололцоогүй байна. Зарим оронд гэр бүлийн хүчирхийллийг шийдвэрлэдэг тухайлсан хуультай байхад, заримд нь ийм хэргийг хүчирхийллийн, бусдын бие махбодид гэмтэл учруулсан, бэлгийн хүчирхийлэл, бусдыг мөрдөж мөшгөсөн, хүн амины болон эрүүгийн бусад хэргийн тухай зүйл, ангид хамруулан шийдвэрлэж байна. Тэр ч бүү хэл нэг улсын дотор хууль зүйн ба эрүүл мэндийн яам гэхчилэн өөр өөр чиг үүргийн яамд нэг хэргийг өөр өөрөөр бүртгэдэг ч явдал байна.

209. Хүчирхийллийн хэргийн маш бага хувь нь эрүүгийн шүүхээр шийдэгдэж байгаа ч шүүхийн статистик мэдээ бол чухал баримт юм. Ийм мэдээ нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн эсрэг хуулийн байгууллагууд ямар арга хэмжээ авч байдаг талаар ойлгоц авахад тустай. Ялангуяа, хүчирхийллийг давтан үйлдэж байгаа байдлын талаарх мэдээлэл нь тухайн орны эмэгтэйчүүдийг хамгаалах хуулийн ямар үр нөлөөг харуулах мэдээлэл юм. Гэвч олон оронд шүүх, хууль зүйн яамны хоорондын холбоо мэдээлэл хангалтгүй байдаг.

210. Гэр бүлийн хүчирхийллээс эмэгтэйчүүдийг иргэний хуулиар ч хамгаалдаг. Зарим орны иргэний шүүхийн хамгаалах, амгалан байдлыг хадгалах, тусгаарлах болон гэр бүлийн хүчирхийллийн тогтоол зэрэг хүчирхийлэгч-хамтран амьдрагч, хохирогчтой харьцахыг хориглодог шийдвэрүүд байдаг. Ийм шийдвэрүүдэд мансууруулах бодис, спиртийн ундаа хэрэглэх, буу зэвсэг эзэмшихийг хориглох зэрэг заалт ч ордог. Хүчирхийлэгч-хамтран амьдрагчийг гэрээс нь явуулж болох өөр төрлийн шийдвэр ч байдаг. Ийм арга хэмжээ хир үр нөлөөтэй, эмэгтэйчүүдэд шаардлагатай нөхцөлд ийм арга хэмжээг авч өгөх байдал хир нийтлэг байдаг талаар илүү их мэдээлэл шаардлагатай байна.

(в) Бусад үйлчилгээ

211. Хүчирхийллийн хохирогчдод үйлчилгээ үзүүлдэг төрийн ихэнхи байгууллагууд үзүүлсэн үйлчилгээнийхээ талаар бүртгэл хөтөлдөг. Ерөнхий болон эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаархи тухайлсан мэдээллийн тоо чанар харилцан адилгүй байна. Ийм үйлчилгээ явуулдаг байгууллагад хоргодуулах, хүүхдийг халамжлах болон бусад үйлчилгээ үзүүлдэг төрийн байгууллагууд орно.

212. Ихэнхи тохиолдолд ТББ-ууд зохион байгуулж зарим үед төрөөс санхүүжсэн дэмжлэгийн олон хэлбэрийн ажил явуулдаг байгууллагууд байдаг ба тэдгээр нь өөрсдөдөө хандаж ирсэн эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн шинж байдал, далайцын талаар мэдээлэлтэй байдаг. Ийм үйлчилгээнд хоргодох, хонуулах байр, зөвлөгөө өгөх утас, болон холбогдох бусад үйлчилгээ багтдаг. Заримдаа эмэгтэй хуульчдын байгууллага, хуулийн зөвлөгөө өгөх газрууд зохих мэдээллийг цуглуулсан байдаг. Эдгээр байгууллагын цуглуулсан мэдээлэл нь чанарын судалгаанд чухам

холбогдолтой. Гэвч эдгээр бүртгэл мэдээлэл нь цуглуулж байгаа мэдээллийн төрөл, чанар зэргээрээ маш их ялгаатай байдаг.

2. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаарх үйлчилгээнд тулгуурласан мэдээлэлд орхигддог зүйлүүд ба дутагдалууд

213. Үйлчилгээнд үндэслэсэн мэдээ, мэдээлэл нь олдоц, чанарын хувьд ихээхэн өөр байдаг. Европ, Хойд Америкийн зарим улсуудад өргөн эх үүсвэрээс авсан мэдээ, мэдээлэл олдоцтой байдаг боловч мэдээ, мэдээлэл байнга нэгтгэгдэн олон нийтэд тарж байдаггүй. Эх үүсвэр багатай зарим орнуудад эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаарх үйлчилгээнд үндэслэсэн мэдээ мэдээллийг цуглуулахад ихээхэн бэрхшээлтэй.

214. Гол төлөв мэдээ, мэдээлэл цуглуулах нь үйлчилгээний байгууллагуудын анхдагч үүрэг биш учраас тэднээс олдож байгаа мэдээлэл нь системтэй бус байдаг. Мэдээллийн чанар тааруу, шинэчлэгдээгүй, эсхүл төлөөлөл болж чадахааргүй байдаг. Эмэгтэй хүн нэг байгууллагад хэд хэдэн удаа хандах, хэд хэдэн байгууллагаас үйлчилгээ авсан тохиолдолд мэдээлэл давхардсан тоогоор гарах нь элбэг. Энэ нь сургалт хангалтгүй, эх үүсвэр дутмаг, байгууллага хоорондын уялдаа холбоо сул байгаатай холбоотой.

215. Нийгмийн үйлчилгээ ядмаг буюу огт байхгүй, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг цагдаагийн байгууллага буюу нийтээрээ эс хайхардаг газруудад үйлчилгээнд үндэслэсэн мэдээ, мэдээлэл гаргах байдал маш хүндрэлтэй байдаг. Гэр бүлийн эсхүл бэлгийн хүчирхийллийн хохирогчид, золиос бологчдыг ичгүүртэй мэт үздэг нийгэмд, хохирогчид тусламж хүсч хандах явдал бага байна. Иймээс тухайн улс орны нөхцөл байдлаас хамаарч үйлчилгээнд үндэслэсэн мэдээ, мэдээлэл зөрүүтэй байдаг. Энэ салбарт мэдээ, мэдээлэл цуглуулах ажлыг сайжруулахын тулд хүчирхийллийн хохирогч, золиос бологчдод үзүүлэх үйлчилгээний тоо чанарыг зэрэг сайжруулах, хохирогчдыг ад шоо үзэх, ялгаварлан гадуурхах байдлыг өөрчлөх шаардлагатай байна.

3. Чанарын судалгааны мэдээлэл цуглуулах

216. Хүн амын дундах ба үйлчилгээнд үндэслэсэн мэдээний өгч буй мэдээлэл нь ихэнхидээ хязгаарлагдмал байдаг нь тэдгээрийн сул тал юм. Судалгаагаар хэдэн эмэгтэй хүчирхийлэлд өртөв, хэд нь цагдаад хандсан гэх мэт тоо байхаас, эмэгтэй хүн хүчирхийллийг ямар байдлаар хүлээж авав, хүчирхийлэл нь тухайн соёл, уламжлалд ямар байр суурь эзлэх, эмэгтэй хүн хуулийн байгууллагад хандахад ямар саад бэрхшээлтэй учирдаг гэх мэт мэдээлэл бараг буюу огт байдаггүй. Тоогоор илэрхийлэгддэг мэдээллийн гаргадаг тоон судалгааны арга барилын чанарын судалгаанаас ялгагдах нь судалгаанд оролцогчдын хүүрнэл яриа, ишлэл, дүрслэл, жагсаалт болон тухайн хэргийн талаарх судалгаа зэргээр илэрхийлэгддэг мэдээллийг цуглуулдаг.

217. Тоон судалгааг нөхөн төгөлдөржүүлэхэд чанарын арга барил зайлшгүй шаардагдана. Жишээ нь: судалгаанд хариулагчийн харж туулсан зовлон ямар нарийн төвөгтэй хүндрэл зовлонтой байдгийг ойлгоход ийм арга барил хэрэгтэй. Асуудалд гүнзгий судалгаа хийх, богино хугацаанд үнэлгээ өгөхийн аль алинд чанарын арга барилыг ашигладаг бөгөөд аливаа асуудлыг анх удаа сөхөн судалж буй асуудлыг танин мэдэх чиглэлийн судалгаанд ч онцгой зохистой арга барил болно. Түүнчилэн чанарын судалгааны үр дүнг эмэгтэйчүүдийн, олон нийтийн хэрэгцээ шаардлага, асуудал бэрхшээлд үнэлэлт өгөх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах,

арга хэмжээг төлөвлөж авч хэрэгжүүлэх, оролцогчдын судалгааны замаар нийгмийн гишүүдтэй ажиллах зэрэгт ашигладаг.

218. Орон нутгийн хөтөлбөрийг бэхжүүлэхийн тулд чанарын судалгааг хийх тохиолдолд, судалгааг хийх явц өөрөө эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаар олон нийтийн хэлэлцүүлэг явагдах, голлох байгууллагуудын төлөөлөлтэй яриа ярилцлагыг эхлүүлэх хөшүүрэг болж болдог. Жишээ нь: Пан Америкийн Эрүүл мэндийн байгууллагаас эрхлэн гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд яагаад тусламж хүсч хандахаар шийдэв гэдэг талаар ойлголт авахын тулд Латин Америкийн 10 оронд судалгаа хийж, түүндээ чанарын арга барилыг ашигласан байдаг. Судалгаанд эмэгтэй хэнд хандан тусламж хүсэв, эмэгтэйн хүсэлтэнд байгууллагын зүгээс ямар хандлага гаргав, ямар арга хэмжээ авав, эмэгтэйг байгууллагад хандах шийдвэр гаргахад юу түлхэв эсхүл юу саад болов? гэх мэт асуулт орсон. Энэ судалгааны үр дүн, түүний олон нийтэд түгээн танилцуулсан явдал нь Латин Америкийн орнууд дахь туршилтын 25 орон нутагт гэр бүлийн хүчирхийллийн эсрэг олон нийтийн уялдаа, холбоо бүхий оролцоог бий болгож, хөгжүүлэх үр нөлөө бүхий түлхэгч хүчин болсон.

219. Өөр нэг жишээ. Зорилтот бүлгийн хэлэлцүүлэг гэх мэт оролцогчдын судалгааны арга барилыг Кени улсын Дадаабын дүрвэгсдийн хуаранд бэлгийн хүчирхийллийн бүртгэгдсэн хэргүүд өсч байгааг шалгах, цаашдын авах арга хэмжээг тодорхойлох зорилгод ашигласан. Судалгааны дүнд хүчингийн хэргийн дийлэнхи нь эмэгтэйчүүд түлээний мод түүхээр хуарангаас гарч явах үед гардгийг тогтоожээ. Иймд түлээний мод түүхээр явж буй эмэгтэйчүүдийг илүүтэй хамгаалах арга хэмжээ авсан байна.

4. Үнэлгээний судалгаа

220. Сүүлийн арван жилд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх ажлын тоо хэмжээ, далайц ихээр өссөн боловч чухам ямар арга барил хамгийн үр нөлөөтэйг олж тогтоох ул суурьтай үнэлгээ, дүгнэлт хийгдээгүй. Хамгаалах тогтоол, хүчирхийлэгчдийг баривчлах, тэдэнтэй ажиллах хөтөлбөр зэрэг арга хэмжээ нь эмэгтэйчүүдийн аюулгүй байдал, амгалан тайван амьдралд ямар нөлөөтэй байгааг үнэлж, дүгнэсэн судалгаа маш цөөн байна. Арга хэмжээнүүдийн үр нөлөөг хооронд нь харьцуулан дүгнэх хамгийн зөв зүйтэй арга нь Түүвэр хяналт, туршилтын арга юм гэж үздэг. Гэхдээ эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, эмэгтэйчүүдийн аюулгүй байдлыг хангах талаар авсан арга хэмжээнд үнэлэлт, дүгнэлт өгөхдөө зарим талаар ёс зүйн хэм хэмжээг харгалзан үзэж энэ аргыг маш цөөн ашиглаж байна. Найдвартай мэдээ, мэдээлэл байхгүй үед олдож буй бага хэмжээний санхүүжилтийг үр нөлөө багатай хөтөлбөрт ашиглах, хөтөлбөрийн үнэлгээ хийхэд хөрөнгө зарцуулах нь ач хобогдолгүй зүйл болно.

Г. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн баримтжуулагдаагүй хэлбэрүүд

221. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрийн талаар мэдлэг, ойлголтыг цаашид ч сайжруулах шаардлагатай байгаа боловч хүчирхийллийн хамгийн нийтлэг хэлбэрүүд, ялангуяа хамтран амьдрагчийн зүгээс үйлдэх хүчирхийлэл, бэлгийн хүчирхийлэл, эмэгтэй хүний бэлэг эрхтнийг зэрэмдэглэх, хүүхдийг бэлгийн харьцаанд татан оруулах зэрэг хэлбэрүүдийг баримтжуулах ажилд ихээхэн ахиц гарсан. Гэсэн ч цаана нь баримтжуулаагүй үлдэж байгаа олон хэлбэрийн хүчирхийлэл нуугдмал хэвээр байна. Харьцангуй цөөхөн эмэгтэйчүүдийг золиос болгож байгаа

ч, тэр эмэгтэйчүүддээ асар их хохирол зовлонг авчирдаг хэлбэрийн хүчирхийлэл ч байна. Шинэ буюу шинээр мэдэгдэж байгаа хэлбэрүүд ч бий. Хүчирхийллийн баримтжуулагдаагүй байгаа хэлбэрүүдийн үйлдэгдэх хэмжээ, далайцын талаар хангалттай ойлголттой болохын тулд мэдээ, мэдээлэл цуглуулах ажлын чанарыг сайжруулах, зарим тохиолдолд шинэ арга барил боловсруулах чиглэлд ажил хийгдэж байна.

222. Эмэгтэйчүүдийн амийг хорлох, зэвсэгт мөргөлдөөний үед, түүний дараахь нөхцөл байдалд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл үйлдэх, бэлгийн мөлжлөгийн, бусад мөлжлөгийн зорилгоор эмэгтэйчүүдийг худалдаалах, зан заншилтай холбоотой бусад хортой үйл ажиллагаа (бэлэг эрхтнийг зэрэмдэглэхээс бусад), жирэмсэн үе дэх хүйсийн сонголт, нялх охидыг хаяж орхих, хүчээр гэрлүүлэх, эрт гэрлэлт, хүчлээр түлэх, инж буюу “нэр хүндийн” гэрлэлт, мөрдөж мөшгөх, ажлын байран дахь бэлгийн дарамт, хуулийн эрхшээлд байгаа нөхцөлд, ажлын байр, боловсролын байгууллагууд дахь халдлагууд, эдийн засгийн хүчирхийлэл зэрэг эмэгтэйчүүдийн эсрэг олон хэлбэрийн хүчирхийлэл баримтжуулагдаагүй байгаа хэлбэрүүдэд орж байна. Үүнд: тодорхой бүлгийн эмэгтэйчүүд буюу тухайлбал, үндэсний цөөнхийн эмэгтэйчүүд, тахир дутуу эмэгтэйчүүд, цагаач болон бичиг баримтгүй эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл бас хамаарна. Эдгээр хэлбэрүүдийн зарим нь 1995 онд Бээжинд хуралдсан Дэлхийн эмэгтэйчүүдийн 4 дүгээр бага хурлаас өмнө эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн хэлбэр хэмээн нийтээр танигдаж ойлгогдоогүй байсан. Хүчирхийллийн эдгээр олон хэлбэрийг хүн амын дундах судалгаагаар олж судалж байдаг. Жишээ нь: ДЭМБ-ын гэр бүлийн хүчирхийллийн талаарх олон улсын судалгаанд гэрлэсэн нас, нөхцөл шалтгаан, гэрлэх ёслол хэрхэн үйлдсэн, мөнгө болоод инж өгч авалцсан эсэх зэрэг нарийвчилсан мэдээллүүдийг авах асуултууд орсон байсан. Зарим хэлбэрийн талаар мэдээ, мэдээлэл цуглуулах шаардлагын талаар дор дурдав.

1. Эмэгтэйчүүдийн амь насыг хөнөөх

223. Эмэгтэй хүний амийг хороох явдал нь эрэгтэй хүнийг алахаас шинж байдлын хувьд өөр бөгөөд ихэнхидээ гэр бүлийн хүчирхийлэл, хэт хардалт, эмэгтэй хүнийг өмчлөх, уур хилэн, инжийн талаарх маргаан болон “нэр төрийн асуудлаас” үүдэн гардгийг сүүлийн үеийн судалгаагаар тогтоосон байна. Бэлгийн хүчирхийлэлтэй холбоотойгоор эмэгтэй хүний амийг хороосон хэрэг их байдаг ба Мексик, Гватемал улсын зарим нутагт эмэгтэйчүүдийг хороох хэргийн гаралт сүүлийн үед өндөр байгаа нь үүнтэй холбоотой байна.

224. Эмэгтэй хүний амийг хороох хэргийн талаарх судалгаа цагдаа шүүх эмнэлгийн бүртгэл мэдээлэлд ихээхэн тулгуурлаж байдаг. Хохирогч, хэрэг үйлдэгчийн хоорондын харилцаа (жишээ нь: хамтран амьдрагч, гэр бүлийн гишүүн, худ ураг эсхүл огт үл таних хүн байх зэрэг), үхэлд хүргэсэн шалтгаан нөхцлийг (үхлийн шалтгаан, хэрэг гарсан газар зэрэг) тогтооход ийм бүртгэл мэдээг ашигладаг. Зарим улсад “нэр төрөө хамгаалан” үйлдсэн болон инжний төлөөх аллагыг тусгай зүйл, ангиар шийдвэрлэдэг ба энэ нь судлаачдын зүгээс ийм төрлийн аллага гарах эрсдлийн хүчин зүйл, онцлог шинжийг судлахад дөхөмтэй болдог. Гэхдээ ийм төрлийн гэмт хэргийг ихээхэн хэмжээгээр нуун дарагдуулдаг гэж үздэг.

225. Ихэнхи орнуудад хүний амь хороосон хэргийн талаарх цагдаа, шүүх эмнэлгийн мэдээлэл бүрэн биш, аллага гарсан нөхцөл байдал, хохирогч, хэрэг үйлдэгчийн хооронд ямар харилцаа холбоо байсан талаар наад захын мэдээллийг гаргадаггүй. Тэр ч бүү хэл нилээд орнуудад хүний амь хороосон хэргийн хохирогчдыг хүйсээр нь

ялгасан мэдээлэл гардаггүй. Хохирогчийн ойр дотны хүмүүстэй уулзаж ярилцлага хийн, аллага гарсан нөхцөл шалтгаан болон уг хэргээс урьдчилан сэргийлж болох боломжууд байсан эсэхийг судалдаг “аман шинжилгээний” арга гэгдэх шинэ арга барилыг судлаачид ашигладаг болж байна. Өмнөд Африкт эмэгтэй хүнийг хороох хэрэг цагдаагийн байгууллагуудад бүртгэгдэлгүй нуун дарагдаж байгааг олон эх үүсвэрээс түүний дотор цогцос хадгалах хувийн газруудаас сурвалжлан тогтоосон байдаг.

2. Зэвсэгт мөргөлдөөн, түүний дараах нөхцөл байдал дахь эмэгтэйчүүдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл

226. Дайны үед хүчингийн хэрэг гардаг нь хэдэн зууны түүхтэй хэдий ч үүнийг хүний эрхийн ноцтой асуудал гэдгийг хүлээн зөвшөөрсөн цаг саяхан. Олныг хамарсан үймээн самуун, хүн ам байнга дүрвэн шилжиж байдаг, аюулгүй байдлын талаарх болгоомжлол зэргээс үүдэн дайн, хүмүүнлэгийн хямралын үеийн бэлгийн хүчирхийллийн хэргийн цар хүрээг тогтоох найдвартай мэдээллийг гаргах нь тун бэрхшээлтэй байдаг. Дэмжлэг авах, шударга ёсыг тогтоох боломж байсан ч дахин залхаан цээрлүүлэл үзэхээс айх, бэлгийн хүчирхийлэлтэй холбоотой ичгүүр, гутамшгийг амсахаас айх зэргээс үүдэн олон эмэгтэй хүчингийн золиос болсоноо хэлж мэдэгдэх дургүй байдаг.

227. Мөргөлдөөний үе дэх бэлгийн хүчирхийллийн талаарх мэдээг тухайн хэргийн талаарх судалгаа, золиос бологчид, хохирогчидтой ярилцлага хийх замаар олж авдаг. Энэ тухай хүн амын дунд хийсэн судалгааг цөөн орны тухайлбал, Колумб, Либери, Руанда, Сьерра Леон, Зүүн Тиморын дүрвэгсдийн хуаран, мөргөлдөөний дараахь байгууламжуудад хийсэн байна. Илүү үр нөлөөтэй, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулах, хохирогчдын хохирлыг барагдуулах арга хэмжээг авч явуулахын тулд мөргөлдөөний болон түүний дараахь үеийн бэлгийн хүчирхийллийн талаар ёс зүй, аюулгүй байдлын талаас нь сайтар анхаарсан судалгааг явуулах шаардлагатай.

228. 2000-2004 онд Мөргөлдөөний үеийн нөхөн үржихүйн эрүүл мэндийн консорциумаас бэлгийн хүчирхийллийн эсрэг дэлхий нийтийн санаачлагыг чиглүүлж ажилласан. Мөргөлдөөний нөхцөлд гарсан хүчирхийллийн талаарх чанарын үнэлгээ, дүгнэлт гаргасан нь энэ ажлын нэг үр дүн болсон юм. Дүрвэгчид, дотоодын шилжин суурьшигчид, мөргөлдөөнд нэрвэгдсэн хүн амын дунд үйлдэгддэг бэлгийн хүчирхийллийн тоо, цар хэмжээг хэмжих механизмыг уг Консорциумаас боловсруулан гаргажээ. Бэлгийн хүчирхийллийн талаарх судалгааны дүн шинжилгээ, хөтөлбөр боловсруулалт, хяналт үнэлгээнд ашиглах арга барилын гарын авлагад чанарын дүн шинжилгээ хийх арга техник, дэлхийн орнууд дахь мөргөлдөөнд нэрвэгдсэн хүн амын эсрэг бэлгийн хүчирхийллийн олон хэлбэрийг судалж, дүгнэх хүн амын дундах судалгааны стандартчилсан аргачлалыг боловсруулан оруулсан байна. Энэ аргачлал одоогоор 4 улсад туршигдаж байгаа юм.

3. Охид, эмэгтэйчүүдийг хил дамнуулан худалдаалах

229. Энэ талын статистик мэдээ тун хангалтгүй байна. Олон оронд хүн худалдаалахын эсрэг хууль тогтоомж байхгүй, байсан ч тэр нь учир дутагдалтай байна. Хууль байлаа ч хэрэг дээрээ маш цөөн тооны хүн худалдаалагчид хуулиар шалгагдаж шийтгэгддэг. Тодорхой төрийн байгууллага, ТББ, хэвлэл мэдээлэл, бүс нутгийн болон олон улсын байгууллага мэдээ тайлан гаргадаг боловч эдгээр мэдээлэл нь хоорондоо авцалдаа муутай, харьцуулалт хийх боломжгүй байдаг.

230. Худалдаалагдсан эмэгтэйчүүд өөрсдийн байдлын талаар эрх бүхий байгууллагуудад мэдээлдэггүй, ийм байдлаасаа аврагдаж гарсан хойноо ч хууль хэрэгжүүлэх байгууллагын ажилтнуудтай хамтран ажиллах сонирхол багатай байдаг. Хүн наймаалагчдын хонзогнолоос айх, эрх баригчдад итгэх итгэл дутах, эрх баригчид тусалж чадахгүй буюу туслахгүй гэж үзэх, гэр бүл нь тэднээс нүүр буруулах, өөрийн улс орондоо ажиллаж, амьдрах бололцоо муутай байх зэрэг нь ийм байдлын үндсэн шалтгаан юм. Тэр ч бүү хэл эх орондоо олохоос илүү мөнгө олж байгаа бол өөрсдийгөө худалдаалагдаж, мөлжигдөж байна гэж үзэхгүй байх ч явдал гардаг.

231. Олон улсын хүний худалдааны эсрэг байгууллага Европт явагдаж байгаа эмэгтэйчүүдийг худалдаалах хэргийг судалж үзээд “эмэгтэйчүүдийг худалдаалах явдлын талаар үнэн зөв, бодитой тооцоо гаргах боломжгүй байна” гэсэн дүгнэлт гаргажээ. Ийм тооцоо хийх аргачлал бараг байхгүй, тооцооны хамрах хүрээ тодорхой бус зэргээс үүдэн эмэгтэйчүүдийг худалдаалах талаарх тооцоог харьцуулж шалгаж үзэхэд хүнд байгаа юм. Энэ талаарх тооцоо хоорондоо их зөрүүтэй, заримдаа нэг төрлийн тоо баримт өөр их үүсвэрээс авагдахдаа даруй 10 дахин их гарах ч явдал бий.

232. Олон улсын хүний худалдаалах чиглэл, эх үүсвэр, дамжин өнгөрөх газрууд, эцсийн цэг болж байгаа улс орон, худалдаалагдсан хохирогчдын тоо, хохироогчдын талаар мэдээллийг багтаасан олон талт мэдээллийн санг боловсруулах чиглэлээр бүс нутгийн болон улс орнуудын санаачилга гарч эхэлж байна.

4. Ажлын байр, сургуулийн орчин дахь бэлгийн хүчирхийлэл

233. Олон улс оронд ажлын байран дахь бэлгийн дарамтын талаарх мэдээллийн эх үүсвэр нь хөдөлмөрийн яам буюу ажил олгогчдын тухай гомдлыг барагдуулдаг байгууллага байдаг. Ажлын байран дахь бэлгийн дарамтын эсрэг хууль тогтоомжгүй улсуудад энэ талаар ямар ч мэдээ бүртгэл байдаггүй. Ажлын байран дахь бэлгийн дарамтын золиос болсон эмэгтэйчүүдийн бодит тоо нь энэ талаар бүртгэгдэж мэдэгдсэн хэргийн тооноос хавьгүй давсан байдаг.

234. Үйлдвэржсэн олон улс оронд ийм төрлийн халдлага ажлын байр болон боловсролын газруудад ямар хувь хэмжээгээр гарч байдаг тооцоог судалгаагаар тогтоож ирсэн. Хөгжиж буй орнуудад ажлын байран дахь бэлгийн дарамтыг ноцтой асуудал гэж ойлгож, хүлээн зөвшөөрдөг боловч ихэнхи мэдээ, мэдээлэл үндэслэл муутай, үнэн зөв бус байхаас гадна, энэ асуудлын хор нөлөө хэмжээ далайцын талаар хийсэн судалгаа, бодит ойлголт муу байсаар байна. Сургуульд үйлдэгддэг охидын эсрэг хүчирхийллийн гаралт, тооны талаар ихэвчлэн Африкт цөөн хэдэн судалгаа хийсэн байна.

5. Албан байгууллага, засан хүмүүжүүлэх байгууллагын орчин дахь хүчирхийлэл

235. Үнэн бодит мэдээлэл олддоггүйтэй холбоотойгоор эрүүл мэндийн байгууллагууд, сэтгэцийн эмнэлгүүдэд гардаг эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаар тоо баримт бага байна. Шорон, саатуулах газар, засан хүмүүжүүлэх газруудад гарч байгаа эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаарх мэдээлэл бас л олддоггүй. Ийм мэдээллийг эрүүл мэндийн болон хууль зүйн яамд, судалгааны бие даасан байгууллагууд цуглуулах шаардлагатай.

Д. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн үзүүлэлтүүд

236. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаар олон улсын багц үзүүлэлт боловсруулахыг бодлого боловсруулагчид, хүний эрхийн идэвхтнүүдийн зүгээс төр, төрийн байгууллагууд болон бусад байгууллагуудад хандан уриалсан.

Ийм үзүүлэлтүүд 3 гол зорилгын үүднээс шаардагдаж байна. Үүнд:

(а) Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх талаар арга хэмжээ авах шаардлага байгааг бодлого боловсруулагчдад ойлгуулах: Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн олон хэлбэрийн мөн чанар, үйлдэгдэж байгаа тоо хэмжээг гаргадаг өрхийн судалгаагаар хамгийн бодит мэдээлэл гарч ирдэг. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаарх судалгааны мэдээ, мэдээлэл нь улс төрийн хүсэл санаачилгыг төрүүлж хууль тогтоомж, бодлогын өөрчлөлт хийхэд түлхэц болсон тухай жишээ дэлхий дахинд олон бий.

(б) Хүчирхийллийн золиос бологсдод үзүүлэх үйлчилгээний хүртээмж чанарыг тодорхойлох: Ийм мэдээллийг ерөнхийдөө хүчирхийллийн хохирогчдод үйлчилгээ үзүүлдэг хууль, эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээний ТББ-уудын бүртгэл мэдээ ба эдгээр үйлчилгээний талаарх эмэгтэйчүүдийн ойлголт, үйлчилгээг хэрэглэсэн байдлын талаарх судалгаанаас авсан байдаг. Хөтөлбөрүүдийн үр нөлөөг шинжлэн дүгнэхэд чанарын болон тоон аргачлалын аль алиныг хэрэглэсэн үнэлгээний судалгаа маш чухал.

(в) Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх талаар олон улсын өмнө хүлээсэн үүргээ төр хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих: Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх талаар авч хэрэгжүүлж байгаа бодлогын үр дүнд хүчирхийллийн гаралт, тохиолдолд ямар өөрчлөлт бий болж байгаа, хуулийн болон бодлогын өөрчлөлтийг боловсруулж батлах ажлын ахиц, үйлчилгээний хүртээмж, хүчирхийлэлтэй тэмцэх ажилд зориулсан төсвийн хуваарилалтын талаар үнэлж, дүгнэхэд ашиглах зохимжтой шалгуур үзүүлэлтүүд байх ёстой.

237. Олон улсын хэд хэдэн багц шалгуур үзүүлэлтийг боловсруулаад байгаа хэдий ч эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг тодорхойлж, тооцох хамгийн сайн шалгуур үзүүлэлтийг нэг мөр тохирон зөвшилцөлд хүрээгүй байна. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, түүний шалтгаан, үр дагаврыг тодорхойлох шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулах саналыг Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаарх тусгай судлаачид тавьсан. Мянганы сорилын төслийн Боловсрол, жендерийн тэгш байдлын ажлын хэсэг “жендерийн тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүдийг хөгжүүлэх” Мянганы хөгжлийн зорилтын ажлын дэлхий дахины ахиц дэвшлийг хянах зорилгоор эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаарх шалгуур үзүүлэлтийг боловсруулан санал болгосон байна.

238. Хүний хөгжлийн жендерийн тэгш байдлын цар хүрээний иж бүрдэл заалтад Жендерийн хөгжлийн заалт буюу Жендерийг хөгжүүлэх арга хэмжээ гэх мэт эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн шалгуур үзүүлэлтийг оруулж өгөх талаар санал хэлэлцүүлэг явагдаж байна. Энэ чиг хандлага нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн асуудлыг, эмэгтэйчүүдийн хөгжилд саад учруулж байгаа ноцтой саад бэрхшээлийнх нь хувьд тодорхойлж өгөх, энэ асуудлыг хүний хөгжлийн асуудлын өргөн хүрээтэй утга агуулгад суулгаж өгөх зорилготой. Иж бүрдэл заалтуудын хэсэг болох эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн асуудлын талаар Засгийн газрууд мэдээ, мэдээлэл цуглуулах ажлыг дэмжих ёстой.

239. Иж бүрдэл заалтын тухайд, ойлгоход энгийн, хялбар, тодорхой харьцуулж болохуйц мэдээ, мэдээлэлд үндэслэсэн нэг л шалгуур үзүүлэлтийг сонгож авах нь

зүйтэй. Ийм шалгуур үзүүлэлт нь дунд болон урт хугацаанд нөхцөл байдалд гарч буй өөрчлөлтийг тодорхойлох боломжтой байх ёстой. Одоогийн байдлаар хамтран амьдрагчийн зүгээс бие махбодийн хүчирхийлэл үйлдэх хэргийн гаралтыг хэмжих шалгуур үзүүлэлт нь хамгийн өргөнөөр хэрэглэгдэж байгаа. Энэ үзүүлэлтийг хамтран амьдрагчтай байж үзсэн эмэгтэйчүүдийн тоог хамтран амьдрагчийн зүгээс үйлдсэн хүчирхийлэлд сүүлийн 12 сарын дотор буюу нийт амьдралын туршид өртөж байсан эсэхтэй харьцуулан тогтоодог. Хамтран амьдрагчийн хүчирхийллийг яаж тодорхойлох талаар судлаачид ихээхэн хэмжээгээр санал нийлж байгаа ба үүнийг эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн зонхилох судалгаануудад оруулсан. Амьдралын турш тохиолдож байгаа хүчирхийллийн тохиолдол, хүчирхийллийн үйлдлийн тоо, давтамж, хор хөнөөл, бэлгийн болон сэтгэл санааны хүчирхийллийн гаралт зэрэг бусад үзүүлэлтийг ч бодлого боловсруулах зорилгоор ашиглах шаардлагатай. Ихэнхи улсын хувьд 12 сарын хугацаанд хамтран амьдрагчийн зүгээс бие махбодийн хүчирхийлэл гарч буй байдлын талаар харуулж чадах олон улсын хэмжээнд харьцуулж судалж болохуйц, мэдээлийн санг хангалттай хөрөнгө оруулалт, хүч чармайлт гарган дараачийн 5-7 жилийн дотор бүрдүүлэх боломжтой юм.

Е. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаарх мэдээлэл цуглуулах ажлыг сайжруулах нь

240. Бодлого, стратеги боловсруулах ажлыг мэдээллээр хангах зорилгоор эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрүүдийн талаар мэдлэгийн санг бэхжүүлэх яаралтай шаардлагатай. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн мэдээ, мэдээлэл цуглуулах ажлын дутагдал, бэрхшээлтэй асуудлын талаарх мэргэжилтний бүлгийн уулзалтаас мэдээ мэдээлэл цуглуулах ажлыг сайжруулах талаар нарийвчилсан багц зөвлөмжийг гаргасан. ТББ, эрдэмтэд, судалгаанд оролцогч талуудыг хамтруулан мэдээ, мэдээллийг системтэйгээр цуглуулах, хэвлэн нийтлүүлэх ажлыг авч хэрэгжүүлэх улс орнуудын үүрэг, хариуцлагыг уг мэргэжилтний бүлгээс онцлон тэмдэглэсэн. Мэдээ, мэдээллийг авах арга зүйн болон ёс зүйн хэм хэмжээг тогтоох, үзэл баримтлалыг дагаж мөрдөх, тогтмол мэдээ цуглуулах, үр дүнг нь цаг тухайд нь өргөнөөр мэдээлэх зэрэг ажилд үндэсний статистикийн газрууд, эрүүл мэндийн болон хууль зүйн гэх мэт холбогдох яамд маш чухал үүрэг гүйцэтгэнэ. Эмэгтэйчүүдийг хөгжүүлэх чиглэлд төрийн механизм дээрх хүчин чармайлттай нягт хамтран ажиллах ёстой.

241. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг бий болгодог хүчин зүйлийн талаар олон улсын ойлголт хөгжихийн хирээр, үйл ажиллагааны тодорхойлолтууд уян хатан байх хэрэгтэй. Мэдээ, мэдээллийг цуглуулах ажлыг зохион байгуулах, гүйцэтгэх ажилд хэрэглэгчдийг татан оруулснаар мэдээ, мэдээллийг гаргагчид, хэрэглэгчдийн хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэх шаардлагатай.

Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн мэдээ, мэдээллийг цуглуулах ажлыг мэдээ, мэдээлэл гаргаж өгч байгаа байгууллага, эмэгтэйчүүдэд үйлчилгээ үзүүлдэг өмгөөлөгч, байгууллагууд, бодлого боловсруулагчид, эрх зүйчид судлаачид гэх мэт оролцогч талуудын өргөн хүрээтэй зөвлөлтөөнийг баримтлан хийж байх нь зүйтэй.

VI. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх төрийн үүрэг

A. Оршил

242. Энэ хэсэгт эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл нь хүний эрхийн санаа зовниулсан асуудал болж байгаа болон ийм хүчирхийллээс урьдчилан сэргийлэх тэмцэх талаар төрийн үүрэг, хариуцлагын тухай нийтлэг ойлголтуудыг нэгтгэн дүгнэсэн болно. Төрийн үүрэг, хариуцлага болон үндэсний түвшинд хариуцлагыг хэрхэн хэрэгжүүлдэг тухай энд тайлбарлав.

243. Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдэд адил тэгш хэрэглэгддэг Хүний эрхийн гэрээнүүдэд эмэгтэйчүүдийг хүчирхийллээс хамгаалах маш чухал ач холбогдол бүхий хэд хэдэн эрхийн заалт байдаг. Эдгээр нь хүний амьд явах эрх, хувь хүний эрх чөлөө, аюулгүй байдлын эрх, эрүүдэн шүүх болон хэрцгийллээс ангид байх, хүнлэг бус, гутаан доромжилсон харьцаа ял шийтгэлээс ангид байх, боолчлолоос ангид байх, хуулийн өмнө тэгш эрхтэй байх, гэр бүл, гэр бүлийн харьцаанд тэгш эрхтэй оролцох, амьжиргааны зохистой түвшингээр хангагдах, шударга ая тухтай ажлын нөхцөлөөр хангагдах, бие сэтгэлийн эрүүл мэндийн өндөр түвшинд байх зэрэг эрхүүд байдаг.

244. НҮБ-ын Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх конвенцийн нэмэлт Хүнийг, ялангуяа эмэгтэйчүүд хүүхдийг худалдаалах явдлаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох түүнд ял шийтгэл оногдуулах тухай протоколд худалдаалахыг урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдыг хамгаалах, тусламж үзүүлэх, улс орнуудын хооронд хамтын ажиллагааг дэмжих үйл ажиллагааны заалтууд байдаг.

245. Олон улсын хүмүүнлэгийн хууль бол зэвсэгт мөргөлдөөний үед эмэгтэйчүүд, охидыг хамгаалах үндсэн ач холбогдолтой хууль бөгөөд олон улсын эрүүгийн хууль, дэлхий дахины шударга хууль ёсны зарчим нь дайн, мөргөлдөөн үймээн самууны үед үйлдэгдсэн эмэгтэйчүүдийн эсрэг гэмт хэргийн золиос болсон эмэгтэйчүүдийн хохирлыг барагдуулах арга хэмжээг тусгасан байдаг. Олон улсын дүрвэгсдийн тухай хууль тогтоомж үүнд: Дүрвэгсдийн эрх зүйн байдлын тухай 1951 оны Конвенц, түүний 1967 оны Протоколд дүрвэгч эмэгтэйчүүдийг хамгаалах заалтууд орсон байдаг.

246. Олон улсын болон бүс нутгийн гэрээнүүд, түүний дотор Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцид эмэгтэйчүүдийн эрхийг тусгайлан зааж өгсөн. Уг конвенцийн 2000 онд батлагдсан Сайн дураар дагаж мөрдөх протоколд хувь хүний гомдлыг авч хэлэлцэх болон лавлагаа явуулах ажиллагааг тогтоосон. Энэ 2 ажиллагаа нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх асуудлаар төрийн хүлээсэн үүрэг, хариуцлагыг дээшлүүлэхэд чиглэн ашиглагддаг.

247. Конвенц нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх тухайлсан гэрээ биш боловч Эмэгтэйчүүдийн эсрэг ялгаварлан гадуурхалтыг устгах хорооноос, Конвенцийн заалтанд хүчирхийлэл гэж дурдагдсан эсэхээс үл хамааран хүйсийн хүчирхийлэл уг Конвенцийн тодорхой заалтуудыг зөрчсөн хэрэг болох юм. “Конвенцийн талууд болох улс орнууд гэр бүл, ажлын байр, нийгмийн амьдралын бусад хүрээнд гарч буй бүх төрлийн хүчирхийллээс эмэгтэйчүүдийг хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх үүрэгтэй” гэж Конвенцид заасан.

Конвенцийн дагуу хүлээсэн эмэгтэйчүүдийн хүчирхийллээс ангид байх эрхийг хамгаалах үүргээ баталгаажуулан, конвенцийн талууд болох гишүүн орнууд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн асуудлаар тайлангаа Хороонд ирүүлж, энэ асуудлыг Хорооны дүгнэлт, тайлбарт оруулж байх журамтай.

248. Белум ду Парын Конвенц бол зөвхөн эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг устгах асуудалд шууд чиглэж гарсан олон улсын гэрээ ба эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаарх гэрээ хэлэлцээрийн жишиг болон хэрэглэгдэж байгаа баримт бичиг болно. Африкийн Хүний болон ард иргэдийн эрхийн харт, Африкийн эмэгтэйчүүдийн эрхийн протокол нь олон заалтуудад эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх талаар оруулж өгсөн байдаг. Өмнөд Азийн хувьд, энэ бүс нутгийн улс орнууд Эмэгтэйчүүд, хүүхдийг биеийг нь үнэлүүлэх зорилгоор худалдаалахаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх бүс нутгийн хөгжлийн төлөө Өмнөд Азийн холбооны конвенц, Өмнөд Азид эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг устгах Дакагийн Тунхаглалд нэгдсэн байдаг. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн холбогдолтой гэмт хэргийн талаар хэрэглэх заалтууд Европын хүний эрхийн конвенцид орсон байна.

249. Олон улсын хууль эрх зүй нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх нарийвчилсан үйл ажиллагааны удирдамж, заалт бүхий өргөн хүрээтэй бодлогын баримт бичиг, арга механизмуудаар баяжин өргөжиж байна. НҮБ-ын төрөлжсөн байгууллагуудаас баталж гаргасан тунхаглал, тогтоолууд, НҮБ-ын бага хурал, чуулга уулзалтуудаас батлан гаргаж буй баримт бичгүүд үүнд мөн хамаарна.

250. Хүний эрхийн гэрээг хэрэгжүүлэх байгууллагууд байгуулагдан ажилласаар байна. Үүнд: Эмэгтэйчүүдийн эсрэг ялгаварлан гадуурхалтыг устгах хороо, Хүний эрхийн хороо, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хороо, Арьсны өнгөөр ялгаварлан гадуурхалтыг устгах хороо, Хүүхдийн эрхийн хороо, Эрүүдэн шүүхийн эсрэг хороо, Цагаач ажилчдын талаархи хороо зэрэг болно. Эдгээр хороод нь холбогдох гэрээгээр хамгаалуулсан эрхээ эдлэх асуудалтай холбоотойгоор эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн асуудлаар ажиллаж байдаг. Гэрээний байгууллагууд нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, бүтцээс шалтгаалан гарах байдлыг судалж, ерөнхий зөвлөмж, дүгнэлт, ажиглалт, хувь хүнээс ирүүлсэн гомдлыг шалгасан ажлын тайлан, лавлагааны ажиллагаагаар дамжуулан эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрийг устгах, түүнтэй тэмцэх талаар улс орнуудын авсан үүрэг, хариуцлагыг тодорхойлж байдаг. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаарх тусгай судлаач гэх мэт НҮБ-ын бусад механизмаар дамжуулан эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, түүнийг устгах талаар төрийн хүлээх үүрэг, хариуцлагын ойлголтуудыг улам боловсронгуй болгож байдаг.

251. Олон улс, бүс нутгийн түвшинд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх хууль эрх зүйн механизм бүрэлдэж байна. Европ, Америк дундын хүний эрхийн тогтолцоо болон Олон улсын эрүүгийн тусгай шүүхээс тухайн тодорхой гэмт хэргүүдийг хянан шийдвэрлэлээ. Эдгээр шийдвэрүүд нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй төр, хувь хүний үүрэг, хариуцлагын талаар олон улсын хуулийг хэрэглэх практикт чухал, жишиг тогтоосон зүйл болов.

252. Үндэсний түвшний хууль шүүхийн байгууллагуудын хөгжил, бэхжилт нь өөрийн орны төр засгийн хүлээх үүрэг, хариуцлагын хэм хэмжээг тогтооход хувь нэмэр оруулж байна. Төр олон улсын хуулийн өмнө хүлээсэн үүргийнхээ дагуу эмэгтэйчүүдийн хүний эрхээ эдлэх байдлыг бусниулан доройтуулах зорилготой буюу бусниулсан хүчирхийллийг хамруулан, хүйсийн ялгаварлалаас эмэгтэйчүүдийг хамгаалах үүрэг, хариуцлагыг хүлээнэ гэж Өмнөд Африкийн Үндсэн хуулийн шүүхээс тогтоожээ.

253. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаар олон улсын хэм хэмжээг сахин биелүүлэх ажил үндэсний түвшинд сонирхогч талуудын өргөн оролцоогоор хангагдах хууль, бодлого бусад олон талт арга хэмжээг авч явуулах шаардлагатай байдаг. Эдгээр ажил засаг захиргааны бүхий л нэгжийн түвшинд, хууль зүй, хууль тогтоох, хууль

сахиулах байгууллагуудыг оролцуулан төрийн бүх байгууллагад оролцоонд хийгдэх ёстой. Түүнчлэн, хүчирхийллийн хор уршгийг арилгах үр нөлөөтэй хандлагыг бий болгоход төрийн болон ТББ, иргэний нийгмийн байгууллагууд гэх мэт сонирхогч талуудын хамтын ажиллагааны ажлын уялдаа холбоо амин чухал үүрэгтэй.

Б. Төрийн үүрэг

254. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл бол эмэгтэйчүүдийн ялгаварлан гадуурхалтын хэлбэр бөгөөд хүний эрхийн зөрчил мөн гэдэг нь олон улсын хууль тогтоомжоор нэгэнтээ тогтоогдсон зүйл юм. Хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах, хэрэгжүүлэн баталгаажуулах төрийн үүргийн дагуу эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, шалган мөрдөх, гэм буруутанд хариуцлага хүлээлгэх нь төрийн үүрэг юм.

255. Төрийн болон төрийн байгууллагуудын нэгдэн нийлсэн олон улсын хүний эрхийн хууль тогтоомж, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх эрх зүйн актуудын дагуу төр үүрэг, хариуцлага хүлээнэ. Төрийн өөрийн үйл ажиллагаа болон хүний эрхийг хамгаалах, баталгаажуулах талаар зохистой алхам хийж чадаагүйн төлөө хариуцлага хүлээдэг. Төр өөрийн байгууллагаар дамжуулан хүний эрхийн зөрчил гаргахаас татгалзана. Түүнчлэн, төрийн бус байгууллагын буюу хүмүүсийн зүгээс хүний эрхийн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, зөрчлийг мөрдөн шалгах, буруутанд хариуцлага хүлээлгэх, хохирогчдын хохирлыг барагдуулах үүрэгтэй. Төрийн бус байгууллага, хүмүүсийн зүгээс хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнийг мөрдөн шалгах, гэм буруутанд хариуцлага хүлээлгэх, хохирлыг барагдуулах ажиллагаанд зохих хариуцлагатай хандаж чадаагүйн төлөө төр хариуцлага хүлээнэ.

256. Хамтран амьдрагч, гэр бүлийн бусад гишүүд, тохиолдлын танил, үл таних хүн, хөршийн болон нутгийн байгууллагууд, гэмт хэргийн бүлэглэлүүд, байгууллага аж ахуйн нэгж гэх мэт хувь хүн, байгууллагын зүгээс эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг маш ихээр үйлддэг. Зохих анхаарал тавьж ажиллах хэм хэмжээ нь эмэгтэйчүүдийг эдгээр хүчирхийллээс үр нөлөөтэйгээр хамгаалах төрийн үүргийг тодруулж өгч байдаг.

257. Зохих анхаарал тавьж ажиллах хэм хэмжээ гэдэг нь Эмэгтэйчүүдийн эсрэг ялгаварлан гадуурхлыг устгах хорооны 19 дүгээр Ерөнхий зөвлөмжид заагдсан хэм хэмжээ болно. Үүнд “эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчлийг мөрдөн шалгах, ял шийтгэл оноох, хохирлыг барагдуулах талаар төрөөс зохих анхаарал тавьж ажиллаж чадаагүй бол хувь хүний үйлдсэн хэргийн өмнөөс төр хариуцлага хүлээнэ” гэж заажээ. Энэ заалт олон улсын болон бүс нутгийн хууль зүй, бодлогын баримт бичгүүдэд тусгалаа олсон. Гондурас Улсын Веласкес Родригесийн хэрэгт Америкийн орнуудын хүний эрхийн шүүхээс төрийн бус байгууллага, иргэний үйлдсэн хүний эрхийн зөрчлийг урьдчилан сэргийлэх, зөрчлийг мөрдөн шалгах, буруутай этгээдийг шийтгэх талаар төр арга хэмжээ авах ёстой гэж заажээ. Энэ хэм хэмжээ нь ямар ч нөхцөл байдалд үйлдэгдсэнээс үл хамаарч эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн үйлдлийн төлөө төр хариуцлага хүлээнэ гэсэн ойлголт бус бөгөөд, учир шалтгааны үүднээс төр хариуцлага хүлээнэ гэсэн ойлголт юм. Энэ нь ялгаварлан гадуурхахгүй байх, шударга ёсны зарчимд үндэслэсэн. Зохих анхаарал тавьж ажиллах хэм хэмжээ нь төрөөс эмэгтэйчүүдийн эсрэг хувь хүний үйлдсэн хүчирхийлэлтэй тэмцэх, цаашид ийм хүчирхийлэл гаргахгүй байх урьдчилан сэргийлэх ажлыг хийх нөхцөл шалтгааныг бүтцийн үүднээс бий болгох талаар төр өөрт байгаа бүхий л арга хэрэгслийг ашиглан ажиллахыг шаардсан заалт юм.

258. Төрийн албан хаагчид ажлын байранд бэлгийн хүчирхийлэл үйлдсэн бол эрүүдэн шүүх үйлдэл хэмээн үзнэ. Жишээ нь: хорионд байгаа эмэгтэй хүнийг цэрэг, цагдаа, хорихын ажилтан хүчиндсэн тохиолдолд үүнийг эрүүдэн шүүх үйлдэл хэмээн үзнэ. Жишээ нь: Өмнө нь аюулаас хамгаалахын ажилтнуудад хүчиндүүлсэн гэгдэх тул дахин эрүүдэгдэн шүүгдэх аюултай байдлын улмаас нэгэн эмэгтэйг Заир Улсад буцааж болохгүй хэмээн Эрүүдэн шүүхийн эсрэг хороо шийдвэр гаргаж байв. Хоригдож байгаа эмэгтэйд бие, сэтгэлийн дарамт үзүүлэх нь эрүүдэн шүүхээс ангид байх, хүнлэг бус доромжлон гутаасан харьцаа, шийтгэлээс ангид байх эрхийг нь зөрчсөн үйлдэл болно гэж Европын Хүний эрхийн шүүхээс тогтоожээ. Хорионд байхдаа Мексикийн цэргийн албан хаагчдад зодуулж бүлгээр хүчиндүүлсэн нэг гэр бүлийн 4 эмэгтэйг эрүүдүүлэн шүүгдсэн гэж үзэх тогтоолыг Америкийн орнуудын Хүний эрхийн комиссоос гаргаж байв.

259. Хуучин Югослав, Руандагийн талаарх Олон улсын эрүүгийн шүүхээс хүчин гэх мэт бэлгийн хүчирхийллийг эрүүдэн шүүлт гэж үзэх ба зарим нөхцөл байдалд хүн төрөлхтний эсрэг үйлдсэн гэмт хэрэг, аймаглан устгах гэмт хэргийн бүрдэл хэсэг гэж үзэж шийдвэр гаргаж байв. “Хүний биеийг хүчээр эзэмдэхийг бэлгийн хүчирхийлэл гэж үзэхээс гадна, хүний биед бэлэг эрхтнээ оруулаагүй зөвхөн биед хүрсэн байхад л бэлгийн хүчирхийлэл гэж үзнэ” гэж Руандагийн талаарх шүүхээс тогтоожээ. Сьерра Леоны тусгай шүүхээс хүчээр гэрлэсэн гэрлэлтийг гэмт хэрэг гэж үзэхээр заасан. Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын заалтаар хүчин, бэлгийн боолчлол, хүчээр биеийг нь үнэлүүлэх, хүчээр жирэмслүүлэх, үргүүдүүлэх болон бусад төрлийн бэлгийн хүчирхийлэл хэрвээ энгийн хүн амын эсрэг өргөн хэлбэрийн системтэй халдлагын хэлбэрээр үйлдэгдсэн бол хүн төрөлхтний эсрэг үйлдсэн гэмт хэргээр зүйлчилж мөрдөн шалгахыг тогтоожээ.

260. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг урьдчилан сэргийлэх, устгах талаар төрийн авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны хэм хэмжээний багцыг олон улсын хууль зүй, бодлогын баримт бичигт тусгасан байдаг. Нөөц бололцоо байхгүй байх зэрэг олон төрлийн нөхцөл байдал, хүчин зүйлс, бэрхшээлт байдал үйл ажиллагааг авч хэрэгжүүлэх байдалд сөргөөр нөлөөлж болно. Харин үйл ажиллагаа явуулахгүй байх буюу хангалттай арга хэмжээ авахгүй байвал төрийн зүгээс ийм хүчирхийллийн эсрэг арга хэмжээ авах үүрэг хариуцлагаа хөсөрдүүлсэн явдал болно. Жишээг дор дурдав.

В. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх асуудлууд

261. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлээс урьдчилан сэргийлэх, хүчирхийллийн хэргийг мөрдөн шалгах, гэмт этгээдэд ял шийтгэл оногдуулах, хохирогчдод нөхөн төлбөр олгуулах талаар авч буй арга хэмжээ нь төр, эмэгтэйчүүдийн байгууллага, хуульчид, хүний эрхийн механизмын зүгээс үндэсний хууль тогтоомж, хөтөлбөр, бодлогод дүн шинжилгээ хийх, тэдгээр нь олон улсын өмнө хүлээсэн үүрэг хариуцлагад нийцэж байгаа эсэхэд үнэлэлт өгөх гол үзүүлэлтүүд юм. Төр эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн хооронд тэгш байдлыг бодитойгоор хангах, эмэгтэйчүүдийн хүний эрхийг бүрэн хэмжээгээр хамгаалах баталгаажуулах хууль зүй, бодлогын хүрээг үр нөлөөтэйгээр боловсруулан хэрэгжүүлэх үүрэгтэй. Орон сууцтай байх, боловсрох, хөдөлмөрлөх гэх мэт эрхээ эдлэх байдал нь хөсөрдсөнөөс эмэгтэйчүүд хүчирхийлэлд өртөх эрсдэл өндөрсдөг тул үүнд төрийн үүрэг, хариуцлага маш чухал. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлд хариу арга хэмжээ авснаар төрийн үүрэг, хариуцлага хязгаарлагдахгүй бөгөөд хүчирхийллийг төрүүлдэг тэгш бус байдлын хэмжээ далайцыг тогтоох, түүнийг даван туулах алхмыг хэрэгжүүлэх нь төрийн үүрэг, хариуцлагад хамаарна.

1. Хууль тогтоомж, бодлогын хүрээг тодорхойлох

262. Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхалтын бүх төрлийг устгах тухай конвенц, түүний Протокол, олон улсын хүний эрхийн бусад гэрээ хэлэлцээрийг даган мөрдөх нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх арга хэмжээ мөн. Үүнтэй адилаар олон улсын хэм хэмжээний дагуу тухайн улс орны үндсэн хууль буюу түүнтэй адилтгах хууль тогтоомжид эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн тэгш байдлын тухай зарчмыг тунхаглан оруулах нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх ажлын хүрээ дайлайцыг нэмэгдүүлэх ач холбогдолтой. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс хамгаалах, эмэгтэйчүүдийн хүний эрхийг баталгаажуулж, хамгаалах ажлыг сайжруулах үндэсний хэмжээний үйл ажиллагааны төлөвлөгөө нь олон улсын хууль тогтоомжид нийцүүлэн авч байгаа арга хэмжээ юм. Засгийн газрууд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх ажилд зохих төсвийг хуваарилдаг байх шаардлагатай.

263. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэртэй тэмцэх хууль тогтоомжийг батлан гаргах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэнд хяналт тавих шаардлагын талаар олон улсын болон бүс нутгийн хэд хэдэн хууль тогтоомжид тодорхойлсон. Унгар Улсын АТ-ийн хэрэгт Эмэгтэйчүүдийн эсрэг ялгаварлан гадуурхалтын эсрэг хороо дүгнэлт хийхдээ гэр бүлийн болон ажлын байран дахь хүчирхийллийн эсрэг тухайлсан хууль тогтоомж байхгүй байгаа нь хүний эрх, үндэсний эрх чөлөө, ялангуяа хувь хүний аюулгүй байх эрхийг зөрчих нөхцөл бий болгожээ гэж тэмдэглэсэн байна. Нидерланд Улсын Х ба Ү-ийн хэрэгт Европын хүний эрхийн шүүхээс дүгнэлт гаргахдаа сэтгэцийн эмгэгтэй залуу эмэгтэй хүчиндүүлсэн тохиолдолд шалгаж шийдвэрлэх зохих хууль тогтоомж байхгүй байсан нь Нидерланд Улсын зүгээс хүний эрхийг хамгаалах талаар хүлээсэн үүргээ зөрчсөн зүйл боллоо гэж үзсэн байна.

264. Перу Улсад Мариа Чавесын хэрэгт (Засгийн газрын үргүйдлийн хөтөлбөрийг хөндсөн) Америкийн орнуудын хүний эрхийн комиссоос дүгнэлт гаргахдаа эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх тухайн үеийн хууль тогтоомж, бодлогоо эргэн хянаж үзэх шаардлагатай болжээ гэж тэмдэглэсэн байна.

265. Болгар Улсын МС-ийн хэрэг хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих асуудлыг чухлыг онцолсон зүйл болсон. Энэ хэрэгт Европын хүний эрхийн шүүхээс Болгар Улсын эрүүгийн хуулийн хүчингийн хэргийг хориглосон зүйл, анги нь хүчингийн хэргийн тохиолдолд “хохирогч биеэр эсэргүүцсэн үйлдэл хийсэн байх шаардлагатай гэж дурдаагүй” боловч хүчингийн хэргийг мөрдөн шалгах практикт биеэр эсэргүүцэл үзүүлсэн байх шаардлага байдаг нь тогтоогдлоо гэжээ.

2. Эрүүгийн эрх зүйн тогтолцоо

(а) Мөрдөн шалгах

266. Төр эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн үйлдлийг олон улсын хууль зүйн актад заасны дагуу мөрдөн шалгах үүрэгтэй. Мөрдөн шалгалтын явцад “ноглох баримтуудыг цуглуулах хэмжээг баримтлан ажиллахын зэрэгцээ хохирсон эмэгтэй хүнийг гутаах эвгүй байдалд оруулахааргүй” арга барилыг ашиглах ёстой. Унгар Улсын АТ-ийн хэрэгт Эмэгтэйчүүдийн эсрэг ялгаварлан гадуурхлыг устгах хороо дүгнэлт хийхдээ “гэр бүлийн хүчирхийллийн бүх хэлбэрийг шуурхай, бүрэн төгс, бүрэн хэмжээгээр шалгаж тогтоох” хэрэгтэй гэж тэмдэглэжээ. Болгар Улсын МС-ийн хэргийн тухайд Европын хүний эрхийн шүүхээс мөрдөн шалгах болон прокурорын чадамгай үйл ажиллагаагаар дамжуулан эрүүгийн хуулийн үр нөлөөг дээшлүүлэх

төрийн үүргийг дээшлүүлэх тухай заажээ. Шүүхээс прокурор, байцаагчдын хандлага нь “төрийн хүлээсэн үүрэг, хариуцлагын шаардлагад хүрээгүй ба орчин үеийн олон улсын хуулийн хэм хэмжээтэй нийцүүлэн хүчин, бэлгийн хүчирхийллийн бүх хэлбэрүүдэд ял шийтгэл оноох эрүүгийн хуулийн үр нөлөөтэй тогтолцоог бий болгон хэрэглэх шаардлагатай” гэжээ. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг мэдээлэх аюулгүй байдлын болон нууцлалын тогтолцоог бүрдүүлэх, гомдол гаргагчдыг хүчирхийлэгчийн зүгээс гарч болзошгүй хонзогнолын үйлдлээс хамгаалах нь мөрдөн шалгах ажиллагааны нэг хэсэг юм.

(б) Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл үйлдэгчдэд ял шийтгэл оногдуулах

267. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл үйлдэгчдэд ял шийтгэл оноох төрийн үүргийн талаар олон улсын актуудад заасан байдаг. Бразилийн Мариа да Пенья Майя Фернандесийн хэргийн талаар Америкийн орнуудын хүний эрхийн комиссоос хэргийг мөрдөн шалгаж эхэлснээс хойш 15 жилийн хугацаа өнгөрчихөөд байхад гэр бүлийн хүчирхийллийн хэрэг үйлдэгчид төр ял шийтгэл оноож чадаагүй нь олон улсын хуулийн өмнө төрийн хүлээсэн үүрэг, хариуцлагатай зөрчилдөж байгаагаар үл барам, төр ийм хэргийг өөгшүүлж байгаа хэлбэр мөн гэж дүгнэв. Үүний адил Мексик улсын Сьюдад Хуарес хотод болон ойр орчимд хэдэн зуун эмэгтэйчүүдийг хүчээр авч явж, хүчиндэж, амь насыг нь бүрэлгэсэн хэргийн талаар лавлагаа хийхдээ, уг Комисс бүтэн арван жилийн туршид олон хэрэг гарсаар байтал, гэр бүл доторхи хүчирхийллийг нийтлэг асуудал гэж үзэн гэмт этгээдүүдэд ял шийтгэлээс зайлсхийх, ял завших бололцоо олгосон асуудлыг сөхөн тавьсан. “Эмэгтэйчүүдийн эсрэг аймшигтай хүчирхийлэл нь нийтлэг шинжтэй болсон нь ялгаварлах үзлийн илрэл болсон” –ыг үл хайхран явж иржээ гэж Комисс тэмдэглэсэн.

268. Нотлох баримтыг цуглуулах гэх мэт эрүүгийн ажиллагаа эмэгтэйчүүдийг “давтан хохирогч” болгохгүйн тулд жэндэрийн мэдрэмж бүхий арга барилыг баримтлан явагдах ёстой. Хохирогч эмэгтэйчүүд хэргийн талаар мэдүүлэхээс ичиж зовон зайлсхийхэд хүргэхгүйн тулд хэтэрхий хүндрэлтэй, сэтгэл зүйн хувьд дарамт болохооргүй нотлох баримт цуглуулах ажиллагааг боловсруулж хэрэглэх шаардлагатай. Эрүүгийн мөрдөн шалгах ажиллагааг илүү жендерийн мэдрэмжтэй болгох стратегид хуулийн ажиллагааг энгийн болгох, боломжтой бол аппарат хэрэгсэл ашиглан хохирогчийн нууцлалыг хангах, хохирогчийг хамгаалж дэмжих арга хэмжээ авах, ажилтнуудыг сургаж бэлтгэх зэрэг шаардлага тавигдаж болох юм.

3. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн хохирогчдын хохирлыг барагдуулах

269. Ял шийтгэл оногдуулах үүрэг, хариуцлагын зэрэгцээ, хохирогчдын хохирлыг шударга, үр нөлөөтэй байдлаар барагдуулах арга хэмжээ авах нь төрийн үүрэг юм. Ерөнхийдөө хохирлоо барагдуулах эрхэнд шударга ёсыг эдлэх, хохирлоо нөхөн төлүүлэх, нөхөн сэргээх эмчилгээнд хамрагдах, гэмт хэрэг дахин давтагдахгүй байхын баталгаа гаргуулах зэрэг эрхүүд орно. Унгарын АТ-ийн хэрэгт нөхөн төлбөр нь бие сэтгэлийн хохирлоос гадна эмэгтэй хүний эрх зөрчигдсөн байдлын хэмжээ, далайцтай дүйцэхүйц байх ёстой гэж тодруулга хийжээ. Бразилийн Мариа да Пенья Майя Фернандесийн хэргийн талаар Америкийн улсуудын хүний эрхийн комиссоос гэр бүлийн хүчирхийллийн хохирогч нь өөрийн нөхрөөс хэрэг үйлдсэний хувьд нь, харин төрөөс хэргийг мөрдөн шалгаж эхэлснээс хойш 15 жилийн хугацаа өнгөрчихөөд байхад гэр бүлийн хүчирхийллийн хэрэг үйлдэгчид төр ял шийтгэл

оноож чадаагүй нь олон улсын хуулийн өмнө төрийн хүлээсэн үүрэг, хариуцлагатай зөрчилдөж байгаагаар зогсохгүй төр ийм хэргийг өөгшүүлж байсны хувьд “ёс зүйн болон бодит нөхөн олговрыг “ авах ёстой гэж үзсэн.

4. Дэмжих үйлчилгээ

270. Хүчирхийллийн золиос болсон эмэгтэйчүүд хоргодох байрны, эмнэлгийн, сэтгэл зүйн болон бусад дэмжлэг, хууль зүйн туслалцаа, олон улсын акт, бодлого, практикт хэрэгжиж байдаг бусад үйлчилгээг авах шаардлагатай. Унгарын АТ –ийн хэргийн тухайд, Унгарт тэр эмэгтэйг болон 2 хүүхдэд нь (1 нь тахир дутуу) дэмжлэг үзүүлэх хүн байхгүй тул хоргодох газар ч олж чадаагүй. Унгарын хуулинд зохицуулсан заалт байхгүй учир түүнийг хамгаалах, аюулгүй байдлыг нь хангах тогтоол ч гараагүй. Шүүхээс шийдвэрлэсэн шийдвэр нь “түүнийг өмнө нь хамтран амьдрагчийн зүгээс дахин дайралтад өртөхгүй баталгаа, яаралтай хамгаалалт болж чадаагүй” гэж Хороо үзсэн. Тус хорооноос гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид шударга ёсыг эдлэх, аюулгүй шуурхай боломж нээлттэй байх, шаардлагатай бол үнэ төлбөргүй хуулийн зөвлөгөө өгөх зэрэг нь хохирогч үр нөлөөтэй, хангалттай нөхөн төлбөр авах боломжийг бий болгоход зайлшгүй шаардлагатай.

5. Хандлага, ойлголтыг төлөвшүүлэх

271. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлд хүйсийн ялгавартай зан заншил, нийгэм соёлын зан үйлийн суурь дэвсгэрийн хүчин зүйлийг олон улсын хууль, практикт харгалзан үздэг. Эмэгтэйчүүдийн эсрэг ялгаварлан гадуурхалтын бүх хэлбэрийг устгах тухай конвенциос ялгаварлан гадуурхалд хүргэдэг нийгэм соёлын суурь дэвсгэр, нийгэм дэх эрэгтэй, эмэгтэй хүний уламжлалт хэв загварын талаар анхаарч ажиллахыг гишүүн улс орнуудаас хүссэн байна. “Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг эс хайхардаг, тэвчдэг тийм хууль зүй болон ёс заншлыг өөрчлөх” талаар Бэлум ду Парын Конвенциос улс орнуудад уриалсан байна. Африкийн эмэгтэйчүүдийн эрхийн Хартийн Протоколд, эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийн ёс заншлын нийгэм, соёлын үндэс суурийг өөрчлөн, ялгаварлан гадуурхах, хор нөлөөтэй практикийг арилгах талаар асуудлыг хөнджээ. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг ёсчилсон, гүнзгийрүүлсэн, тэвчсэн бүх хэвшмэл загварыг устгах нь зүйтэй гэж үзжээ. Ёс заншил, уламжлал, шашин шүтлэгийн асуудлаар халхавчлан эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг устгах үүргээсээ зайлсхийхгүй байх талаар олон улсын хууль тогтоомжинд онцлон тэмдэглэсэн байдаг.

272. Мексикийн Сьюдад Хуарес хотод болон ойр орчимд эмэгтэйчүүдийг хүчээр авч явж, хүчиндэж амь насыг нь бүрэлгэсэн хэргийн талаар лавлагаа хийхдээ, зан үйлийн тогтсон хэв шинж, нийгэм, соёлын суурь дэвсгэр энэ хэрэгт ямар үүрэг гүйцэтгэв гэдгийг Хороо судалж үзсэн. “Хүн амын ёс заншил ухамсарт гүн шингэсэн нийгмийн байгууллын талаарх үзэл бодол, нийгэм, соёлын тогтсон хэв шинж, нийгэм соёлын одоогийн суурь дэвсгэрийг үндсээр нь” өөрчлөх, “хүйсийн хүчирхийлэл зайлшгүй байдаг зүйл гэж үзэх ойлголтыг устгах” шаардлагатайг онцлон тэмдэглэсэн. Унгарын АТ –ийн хэргийн тухайд ч Хороо энэ асуудлыг хөндөж тухайн хэрэг нь Конвенцийн 5-ын а заалтыг зөрчсөн байна гэж үзсэн.

6. Чадавхи бэхжүүлэлт, сургалт

273. Хууль хэрэгжүүлэх байгууллагын, цагаачлалын, шүүхийн ажилтан, эмнэлгийн ба нийгмийн халамжийн ажилтнууд гээд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцдэг хэн боловч ийм хүчирхийлэлтэй жендерийн мэдрэмжтэй арга барилыг

баримтлан ажиллах ур чадвар эзэмшсэн байх шаардлагатай. Ийм төрлийн хүчирхийллийн талаарх сургалт, удирдамж, гарын авлага энэ ажилд ихээхэн тустай. Сьюдад Хуаресын хэргийн лавлагаанд, мөрдөн байцаалтын ажилд оролцдог төрийн бүх ажилтнууд мөрдөн байцаалтын арга зүйн талаар ч, мөн эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл нь эмэгтэй хүний эрхийг зөрчсөн асуудал гэсэн утгаар ч тодорхой мэдлэг эзэмших сургалт явуулж байх нь Конвенцийн гишүүн орнуудын төрийн үүрэг гэж Хорооноос онцлон заасан.

7. Мэдээ мэдээлэл, статистик

274. Үнэн зөв, олон талт мэдээ, мэдээлэл, бусад баримт нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн эсрэг тэмцэлд төрийн хүлээх үүрэг хариуцлагыг хянах, өргөжүүлэхэд нэн чухал ач холбогдолтой. Судалгаа явуулах, мэдээ баримт цуглуулах, статистикийн мэдээлэл боловсруулах зэрэг төрийн бусад үүргийн талаар Бодлогын механизм гэсэн хэсэгт дурдав.

Г. Олон улсын хэм хэмжээг үндэсний түвшинд хэрэгжүүлэхэд гарч буй бэрхшээлүүд

275. Дэлхий даяар эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл үргэлжлэн гарсаар байгаагаас үзэхэд олон улсын хэм хэмжээг үндэсний түвшинд хэрэгжүүлэх байдал хангалтгүй байна. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй холбоотой олон улсын өмнө хүлээсэн үүргийн хэрэгжилтэнд цоорхой гарч байгаад гэрээний байгууллагууд байнга анхаарал хандуулж ирлээ. Хүний эрхийн гэрээний бусад байгууллагын адил Эмэгтэйчүүдийн эсрэг ялгаварлан гадуурхалтыг арилгах хороо санаа зовниж байгаа асуудлуудыг олж тогтоож байна. Эдгээр асуудлуудын шийдвэрлэж байгаа сайн болон ирээдүйтэй арга барилын талаар 7 дугаар бүлэгт өгүүлэв.

1. Хууль тогтоомж, түүний хэрэгжилт

276. Гишүүн орнуудын хууль зүйн тогтолцоонд гэр бүлийн хүчирхийлэл, гэр бүлд үйлдэгдэх хүчин, ажлын байран дахь бэлгийн дарамт, эмэгтэй хүнд хор нөлөө үзүүлэх уламжлалт зан үйлийг хэрэглэх зэрэг хүчирхийллийг шийдвэрлэх тусгай хууль тогтоомж буюу хуулийн зүйл анги байхгүй байгаа нь Хүний эрхийн байгууллагуудын санаа зовоосон асуудал болж байдаг. Олон улс оронд эмэгтэйчүүдийг худалдахын эсрэг хууль байхгүй бөгөөд хохирогчдод хоргодох байраар туслан, тэдэнд жендерийн мэдрэмжтэй хандлагаар хандах хуулийн заалт байхгүй нь сэтгэл зовоосон асуудал юм гэж гэрээний байгууллагууд үзэж байна.

277. Харилцан зөвшөөрөл байхгүй нь бус хүч хэрэглэснээр нь хүчингийн хэргийг тодорхойлдог, зөвхөн бие махбодийн хүчирхийллийг гэр бүлийн хүчирхийлэл гэх, эмэгтэйчүүдийн эсрэг бэлгийн хүчирхийллийг эмэгтэйчүүдийн биеийн халдашгүй байх эрхийг зөрчсөн гэхээсээ гэр бүлийн нэр хүндийн эсрэг, нэр төрийн эсрэг хэрэг гэж үзэх, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн хэрэгт “нэр төрийн” өмгөөллийг ашиглах, түүгээрээ ял шийтгэлийг зөөлрүүлэх, хэрвээ хүчирхийлэгч этгээд хохирогчтой гэрлэвэл ял шийтгэлийг нь хөнгөрүүлэх заалт, худалдаалагдсан эмэгтэйчүүдийг хангалтгүй байдлаар хамгаалах, тэднийг хохирогч гэхээсээ илүү гэмтэн мэт үзэх, хохирогч өргөдлөө буцааж авбал эрүүгийн хэргийг хаах, хүчингийн хэргийн хохирогчийг үр хөндүүлсэнд нь торгууль ногдуулах, эрт болон хүчээр гэрлэснийг хуульчилсан байх, хүчирхийллийн үйлдэлд хангалтгүй ял шийтгэл оноох, ялгаварлан гадуурхаж ял оноох зэрэг улс орнуудын одоогийн мөрдөж байгаа

хууль тогтоомж, түүний заалтуудын талаар гэрээний байгууллагууд ихээхэн зовниж байдаг.

278. Зарим улсад хууль тогтоомж нь байгаа хэдий ч хэрэгжүүлэх механизм нь хангалтгүй талаар гэрээний байгууллагууд удаа дараа анхааруулж байдаг. Хууль хэрэгжүүлэх дүрэм, журам нь боловсроогүй, хууль хэрэгжүүлэх болон эмнэлгийн ажилтнуудын ажиллагааны талаарх тодорхой журам байдаггүй, эмэгтэй хүн хэргийн талаар мэдээлэхийг хуулийн ажилтнууд зогсоодог, цагдаа, прокурорын зүгээс хэргийг ихээр хэрэгсэхгүй болгодог, хохирогчид өргөдлөө буцааж авах байдал их байх, ял шийтгэл оногдуулах нь цөөн байх, шүүхээс хохирогчийг хамгаалах шаардлагын талаар нэгдсэн шалгуур үзүүлэлт тогтоохгүй байх, хуулийн туслалцаа авч чадахгүй байх, шүүхэд өмгөөлөл явуулах өртөг өндөр байх, эмэгтэйчүүдийг өөрсдийн нь зөвшөөрөлгүйгээр “хамгаалалтандаа авч” саатуулах, эрүүгийн болон гэр бүл салалттай холбоотой хэрэгт хохирогчид хохирол учруулах байдлаар хохирогч, хүчирхийлэгчийг эвлэрүүлэх шийдвэр гаргах зэрэг сэтгэл зовниулсан асуудлууд байдаг.

279. Зарим оронд батлагдсан хууль тогтоомжоос ёс заншлын хууль дээгүүр тавигдаж байдаг. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн хуулийг үл хайхарсан, ялгаварлан гадуурхсан шинжтэй ёс заншлын холбогдолтой хууль практик үйлчилсээр байгаад Хороо болон гэрээний бусад байгууллагууд маш эмзэглэж байдаг.

2. Сургалт

280. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн асуудлаар гарсан хууль тогтоомж, бодлогыг үр нөлөөтэй хэрэгжүүлэхийн тулд хэрэгжилтийг хариуцсан ажилтнууд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн бүх төрлийн талаар мэдлэг эзэмших, жэндэрийн мэдрэмжтэй хандах талаар сургалтанд хамрагдах ёстой.

3. Үйлчилгээний хүртээмж

281. Гишүүн улсууд хүчирхийллийн хохирогч эмэгтэйчүүдэд дэмжлэг үзүүлэх хангалттай арга хэмжээ авдаггүйд гэрээний байгууллагууд зовниж байгаагаа илэрхийлсээр байна. Хохирогчид хоргодох байр, хууль, эмнэлэг, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх нь төрийн хүлээсэн үүрэг гэдгийг гэрээний байгууллагууд онцлон тэмдэглэж байна. Эмэгтэйчүүдийн эсрэг ялгаварлан гадуурхалтыг устгах хороо үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудыг хангалттай байдлаар санхүүжүүлдэггүй, хүчирхийллийн хохирогчдод үйлчилгээ үзүүлэх хөтөлбөрт тавих хяналт байдаггүйд зовниж байдгаа илэрхийлжээ.

4. Хандлага ба хэвшмэл хэв загвар

282. Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхдаг уламжлал, ёс заншил, хүйсийн талаарх хэвшмэл хэв загвар, хууль болон хуулийн практикт эмэгтэйчүүдийн эсрэг ялгаварлан гадуурхалт байсаар байгаа зэрэг нь эмэгтэйчүүдийг захирагдлын байдалд байлгаж, түүгээрээ хүчирхийллийн эрсдэлд оруулж байдгийг гэрээний байгууллагууд онцлон тэмдэглэжээ. Ялгаварлан гадуурхалт, хэвшмэл хэв загварыг байнга мөнхөд хадгалах гэсэн хандлагууд нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, түүний дотроос хувийн амьдрал хэнд ч хамаагүй байх л зүйл хэмээн үзэгддэг гэр бүлийн хүчирхийллийг төрүүлж байдгийг гэрээний байгууллагууд тэмдэглэж ирлээ. Гэрээний байгууллагууд ийм хандлага хэв загварыг устгахын чухлыг гишүүн орнууддаа цохон тэмдэглэсэн байна.

5. Мэдээ мэдээлэл, судалгаа

283. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрүүдийн талаар системтэй мэдээлэл үгүй байгаа гэмт хэргийн хохирогчдын талаар хүйсээр заасан мэдээлэл байхгүй байгаад гэрээний байгууллагууд зовниж байна.

Е. Олон улсын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх төрийн үйл ажиллагаа

284. Улс орнууд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх талаар хуулийн болон бодлогын хүрээнд хүлээсэн үүргээ биелүүлэх үйл ажиллагааны хэм хэмжээг олон улсын хууль зүй бодлогын баримт бичгүүдэд заасан байдаг. Эдгээрийг доорхи төрөлжсөн хэсгүүдэд хувааж болно. Үүнд:

- Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрийг устгах конвенц түүний Сайн дураар биелүүлэх протокол зэрэг олон улсын хүний эрхийн бүх баримт бичигт нэгдэн орох
- Эмэгтэй хүний тэгш эрхийг баталгаажуулж, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг хориглох заалтуудыг үндсэн хуулиндаа оруулах
- Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрийг гэмт хэрэгт тооцох хууль тогтоомжийг батлах, шинэчлэх, жэндэрийн мэдрэмжтэй хандлагыг ашиглан хэрэгжүүлэх
- Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг устгах бодлого үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх, бодлого, үйл ажиллагааны төлөвлөгөөнд тогтмол хяналт үнэлгээ хийх
- Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн хэргийг шуурхай, төгс байдлаар, жендерийн мэдрэмжтэй арга барилаар шалгаж мөрдөх. Үүнд: бүх өргөдлүүдэд бүртгэл хөтлөх, шалган мөрдөх баримт цуглуулах ажлыг маш хянуур нямбай гүйцэтгэх, баримт цуглуулж хамгаалах, хэрэгцээтэй бол гэрчийг хамгаалалтанд авах, эмэгтэйчүүд дадлага, туршлагатай мэргэжлийн эмэгтэй ажилтанд мэдүүлэг өгөх гомдлоо гаргах бололцоогоор хангах гм.
- Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн бүх хэрэгт ял шийтгэл оноох, ийм хэрэгт ял завших аливаа уур амьсгалыг устгах
- Нотолгоо баримт цуглуулах зэрэг эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг үл ялгаварлан гадуурхах, жендерийн мэдрэмжтэй арга барилаар явуулж, хүчирхийллийн хохирогч эмэгтэйчүүд хэргийн талаар бодит мэдүүлэг өгөх байдлыг баталгаажуулах
- Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрийг үйлдэгчдэд гэм бурууд нь тохирсон ял шийтгэл оноох
- Хохирогчдын хохирлыг барагдуулах, хохирогч гэм буруутны эсрэг дахин иргэний шүүхэд хандах шаардлагагүйгээр ёс зүйн болон бодит нөхөн төлбөрөө гаргуулж авах бололцоогоор хангах арга хэмжээ авах
- Эмэгтэйчүүдийн эрхийн асуудлаар ерөнхийлөн, Эмэгтэйчүүдийн эсрэг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай Конвенц, түүний Сайн дураар биелүүлэх Протоколын талаар тухайлан шүүгч, прокурор, хуулийн бусад мэргэжилтнүүдэд танилцуулах сургалт, мэдлэг олгох хөтөлбөрийг хэрэгжүүлэх

-
- Хууль, эрх, эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээ, нийгмийн ажил, боловсрол, цагдаа болон цагаачлалын байгууллагуудын ажилтнуудыг сургалтанд хамруулан эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн нийгмийн хор хөнөөлийн талаар ойлголт өгөх
 - Хэвшмэл хэв шинжийг арилгах, бэлгийн давуу талын талаар аливаа зүйлийг сургуулийн хөтөлбөрөөс хасах, эмэгтэйчүүдийн талаар эерэг дүр төрх бүрдүүлэх, ээгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор нутгийн иргэдэд тулгуурласан сургалтын хөтөлбөрийг зохион байгуулж, дэмжих бололцоотой бол санхүүжүүлэх, бодлого хөтөлбөрт жендерийн тэгш байдлын талаар идэвхитэй, харагдахуйц бүрдэл хэсгийг дэмжиж оруулж өгөх зэрэг арга хэмжээгээр дамжуулан эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрийг устгах, энэ асуудлын талаар олон нийтийн мэдлэг мэдээллийг сайжруулах үйл ажиллагаа явуулах
 - Иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран дараахь салбаруудад үйлчилгээ бий болгох. Үүнд: хуулийн шударга ёсыг эдлэх, шаардлагатай бол үнэ төлбөргүй хуулийн зөвлөгөө авах, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаар эмэгтэйчүүдэд мэдэгдэх, мэдээлэл өгөх боломжоор хангагдсан аюулгүй, нууцлалыг хадгалах боломжтой орчинг бий болгох, хоргодох газрууд, тусламжийн үйлчилгээг хангалттай санхүүжүүлэх, эмнэлгийн тусламж зөвлөгөө өгөх үйлчилгээг хангалттай санхүүжүүлэх, шаардлагатай эмэгтэйчүүдэд хэл, соёлын хувьд хүртээмжтэй үйлчилгээ явуулах, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл үйлдэгчдэд сургалт явуулах, засч хүмүүжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх гэх мэт
 - Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэр гарч буй байдлын талаар аль болох нарийн мэдээлэлтэй байх үүднээс хохирогчдын нас, яс үндэс, хүчирхийллийн шалтгаан, үр дагавар, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх болон түүнтэй тэмцэх арга хэмжээний талаар системтэй мэдээлэл цуглуулах.

VII. Үр дүнтэй үйл ажиллагаа хэрэгжүүлэлтийн тэргүүн туршлага, бэрхшээлүүд

A. Оршил

285. Олон улс орнуудад эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэх хүчирхийлэлтэй тэмцэх үр дүнтэй үйл ажиллагааг Улсын зүгээс хүний эрхийг хангах үүргийнхээ үүднээс авч хэрэгжүүлж байна. Олон улс орнуудад эмэгтэйчүүдийн ТББ-уудаас эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг устгах олон талт арга хэмжээ, шинэлэг үйл ажиллагаануудыг авч хэрэгжүүлдэг бөгөөд зарим тохиолдолд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн бүхий л хэлбэрийг төгсгөл болгох чиглэлээр төрийн байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Хэдий тийм ч эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэгдэж буй хүчирхийлэлийн хэлбэр, болж байгаа нөхцөл байдал нь олон янз байдгаас олон улсын түвшинд хэрэгжүүлэх хамгийн үр дүнтэй үйл ажиллагааг тодорхойлоход амаргүй байсаар байна. Энэ чиглэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, ялангуяа янз бүрийн санаачлагуудыг үнэлж, дүгнэхэд шаардлагатай тогтвортой нөөц дутагдалтай байдаг нь үйл ажиллагааны ямар хэлбэр тохиромжтой болох талаар хэт ерөнхийлөх байдалд хүргэдэг. Ийм учраас энэ судалгаанд “үр дүнтэй”, “сайн” үйл ажиллагаа гэсэн тодорхойлолтыг ашигласан.

286. Үр дүнтэй үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтийн талаар одоог хүртэл ямар нэг нэгдмэл ойлголтонд хүрээгүй байна. Үйл ажиллагааны сайн, үр дүнтэй, үр ашигтай байх эсэх нь үнэлгээнд ашигласан стандарт болон орон нутгийн онцлогийн аль алианаас хамаардаг. Гэр бүлийн хэлбэрүүд, амьдралын хэв маяг, аж амьдрал болон төрийн хүчин чадавхи зэрэг нь харилцан адилгүй байдаг нь ижил төстэй асуудлуудыг адилгүй арга замаар шийдвэрлэхэд хүргэдэг. Үйл ажиллагаа үр дүнтэй байх нь тухайн улсын төрийн хэв маяг, түүний эмэгтэйчүүдийн тэгш байдлыг бий болгох чиглэлээр гаргаж байгаа эрмэлзэл, ТББ болон иргэний нийгэмтэй харилцах харилцаа энэ чиглэлийн үйл ажиллагаанд зарцуулж байгаа нөөц зэргээс ихээхэн хамаардаг. Зөрчилтэй асуудалд төр оролцож байгаа эсэх, мөн олон тооны дүрвэгсдийг хүлээн авсан тохиолдолд энэ нь бас нэг чухал хүчин зүйл болдог. Үйл ажиллагаа, өөрчлөлт, шинэчлэлийн ач холбогдлыг бууруулахгүй, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн эсрэг тэмцэлд төрийн гүйцэтгэх үүргийг бууруулахгүйгээр тодорхойлох нь бэрхшээлтэй асуудал юм.

287. Дэлхийн улс орнуудын үйл ажиллагаанд авч хэрэглүүштэй, үр дүнтэй олон хэлбэрийн туршлага байдаг. Иймэрхүү үйл ажиллагааны ерөнхий зарчимд хүчирхийлэл бол хууль бус зүйл гэдгийг тодорхой бодлого, хууль дүрмээр тунхаглах, түүнийг хэрэгжүүлэгч хүчтэй механизмыг бий болгох, сайн сургаж бэлтгэгдсэн боловсон хүчин, олон салбаруудын идэвхитэй оролцоо, мөн орон нутгийн эмэгтэйчүүдийн байгууллагууд, иргэний нийгмийн байгууллагууд, эрдэмтэн, мэргэжилтнүүдтэй ойр хамтран ажиллах зэрэг олон хэлбэрийн үйл ажиллагаа хамаарна. Бүхий л хэлбэрийн ялгаварлан гадуурхах байдлаас үүссэн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн туршлага дээр тулгуурлах замаар бодлого, хөтөлбөрүүдийг боловсруулахад эмэгтэйчүүдийг бүрэн хамруулах нь чухал. Бүх салбарт үйл ажиллагааг үр дүнтэй болгоход эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг арилгах улс төрийн эрмэлзэл чухал төдийгүй засгийн газрын өндөр албан тушаалын ажилтнуудын зүгээс тодорхой үйл ажиллагаа явуулж шийдвэр гаргах зэрэг бодитой үйл ажиллагаагаар дэмжих нь чухал.

288. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг устгахад чиглэсэн үр дүнтэй үйл ажиллагаа нь урьд өмнө явуулж байсан үйл ажиллагааны туршлага, сургамж дээр тулгуурлан, тодорхой нөхцөл байдалд бий болдог. Үр дүнтэй үйл ажиллагааг түүний үр нөлөө, уян хатан байдал, тогтвортой хэрэгжих боломж, тохиромжтой байдал, хэрэгцээнд нийцсэн байдал, үр дүн, шинэлэг байдал зэрэг олон шалгуураар үнэлдэг. Мөн үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх үйл явцыг харгалзан үр дүнтэй сайн үйл ажиллагаа гэж үзэж болно. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаар өмнөх Тусгай ажилтан хэлэхдээ үйл ажиллагаа нь бодитой өөрчлөлт рүү хөтлөн дагуулсан, хүйсийн тэгш байдлыг бий болгох, эмэгтэйчүүдийн хувьд уламжлалт бус үйл ажиллагааны шинэ хэлбэрийг бий болгоход чиглэсэн бодлогын орчинг бүрхэгдүүлэхэд нөлөөлсөн нөхцөлд үр дүнтэй, сайн үйл ажиллагаа болж чадна гэж тодорхойлсон.

289. Засгийн газар, ТББ-ууд болон иргэний нийгмийн байгууллагуудын хамтын ажиллагаа, үйл ажиллагааны зохицуулалт нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг арилгах үр дүнтэй үйл ажиллагааг боловсруулахад чухал нөлөөтэй байсаар байна. Жишээ нь, хөтөлбөр боловсруулах болон хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хамгийн идэвхитэй, мэдээлэл сайтай хамтрагчдын мэргэжлийн туршлага мэдлэг дээр тулгуурласан эмэгтэйчүүдийн бүлгүүд, сүлжээ зэрэг Засгийн газар, ТББ-уудын хамтын холбоо, эвслүүдийг оролцуулах. Шүүхийн тогтолцоо, эрүүл мэнд, боловсрол, ажил олгогч салбар зэрэг засгийн газрын салбаруудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах нь үр дүнтэй үйл ажиллагааны хэлбэр болж байна. Мөн эмэгтэйчүүдийн

эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа бүлгүүд, бусад БЗХӨ/ДОХ, эмэгтэйчүүдийн эдийн засгийн хүчин чадавхийг дээшлүүлэх, болон бусад нийгмийн тулгамдсан асуудлуудаар үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын хамтын ажиллагааны эвсэл холбоо байгуулах нь мөн үр дүнтэй сайн үйл ажиллагаанд тооцогдож байна.

290. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн асуудлаар ажилладаг засгийн газар, ТББ-ууд, эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалагч байгууллагууд нь хууль, үйлчилгээ үзүүлэх, хүчирхийлээс сэргийлэх зэрэг үндсэн гурван чиглэлээр өөр хоорондоо уялдаа холбоогүй, өөр өөр үйл ажиллагаануудыг явуулж байна. Олон орны Засгийн газар эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх тэмцэлд хуулийн арга хэмжээ, үйлчилгээ үзүүлэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг багтаасан үндэсний хэмжээний үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж байна. Ийм хэлбэрийн төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааны үр дүнтэй хэлбэр нь эмэгтэйчүүдийн бүлгүүд, бусад иргэний нийгмийн байгууллагуудтай зөвлөлдөх, тодорхой хугацаа, шалгуур үзүүлэлтүүдийг бий болгох, үйл ажиллагааны хэрэгжүүлэх ил тод механизмыг бий болгох, үнэлгээний тодорхой үзүүлэлтүүд, санхүүжүүлэх боломжтой эх үүсвэрийг тодорхойлох, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааг бусад хөтөлбөрүүдтэй уялдуулах зэрэг болно.

291. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн эсрэг тэмцэлд улсын зүгээс хүлээх үүрэг буюу энэ үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад гарч байгаа алдаа дутагдлын талаар 6 дугаар бүлэгт өгүүлэх болно. Энэ бүлэгт үндэсний түвшинд явуулж байгаа үйл ажиллагааны дутагдалтай талыг бусад салбаруудад үр дүнгээ өгсөн шилдэг аргуудыг танилцуулан хэрэгжүүлснээр нөхөх боломжтой болохыг тодорхойлсон. Эдгээр аргууд нь мэдээллийн хувьд арай илүү хүртээмжтэй байдаг гэр бүлийн хүчирхийлэл, бэлгийн хүчирхийлэлтэй тэмцэх арга туршлага дээр тулгуурлан боловсруулагдсан боловч өргөн хүрээний үйл ажиллагаа явуулахад ашиглах боломжтой. Жишээ болгон авсан жагсаалт нь төгс бус цаашид гарч болох юм. Туршлага нэмэгдэх тусам үйл ажиллагааны одоогийн арга барил нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх илүү үр дүнтэй шинэлэг аргуудаар баяжигдаж байдаг. Ийм хэлбэрийн шинэлэг арга зүйг үйл ажиллагаандаа ашиглахыг дэмжих нь заналхийлэлд өртөгч талуудын илэрхийлдэг хууль эрх зүйн орчны болон түүнийг хэрэгжүүлэх явцад гардаг бэрхшээлүүд, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үйлчилгээ үзүүлэх явцад тохиолддог асуудлуудыг шийдвэрлэх боломжийг давхар олгодог .

Б. Хууль эрх зүйн орчны үр дүнтэй үйл ажиллагаа

292. Үндсэн хууль болон түүнтэй дүйцэхүйц бусад хууль тогтоомжинд хүйсийн тэгш байдлыг хангах асуудлыг хуульчлан тусгах, ялгаварлан гадуурхах үйлдлийг бүхий л салбарын хууль тогтоомжинд тусгах нь эмэгтэйчүүдийг хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлж, үр дүнтэй арга зүйг хэрэгжүүлэхэд их түлхэц болдог. Хууль нь буруу зөвийн стандартыг тогтоох, эрэн сурвалжлах, баривчлах, хүчирхийлэл үйлдэгсдийг шийтгэх, болон хохирогсдыг эмчлэх зэрэг замаар буруу үйлдэл хийгсдийг зогсоох арга хэмжээ авдаг. Хуулиуд нь хуулийн байгууллага болон нөөцийн хуваарилалт, хохирогчдод зориулсан үйлчилгээг хүртээмжтэй байлгах нөхцлийг бүрдүүлдэг. Хуулиуд нь дангаараа хангалттай бус ба олон нийгэд хандсан бодлого, мэдээлэл сурталчилгаа, үйлчилгээ, урьдчилан сэргийлэх өргөн хүрээтэй үйл ажиллагааны бүрэлдэхүүн хэсэг байснаар үр дүнтэй.

1. Эрх зүй, хуулийн байгууллагын үйл ажиллагааны үндсэн зарчмууд

293. Үйл ажиллагааны туршлагаас харахад хуулиуд нь үйл ажиллагааны тодорхой зарчмууд дээр тулгуурлан, түүнийг мөрдсөн нөхцөлд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй үр дүнтэй тэмцэхэд чухал үүрэг гүйцэтгэх боломжтой. Эдгээр зарчмууд нь:

- Жендерт суурилсан ялгаварлан гадуурхах үйлдлийн нэг хэлбэр болсон эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааг эмэгтэйчүүдийг хүчирхийлэх, эмэгтэйчүүдийн эрхийг зөрчих бусад хэлбэрүүдтэй уялдуулах
- Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл нь огт хүлээн зөвшөөрөх ёсгүй асуудал бөгөөд түүнийг бүрмөсөн устгах нь олон нийтийн үүрэг байх ёстой гэдгийг олон нийтэд ойлгомжтой болгох.
- Амьдралд хэрхэн хэрэгжиж байгаа байдалд үнэлгээ хийх замаар хуулийн шинэчлэлтийн хэрэгжилтэнд хяналт тавих
- Хууль эрхийн баримт бичгүүдийг байнга хянаж, нягтлан шинэ мэдээлэл, ойлголтонд тулгуурлан байнга шинэчилж байх
- Хохирогчдыг хуулийн байгууллага, тэдний үйл ажиллагааны явцад дахин хохирохгүй байх нөхцлийг бүрдүүлэх
- Эмэгтэйчүүдийн байгууллагыг дэмжин, хохирогч эмэгтэйчүүдийн өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг дэмжих
- Олон нийтийн газруудад эмэгтэйчүүдийн аюулгүй байдлыг хангахад анхаарах
- Эмэгтэйчүүдийн арьсны өнгө, нийгмийн байр суурь, яс үндэс, шашин, зан соёл, уугуул болон цагаач, нас, бэлгийн зан үйл зэргийн ялгаатай байдлыг тэдэнтэй ажиллах үйл ажиллагаандаа анхааран үзэх

2. Хууль, эрх зүйн тогтолцоо

(а) Хууль тогтоомжийг батлах

294. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн тодорхой хэлбэрүүдийг хориглох хуулийн хэрэгжилтийг сайжруулах нь ийм хэлбэрийн хүчирхийллийг арилгах чухал үе шат болдог. Ийм хэлбэрийн хуулийг боловсруулах үйл ажиллагааны үр дүнтэй хэлбэр нь иргэний нийгмийг, ялангуяа хохирогч эмэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагууд, тухайн хуулийн хэрэгжилтийг амьдрал дээр зохион байгуулдаг хүмүүсийг оролцуулсан өргөн хүрээтэй ярилцлага өрнүүлэх, тэдний санал бодлыг тусгах явдал юм. Жишээ нь, 2004 оны Испанийн Хүчирхийллээс хамгаалах хууль нь эмэгтэйчүүдийн байгууллагуудын идэвхитэй оролцоотой боловсруулагдсан бөгөөд хүчирхийллийн бүхий л хэлбэрүүд болох бэлгийн, харгислал, заналхийлэл, хүчирхийлэл, хүсээгүй зүйлийг нь шахан тулгах зэрэг сэтгэл зүйн хүчирхийллийн хэлбэрүүдийг тодорхойлсон.

(б) Хуулийн хэрэгжилт

295. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн асуудлаарх хууль нь хэрэгжихгүй нөхцөлд үр дүнгээ өгөхгүй. Хуулийн хэрэгжилт нь хуулийг хэрэгжүүлэх албаны ажилтнуудын хүйсийн мэдрэмжийг дээшлүүлэхэд чиглэсэн, заавал оролцох системтэй сургалтуудыг зохион байгуулснаар сайжрах боломжтой. Түүнчилэн

эмэгтэйчүүдийн хуулийн ерөнхий болон түүний хамгаалах боломжуудын талаарх мэдлэг, хуулиар олгогдсон эрхээ зөв эдлэх чадвар зэргээс бас ихээхэн хамаарна.

296. Хуулийг хэрэгжүүлэх үүрэг бүхий ажилтнуудын хүйсийн мэдрэмжийг дээшлүүлэх сургалт нь олон орнуудад засгийн газар, иргэний нийгмийн байгууллагуудын хамтын оролцоотойгоор зохион байгуулагддаг. Эдгээр сургалтуудыг үр дүнтэй болгоход системтэй төдийгүй заавал оролцуулах шаардлага тавих нь чухал ач холбогдолтой. Жишээ нь: Бразил, Парагвай улсад цагдаагийн сургагчдад эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн асуудлаар заавал суух хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж байна. Люксембургийн эмэгтэйчүүдийн асуудлаарх яамнаас үндэсний цагдаагийн удирдлагууд, үндэсний цагдаагийн академийн ажилтнууд, төрийн хууль тогтоох байгууллагын ажилтнуудад сургалт явуулдаг. БНСУ-ын үндэсний цагдаагийн байгууллага нь ажилтнууддаа гэр бүлийн хүчирхийллийн хууль, мэдээллийн дагуу үйл ажиллагаа явуулах журам, хохирогчийг хамгаалах үе шатуудын талаар сургалт явуулдаг. Түүнчлэн эдгээр асуудлуудаар үндэсний хэмжээний цагдаагийн албан хаагчдаас шалгалт авдаг. Чили Улсад гэр бүлийн асуудлын хүрээн дэх хүчирхийллийн яам дундын комиссын боловсруулсан хөтөлбөрөөр 25 мянга гаруй ажилтнуудыг сургасан. Нидерландад гэр бүлийн хүчирхийллийн үндэсний хэмжээний төслийг 2003 онд цагдаагийн комиссаруудын зөвлөлөөс хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд цагдаагийн бүх байгууллагуудыг гэр бүлийн хүчирхийллийн асуудлаар ажиллах, бодлого боловсруулах, мэргэжилтнүүдийг бэлтгэх, үндэсний хэмжээнд гэр бүлийн хүчирхийллийн асуудлыг бүртгэх боломжийг бүрдүүлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Бангладешийн эмэгтэйчүүд, хүүхдүүдийн судалгааны төвөөс цагдаагийн ажилтнуудад зориулсан хохирогчдын хэрэгцээ болон гэр бүлийн, бэлгийн, бусад хэлбэрийн хүчирхийлэлтэй тэмцэхэд хуулийг хэрэгжүүлэх албаны ажилтнуудын үүргийн асуудлуудыг хамарсан сургалтын гарын авлага боловсруулсан.

297. Эмэгтэй шүүгчдийн олон улсын холбооноос Африк, Латин Америк дахь хамтрагчидтайгаа хамтран боловсруулсан шүүгчдийн хүйсийн мэдрэмжийг дээшлүүлэхэд чиглэсэн хөтөлбөр нь хуулийн өмнө тэгш эрхтэй байх асуудлыг багтаасан. Энэ хөтөлбөр нь шүүгчдийн эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн холбогдолтой хэргүүдэд олон улсын болон бүсийн хүний эрхийн хуулийг хэрхэн ашиглах талаар мэдлэгийг дээшлүүлнэ. Эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллага Сакши нь хуулийн байгууллагын ажилтнуудыг харилцан ярилцлага, жижиг бүлгээр асуудлыг шийдвэрлэх дасгал, халамжийн төвүүдэд очих, ТББ-ын ажилтнуудтай уулзуулах зэрэг хэлбэрээр эмэгтэйчүүдийн байдлыг илүүтэй ойлгуулах зорилгоор сургалт зохион байгуулсан. Эмэгтэйчүүд ба хууль-Африкийн хөгжил нэртэй ТББ нь хуульчдад зориулсан сургалтын багцыг бэлтгэсэн. Филиппинд иргэний нийгмийн оролцоотойгоор Хүйсийн Шударга Байдлын шагналыг эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл гарсан тохиолдолд хүйсийн мэдрэмжтэй хандаж шийдвэр гаргасан шүүгчдийн үйл ажиллагааг үнэлэх зорилгоор Засгийн газраас зохион байгуулсан.

298. Хуулийг хэрэгжүүлэх удирдамж журам, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн бодлогыг хэд хэдэн орнуудад боловсруулсан. Ийм удирдамж, журмууд нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн асуудлаар ажилладаг цагдаа, бусад байгууллагуудад дагаж мөрдвөл зохих тодорхой стандартыг бий болгосноороо тэргүүн туршлага болсон юм. Өмнөд Африкийн цагдаагийн байгууллага болон үндэсний хууль тогтоох байгууллагаас гэр бүлийн хүчирхийлэл, бэлгийн заналхийллийн тохиолдлыг хэрхэн шийдвэрлэх стандартыг бий болгосон. Нэгдсэн Вант Улсад цагдаа, нийгмийн ажилтнууд, боловсролын байгууллагын ажилтнуудад зориулсан хүчээр гэр бүл болох асуудлаар ажиллах удирдамж байдаг.

299. Эмэгтэйчүүдийн эрхийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх, энэ эрхээ амьдрал дээр хэрэгжүүлэх чадавхийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн эмэгтэйчүүдэд эрх олгох хөтөлбөр, стратегиуд олон оронд боловсруулагдаж ТББ-аар дамжин хэрэгжиж байна. 2004 онд Афганистаны эмэгтэйчүүдийн нөөцийн төвөөс Афганистаны алслагдсан дүүргийн 500 гаруй эмэгтэйчүүдийг тэдний эрхийн асуудал, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, хүчээр гэр бүл болгох асуудлуудаар сургалтанд хамруулсан. Тимор Лесте, Фокуперс ТББ-аас хохирогч эмэгтэйчүүдэд зориулан хуулийн туслалцаа үзүүлэх үйлчилгээг үзүүлдэг бөгөөд гэр бүлийн хүчирхийлэл эмэгтэйчүүдийн хууль ёсны эрхийн асуудлаарх мэдлэгийг дээшлүүлэхэд тусалдаг. Энэ байгууллагын Бабадок нэртэй сэтгүүл болон олон нийтийн мэдээллийн танилцуулагыг үйлчилгээ үзүүлэгч, шашны байгууллага, Засгийн газрын байгууллагууд, хууль боловсруулагчдад тараадаг.

(в) Хууль тогтоомжид хяналт шинжилгээ хийх

300. Хуулийн хэрэгжилтэнд хяналт тавих, үнэлэх үр дүнтэй аргууд нь хяналтын байгууллагад үндэсний мэдээлэх, ажиглах, хүйсийн тэгш байдлыг хангах байгууллагуудаас эдгээр механизмыг үр дүнтэй ашиглах явдлыг дэмжихэд чиглэгддэг. Жишээлбэл, Непал болон Нидерланд улсуудад хүн худалдаалахтай холбогдсон үйл ажиллагаанд хяналт тавих үндэсний байгууллага ажилладаг.

301. Хууль болон бодлогын хэрэгжилтэнд хяналт тавих үйл ажиллагаанд иргэний нийгмийн байгууллагууд чухал үүрэг гүйцэтгэдэг. Европын эмэгтэйчүүдийн лобби бүлэг нь Европын холбооны хамгийн том, эмэгтэйчүүдийн бусад холбоодын удирдах байгууллага бөгөөд 1997 онд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн асуудлаар Европын ажиглалтын байгууллагыг байгуулсан. Энэ байгууллага нь Европын холбооны гишүүн орон бүрээс нэг эмэгтэй мэргэжилтнийг багтаадаг ба үндэсний, Европын болон олон улсын хэмжээнд бодлогын хэрэгжилтэд хяналт тавих, тэргүүн туршлагыг олж илрүүлэн бусад орнуудад түгээн дэлгэрүүлэх үүргийг гүйцэтгэдэг. Түүнчилэн Европын таван оронд үндэсний хэмжээний ажиглах байгууллагыг байгуулсан.

(г) Хууль тогтоомжуудыг тогтмол хянан үзэж, шаардлагатай өөрчлөлтүүдийг хийх

302. Хууль тогтоомжуудыг тогтмол хянан үзэж, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн асуудал, түүнийг шийдвэрлэх арга замын талаарх шинэ мэдээллүүд, олон улсын хүний эрхийн хууль, түүнийг хэрэгжүүлэх, хянах, үнэлэх явцад гарсан шинэ соргог мэдээллүүдийг тусган, шаардлагатай өөрчлөлтүүдийг хийх нь үр дүнтэй арга юм. Белим дү Парб-ын конвенц нь Латин Америкийн орнуудад эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн хуулийг гаргахад нөлөөлсөн ийм хэлбэрийн хуулиудыг хэрэгжүүлэх явцад ажиглагдсан шинэ санаанууд нь Белаиз, Перу, ПуэртоРикод гэр бүлийн хүчирхийллийн хууль зэрэг олон хуулиудыг өөрчлөхөд хүргэсэн бөгөөд түүний хэрэгжилт үр дүнг дээшлүүлэхэд нөлөөлсөн.

303. Шинэчлэгдсэн мэдлэг нь хууль тогтоомжид шинэ стандартуудыг оруулахад нөлөөлсөн. Канадад бэлгийн хүчирхийллийн улмаас шийтгэгдэж байгаа хүмүүс энэ үйл ажиллагаанд зөвшилцөл байсан эсэх, хохирогч түүний эсрэг татгалзсан эсэх зэргийг тодорхойлох хэд хэдэн үе шаттай мөрдөн байцаалт явуулах шаардлагатай байдаг. Гэрлэгсдийн хүчингийн асуудлыг олон орнуудад хуулийн заалтаас хассан байдаг боловч зарим орнуудад үүнийг гэмт хэрэг гэж үздэг. (10 дугаар хүснэгтийг үзнэ үү) Тунист “нэр хүнд”-ийг хамгаалах нэрийдлээр эмэгтэйчүүдийн амийг хөнөөх гэмт хэрэгт оногдуулах шийтгэлийг үгүй болгосон байхад, Туркт ийм хэлбэрийн

гэмт хэрэгт насаар нь хорих ял оноодог ажээ. Сэтгэл зүйн болон эдийн засгийн хүчирхийлэл нь Коста Рика, Гватмал, Гондурас, Өмнөд Африк зэрэг хэд хэдэн орнуудад гэр бүлийн хүчирхийлэлд тооцогддог.

3. Эрүүгийн хууль

(а) Гэмт хэрэгтэнд ял шийтгэл оногдуулах

304. Хүчирхийлэл үйлдэгчийг баривчлах, ял шийтгэл хүлээлгэх бодлого нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл нь ноцтой гэмт хэрэг гэсэн ойлголтыг нийгэмд төрүүлдэг. Гэвч эмэгтэйчүүдийн эсрэг гэмт хэргийн мэдээлэгдсэн ихэнх тохиолдол ял шийтгэлгүй өнгөрдөг төдийгүй, эдгээрийн ихэнх нь огт буруутгүй болж өнгөрдөг. Гэмт хэрэг үйлдэгчид буруутгагдсан тохиолдолд ч ихэвчлэн үйлдсэн хэргийнхээ гэм бурууд тохирсон шийтгэл хүлээдэггүй. Эмэгтэйчүүдийг хууль хяналтын байгууллагад хандах боломжийг бүрдүүлэх тухайлбал, цаг алдалгүй гэмт хэрэгтнийг баривчлах үр дүнтэй хяналт шалгалт явуулах, шийтгэх зэрэг арга хэмжээ нь тэргүүн туршлага мөн. Хэд хэдэн байгууллагуудын хамтарсан төсөл болох Австралийн Камбира дахь гэр бүлийн хүчирхийллийн хөтөлбөр нь гэр бүлийн хүчирхийллийн нэг ч тохиолдлыг хяналтын гадуур орхигдуулахгүй байх чиглэлээр хууль хяналтын байгууллагынхантай ажилладаг. Тэд хамтрагч байгууллагуудын хэлэлцэн тохиоролцсон протоколын дагуу хохирогч болон гэмт хэргийн үйлдлийг баримтжуулах замаар шүүхэд үзүүлэх нотолгоо, баримттай байлгах арга зүйг ашигладаг. Энэ төсөл хэрэгжсэнээр хүчирхийлэл үйлдэгчид шийтгэл хүлээлгэсэн тохиолдол 288 хувиар өссөн.

306. Зарим нэг гэмт хэрэгтэнд хамгийн бага ялыг оноож, үйл ажиллагаанд нь нарийн хяналт тавих нь шийтгэл оноох хамгийн тохиромжтой хэлбэр юм. Шри Ланка зэрэг хэд хэдэн орнууд хүчингийн хэрэгт хамгийн бага хугацаагаар шоронд хорих шийтгэл оноодог. Нэгдсэн Вант Улсын хотын ерөнхий шүүгч нь бүх оноосон ял шийтгэлд хяналт тавьж хэрэв хүндэдсэн гэж үзвэл эрүүгийн хэргийн шүүх рүү хэргийг шилжүүлдэг.

(б) Хохирогчийн эрхийг хамгаалах

307. Хүчирхийллийн хохирогч болсон эмэгтэйчүүд бусдаас ичих, эрүүгийн хуулийн системийн шийтгэлээс айх зэрэг шалтгаанаар ихэвчлэн хуулийн байгууллагад ханддаггүй. Хохирогчийн аюулгүй амьдрах эрхийг хамгаалах, тэдний хувь хүний халдашгүй дархан байдал, нэр хүндийг хүндэтгэх системийг бий болгох зэрэг нь үр дүнтэй аргууд бөгөөд мэдээлэх үр дүнтэй аргуудыг нэмэгдүүлэхэд чухал хөшүүрэг болдог.

308. Олон улс орнууд хохирогчийн бэлгийн зан үйлтэй холбогдолгүй тохиолдлуудыг хяналт шалгалтын явцад хохирогчийн эсрэг ашиглахаас урьдчилан сэргийлэх замаар хүчингийн хэргийн хохирогчдыг хуулиар хамгаалах замаар дээрх зорилтыг биелүүлж байна. Филиппинчүүд хүчингийн хэргийн хохирогчдод үзүүлэх тусламж, тэднийг хамгаалах хуулийг 1998 онд бий болгосон нь нэг жишээ юм. Болсон явдлыг дүрс бичлэгээр харуулах буюу шүүхийн танхимд олон нийтийг оруулахыг хориглох зэрэг хохирогчийн халдашгүй дархан эрхийг хамгаалах шүүхийн танхим дахь журмуудыг Финланд, Ирланд, Япон, Непал зэрэг олон орнуудад өргөн хүрээтэй ашиглаж байна.

309. Хохирогчдыг эрүүгийн шүүн таслах үйл явцад дахин хохироохоос зайлсхийх үйл ажиллагаанд зарим нэг ахиц гарч байна. Жишээлбэл, хүчингийн тохиолдолд “онгон эсэхийг шалгах” шалгалтыг Иордан болон Туркт хориглосон. Египет, Коста

Рика, Этиоп, Перу, Турк зэрэг орнуудад хүчингийн хэрэг үйлдэгч нь хохирогчтойгоо гэрлэсэн тохиолдолд шийтгэлээс чөлөөлөхийг зөвшөөрдөг.

4. Иргэний эрх зүйн хамгаалалт

310. Эрүүгийн арга хэмжээг нөхөхүйц иргэний хуулиуд нь хохирогчдод учирсан хохирлыг барагдуулах, нөхөн сэргээх үйлчилгээ хүртэх боломжийг олгоход чухал үүрэг гүйцэтгэдэг. Иргэдийг хамгаалах журам, ялгаварлан гадуурхахын эсрэг хууль тогтоомжууд, гэмт хэрэг үйлдэгчийг шийтгэх, төрийн үйлчилгээний ажилтнуудыг хохирогчдын нөхөн төлбөрийг олгуулахаар хүсэлт гаргахыг дэмжсэн иргэний хуулиуд, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн хэргүүдийг багтаасан хохирогчийн нөхөн төлбөр олгох сан зэрэг иргэдийн эрх ашгийг дээдэлсэн үйл ажиллагаанууд тэргүүн туршлагад тооцогдоно.

311. Тогтоосон хугацааны туршид гэмт хэрэг үйлдэгчдийг хохирогчтой уулзахыг хязгаарлах, тэднийг гэрээс нь тусгаарлах замаар эмэгтэйчүүдийг болзошгүй хүчирхийллийн заналхийллээс хамгаалахад иргэдийг хамгаалах журмын зорилго оршидог. Иймэрхүү журмуудыг дэлхийн улс орнууд өргөнөөр авч хэрэгжүүлж байна. Гэр бүлийн хүчирхийллээс сэргийлэх тухай Австрийн Холбооны хуульд цагдаа хүчирхийлэл үйлдэгчийг гэрээс нь тусгаарлах шийдвэр гаргаж хохирогчийн гэрээс 10-20 хоногийн хугацаагаар хол байлгах арга хэмжээ авах эрхтэй байдаг. Мөн шүүх байгууллагын түр хугацааны захирамжаар удаан хугацааны хамгаалах үйл ажиллагааг явуулдаг. Энэ хуулийг Герман зэрэг Европын бусад орнуудад авч хэрэгжүүлж байна.

312. Ихэнх орнуудад хуулиар эмэгтэйчүүд хүчирхийлэл заналхийлэл, сэтгэл зүйн хохирлын асуудлыг олон нийтийн шүүхээр шийдвэрлүүлэх эрхийг олгосон боловч ихэвчлэн тэд үүнийг хийдэггүй. Иргэний шүүх нь учирсан хохирлыг мөнгөн илэрхийллээр нөхөх шийдвэр гаргаж болох юм. Хүчирхийллийн хохирогчид, тэдний гэр бүлийнхэн гэмт хэрэг үйлдэгчдийн эсрэг төдийгүй хохирогчдын эрх ашгийг хамгаалах чиглэлээр бодитой ажил хийж чадаагүй хуулийг хэрэгжүүлэгч ажилтнуудын эсрэг иргэний гомдол гаргах боломжтой.

313. Ялгаварлан гадуурхахын эсрэг хууль болон эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг эмэгтэйчүүдийн хүний эрхийг зөрчиж байгаа зүйл гэж тодорхойлсон хуулиуд нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл нь зөвхөн нэг хувь хүн нөгөөгийнхөө эсрэг үйлдэж буй хэрэг бус, тэгш эрхтэй байх тухай олноороо хүлээн зөвшөөрсөн үзэл санааны эсрэг үйлдэж байгаа гэмт хэрэг мөн гэсэн мэдээллийг олон нийтэд хүргэж байгаагаараа үр дүнтэй арга зүй юм. АНУ-ын Нью Йорк зэрэг зарим муж нутгуудад эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн аливаа үйлдэл нь эмэгтэйчүүдийн эрхийг зөрчиж буй хэрэг болохыг тодорхойлдог хууль гаргасан. Өмнөд Африкийн тэгш байдлыг дэмжих, шудрага бус ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх хууль нь жендерт суурилсан хүчирхийлэл нь шудрага бус ялгаварлан гадуурхалт мөн бөгөөд улсын болон хувийн байгууллагын хууль сахиулагчид ялгаварлан гадуурхах явдлыг арилгах тэгш байдлыг дэмжих, үр дүнтэй арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг шаардсан. Шинэ Зеланд зэрэг хэд хэдэн орнуудад бэлгийн дарангуйллыг ялгаварлан гадуурхах болон эмэгтэйчүүдийн эрхийг зөрчиж буй нэг хэлбэр гэж үздэг.

5. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх тусгай хууль, тогтоомж

314. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх тусгай хууль, журмуудыг гаргах нь улсын зүгээс энэ хэлбэрийн хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, эмэгтэйчүүдийн

эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх үр дүнтэй арга юм. Зарим орнуудад эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх тусгай хууль, журмуудыг энэ асуудлыг шийдвэрлэх зорилгоор гаргасан. Жишээ нь: АНУ-д 1994 онд баталсан эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн холбооны хууль нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн давтамжийг бууруулах, хохирогчдод шаардлагатай тусламж үзүүлэх, гэмт хэрэг үйлдэгчдэд хариуцагаа тооцох, хуулийн хэрэгжилтийг сайжруулах, судалгаа мэдээллийн чанарыг сайжруулах, цагаач эмэгтэйчүүдийг хүчирхийлэгчдээс аврах зорилгоор цагаачлалын хуульд өөрчлөлт оруулах зэрэг асуудлуудыг багтаасан. Цагдаагийнхан, шүүхийн ажилтнуудыг сургах, эмэгтэйчүүдийг халамжийн, хүчингээс сэргийлэх хөтөлбөрүүдийг дэмжих, гэр бүлийн хүчирхийллийн үндэсний хэмжээний үнэгүй итгэлтэй утсыг ажиллуулах, орон нутгийн мужийн холбооны хэмжээний хууль сахиулах байгууллагуудын мэдээллийн бүртгэлийн болон мэдээлэл түгээх системүүдийг бий болгох зэрэг үйл ажиллагаанд улсын зүгээс нэг тэрбум америк доллар гаргахыг зөвшөөрсөн. Филиппинд эмэгтэйчүүд, тэдний хүүхдүүдийн эсрэг хүчирхийллийн хуулийг 2004 онд батлан гаргаж гэр бүлийн болон ойр дотно харилцаатай хүмүүсийн хооронд үүссэн биеийн, бэлгийн, сэтгэл зүйн, эдийн засгийн хүчирхийллийг гэмт хэрэг гэж үзэхийг тунхагласан. Хуулиар шүүхийн зүгээс түр зуур хамгаалах захирамж гаргах, хөдөө орон нутгийн эмэгтэйчүүдийг тосгоны удирдлагын зүгээс хамгаалах арга хэмжээ авахыг үүрэг болгосон.

315. Мэргэшсэн шүүхүүд нь шүүх болон яллан шийтгэх байгууллагын ажилтнуудад шаардлагатай сургалт явуулснаар хохирогчдын дарамтыг аль болох багасгах, үйл ажиллагааны үр дүнг нэмэгдүүлэх боломжтой. Эдгээр шүүхүүд нь иргэний болон эрүүгийн зэрэг хуулийн системийн бүрэлдэхүүн хэсгүүд болон хохирогчдод үзүүлэх үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлэх зэрэг, хуулийн бус чиглэлийн үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах олон хэлбэрийн арга хэмжээг авч хэрэгжүүлэх боломжтой. АНУ-ын Нью Йорк мужид гэр бүлийн хүчирхийллийн шүүхийн нэгдмэл загвар боловсруулагдсан бөгөөд энэ загварыг дэлхийн бусад орнууд тухайлбал, Нэгдсэн Вант Улс авч хэрэглэсэн.

316. Хүчирхийллийг мэдээлсэн эмэгтэйчүүдийн аюулгүй байдлыг хангах, эмэгтэйчүүдэд тусламж үзүүлэх үйл ажиллагааг мэргэшсэн цагдаагийн байгууллага бэлтгэгдсэн ажилтнуудаараа дамжуулан гүйцэтгэдэг. Ийм хэлбэрийн анхны эмэгтэйчүүдийн цагдаа 1985 онд Бразилийн Сан Паулод байгуулагдсан. Энэ туршлагыг Аргентин, Эквадор, Перу, Уругвай зэрэг Латин Америкийн орнууд авч хэрэгжүүлсэн. Доминиканы Бүгд Найрамдах Улсад гэр бүлийн хүчирхийллийн хуулийг гэр бүлийн хүчирхийллийн асуудлаар дагнан ажилладаг 6 яллан шийтгэх байгууллага, эмэгтэйчүүдийг хүчирхийллээс хамгаалах үүрэгтэй сэргийлэхийн 6 алба, зөвхөн гэр бүлийн асуудлаар ажилладаг иргэний ба эрүүгийн шүүх зэрэг байгууллагууд хэрэгжүүлдэг. Бельги Улсад хүн худалдаалахтай тэмцэх алба энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх үүрэгтэйгээр сэргийлэх байгууллагын нэг алба болон ажилладаг.

6. Эрх зүйн бусад асуудлууд

317. Хүчирхийлэл нь эмэгтэйчүүдийн амьдралын бүхий л хүрээнд нөлөөлдөг учраас хохирогчдод нөлөөлж болохуйц хуулийн бүх асуудалд анхааралтай хандах нь үр дүнтэй байдаг. Эмэгтэйчүүдийн эрхийн асуудлаар ажилладаг хүмүүс эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг салалт, хүүхдийн асран хамгаалагчийг сонгох, хүүхэдтэйгээ уулзах, хүүхдийг хүчирхийлэх, үл хайхрах, халамжийн болон нийгмийн үйлчилгээг хүртэх, цагаачлал, ажил эрхлэлт, орон байраар хангах зэрэг олон асуудалтай нэгдмэл

байдлаар шийдэх мэдрэмж бий болгох чиглэлээр ажиллаж байна. Хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдэд үзүүлэх иргэний болон эрүүгийн хуулийн үйлчилгээ нь хэрэв хохирогч хуулийн бусад заалтын дагуу давуу бус эрхтэй байгаа нөхцөлд тэдэнд хязгаарлагдмал боломжийг олгодог. Жишээ нь: гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн боловч нөхрийнхөө цагаачлалын хараат байдалд буй цагаач эмэгтэй энэ байдлаасаа болж хүчирхийллийн талаар мэдээлэхгүй байх боломжтой. Канад, Нидерланд, АНУ зэрэг улс орнуудад ийм тохиолдолд гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдыг тэдний гэр бүлийн хүний зөвшөөрлийг заавал авах шаардлагагүйгээр байнгын оршин суугч болохоор өргөдөл гаргахыг зөвшөөрдөг.

7. Олон улсын эрх зүйн хэм хэмжээг үндэсний шүүхэд хэрэглэх нь

318. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн асуудлаар олон улсын хуулиудыг орон нутгийн шүүхийн үйл ажиллагаанд ашиглах нь үр дүнтэй. Нэгэн эмэгтэйг хүчирхийлсэн залуугийн хэргийн тухайд өмнөд Африкийн үндсэн хуулийн шүүх нь цагдаа, хуулийн байгууллага тухайн эмэгтэйд хохирол учруулахаас тухайн эрэгтэйг урьдчилан сэргийлэх шаардлагатай арга хэмжээг авч чадаагүй болохыг тогтоосон. Гэр бүлийн хүчирхийллийн хуулийн үндсэн заалтуудыг хэрэгжүүлэхэд тохиолдож байгаа бэрхшээлийг үл хайхран шүүхээс эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенц зэрэг олон улсын хуулийн дагуу шаардлагатай, үр дүнтэй арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь тухай улсын үүрэг гэдгийг тодорхойлсон. Энэтхэгийн Дээд шүүхээс эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах конвенц болон Бээжингийн бага хурлын шийдвэрийн дагуу ажлын байранд бэлгийн дарамт үзүүлэхээс, хамгаалах журам, хэм хэмжээг бий болгох үүргийг Энэтхэгийн Засгийн газарт даалгасан. Эдгээр хэм хэмжээ нь үндэсний хэмжээний холбогдох актуудад тусгагдах ёстой.

Жишээ 11

Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаарх үндэсний хууль тогтоомж

Сүүлийн 10-аад жилийн турш олон улс орнууд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх хууль тогтоомж батлан гаргалаа. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх төрийн үүрэг хариуцлагын талаар 6 дугаар хэсэгт авч үзсэн. Мөн энэ хэсэгт хуулийн цоорхой, хууль хэрэгжүүлэхтэй холбогдсон бэрхшээлтэй асуудлуудын талаар гэрээний байгууллагуудын санал зовнил ч хөндөгдсөн билээ. Гэрээний байгууллагууд анхаарлаа хандуулж байгаа одоогийн хууль тогтоомж дахь таван зүйлийг энд онцлон тэмдэглэв.^a Мэдээллийг 2006 оны 4 сарын 30-ны байдлаар шинэчилсэн болно.^b

Гэр бүлийн хүчирхийлэл

Одоогийн байдлаар тухайлан гэр бүлийн доторх хүчирхийлэлтэй тэмцэх хууль тогтоомж 89^b улсад байдаг. Эдгээрээс 60 нь гэр бүлийн хүчирхийллийн эсрэг тусгай хуультай, 7 нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн хуультай, нэг нь хүчирхийллийн эсрэг төвийг сахисан жендерийн баримтлал бүхий хуультай, 14 нь эрүүгийн хуулиндаа гэр бүлийн хүчирхийллийн эсрэг тусгай заалттай, 5 нь гэм буруутай этгээдийг зайлуулах иргэний ажиллагаатай, 1 нь гэр бүлийн хүчирхийллийг гэр бүлийн тухай хуулиар зохицуулдаг байна. Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг тусгай хуультай улсын 12 нь хүчирхийллийг жендерийн

эсрэг хүчирхийлэл бус гэр бүлийн асуудлаас үүссэн хэрэг гэж үздэг байна. Хуулинд гэр бүлийн хүчирхийллийн талаар тухайлсан заалт байдаг эсэх нь тодорхой бус байгаа 102 улс байна. 20 улсад гэр бүлийн хүчирхийллийн эсрэг хуулийн төсөл боловсруулах ажил аль нэг шатандаа явагдаж байна. 4 улс гэр бүлийн хүчирхийллийн талаар тухайлсан хууль буюу заалт гаргах сонирхолтой байгаагаа илэрхийлээд байна.

Гэр бүл дэх хүчин

104^г улс оронд гэр бүл дэх хүчингийн хэргийг шалгаж шийтгэдэг. Эдгээрээс 32 улсад гэр бүлийн хүчингийн хэргийг эрүүгийн тусгайлсан зүйл ангиар шийдвэрлэдэг, 74 улсад нь гэр бүл дэх хүчингийн хэргийг хүчингийн хэргийн ерөнхий заалтаас тусад нь авч үздэггүй. 53 улс оронд гэр бүл дэх хүчинг мөрдөн шалгах боломжтой хэрэг гэж үздэггүй. 4 улсад хэрэв эхнэр, нөхрүүд хуулийн дагуу тусдаа амьдарч байх үед үйлдэгдсэн бол гэр бүл дэх хүчинг эрүүгийн хэрэг гэж үздэг. 4 улс гэр бүл дэх хүчинг мөрдөн шалгах боломжтой хууль тогтоомж гаргах талаар судалж байгаа юм.

Ажлын байран дахь бэлгийн дарамт

90^а улсад ажлын байран дахь бэлгийн дарамтын эсрэг аль нэг хэлбэрийн хууль тогтоомж байна. Үүнээс 11 улс тусгай хууль тогтоомжтой, 31 улс ажлын байран дахь бэлгийн дарамтын талаар тусгайлсан зүйл ангийг эрүүгийн хуулиндаа нэмж оруулсан. 18 улс ажлын байран дахь бэлгийн дарамтыг хөдөлмөрийн буюу хөдөлмөр эрхлэлтийн хуулиар шийдвэрлэдэг байна. 18 улс энэ асуудлыг ялгаварлан гадуурхалтын эсрэг буюу жендерийн тэгш байдлын хуулиараа шийдэж байна. 12 улс дээрх гурван салбар дахь заалтуудыг нэгтгэсэн хэлбэртэй хууль тогтоомжтой. 2 улс хууль тогтоомждоо байна. ° 7 улсад ажлын байран дахь бэлгийн халдлагыг хориглох хуулийн төсөл боловсруулж байна.

Хүн худалдаалах

93 улсад хүн худалдаалахын эсрэг аль нэг хэлбэрийн хуулийн акт байна. Эдгээрээс 10 нь зөвхөн хүүхдийн талаар хэрэглэгддэг хуулийн заалтуудтай. Одоогоор 7 улс хүн худалдаалахын эсрэг хуулийн төсөл боловсруулж байна.

Эмэгтэйчүүдийн бэлэг эрхтнийг зэрэмдэглэх

Эмэгтэйчүүдийн бэлэг эрхтнийг зэрэмдэглэх зан үйл гардаг Африкийн 28 орны 15-д нь ийм үйлдлийг гэмт хэрэг гэж үзэх хууль хэрэгжиж байна. Түүн дээр 1 улс эмэгтэйчүүдийн бэлэг эрхтнийг зэрэмдэглэх явдлыг хориглодог эрүүл мэндийн тухай хуультай. 2 улс энэ хэргийг яамны сайдын тогтоолоор хориглодог. Холбооны нэг улсын хэд хэдэн муж улсад энэ хэргийг гэмт хэрэг гэж үзэж байна. Африкийн 5 улс эмэгтэйчүүдийн бэлэг эрхтнийг зэрэмдэглэх явдлын эсрэг хуулийн төсөл боловсруулж байна. Хүн амын тодорхой бүлгийн дотор эмэгтэйчүүдийн бэлэг эрхтнийг зэрэмдэглэх уламжлал байдаг Ази, Арабын хойгийн 9 улсаас 2 нь ийм хэргийг хориглох хуулийн арга хэмжээ авч байна. Түүнчилэн дэлхийн бүс нутгийн 10 орон ийм зан үйлийг гэмт хэрэг гэж үзэх хууль хэрэгжүүлж байна.

а 191 улсын хуулийн талаар судалгаа хийсэн. Судалгааны гол эх үүсвэрүүд нь : Конвенцид ирүүлсэн улс орнуудын тайлан, 10 жилийн хугацаанд Конвенцийг хянан үзэхэд зориулсан асуулгад гишүүн орнуудын ирүүлсэн хариу, Бээжингийн Үйл ажиллагааны хөтөлбөр түүний үр дүнгийн баримт бичгийн талаархи дүгнэлт, ЕНБД-ын судалгаанд гишүүн улсуудын оролцоо, Тусгай судлаачийн тайлан, ОУХөдөлмөрийн байгууллагын тайлан, ТББ-уудын тайлан, засгийн газрын вэбсайтууд.

б Энэ хүснэгтийг хийхэд үндэслэсэн мэдээ нь:

<http://www.un.org/womenwatch/daw/vaw/index.htm>-д байгаа.

в Үүнд гэр бүлийн хүчирхийллийн эсрэг холбооны хуульгүй боловч, муж улсын түвшинд олон хууль үйлчилж байдаг Канад улс орно.

г Гэр бүл дэх хүчингийн эсрэг хуулийн талаархи тоонд энэ талаар мэдээлэл олдохгүй байсан 16 улсыг оруулсангүй.

д Ажлын байран дахь бэлгийн халдлагын талаархи хуулийн арга хэмжээ нь үйлчлэх хүрээний хувьд бүх талыг хамарсан байж чадаагүй. Жишээ нь : зарим хуульд зөвхөн төрийн албан хаагчдыг хамруулан үзсэн байхад заримд нь ажлын байран дахь бэлгийн халдлагыг ёсзүйн хууль тогтоомжид авч үзсэн байх жишээтэй.

е Ражастан мужийн Вишакагийн хэрэг, 1997 S.C. 3011 (Энэтхэг); ба Банкны ажиллагсдын холбоо Рипаблик банкны эсрэг хэрэг 1995 (Тринидад ба Тобаго улс)

В. Үйлчилгээ үзүүлэх тэргүүн туршлага

319. Дэлхийн өнцөг булан бүрт эмэгтэйчүүд биеийн болон сэтгэл зүйн хүчирхийлэлд өртөж байна. Тэдний амьдралд, өдөр тутмын харилцаанд, идэвхитэй байдалд нь болон боловсрол эзэмших, хөдөлмөр эрхлэх боломжийг нь хязгаарладаг. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлд өртсөн хохирогчид нь цаг алдалгүй эрүүл мэндийн болон дэмжлэг үзүүлэх үйлчилгээг хүртэх шаардлагатай. Улс оронд нь эрүүл мэндийн үйлчилгээ хангалтгүй эсхүл хохирогчид үйлчилгээнд хамрагддаггүй эсхүл ийм төрлийн үйлчилгээ байдаг тухай мэддэггүй байдал янз бүрийн шалтгаанаар тухайн үйлчилгээ үзүүлэгч байгууллагад хандах дургүй байдаг зэргээс олон хохирогчид хэрэгцээтэй туслалцаагаа одоог хүртэл хүртэж чадахгүй байна. Харин үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааны үр дүнтэй арга зүй нь эдгээр бэрхшээлүүдийг шийдвэрлэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ.

320. Дэмжлэг үзүүлэх үйлчилгээнүүдийг төрийн байгууллагууд ТББ-ууд үзүүлдэг. Мөн эрүүл мэндийн ажилтнууд, хувийн эмч нар, хувь хүмүүс уг үйлчилгээг үзүүлдэг. Хохирогчдод үзүүлэх үйлчилгээнд төрийн сангийн санхүүжүүлэлт болон ТББ, төрийн байгууллагын хамтын дэмжлэг хэрэгтэй. Үйлчилгээ нь эрүүл мэнд, хууль хэрэгжүүлэх, шударга ёс, нийгмийн халамжийн болон боловсролын зэрэг төрийн байгууллагуудыг сургалтанд хамруулах, хүчин чадлыг бий болгохыг шаарддаг.

1. Үйлчилгээ үзүүлэх тэргүүн туршлагын зарчмууд

321. Үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааны үр дүнтэй аргууд нь хэд хэдэн ерөнхий зарчим дээр тулгуурладаг болохыг энэ чиглэлийн туршлага харуулж байна. Эдгээр нь:

- Хохирогчдын сайн сайхан амьдрах боломж, биеийн болон эдийн засгийн аюулгүй байдлыг хангах, эмэгтэйчүүдэд хүчирхийллээс үүдэх олон үр дагаврыг даван туулж, амьдралаа дахин эхлэхэд дэмжлэг үзүүлэх
- Олон хэлбэрээр ялгаварлан гадуурхагдсан эмэгтэйчүүдийн хэрэгцээнд нийцсэн, тэдэнд тохиромжтой үйлчилгээ хүртээмжтэй байх нөхцлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх
- Үйлчилгээ үзүүлэгчид нь чадвартай, хүйсийн мэдрэмжтэй байж, тогтмол сургалтанд хамрагдаж, үйл ажиллагаагаа тодорхой удирдамж, журам, ёс зүйн хэм хэмжээнд

нийцүүлэн явуулдаг байх төдийгүй боломжтой бол эмэгтэй ажилтан байх

- Хохирогчийн хувийн халдашгүй дархан байдал болон нууцлалыг хадгалах
- Хүчирхийлэлд өртсөн хохирогчид үйлчилгээ үзүүлдэг бүх байгууллагуудтай хамтран ажиллах
- Үйлчилгээнд хяналт тавьж, үнэлгээ өгөх
- Хүчирхийлэл үйлдсэн эрэгтэйчүүдийг өмгөөлөх, уучлах, тэдний үйлдлийг зөвтгөн, хохирогчийг буруутгах үйл ажиллагааг үгүйсгэх
- Эмэгтэйчүүдийг бие даасан байдал, хараат бус байх явдлыг дэмжих

2. Үйлчилгээ үзүүлэх хэлбэрүүд

(а) Эрүүл мэндийн үйлчилгээ

322. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх тогтолцоо нь хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдэд хамгийн анхны үйлчилгээ үзүүлж, холбоо тогтоох тогтолцоо юм. Эрүүл мэндийн системийн хувьд хохирогчдод төрөл бүрийн дэмжлэг үзүүлж, эмнэлэг, эрүүл мэндийн тусламжийн байгууллагад үйлчилгээ хүртэх явцдаа давхар хүчирхийлэлд өртөхгүй байх нөхцлийг бүрдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг явуулдаг нь үр дүнтэй арга зүйд тооцогддог. Жишээ нь: эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгчдэд зориулсан сургалтын протокол, эрүүл мэндийн байгууллагын хүрээнд хохирогчдод үзүүлэх үйлчилгээг уялдуулан зохион байгуулах, эрүүл мэндийн тусламж, зөвлөгөө өгөх үйлчилгээ, орон байраар хангах, хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэхэд чиглэсэн үйлчилгээ, хүчирхийлэл үйлдэгчдэд зориулсан хөтөлбөр хэрэгжүүлэх зэрэг нь энэ салбарт хэрэгжиж байгаа үр дүнтэй аргууд юм.

Жишээ 12

Нэг цэгийн үйлчилгээний төвүүд

Үйлчилгээний түвшинд хамгийн үр дүнтэй тооцогддог хэлбэрийн нэг нь “нэг цэгийн үйлчилгээ гэж нэрлэгддэг, бүхий л шаардлагатай үйлчилгээг нэг дор зохион байгуулсан гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн хохирогчдод үйлчилгээ үзүүлэхэд зориулсан төв юм. Ийм хэлбэрийн үйлчилгээг анх удаа Малайзийн засгийн газрын томоохон ерөнхий эмнэлэгт хэрэгжүүлсэн. Хохирогчийг эмчийн үзлэгт оруулсны дараа эмчилгээ хийхийн зэрэгцээ 24 цагийн дотор үйлчлүүлэгчийн хувийн халдашгүй байдал, нууцлалыг бүрэн хамгаалсан тусгайлан бэлтгэсэн өрөөнд зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлдэг. Хэрвээ хохирогч эмэгтэй гэртээ буцан очих нь аюултай байхаар байвал эмч болон зөвлөгч түүнийг яаралтай тусламж үзүүлэх хамгаалах байр эсхүл яаралтай тусламжийн төвд 24 цагаар байлгах шийдвэрийг гаргадаг. Хэрвээ үйлчлүүлэгч хамгаалах байранд очихыг хүсээгүй нөхцөлд дараа нь эмнэлэг дээр ирж нийгмийн ажилтантай уулзах боломжийг бий болгодог. Түүнчилэн хохирогч эмэгтэй эмнэлэг дээр байрладаг цагдаагийн нэгж дээр байцаалт өгөх боломжтой. Ноцтой гэмтэл учруулсан тохиолдолд цагдаа үйлчлүүлэгчийг эмнэлгийн байранд ирж байцаан, тэмдэглэл хөтлөж мөрдөх ажиллагааг эхлүүлдэг. Энэ загвар нь Азийн болон Өмнөд Африкийн олон орнуудад хэрэгжиж байна.

(б) Бэлгийн хүчирхийллээс хамгаалах төвүүд

323. Хүчин зэрэг бэлгийн хүчирхийллийн хохирогчид нь нэн яаралтай эрүүл мэндийн үйлчилгээ, дэмжлэг авах, хуулийн холбогдолтой шаардлагатай мэдээллүүдийг цуглуулах шаардлагатай болдог. Бэлгийн хүчирхийллийн дараа биеийн үзлэг

хийх нь хохирогчдыг бас нэг хэлбэрийн хүчирхийлэлд өртөхөд хүргэдэг. Дээрх хэлбэрийн үйлчилгээнд цаг алдалгүй хамрагдаж чадахгүй байх нь хүчингийн хэргийг шүүн шийтгэх нотолгоог бүрдүүлж чадахгүйд хүргэдэг. Тиймээс эмэгтэйчүүдэд дээрх хэлбэрийн үйлчилгээ хүртээмжтэй байх нь чухлын нэгэн адил бэлгийн хүчирхийлэлд өртсөн тохиолдолд үзлэгийг зайлшгүй хийх тухай журам чухал юм. Бэлгийн хүчирхийллийн эсрэг төв нь бэлгийн хүчирхийлэлд өрсөн хохирогчдод өндөр чанартай, өргөн хүрээтэй үйлчилгээ тусламж үзүүлдэг. Олон орнуудад хамтран ажилладаг эмнэлгийнхээ дэргэд эмнэлгийн өөрийн бэлгийн хүчирхийллийн эсрэг төв буюу олон нийтэд суурилсан төвүүдийг ажиллуулдаг. Канад зэрэг зарим орнуудад ийм хэлбэрийн төвүүдийн өргөн хүрээтэй сүлжээ ажилладаг бол Герман, Швецари, Нэгдсэн Вант Улс зэрэг орнуудын гол хотуудад эмэгтэйчүүдийн бүлгүүд болон эмнэлгийн ажилтнууд, орон нутгийн үйлчилгээг сайжруулах хөдөлгөөнүүдийг тогтмол зохион байгуулдаг хэд хэдэн төвүүд ажилладаг.

(в) Итгэлийн утас

324. Итгэлийн утас нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлд өртсөн хохирогчдод мэдээлэл хүргэх дэмжлэг үзүүлэх системд холбогдох боломжийг бүрдүүлдэг. Ийм хэлбэрийн зөвлөгөө өгөх шугам нь олон орнуудад хохирогчдод зориулсан үйлчилгээний чухал бүрэлдэхүүн хэсэг болдог. Олон эмэгтэйчүүд хүчирхийлэлд өртсөн тохиолдолд тусламж хүсэхээс зайлсхийдэг тул зөвлөгөө өгөх утаснууд нь үйлчлүүлэгчдийн нууцлалыг хамгаалж чаддаг бөгөөд мэдээллээр хангадаг. Мэдээлэл харилцааны шинэ технологиуд ийм төрлийн үйлчилгээнүүд урьд өмнө боломжгүй байсан газруудад олон хэл дээр явуулах бололцоог бүрдүүлж байна.

325. 24 цагийн үндэсний хэмжээний яаралтай тусламжийн утас ажиллуулах, мэдээлэл сурталчилгаа, дэмжлэг, хямралын үед зөвлөгөө өгөх үйлчилгээ зэрэг нь үйл ажиллагааны үр дүнтэй хэлбэр юм. Тусламжийн утасны тухай мэдээллийг хамгийн тохиромжтой хэлбэрээр түгээх, түүнийг байнгын ажиллагаатай байлгах нөхцөл нь чухал. Коста Рикагийн эмэгтэйчүүдийн үндэсний институтээс “анир чимээгүйг эвдье” нэртэй 24 цагийн үнэгүй утсыг 1997 онд бий болгосон. 2000, 2001 онд энэ утасны сурталчилгаа болон түргэн тусламжийн утастай нягт хамтран ажилласны үр дүнд дуудлагын тоо эрс өссөн. БНСУ-д 1366 гэсэн итгэлтэй утас нь хүчирхийлэлд өртөгсдөд тусалж зөвлөгөө өгдөг бөгөөд 24 цагаар ажилладаг төдийгүй, хүн наймаалах гэмт хэргийн хохирогчдод орчуулгын үйлчилгээ бас үзүүлдэг. Хорватын Засгийн газраас хүн худалдах гэмт хэргийн хохирогчдод зориулсан үндэсний хэмжээний SOS итгэлтэй утсыг санхүүжүүлэн ажиллуулдаг.

(г) Хамгаалах байр

326. Хамгаалах байр нь эмэгтэйчүүдийн байгууллагаас хүчирхийлэлтэй орчинд амьдарч буй аюулгүй байдлаа хамгаалуулах, тусламж хэрэгтэй эмэгтэйчүүдэд зориулсан үйлчилгээ явуулдаг газрууд юм. Эдгээр төвүүд нь “аюулгүй амьдрах байр”-ны үүргийг ихэвчлэн гүйцэтгэдэг бөгөөд олон төрлийн үйлчилгээг үзүүлдэг. Эмэгтэйчүүдийг хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлж хамгаалах аюулгүйн стандартыг хангасан хамгаалах байруудыг тусламж шаардлагатай эмэгтэйчүүдэд хүртээмжтэй байлгах нь үйл ажиллагааны үр дүнтэй хэлбэр мөн. Европын зөвлөлийн мэргэжилтнүүдийн бүлгийн зөвлөмжөөр ийм хэлбэрийн нэг төвд ойролцоогоор 7500 хүн үйлчлүүлэхээр зохион байгуулагдах ёстой бөгөөд хамгийн наад захын стандарт нь нэг төвд 10000 үйлчлүүлэгч оногдох ёстой. Эмэгтэйчүүдийн хүчирхийллийн эсрэг Европын сүлжээнээс эмэгтэйчүүдийн хамгаалах байрны төвийн чанарын стандартыг боловсруулсан.

327. Иймэрхүү хамгаалах байруудын үйл ажиллагаа явуулахад төр төдийлэн хангалттай оролцож чаддаггүй учраас ийм төвүүдийг байгуулах, үйл ажиллагааг явуулах ажлыг ТББ-аар гүйцэтгүүлэн, тэдэнд дэмжлэг үзүүлэх, санхүүжүүлэх, хамтран ажиллах нь үйл ажиллагааны үр дүнтэй хэлбэр мөн. Жишээ нь: Украин Улсын Киев хотод эмэгтэйчүүдийн анхны төв нь эмэгтэйчүүдийн бүлэг болон хотын захиргааны хамтын чармайлтаар байгуулагдсан. Энэ санаачлага нь улс орон даяар ийм хэлбэрийн олон төвүүд байгуулагдахад хүргэсэн. Эдгээр төвүүд нь 24 цагийн ажиллагаатай бөгөөд эмэгтэйчүүд, хүүхдүүдийг үнэгүй амьдрах байраар хангах, эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх, хуулийн, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх зэрэг олон хэлбэрийн нийгмийн дэмжлэг үзүүлдэг. Пакистаны Лахорын Дастакад хүчирхийллийн улмаас гэр орноосоо дайжсан бүх насны эмэгтэйчүүдэд түр амьдрах аюулгүй орон байраар хангаж, хуулийн тусламж, чадвар олгох сургалтыг зохион байгуулдаг.

(д) Дэмжих бүлэг ба сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээ

328. Өөрөө өөртөө туслах бүлэг буюу зөвлөгөө өгөх үйлчилгээ нь тэдний хувийн эрх чөлөөг хүндэтгэн бие даасан шийдвэр гаргах боломжийг бүрдүүлэх замаар эмэгтэйчүүдэд дэмжлэг үзүүлдгээрээ үйл ажиллагааны үр дүнтэй хэлбэр болдог. Зөвлөгөө өгөх үйлчилгээ нь хохирогчидтой мэргэжлийн хүмүүс ажиллахын зэрэгцээ хохирогчдоос бүрдсэн өөрөө өөртөө туслах бүлгүүд нь бие биедээ дэмжлэг үзүүлдэг. Жишээ нь: Коста Рикад “Эмэгтэй та ганцаараа биш” гэсэн нэртэй өөрөө өөртөө туслах бүлэг нь гэр бүлийн хүчирхийллийн асуудлаар ажилладаг бөгөөд эмэгтэйчүүдэд өөртөө итгэх итгэл төрүүлэх, хүчирхийлэл бүхий харилцааг эцэс болгох, хүчирхийлэгчтэй зөвшилцөхөд шаардлагатай тусламжийг нь үзүүлдэг. Эдгээр бүлгүүдийн үйл ажиллагаа амжилттай болоход нөлөөлдөг хүчин зүйлс нь хүчирхийлэл бүхий харилцаанаас ангижирч чадсан хэн нэгний ярихыг сонсоод эмэгтэйчүүд өөртөө итгэх итгэл нь нэмэгдэх, байнгын асуултанд өртөхгүйгээр бусдад өөрийгөө ойлгуулж талархал хүртэх, өөрсдийнхөө тухай эргэцүүлэн бодох замаар өөрсдийн эрхийн талаар мэдлэгтэй болох зэрэг боломжуудыг олгодог явдал юм. Бельград дах эмэгтэйчүүдийн өөртөө туслах төв нь хүчирхийлэлд өртсөн хохирогчдод зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлдэг. Төвийн зөвлөгөө өгөх ажилтнууд ёс зүйн хэм хэмжээ, тодорхой ойлгомжтой удирдамж, тогтоол зэргийг мөрдөж, сургалтанд хамрагддаг. Тэд эмэгтэйчүүдэд тохиолдсон явдалд итгэх, хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийг буруутгахгүй байх болон тэдэнд зөвлөгөө өгөлгүй харин өөртөө итгэлтэй зоримог байхад нь дэмжлэг үзүүлэх зэрэг үйлчилгээ үзүүлэхэд анхаарах үндсэн гурван зарчмыг мөрддөг.

(е) Эрх зүйн үйлчилгээ

329. Хүчирхийлэлд өртсөн эмэгтэй хохирогчдод ихэвчлэн гэр бүл салалт, хүүхдээ асран хамгаалах эрх, хүүхдийн ирээдүйн талаарх асуудлууд, өмч хуваах, орон байрны, ажлын байрыг шийдвэрлүүлэх хуулийн үйлчилгээ шаардлагатай болдог. Хүчирхийлэлд өртсөн ядуу эмэгтэйчүүдэд хуулийн үнэгүй тусламж, зөвлөгөө үзүүлэх, иймэрхүү үйлчилгээ нь үр дүнтэй үйл ажиллагааны нэг хэлбэр мөн. Хуулийн үйлчилгээг хуулийн туслацга үзүүлэх төвүүд, хуулийн үнэгүй үйлчилгээ үзүүлдэг хуульч нар өгдөг. Хүчирхийлэлд өртсөн ядуу эмэгтэйчүүдэд хуулийн үнэгүй тусламж, зөвлөгөө өгөх нь үр дүнтэй үйл ажиллагааны нэг хэлбэр юм. Филиппиний Габриела ТББ нь хуулийн үйлчилгээ зөвлөгөө өгөх, гэрээр зөвлөгөө өгөх, хамгаалах байранд үйлчилгээ үзүүлэх зэрэгтэй нэгтгэн үйл ажиллагаа явуулдаг. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлд өртсөн хохирогчдод үзүүлэх хуулийн үйлчилгээг ихэвчлэн иргэний

нийгмийн байгууллагууд үзүүлдэг байхад, Засгийн газрын хувьд санхүүжүүлэх замаар иймэрхүү төсөл хөтөлбөрүүдийг дэмжих нь үр дүнтэй үйл ажиллагаа юм.

(ё) Хүн хил давуулан худалдаалах гэмт хэргийн хохирогчдод үзүүлэх үйлчилгээ

330. Хүн хил давуулан худалдаалах гэмт хэргийн хохирогчид эргээд хүн наймаалах сүлжээнд өртөхөөс айх, хуулийн тогтолцоонд хуулиар хамгаалагдах эрх дутмаг байх, хууль ёсоор тухайн нутаг дэвсгэрийг орхих болон хэлний бэрхшээлтэй байдлаас болоод үйлчилгээ хүртэхэд маш олон саад бэрхшээлтэй тулгардаг. Гэтэл тэднийг яаралтай хамгаалалтанд авах, эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх, хуулийн зөвлөгөө үзүүлэх хэрэгтэй байдаг. Хэрэв тэд эх орондоо буцаагдсан тохиолдолд өөрийн орныхоо үйлчилгээг хүртэх шаардлагатай болдог. Хүн хил давуулан худалдаалах гэмт хэргийн хохирогчдод үзүүлэх үйлчилгээ дээрхи асуудлуудыг шийдвэрлэх нь үр дүнтэй үйл ажиллагаа юм.

331. Босни Герцеговинад Засгийн газар нь хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хохирогчдод хуулийн үнэгүй тусламж үзүүлдэг бөгөөд тэдэнд зориулсан ТББ-ын хамгаалах байруудыг санхүүжүүлдэг. ТББ болон Засгийн газрын хамтран боловсруулсан чухал бодлого нь хүн хил давуулан худалдаалах гэмт хэргийн хохирогчдыг мэдүүлэг өгөх/ярилцлаганд орохоос өмнө 15 хоног хамгаалах байрандаа байрлуулан бүх шаардлагатай үйлчилгээг үзүүлэхээр шийдвэрлэсэн явдал юм.

332. Италид хүн хил давуулан худалдаалах гэмт хэргийн хохирогчдын амь насанд аюул учрахаар байгаа, учирч болох цаашид эрсдэлтэй тохиолдолд тэдэнд оршин суух зөвшөөрлийг олгодог байна. Оршин суух зөвшөөрөл нь хүн хил давуулан худалдаалах гэмт хэргийн хохирогчдод ажиллах, тусламж авах хөтөлбөрүүдэд хамрагдах боломжийг өгдөг. Уг гэмт хэргийн хохирогчид нь ТББ, хууль хэрэгжүүлэгч байгууллага болон, нутгийн эрх барих байгууллагуудын хамтын ажиллагааны үр дүнд эмнэлгийн, сэтгэл зүйн тусламж, хуулийн зөвлөгөө, сургалтанд хамрагдах, боловсрол хүртэх зэрэг боломжуудыг хүртдэг.

333. Румынд ТББ-ын авч хэрэгжүүлдэг хөтөлбөр нь бэлгийн мөлжлөгөд ашиглах зорилгоо хил давуулан худалдаалах гэмт хэрэгт өртсөн эмэгтэйчүүд, охидод зориулан хамгаалах байр, зөвлөгөө өгөх, эмнэлгийн, боловсролын, ажил мэргэжил олгох зэрэг тусламж үзүүлдэг бөгөөд мөн амьдрах ухааны сургалтуудыг явуулдаг. Тухайн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд нь эмэгтэйчүүдэд хамгаалах байрнаас гараад амьдрах орон байрыг олоход нь тусламж үзүүлдэг бөгөөд мөн зөвлөгөө өгөх үйлчилгээг үзүүлсээр байдаг.

(ж) Зэвсэгт мөргөлдөөн, түүний дараахь үед эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлд өртсөн хохирогчдод үзүүлэх үйлчилгээ

334. Зэвсэгт мөргөлдөөний үеэр, дараагаар олон тооны эмэгтэйчүүд олон хэлбэрийн хүчирхийллийн, тухайлбал, хүйсээр ялгаварлан гадуурхах онцгой хэлбэрийн хүчирхийллийн золиос болдог. Ийм төрлийн хүчирхийллийн улмаас тэдэнд биеийн, сэтгэл санааны болон нөхөн үржихүйн ноцтой хохирол учрахад хүрдэг. Эмэгтэйчүүд зэвсэгт мөргөлдөөний үеэр хүчиндүүлэх зэргээр бэлгийн хүчирхийлэлд ихээр өртдөг. Иймэрхүү хүчирхийлэл нь БЗХӨ, ДОХ зэрэг бэлгийн замаар халдварладаг өвчний халдвар авах болон хүсээгүй жирэмслэлт зэрэг үр дагаварт хүргэдэг. Түүнчилэн дүрвэгч эмэгтэйчүүд хүйсээр ялгаварлан гадуурхах хүчирхийлэлд өртөх эрсдэлтэй байдаг. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлд өртсөн хохирогчдод аюулгүй үр хөндөлт хийх гэх мэт олон талын эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх, зөвлөгөө өгөх,

хамгаалах байраар хангах, хоол хүнс, ариун цэврийн хэрэгсэл зэрэг наад захын хэрэгцээтэй зүйлээр хангах болон нийгмийн үйлчилгээ мөн боловсрол олгох зэрэг өргөн хүрээтэй үйлчилгээг үзүүлэх шаардлагатай байдаг.

3. Зохицуулалт, байгууллага хоорондын ажиллагаа

335. Хохирогчдод зориулсан үйлчилгээ, тусламж, хүчирхийлэл үйлдэгчийг шийтгэх үйл ажиллагааг явуулахад олон тооны байгууллагууд хамтран ажиллах шаардлагатай учраас үйлчилгээ үзүүлэхэд хамтран ажиллах нь үр дүнтэй үйл ажиллагааны хэлбэрт тооцогддог. Эмэгтэй хохирогчид ихэвчлэн эрүүгийн болон иргэний хуулийн, мөн орон байр, ажлын байраар хангахтай холбогдсон өргөн хүрээтэй асуудлуудтай тулгардаг. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг зохицуулах үйл ажиллагааг нэгтгэн зохион байгуулсан олон байгууллагууд болох нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх төв зэрэг нь үйлчилгээний олон хэлбэрүүдийг нэгтгэдэг. Сингапурт эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэхэд “туслагчид” нэртэй аргыг ашигладаг бөгөөд хамтран ажиллах сүлжээний хамтрагч байгууллагуудын үүрэг хариуцлага, дүрэм, журам болон үйл ажиллагааны удирдамжийг нарийн тодорхойлсон “Сингапур дахь гэр бүлийн хүчирхийллийн асуудлыг нэгтгэн зохион байгуулах нь” нэртэй гарын авлагыг боловсруулаад байна. Грек улсад хүйсийн тэгш эрхийн асуудлаар холбогдох яамд болон ерөнхий нарийн бичгийн даргын газрыг оролцуулан хүн хил давуулан худалдаалах гэмт хэргийн эсрэг үйл ажиллагааны нэгдсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд бэлэн болоод байна. Хөтөлбөрт яамд болон ТББ-уудын санал бодол, мэдээлэл харилцан солилцох чуулганыг тогтмол зохион байгуулах талаар тусгасан байна.

Жишээ 13

Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг олон нийтэд түшиглэсэн Дулутын загвар

Дулут хотын гэр бүлийн хүчирхийлэлтэй зохион байгуулалттай тэмцэх олон нийтэд түшиглэсэн загварыг АНУ-ын Миннесота мужийн Дулут хотод бий болгожээ. Дулут хотын уг хөтөлбөр нь цагдаа, эрүүгийн шүүх, иргэний шүүх, хүүхдийн гэмт хэргийг хариуцсан шүүгчид зэрэг хуулийн тогтолцооны өөр үүрэг бүхий талуудын үйл ажиллагааг зрхицуулдаг бөгөөд хуулийн тогтолцоо, хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийг хамгаалах байрууд, олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх, нөлөөлөл сурталчилгаа хийх хөтөлбөрүүдийн хооронд хамтын ажиллагаа, уялдаа холбоог бий болгодог. Энэхүү аргыг төв болон зүүн Европын хэд хэдэн орнууд мөн хуучин Зөвлөлтийн холбооны Улс орнууд зэрэг дэлхийн олон улс орнууд авч хэрэгжүүлж байна.

Г. Урьдчилан сэргийлэх тэргүүн туршлага

336. Урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа нь анхан шатны буюу хүчирхийлэл үйлдэгдэхээс өмнө түүнийг зогсоох, хоёрдугаар шатны буюу хүчирхийлэл үйлдэгдсэний дараа газар авахаас нь өмнө цаг алдалгүй хариу арга хэмжээ авах, гуравдугаар шатны буюу хүчирхийлэлд өртөгчдөд удаан хугацааны үйлчилгээ, тусламж үзүүлэх гэсэн үндсэн гурван хэсэгт хуваагддаг. Энэ бүлэг нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлээс урьдчилан сэргийлэх анхан шатны үйл ажиллагааны үр дүнтэй хэлбэрүүдэд гол анхаарлаа хандуулсан.

337. Анхан шатны урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа нь нийгэм дэх хандлага, хэвшсэн ойлголтыг өөрчлөх, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг хүлээн зөвшөөрдөг байдлыг төгсгөл болгохын төлөө тэмцэгч олон нийтийг дэмжихийг шаарддаг. Мөн эмэгтэйчүүдийг өөрсдийн хараат байдлаас ангижран, түүнийг даван туулахын тулд улс төрийн, эдийн засгийн хувьд хүчтэй байх явдлыг дэмжихийг шаарддаг. Урьдчилан сэргийлэх олон хэлбэрийн арга хэмжээний үр нөлөөг үнэлэх үйл ажиллагаа амаргүй хэвээр байна. ТББ-ууд ухуулга сурталчилгаа хийх, энэ талын мэдлэгийг дээшлүүлэх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх замаар урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны анхны санаачлагчид бөгөөд төр ч энэ салбарт илүү идэвхитэй оролцох болсон. Тэд ялгаварлан гадуурхах байдлыг устгахад чиглэсэн хуулийн орчинг бүрдүүлж, үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөө боловсруулж, мөн нийгмийн аюулгүй байдал, боловсрол олгох, хэвлэл мэдээллийнхний оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

1. Урьдчилан сэргийлэх тэргүүн туршлагын зарчмууд

338. Туршлагаас үзэхэд анхан шатны урьдчилан сэргийлэх үр дүнтэй үйл ажиллагаа нь дараахь хэд хэдэн зарчим дээр үндэслэх шаардлагатай. Үүнд:

- Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг бүх бодлого, хөтөлбөрүүдэд эн тэргүүнд анхаарах асуудал болгон тусгах
- Урьдчилан сэргийлэх бүхий л хэлбэрийн үйл ажиллагаанд зориулан тусгайлан нөөц хуваарилах
- Урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд тогтвортой, урт хугацааны хөрөнгө оруулалтыг улс төрийн аргаар дэмжих
- Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн шалтгааныг шийдвэрлэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны стратегийг боловсруулах
- Урьдчилан сэргийлэх ямар үйл ажиллагаа юуг, хэрхэн өөрчлөхийг зорьж байгааг тодорхойлсон ойлгомжтой зорилгыг тодорхойлж, хянах, үнэлэх үйл ажиллагааг тогтмол явуулах
- Урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг боловсруулахад эмэгтэйчүүдийн, ялангуяа хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн дуу хоолой чухал болохыг анхаарах
- Үр дүнтэй стратегийг боловсруулахаар Засгийн газрын байгууллагууд, ТББ, ажилчдын байгууллагууд олон нийтийн удирдагчид зэрэг бүхий л талуудтай хамтран ажиллах
- Эмэгтэйчүүдийн эсрэг эрчүүдийн үйлдэх хүчирхийллээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг боловсруулах, хэрэгжүүлэхэд эрчүүд болон хөвгүүдийг татан оролцуулах
- Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл бол хүлээн зөвшөөрч болохгүй зүйл, үүнийг арилгах нь хүн бүрийн үүрэг гэдгийг онцлох
- Эмэгтэйчүүдийн аюулгүй байдлыг сурталчлах
- Урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа нь өргөн хүрээтэй явагдах шаардлагатай бөгөөд ялгаварлан гадуурхах бүхий л хэлбэрүүд, эмэгтэйчүүдтэй холбоотой ХДХВ/ДОХ зэрэг олон чухал асуудлуудыг харгалзан үзэх шаардлагатай

2. Урьдчилан сэргийлэх стратеги

(а) Нөлөөллийн ажил, олон нийтийн аян

339. Ухуулга сурталчилгаа ялангуяа, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл нь байж болшгүй зүйл гэсэн үзэл санааг олон нийтэд хүргэх, төлөвшүүлэх сурталчилгааны компани ажил нь өөрчлөлтийг бий болгох үр дүнтэй үйл ажиллагааны хэлбэр байсаар байна. Ийм хэлбэрийн үйл ажиллагаа нь эмэгтэйчүүдэд тэдний эрхийн болон, хүчирхийлэлд өртсөн тохиолдолд тэдэнд үзүүлэх үйлчилгээний ямар хэлбэрүүд байдаг талаар тэдэнд ойлголт өгдөг. Ийм хэлбэрийн үйл ажиллагааг эмэгтэйчүүдийн хөдөлгөөн эхлүүлсэн ба одоо Засгийн газрын зүгээс урьдчилан сэргийлэх, мэдлэгийг нэмэгдүүлэх үйл ажиллагаанд тэднийг татан оролцуулдаг. Компани ажлууд нь театр, эсэргүүцлийн жагсаал, ухуулга хуудас хэвлүүлэх, телевиз, радио болон интернет зэрэг янз бүрийн аргуудыг хэрэглэж байна.

340. Шотландын “хүчирхийллийг эсэргүүцэх, тэвчихгүй” гэсэн уриатай хүчин, бэлгийн дарангуйлал, гэр бүлийн хүчирхийлэл, насанд хүрээгүй хүүхдийг бэлгийн мөлжлөгөд ашиглах зэрэг хүчирхийллийн асуудлаар таван жил явагдсан үндэсний компани ажил нь үйл ажиллагааны үр дүнтэй хэлбэрүүдийн нэг жишээ юм. Компани ажлуудыг төрийн дэмжлэгтэйгээр ТББ-ууд зохион байгуулдаг. Энэ үйл ажиллагаа нь “эрчүүд давуу эрхтэй биш” гэсэн анхаарал татахуйц лоозон бүхий зурагт хуудсуудыг зарлалын самбар, автобус болон олон нийтийн газруудад тавих замаар график дизайн, нийгмийн маркетингийн арга техникүүдийг ашигласан. Компани ажлын үе шатууд нь судалгаагаар эхлээд түүний үр дүн дээр тулгуурлан бий болгосон үйлчилгээ үзүүлэх, хамгаалах, урьдчилан сэргийлэх гэсэн гурван “п”-ийн үйл ажиллагаа явагддаг.

341. Австралийн Засгийн газар 2004 онд гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийг эсэргүүцсэн компани ажил явуулсан. Энэ компани ажилдаа телевиз, радио, кино театр, сэтгүүл, гэр бүлийн мэдээллийн товхимол, веб хуудас болон 24 цагийн итгэлийн утас зэргийг ашигласан. Данийн Засгийн газар мөн үүнтэй адил үр дүнтэй үндэстнийг хамарсан “эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг зогсооё: анир чимээгүйг эвдье” уриатай компани ажлыг 2003 онд явуулсан. Уг компани ажил нь Дани, Англи, Араб, Түрк болон Сомали хэл дээр явагдсан бөгөөд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн олон хэлбэрийг арилгах, эмэгтэйчүүдэд тэдний эрх болон боломжийн талаар сурталчилахад чиглэгдсэн.

342. Танзанийн хэвлэл мэдээллийн эмэгтэйчүүдийн холбоо нь ТББ бөгөөд 1998 онд эмэгтэйчүүдийн бэлэг эрхтнийг зэрэмдэглэх зан үйлийг гэмт хэрэг гэж үзэх Бэлгийн Гэмт Хэргийн тухай онцгой хуулийг сурталчлах үр дүнтэй хэвлэлийн компани ажил явуулсан. Уг компани ажилд нийгмийн, сэтгүүл зүйн судалгаа, радиогийн нэвтрүүлгүүд, телевиз, мэдээллийн олон хэрэгслийг ашигласан. Мөн ТББ, хэвлэл мэдээллийн ажилтнууд, театрын уран бүтээлчдийг үйл ажиллагаандаа хамруулжээ. Компани ажлын хүрээнд боловсрол олгох материал, мэдээлэл олгох гарын авлагууд, олон улсын тунхаг бичиг, веб хуудсуудыг Англи, Франц болон Араб хэл дээр боловсруулжээ.

343. 1991 оноос хойш жил бүрийн 11 сарын 25-наас 12 сарын 10-ны хооронд “эмэгтэйчүүдийн эсрэг жендерт суурилсан хүчирхийллийн эсрэг 16 өдрийн аян” нэртэй дэлхий нийтийг хамарсан ТББ-ын компани ажлыг явуулж эхлээд байна. Уг үйл ажиллагаанд дэлхийн бараг бүх орны энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бүлгүүд оролцдог. Компани ажлын хүрээнд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаарх олон нийтийн мэдлэг ухамсрыг дээшлүүлэхэд чиглэгдсэн дэлхий нийтийн

болон орон нутгийн үйл ажиллагааны гарын авлага материалуудыг боловсруулж, эдгээр үйл ажиллагааг ХДХВ/ДОХ-оос урьдчилан сэргийлэх зэрэг бусад тулгамдсан асуудлуудаар үйл ажиллагаагаа уялдуулдаг. Түүнчлэн, үйл ажиллагааны стратегийг боловсруулах, санал солилцох зорилготой дэлхийн хэмжээний чуулга уулзалтыг зохион байгуулдаг. 2005 онд энэхүү компанид ажилд 130 гаруй орны Засгийн газрын бүх түвшний, салбарын байгууллагууд, НҮБ-ын зарим байгууллагууд, олон улсын болон орон нутгийн ТББ-ууд оролцуулсан өргөн хүрээтэй үйл ажиллагаа явуулсан. “16 өдрийн аян” нэртэй энэхүү компанид ажил нь иргэний нийгмийн санаачилсан үйл ажиллагаанд Засгийн газрыг татан оролцуулж, мэдээлэл, харилцаа холбооны шинэ технологийг үр дүнтэй, бүтээлчээр ашигласнаараа үлгэр жишээ ажил болсон.

(б) Олон нийтийг дайчлан оролцуулах

344. Хамт олны түвшинд олон нийтийг дайчлах стратеги нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үр дүнтэй аргад тооцогддог. Олон нийтийг дайчлах үр дүнтэй үйл ажиллагаанд орон нутгийн засаг захиргааны төлөөлөгчид, олон нийтийн удирдагчид, ТББ-ууд, эмэгтэйчүүдийн бүлгүүд зэрэг нийгмийн бүх түвшнийхэн оролцдог.

345. Компанид ажлын хүрээнд явагдсан “дуу хоолойгоо нэгтгэе” хөтөлбөр нь орон нутгийн зөвлөл, цагдаа, олон нийтийн зүгээс эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг устгах үйл ажиллагаанд өөрчлөлт хийх зорилготой хамт олны түвшин дэх олон салбарын хамтын ажиллагаанд дээр тулгуурласан урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа юм. Эмэгтэйчүүдийн бэлэг эрхтнийг зэрэмдэглэх зан үйл түгээмэл байдаг дээд Египетийн Миньягийн Дэйр Эль Барша гэдэг газар ТББ-ууд орон нутгийнхан болон пашны удирдагчдад хандан энэ зан үйлийн сөрөг үр дагаврын талаар сурталчлан ойлгуулах үйл ажиллагаандаа олон нийтийг дайчлах аргыг ашиглажээ. Эдгээр удирдагчид өөрсдийн харьяа нутаг дэвсгэрт амьдардаг өрхүүдэд хүрч тусламж үзүүлжээ. Энэ үйл ажиллагааны үр дүнд энэ тосгоныхон эмэгтэйчүүдийн бэлэг эрхтнийг зэрэмдэглэх зан үйлийг үйлдэхээ зогсоож, эцэг эхчүүд уг зан үйлийг хийхгүй байхаар тохиролцож, эрчүүд уг зан үйлийг хийлгээгүй охидтой гэрлэх болж, уг зан үйлийг үйлдэх зохисгүй заншлыг таслан зогсоож чаджээ.

(в) Эрчүүдтэй ажиллах

346. Хүйсийн харилцаанд гардаг тэгш бус байдал, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг арилгах үйл ажиллагаа нь эрэгтэйчүүдийн оролцоогүйгээр амжилттай хэрэгжих боломжгүй юм. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг тэвчихгүй байх нийгмийн сэтгэлгээг бий болгох, эмэгтэйчүүдийн манлайллыг дэмжих үйл ажиллагаанд эрэгтэйчүүдийг оролцуулах нь үйл ажиллагааны үр дүнтэй хэлбэрт тооцогддог. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд эрчүүдийг татан оролцуулах стратегид цэрэг, үйлдвэрчний эвлэл, спортын баг, цагдаа зэрэг зохион байгуулалттай бүлгүүдийн тухайн асуудлын талаарх мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр хамтран ажиллах, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх тэмцэлд үлгэр жишээ болохуйц эрэгтэйчүүдийг оролцуулсан компанид ажлыг зохион байгуулах зэрэг үй ажиллагаа багтана.

347. “Цагаан тууз” нэртэй компанид ажлын хүрээнд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг хэзээ ч үйлдэхгүй гэсэн амлалтын илэрхийлэл болсон цагаан туузыг эрчүүд, хөвгүүд Эмэгтэйчүүдийн Эсрэг Хүчирхийллийг Арилгах Олон Улсын өдөр болох 11 сарын 25-ны өдөр зүүдэг. Энэхүү компанид ажлын хүрээнд эмэгтэйчүүдэд хандах эрэгтэйчүүдийн хандлагыг өөрчлөхөд чиглэсэн боловсрол олгох үйл

ажиллагааны гарын авлагыг боловсруулан дунд сургууль, их сургууль, бизнесийн байгууллагууд, үйлдвэрчний эвлэлийн байгууллагуудад тараадаг. Канадад 1991 онд анх эхэлснээс хойш цагаан тууз компани ажил Африк, Ази, Европ, Латин Америк, Номхон далайн зэрэг нийт 47 оронд хэрэгжиж байна.

348. Гондурасын нэгэн хотын дарга эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаар олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх үйл ажиллагаанд эрэгтэйчүүдийг татан оролцуулж эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаар эрэгтэйчүүдэд зориулсан сургалтыг хөл бөмбөгийн шинэ тоног төхөөрөмж худалдан авах үйл ажиллагаатай уялдуулж өгсөн. Олон эрчүүд уг компани ажилд идэвхитэй хамрагдсан бөгөөд эрэгтэйчүүдийн хөл бөмбөгийн багууд тоглолтын өмнө болон дундуур эмэгтэйчүүдийн эрхийг хүндэтгэхийг сурталчилсан зурагт хуудсуудыг барин гарч ирдэг болсон байна. Австралийн Нью Сауф Велсийн засаг захиргаа “эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл нь бүх хууль дүрмийг зөрчиж байгаа хэрэг мөн” гэсэн уриатай 21-29 насны эрэгтэйчүүдэд чиглэсэн нийгмийн боловсрол олгох компани ажилд алдар цуутай эрэгтэй тамирчдыг татан оролцуулсан байна.

(г) Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, мэдээлэл технологийг ашиглах нь

349. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг мэдээлэх сэтгүүлчид, бусад хэвлэл мэдээллийн ажилтнуудыг сургалтанд хамруулах нь мэдээллийн чанарыг сайжруулах, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн шалтгаан, уршгийн тухай нийгэм дэх ерөнхий ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэхэд ач холбогдолтой тул үр дүнтэй үйл ажиллагааны хэлбэрт тооцогддог. Непалд сонинд гарсан гэр бүлийн хүчирхийллийн асуудлаарх мэдээлэлд хяналт тавих, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаар хэвлэл мэдээллийнхэнд сургалт зохион байгуулах, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн тохиолдлыг хохирогчийн эрх ашгийг хүндэтгэсэн, мэдрэмжтэй байдлаар мэдээлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор эмэгтэй сэтгүүлчдийн бүлгийг байгуулжээ.

350. Аль болох олон хүнд мэдээлэл хүргэх зорилгоор олон нийтийн дунд нэр хүндтэй, олон хүн үздэг мэдээллийн хэрэгслүүдийг ашиглах нь мөн үр дүнтэй үйл ажиллагааны хэлбэрт тооцогддог. Тухайлбал, Энэтхэгийн эмэгтэйчүүдийн хүний эрхийн бүлгээс хийсэн “бэрхшээлийг даван тууль” нэртэй хөгжмийн видео клип нь гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүчирхийлэлд өртөгчдийг дэмжих асуудлыг хөндсөн. Уг видео клип нь Энэтхэгийн 26 сая айл өрхөд хүрч чадсан бөгөөд Энэтхэгийн шилдэг 10 хөгжмийн нэгд багтаж чаджээ.

351. Гар утас, интернет зэрэг мэдээлэл, харилцааны шинэ технологиудыг ашиглах нь мэдээллийг өргөн хүрээнд түгээх, дэлхийн өнцөг буланд байгаа хамтрагчдыг хоорондоо холбогдох боломжийг бий болгоход үр дүнтэй үйл ажиллагаа юм. www.stopfgm.org хаяг бүхий веб хуудас нь интернет ашиглан мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, болон түгээх, эмэгтэйчүүдийн бэлэг эрхтнийг зэрэмдэглэх зан үйлийг устгахад чиглэсэн үйл ажиллагааны үр дүнтэй хэлбэрүүдийг түгээн дэлгэрүүлэх, олон улсын хэмжээнд санал бодлоо илэрхийлэх индэр болгон ашиглаж байгаа үйл ажиллагааны үр дүнтэй хэлбэрийн нэг жишээ юм.

(д) Нийгмийн аюулгүй байдлыг дэмжих нь

352. Эмэгтэйчүүдийн амьдрах орчныг илүү аюул багатай болгоход чиглэсэн үйл ажиллагааны үр дүнтэй хэлбэрүүд нь нийгмийн аюулгүй байдлын хяналтын байгууллагаас аюултай газруудыг тодорхойлох, эмэгтэйчүүдийн айдас түгшүүрийн талаар ярилцах, тэдний аюулгүй байдлыг сайжруулах асуудлаар эмэгтэйчүүдийн

санал бодлыг сонсох зэрэг болно. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх асуудал нь хот суурин газрууд, хөдөө орон нутгийн төлөвлөлт, барилга байгууламж, орон сууцны дизайны төлөвлөлтийн тодорхой бүрэлдэхүүн хэсэг байх ёстой. Сургууль, боловсролын байгууллагууд, худаг, тариалангийн талбай, үйлдвэр зэрэг эмэгтэйчүүд олноор зорчдог газрууд руу явах нийтийн тээврийн хэрэгслүүд, замын аюулгүй байдлыг сайжруулах нь нэг төрлийн урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа юм. Тухайлбал, Танзанийн Бүгд Найрамдах Улсын “аюулгүй хот” нэртэй үйл ажиллагааны явцад хотын аюултай байдлыг хангах талаар орон нутгийн байгууллагуудын чадавхийг дээшлүүлэх чиглэлээр орон нутгийн оршин суугчид, бусад байгууллагуудтай хамтран ажилласан. Энэ үйл ажиллагааны явцад аюулгүй байдлыг хянах үйл ажиллагааны хүрээнд эмэгтэйчүүдийн оролцоотойгоор аюултай байж болох газруудыг тодорхойлж, асуудлыг шийдвэрлэх чиглэлээр холбогдох байгууллагуудад санал, зөвлөмж өгсөн. Мөн дүрвэгсдийн сууринд эмэгтэйчүүдийн амьдрах аюулгүй байдлыг сайжруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

(е) Боловсрол, чадавхийг бэхжүүлэх нь

353. Албан ёсны боловсрол олгох тогтолцоог эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн мэдлэг, сэрэмжийг дээшлүүлэх, хүйсийн талаарх хэвшмэл ойлголтыг арилгахад үндсэн арга хэрэгсэл болгон ашиглаж болно. Боловсролын хөтөлбөр дэх хүйсийн талаарх хэвшмэл ойлголтыг арилгах, багш нарт хүйсийн мэдрэмжийг дээшлүүлэх сургалт явуулах, хүчирхийллийг хүлээн зөвшөөрдөггүй орчныг сургуулиудад бүрдүүлэх болон хүний эрхийн талаар, тэр дундаа, эмэгтэйчүүдийн эрхийн талаар мэргэжлийн сургалтуудыг явуулах зэрэг нь үр дүнтэй үйл ажиллагааны хэлбэрт тооцогддог.

(ё) Урьдчилан сэргийлэх бусад стратегиуд

354. Урьдчилан сэргийлэх үр дүнтэй үйл ажиллагааны олон үр дүнтэй хэлбэрүүд байдаг. ТББ-ууд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлд өртсөн хохирогчдын дуу хоолойг сонсох, тэдэнд тохиолдсон учралыг ярилцах зэргээр ийм төрлийн хүчирхийллийн бодит байдлыг олон түмэнд ойлгуулах, түүний хор уршгийг илчлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахад уриалах зэргээр идэвхитэй үйл ажиллагаа явуулж байна. Эмэгтэйчүүдийн эрхийн төлөө тэмцэгчид Засгийн газар, парламентын гишүүдийг урьдчилан сэргийлэх илүү идэвхитэй үйл ажиллагаа явуулахыг шаардаж, ухуулан сурталчлах үйл ажиллагааг тууштай явуулж байна. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн асуудлаарх маргаан нь хохирогчдыг хамгаалах, энэ төрлийн хэргийг шийдвэрлэх үйл ажиллагаанд оршиж байгаа сул тал, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа илүү их шаардлагатай байгааг харуулж байна. Урьдчилан сэргийлэх стратеги нь хүчирхийлэл үйлдэгчидтэй хүйсийн тэгш байдлыг бий болгох чиглэлээр ажиллах, хамт олны гишүүдийн дунд зөрчлийг шийдвэрлэх наад захын чадвар эзэмшүүлэх чиглэлээр сургалт явуулах зэрэгт ихэвчлэн тулгуурладаг. Туршлага солилцох үйл ажиллагаа нь урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны мэдлэгийг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой ба тогтмол үйл ажиллагаа болгон явуулахад дэмжлэг шаардлагатай байдаг.

Д. Үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд тулгарч буй бэрхшээлүүд

355. Хэдийгээр сүүлийн жилүүдэд тодорхой үр дүн гарч, үр дүнтэй үйл ажиллагааны хэлбэрүүд олноор бий болсон ч эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг арилгах үйл ажиллагаанд олон бэрхшээл тулгарсаар л байна. Түүнчлэн, зарим үр дүнтэй аргуудыг хэрэгжүүлэх явцад бэрхшээл тулгарч бөгөөд энэ асуудлыг бас анхааран үзэх

шаардлагатай болдог. Жишээ нь: хэдийгээр эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн тохиолдлыг шуурхай мэдээлэх, мөрдөн шинжлэх, шүүн таслах үйл ажиллагааны тусгай дүрэм, журмууд гаргасан ч бодит байдалд иймэрхүү дүрэм, журам нь анхаарлын гадна орхигдоод, хэрэгжүүлэхэд шаардлагатай нөөц, дэмжлэгийг авч чадахгүй байх нь бий. Эдгээр дүрэм, журам нь цагдаа, шүүх зэрэг хуулийн байгууллагуудын үйл ажиллагааны механизмыг олгодог хэдий ч эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн асуудлыг мэргэжлийн түвшинд үр дүнтэй шийдвэрлэхэд шаардлагатай мэдлэгийг бий болгодоггүй. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн асуудалтай тэмцэх аргуудын дотроос маргааныг шийдвэрлэх хамгийн боломжтой механизмыг сонгохдоо түүний тохиромжтой эсэх, гарч болох үр дагаврыг сайтар нягтлан үзэх шаардлагатай бөгөөд ялангуяа, энэхүү механизм нь хамт олны нэгдэл нягтрал, гэр бүлийн нэр хүндийг хохирогчдын эрхээс дээгүүр тавьсан тохиолдолд бүр илүү анхаарал тавих нь чухал.

356. Хэдийгээр эмэгтэйчүүдийн байгууллага, эмэгтэйчүүдийг дэмжих нь үр дүнтэй үйл ажиллагааны чухал бүрэлдэхүүн хэсэг боловч энэхүү зорилгыг хэрхэн үр дүнтэй хэрэгжүүлэх вэ гэдэг асуудал үргэлж тодорхой биш байдаг. Жишээ нь: хохирогч хэдийгээр энэ хэргийг хэрэгсэхгүй болгохыг хүссэн ч төрийн зүгээс хэргийн мөрдөх, шүүн таслах үйл ажиллагааг зогсоолгүй явуулах бодлого байдаг. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл үйлдсэн этгээдийг шоронд хорих зэрэг зохих шийтгэлийг оногдуулах үйл ажиллагаа хохирогчдын зүгээс олон шалтгааны улмаас хүчирхийлэгч, хамтран амьдрагчаа шоронд оруулахыг хүсээгүйн улмаас хэргийг мэдээлэхэд саад болох хүчин зүйл болдог.

1. Улс төрийн эрмэлзлийн дутмаг байдлыг илэрхийлэх тогтвортой бус үйл ажиллагаа, хөрөнгө нөөцийн хомсдол

357. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн асуудлаарх төрийн үйл ажиллагаа нь чиглэсэн зорилгогүй, тогтвортой, системтэй биш байдаг. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг үндэстний хэмжээнд устгахад чиглэсэн үйл ажиллагааны олон дутагдалтай талуудыг хүний эрхийн олон улсын хэлэлцээрийн байгууллагаас VI хэсэгт дурдсан байдлаар тодорхойлсон. Ийм системтэй үйл ажиллагаа дутагдалтай байгаагийн шалтгаан янз бүр байдаг ч эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг бусад гэмт хэрэг, хүний эрхийг зөрчсөн үйлдлүүдийн хэлбэрүүдтэй харьцуулахад тийм ч ноцтой байдлаар авч үздэггүй. Хуулийн болон дэмжлэг үзүүлэх зэрэг урьдчилан сэргийлэх үйлчилгээнд зориулсан хөрөнгө оруулалт, нөөцийн хэмжээ нь бусад олон асуудалтай харьцуулахад харьцангуй бага байсаар байна.

2. Нэгдмэл үйл ажиллагааны дутагдал

358. Хэдийгээр эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг устгах тэмцэлд олон салбарын оролцогчдын хамтарсан өргөн хүрээтэй, нэгдмэл арга зүйн чухлыг олноороо хүлээн зөвшөөрдөг боловч ийм хэлбэрийн үйл ажиллагаа түгээмэл, тогтмол хэлбэртэй байж чадахгүй байна. Хэдийгээр өргөн хүрээтэй, нэгдмэл үйл ажиллагааны загвар хэдийнээ боловсруулагдсан боловч энэ загвар нь хэрэгжихгүй, хэрэгжсэн ч тэр бүр амжилттай байж чадахгүй, нөөц боломж зэрэг олон чухал хүчин зүйлийг байнга орхигдуулсаар байна.

3. Санхүүгийн дутагдалтай байдал

359. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх хуулийг хэрэгжүүлэх, үйлчилгээ үзүүлэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд тогтвортой санхүүжилт шаардлагатай байдаг. Ийм хэлбэрийн үйл ажиллагааны гол санхүүжүүлэгчид нь

Улсын төсөв болон донорууд байдаг. Гэвч эдгээр үйл ажиллагаанд Улсын төсвөөс өгөх санхүүжилт байнга л дутагдалтай байдаг. Харин доноруудын санхүүжилт нь ихэвчлэн төслийн хүрээнд хязгаарлагддаг бөгөөд тогтвортой биш байдаг төдийгүй зарим тохиолдолд энэ асуудлаар ажиллаж байгаа эмэгтэйчүүдийн бүлгийнхний хүсэл эрмэлзэлд нийцэхгүй байх нь бий. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааг тогтвортой, үр дүнтэй байлгахын тулд тусгайлсан санхүүжилтээс гадна үндэсний төсвөөс санхүүжилт гаргах шаардлагатай.

4. Хүчирхийлэл үйлдэгчдийн ял завших явдлыг зогсоох үр дүнгүй ажиллагаа

360. Шинэ хууль гаргах, хуулийн хэрэгжилтийн үр дүнг дээшлүүлэх зэргээр эрүүгийн хуулийн системийг шинэчлэх үйл ажиллагаа үргэлжилсээр байгаа боловч эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл үйлдэгчид цээрлэлгүйгээр амар тайван амьдарсаар байна. Хүчирхийлэл үйлдэгчдийг хуулийн хариуцлагад татах явдлыг дэмжих нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл үйлдэгчдэд шийтгэл оноохоос илүү чухал. Үнэн хэрэгтээ хэт хүнд ял оноох нь хүчирхийллийн тохиолдлыг нуун дарагдуулах, мэдээлэх явдлыг багасгах үр дагаварт хүргэж болзошгүй. Түүнчилэн хэрвээ ял шийтгэл хэт хөнгөн, эмэгтэйчүүдийг хамгаалах чадваргүй бол эмэгтэйчүүдийн зүгээс хуулийн системд итгэх итгэл алдрах боломжтой.

5. Ялгаварлан гадуурхах хэлбэрүүдийн хоорондын хамаарал

361. Арьс, үндэс угсаа, нас, нийгмийн байдал, шашин, соёл, хэл, бэлгийн чиг баримжаа, цагаачлагч болон дүрвэгсэд, тахир дутуу зэрэг байдалд эрэгтэйчүүдийн давамгайлах хандлага нь олон түвшинд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй холбоотой байдаг. Олон хэлбэрийн ялгаварлан гадуурхах явдал нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг бий болгодог. Хүчирхийлэл үйлдэгчид нь зарим эмэгтэйчүүд бусад эмэгтэйчүүдээс нийгмийн байдлын хувьд доогуур тул тэдэнд тусламж хүсэх мэдээлэх боломж харьцангуй бага гэдгийг мэддэг учраас зарим эмэгтэйчүүдийг тодорхой хэлбэрийн хүчирхийлэлд илүү өртөмхий болоход нөлөөлдөг.

6. Үнэлгээний дутмаг байдал

362. Хэдийгээр үйл ажиллагааны талаарх судалгаа шинжилгээний ажил харьцангуй нэмэгдэж байгаа ч “чухам юу болж байна вэ” гэдэг талаарх мэдээлэл дутмаг байсаар байна. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг эцэс болгоход шаардлагатай өөрчлөлтүүдийг бий болгох арга зүйг боловсруулахад нөөц хангалтгүй байсаар байна. Төрийн байгууллагуудаас ТББ-ууд болон судлаачидтай хийж байгаа ярилцлага, хэлэлцээрүүд нь бүхий л түвшинд дүн шинжилгээ хийхэд тохиоромжтой арга хэмжээг олж илрүүлэх, боловсруулахад хувь нэмрээ оруулна.

VIII. Дүгнэлт, зөвлөмж

A. Дүгнэлт

363. Судалгааны дүнгээс эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл нь маш олон эмэгтэй хүний амьдралд сөргөөр нөлөөлж байгаа, өргөн дэлгэрсэн, ноцтой асуудал бөгөөд дэлхий даяар тэгш байдал, хөгжил дэвшил, энх тайванд хүрэхэд учирч буй бэрхшээл тогтор юм. Хүчирхийлэл эмэгтэйчүүдийн амьдралыг аюултай байдалд оруулж, эмэгтэйчүүд өөрт заяасан авьяас, чадвараа бүрэн хөгжүүлэхэд саад болж байдаг. Энэ нь иргэний хувьд эрхээ эдлэхэд бэрхшээл үүсгэж, гэр бүл, иргэдэд хор хохирол учруулж, ихэнхидээ үхэлд хүргэдэг бусад хэлбэрийн хүчирхийллийн нийгмийн дунд өөгшүүлэх хүч болдог.

364. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл нь түүхийн хувьд эрэгтэй, эмэгтэй хүний тэгш бус эрх мэдэлд үндэслэсэн, нийгэм хувь хүний амьдралын хүрээнд системтэйгээр үйлдэгддэг ялгаварлан гадуурхал болохынхоо хувьд хүний эрхийн зөрчил болдог юм. Хүчирхийлэл нь эцгийн эрхт ёсон дахь эрх мэдлийн тэгш хуваарилалт, хүйсийн ялгаварлалыг төрүүлж байдаг нийгэм, эдийн засгийн хэм хэмжээ, практик, эдийн засгийн тэгш бус байдал зэргийг хамарсан өргөн хүрээтэй эх сууриас гаралтай. Үүний тоо хэмжээ, далайц нь гол төлөв бусад хэлбэрийн ноёрхолтой сүлэлдсэн, хүйсийн ялгаварлалын хэмжээ, далайцын тусгал болж байдаг. Иймд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг устгах ажлыг бүх хэлбэрийн ялгаварлан гадуурхлыг устгах, жендерийн тэгш байдлыг хөгжүүлэх, эмэгтэйчүүдийг чадваржуулах, эмэгтэй хүн хүний бүх эрхээ эдэлж чаддаг тийм дэлхий ертөнцийг бүтээн босгох ажлын өргөн утгаар авч үзэх ёстой.

365. Энэ судалгаагаар эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн олон хэлбэр, илрэлүүдийг гэр бүл, нийгэм, төрийн хууль цаазын бусад байгууллагууд, зэвсэгт мөргөлдөөн, дүрвэгсэд, дотоодын шилжин суурьшлын хөдөлгөөн зэрэг өргөн хүрээтэй орчин нөхцөлд авч үзлээ. Хүчирхийлэл эмэгтэй хүний амьдралын туршид хөндий орон зай үүсгэж, хувийн болон нийгмийн амьдралын хүрээний алинд ч тохиолдож, нэг хүчирхийлэл нөгөө хэлбэрийн хүчирхийллийг бий болгох байдлыг үүсгэдэг. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл ихэнхидээ бие махбодид шууд халдсан хэлбэрээр гарах боловч сэтгэл зүйн, эдийн засгийн дарамт байдлаар ч илэрдэг. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн олон хэлбэрийг тогтоон таньж мэдэх нь нэмэгдсэн хэдий ч ийм хүчирхийллийн янз бүрийн хэлбэрийн бодит хэмжээ, далайцыг тогтоох олон талт мэдээллийг цуглуулах ажил хангалтгүй хэвээр байна.

366. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл дэлхий нийтийн шинжтэй, бүхий л нийгэм, соёлын хэв шинжид тохиолдож байхын зэрэгцээ өөр өөр хэлбэрээр илэрч, мэдрэгдэж байна. Эмэгтэй хүн хохирч байгаа хүчирхийллийн хэлбэр, илрэл нь хүйсийн хүчин зүйл талаасаа арьсны өнгө, үндэс угсаа, анги зиндаа, нас, бэлгийн чиг баримжаа, хөгжлийн бэрхшээл, үндэстэн, эрх зүйн байдал, шашин, соёл зэрэг өөр өөр хүчин зүйлүүдтэй харилцан холбоотойгоор биежин илэрдэг. Иймд нийт эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг устгахын тулд тэдгээр хүчин зүйлс анхааралдаа авсан стратегийг баримтлах ёстой болно.

367. Сүүлийн 20 жилийн турш эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх олон улсын хэм хэмжээг зөвшилцөн боловсруулахад ихээхэн ахиц дэвшил гарлаа. Ингэснээр сонирхогч талууд болох улс орон, НҮБ-ын зүгээс эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг эцэс болгох зорилгыг гаргажирэх үндэс суурь бүрдэв. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх төрийн үүрэг, хариуцлага ил, тодорхой байх ёстой

бөгөөд төрийн байгууллагын, албаны бус этгээдийн үйлдлийн алиныг ч энэ үүрэг хариуцлагад хамааруулна. Төрөөс эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, ийм хэрэг гарсан тохиолдолд мөрдөн шалгаж, буруутай этгээдэд ял оноох, хохирогчдын хохирлыг барагдуулах арга хэмжээ авах үүрэг хүлээдэг.

368. Харамсалтай нь улс орнууд эдгээр үүрэг хариуцлагаа биелүүлэх явдал туйлын хангалтгүй байна. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл ял зэм хүлээхгүй өнгөрч байгаа нь хүчирхийлэл эрэгтэйчүүд эмэгтэйчүүдийг эрхшээлдээ байлгах механизм болсныг харуулж байна. Төр хүчирхийлэл үйлдэгчдийг хариуцлагад татаж чадахгүй, нийгэм хүчирхийллийг ил, далдаар өөгшүүлдэг нөхцөлд хүчирхийлэл ял зэмгүй өнгөрч байгаа нь, түүнийг цаашид даамжруулахад зогсохгүй, эрэгтэйчүүд эмэгтэйчүүдийг захирах, эрхшээлдээ байлгах байдал нь байх ёстой зүйл мэтээр ойлголт төрүүлж байна. Шийтгэл хүлээдэггүй байдал нь тухайн хэргийн хохирогч хуулийн шударга ёсыг хүртэх боломжийг хаан боогдуулахаар барахгүй, хүйсийн харилцааны давамгайллыг батжуулж, эмэгтэйчүүд, охидын тэгш бус байдлыг цаашид нэмэгдүүлэх хор уршигтай.

369. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх олон улсын хэм хэмжээ, түүнийг хэрэгжүүлэх улс төрийн хүч нөөцийг гаргах тодорхой амлалт үүрэг хоёрын хооронд асар их хүлээж авч боломгүй зааг завсар байна. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл гарч байдаг өргөн утгаар нь төрийн үүрэг, хариуцлагыг тухайлан тодорхойлж өгөх шаардлагатай байна. Ийм өргөн хүрээтэй нөхцөл байдал, бэрхшээл дунд тухайн улс орнууд өөр өөр арга хэмжээ авч хэрэгжүүлж болох боловч гар хумхин суух нь уучилж болшгүй зүйл.

370. Төр эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, шийтгэл оногдуулах, устгах үүрэгтэй бөгөөд энэ үүрэг, хариуцлагаа өөр байгууллагад шилжүүлэх ёсгүй. Гэхдээ төрийн байгууллагаас дэмжиж, дэлгэрүүлж, бүтцийн хувьд албан ёсны болгож болох туршилтын хөтөлбөрүүдийг эмэгтэйчүүдийн байгууллагаас хэрэгжүүлж байдаг учир төрөөс ТББ, иргэний нийгмийн бусад байгууллагууд, хувийн хэвшлийн салбарынхантай хамтран нөхөрлөл хэлбэрээр ажиллаж ихээхэн амжилт гаргаж байна. Цаашид эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх төрийн стратеги боловсруулах ажил эмэгтэйчүүдийн туршлага оролцоонд суурилах ёстой.

371. Эмэгтэйчүүд хүчирхийлэлд өртөж буй олон арга замуудыг олж тогтоох, тэдгээрийг үндэсний ба олон улсын анхааралд ил гарган тавих ажилд эмэгтэйчүүдийн хөдөлгөөн чухал үүрэг гүйцэтгэнэ. Эрэгтэйчүүд эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэж байгаа хүчирхийлэл нийгэм эдийн засаг, улс төрийн үйл явцыг даган өөрчлөгдөн хувирч байдаг тул тухайн цаг үед гарсан хүчирхийллийн тоо хэмжээ нь уг үзэгдлийн бүрэн хэмжээг хамарч чадахгүй. Интернет гэх мэт шинэ технологи, чөлөөт худалдааны бүс зэрэг шинэ нөхцөл байдлууд бий болгож байна. Төр эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн шинэ хэлбэрүүдийг гарсан, тогтоогдсон даруйд нь асуудлыг шийдвэрлэхэд бэлэн байх ёстой.

372. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл өргөн хүрээнд нарийн төвөгтэй байдлаар илэрч байдаг. Энэ байдал нь асуудал шийдэж болшгүй юм уу зайлшгүй зүйл гэдгийг харуулж байгаа явдал биш. Нэгэнт эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл нийгмээс урган гарч байгаа болохоор, түүнийг төрүүлж буй үйл явцыг нь таслан зогсоож болно. Хүчирхийллийг устгах, эмэгтэйчүүд өөрсдийн хүний эрхээ эдлэх боломжийг нь баталгаажуулах улс төрийн хүсэл зориг нөөц бололцоог дайчилбал, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг ихээхэн бууруулж, улмаар устгах боломжтой. Жендерийн тэгш байдлыг, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг дуусгавар болгох ажлын аль нэг

хувилбар, хоёрдугаар зэргийн зорилт болгон авч үзэж болохгүй. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх ажилд уялдаа холбоо бүхий олон салбарыг хамаарсан үйл ажиллагаа шаардлагатай. Үйл ажиллагаа, уялдаа холбоо, хяналт, хариуцлагын тогтолцоог баталгаажуулахад үндэстэн, бүс нутаг, олон улсын түвшинд бүтцийн хүчирхэг механизм байх шаардлагатай.

373. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл их хэмжээгээр үргэлжлэн гарсаар байгаа нь дэлхий даяар хүчирхийллийг гааруулж, хүний эрх, хөгжил дэвшил, энх тайванд хүрэх зорилгод саад учруулж байна. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн эсрэг тэмцэлд нийт хүн төрөлхтөн хүчин чармайлтаа нэгтгэх шаардлагатай байна. Энэ асуудлыг бүх улс гүрэн, хүн ард, орон нутгийн, үндэсний, бүсийн болон олон улсын тэргүүлэх чиглэлийн асуудал болгох цаг болсон байна.

Б. Ял завших, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх арга хэмжээ

374. Бээжингийн Тунхаглал болон Үйл ажиллагааны үндэслэл зэрэг Засгийн газар хоорондын гэрээ, НҮБ-ын байгууллага, албад, судлаачид, ТББ-ын гаргасан тайлан, судалгаа, удирдамжуудад эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх арга хэмжээний талаар нарийн тодорхой зөвлөмжүүдийг боловсруулсан байдаг. Харин тэдгээрийг хэрэгжүүлэх байдал хангалтгүй байна. Энэхүү зөвлөмж нь одоо ашиглагдаж байгаа зөвлөмжүүдийг цаашид хөгжүүлэн, олон улсын, хэм хэмжээ, үүрэг, хариуцлагаа биелүүлэх ажлыг хурдасгах зорилготой юм.

375. Энэхүү зөвлөмж нь улс орны түвшинд 6 гол салбарт үйл ажиллагаа явуулахад чиглэсэн. Түүнчилэн Засгийн газруудын хооронд болон НҮБ-ын системд чиглэсэн тодорхой зөвлөмжүүд ч бий. Зөвлөмжид үндэслэн оролцогч талуудын авч хэрэгжүүлэх арга хэмжээг баталгаажуулахад Ерөнхий Ассамблей ямар үүрэг гүйцэтгэж болох талаар зөвлөмжид онцлон тэмдэглэсэн. Ийм арга хэмжээг авахгүйгээр цааш явах нь эмэгтэйчүүд, тэдний гэр бүл, эмэгтэйчүүдийн байгууллага, нэгдлүүдэд ямар хор хохирол учруулж болохыг гишүүн улсууд, олон улсын хамтын нийгэмлэг ойлгож ухамсарлах ёстой. Эцэст нь энэхүү зөвлөмж эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, түүнийг устгахад хэмжиж болохуйц ахиц гаргахын тулд гишүүн улс орнууд НҮБ-ын системд ямар стратеги баримтлах ёстой талаарх зөвлөмж юм.

1. Үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх зөвлөмжүүд

376. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх асуудалд ахиц дэвшил гаргахад энэ судалгаанаас гарсан стратегийн зөвлөмжүүд маш чухал ач холбогдолтой. Эдгээр зөвлөмжүүд нь хоорондоо уялдаа холбоотой эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг устгах үр нөлөөтэй, системтэй, олон талт байдлаар тэмцэхэд голлох үүрэгтэй.

(а) Жендерийн тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүдийн хүний эрхийг хамгаалах

377. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл нь эмэгтэйчүүдийн эсрэг ялгаварлан гадуурхал, эмэгтэйчүүдийн тэгш бус байдал, захирагдлын үндэс, үр дагаврын аль аль нь болж байдаг. Төр эмэгтэй хүнийг ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийг оролцуулан хүний бүх эрхийг хүндлэх, хамгаалах, баталгаажуулан хэрэгжүүлэх үүрэгтэй. Энэ үүргээ биелүүлж чадахгүй байгаагаас үүдэн хүчирхийлэл үүсч, газар авч байдаг.

378. Иймд улс орнууд:

- Хүний бүх эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалж хэрэгжүүлэх явдлыг баталгаажуулах
- Хүний эрхийн бүх гэрээ, ялангуяа Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрийг устгах Конвенц, түүний Сайн дураар биелүүлэх Протоколд аливаа тайлбаргүйгээр нэгдэн орох, батлах
- Эмэгтэйчүүдийг эрхээ мэддэг, түүнийгээ шаардаж, эдэлж чаддаг болгон чадваржуулах
- Эмэгтэй хүний эрх бусдын эрхийг хүндлэх байдалд эрэгтэй, эмэгтэйчүүд, хүүхэд багачуудыг сургах
- Эмэгтэй хүн шударга ёсыг эдэлдэг, хуулийн өмнө тэгш байдлаар хамгаалуулдаг, хүчирхийлэл үйлдэгсдийг ял зэмгүй өнгөрүүлдэггүй байх асуудлыг баталгаажуулах
- Эмэгтэй хүн бие махбодийн, бэлгийн эрх чөлөө эдлэх эрхийг хүлээн зөвшөөрч хамгаалах
- Эдийн засаг нийгмийн олон эрхүүдээс эмэгтэй хүн өмчийг өвлөх, өмчлөх, орон байртай байх, нийгмийн хамгаалалд багтах эрхийг баталгаажуулах
- Хөгжлийн төлөвлөлт гэх мэт нийгэм, эдийн засгийн бодлогын жендерт нөлөөлөх нөлөөлөлд дүн шинжилгээ хийх, эдгээр бодлого нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг гаргах, газар авахуулах бус харин түүнээс урьдчилан сэргийлж устгах нөлөөтэй байх.
- Эмэгтэй хүнийг хохироож буй хүчирхийллийн хэлбэрүүд тэдгээрийн илрэл нь гол төлөв хүйсийн хүчин зүйл, арьсны өнгө, үндэс угсаа, анги зиндаа, нас, ДОХ-ын өвчлөл, бэлгийн чиг баримжаа, хөгжлийн бэрхшээл, үндэстэн, эрх зүйн байдал, шашин, соёл зэрэг өөр өөр хүчин зүйлстэй харилцан холбоотойгоор биежин илэрдэг тул тэдгээрт зүй зохистой арга хэмжээ авахыг зөвлөж байна.

(б) Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх ажлыг манлайлах нь

379. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрийг устгах, энэ талаар олон нийтэд зориулсан боловсрол, сурталчилгааны ажлыг дэмжих явдалд бүх түвшний (орон нутаг, үндэсний, бүсийн олон улсын) бүх салбарын (төрийн байгууллага, олон нийтийн санаа бодлыг бүрдүүлэгчид, бизнесийн болон иргэний нийгмийн байгууллага, иргэдийн холбооны удирдлага гэх мэт) манлайлал онцгой шаардлагатай. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл үйлдэгсэд ял зэмгүй өнгөрөх байдлыг эцэслэх, хүлээх хариуцлагыг баталгаажуулах нь хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, түүнийг багасгахад чухал бөгөөд улс орны хувьд арга хэмжээ авах үүргээ биелүүлж байгаагийн харагдахуйц илэрхийлэл болох юм.

380. Түүнчилэн:

- Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг нэн даруй эцэслэх, хүчирхийллийн тохиолдлуудад олон нийтийн хүлээх хариуцлагыг баталгаажуулах, нийгмээрээ хүчирхийллийг жигшин зэвүүцэх, хүчирхийллийг үл хайхрах, зөвтгөх, тэвчих тогтолцооны болон соёлын шинжтэй хандлагуудыг устгах талаар төрийн дуу хоолой бүрэн хэмжээгээр гарч байх,
- Төр эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл үйлдэхгүй байх, төрийн байгууллага, албан хаагч ийм үйлдэл хийхгүй байх, үйлдсэн тохиолдолд шийтгэл, сахилгын шийтгэл хүлээлгэж байх, төрийн албаны бус этгээд хүчирхийлэл үйлдэхээс сэргийлэх,

буруутай бүх этгээдийг шалгаж ял шийтгэл ногдуулах, хохирогчдын хохирлыг барагдуулах,

- Эрчүүд эмэгтэйчүүдийг хүчирхийлэх байдлыг иргэд тэвчих, хүлээн зөвшөөрөх хандлагыг эцэс болгох улс төрийн хүсэл зорилгыг бий болгох, шийдвэртэй арга хэмжээ авахад иргэдийг манлайлагч олон нийтийн санал бодлыг бүрдүүлэгчид (сургууль, шашин, уламжлалын байгууллагууд, нутгийн зөвлөлүүд, үйлдвэрчний эвлэл, бизнесийн болон нийтийн мэдээллийн хэрэгслүүд) голлох үүрэгтэй.
- Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг эрс эсэргүүцэх, гэм буруутай этгээдийг хамгаалж өөгшүүлэх явдлыг зогсоох талаар эрчүүд, эрэгтэй хүүхдүүдийн дуу хоолойг сонсгох, дэмжих
- Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг устгах талаар эмэгтэйчүүдийн анхан шатны байгуулагаас эхлэн бүх шатанд эмэгтэйчүүдийн манлайллыг хүлээн зөвшөөрч, ажлаа саадгүй явуулах бололцоогоор хангах, тэдний хүчин чармайлтыг идэвхитэйгээр дэмжихийг зөвлөмж болгож байна.

(в) Олон улсын стандарт, үндэсний хууль тогтоомж, бодлогууд түүний хэрэгжилтийн явц дахь хийдлийг арилгах

381. Олон улсын хэм хэмжээ амьдралд хангалттай хэрэгжихгүй байна. Олон улсын хэм хэмжээг улс орон, орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх арга хэмжээ авч чадахгүй байгаагаас эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл үйлдсэн төрийн ба төрийн бус этгээдүүд гэм зэмгүй өнгөрөх явдал гарсаар байна.

382. Иймд улс орнуудад хандан дараахь зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

- Үндэсний хууль тогтоомж, бодлого, практикийг олон улсын хууль тогтоомжид нийцүүлэх
- Улс орнуудын тайлан, олон улсын байгууллагуудтай харилцсан баримт бичиг, лавлагаанд хүний эрхийн гэрээний байгууллагууд, ялангуяа, Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг устгах хорооны гаргасан зөвлөмжүүдийн дагуу арга хэмжээ авах, тэдгээрийг хэрэгжүүлэх
- Эмэгтэйчүүдийн эсрэг ялгаварлан гадуурхсан шинжтэй бүх хууль тогтоомжийг хүчингүй болгох, ялгаварлан гадуурхлын шинж байгаа эсэх талаар бодлого, практикийг эргэн хянаж үзэх, ялгаварлан гадуурхахгүй байх зарчимд үндэслэн олон улсын хүний эрхийн хэм хэмжээнд өөрийн дотоодын хууль тогтоомжийг нийцүүлэх
- Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрүүдтэй зохистой тэмцэх хуулиуд байх талаар арга хэмжээ авах
- Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, түүнийг мөрдөн шалгах, гэм буруутан нь хэн байхаас үл хамааран шийтгэл ногдуулах, хохирогчдын гомдлыг барагдуулах талаар зохих анхаарал тавьж ажиллах
- Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл үүсэх тогтолцооны шинжтэй шалтгааныг арилгах, ялгаварлан гадуурхах практик, нийгмийн хэм хэмжээг гаргуулахгүй байх урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх талаар зохистой арга хэмжээ авах
- Иргэний нийгмийн байгууллага, ялангуяа, ТББ, эмэгтэйчүүдийн бүлэг, сүлжээтэй зөвлөлдөн, хянаж, шинэчлэх боломжтой үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх

- Хохирогчдод тэдний эрх, хуульд зааснаар хохирлоо барагдуулах боломж, арга замын талаар ойлголт, мэдлэг олгох
- Хохирогчдын хэрэгцээ, шаардлагыг хангах, тэдний эрхийг баталгаажуулж ажиллах ур чадвар бий болгохын тулд хууль хяналт, эрүүл мэнд боловсролын системийн нийт ажиллагсдыг мэргэжлийн боловсрол, сургалт, чадавхийг бэхжүүлэх бусад арга хэмжээ авах
- Эмэгтэйчүүдийн аюулгүй байдлыг хангадаг зохистой, хүртээмжтэй үйлчилгээгээр хохирогч эмэгтэйчүүдэд үзүүлэх дэмжлэгийг баталгаажуулах
- Эмэгтэйчүүд хүчирхийлэлд өртөх эрсдэл ихтэй хямралын, түүний дараахь үе, дүрвэгсдийн болон дотоодын шилжин суурьшигчдын хуаран, байруудад эмэгтэйчүүдийг хамгаалах, хохирлоо барагдуулах бололцоогоор хангаж өгөх, хоргодох байр гаргах явцад жендерийн мэдрэмжтэй хандлагыг баримтлах
- Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл гарахад нөлөөлдөг эрэгтэйчүүд эмэгтэйчүүдийг дарангуйлах хэвшмэл ойлголт, зан үйлийг арилгах, эрэгтэйчүүд, хүүхдүүдтэй тулж ажиллах, үүнийг эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажлын нэгэн хэсэг болгон, сонирхогч талуудын зүгээс зохиох ажлыг дэмжих
- Гэм буруутай этгээдтэй ажиллах ажлыг хянан үзэж чангатгах, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх стратегийг өргөтгөх хүрээнд хүмүүжлийн хөтөлбөрүүдэд дүн шинжилгээ хийх

(г) Бодлого боловсруулах ажлыг дэмжих зорилгоор эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрийн талаархи мэдээллийн санг сайжруулах

383. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн хэмжээ, далайц, түүний зарим хэлбэрүүдийн талаар найдвартай мэдээлэл хомсдолтой байна. Хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, тэмцэхэд ямар бодлого, практик үр дүнтэй байгаа талаар дүн шинжилгээ хийсэн мэдээ ховор байна. Мэдээ, мэдээлэл хомс байгаа нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх төрийн үүрэг, хариуцлагыг бууруулах учиргүй.

384. Иймд улс орнуудад хандаж дараахь зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

- Мэдээ, мэдээллийг системтэй цуглуулж дүн шинжилгээ хийх. Энэ ажлыг төрийн зүгээс болон бусад байгууллагуудтай хамтран гүйцэтгэх. Энэ ажилд оролцдог ТББ, судлаачид болон бусад хамтрагчдын үйл ажиллагааг дэмжих
- Мэдээллийг хүйсээр, арьсны өнгө, нас, хөгжлийн бэрхшээл зэрэг бусад хүчин зүйлээр ангилж гаргах
- Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаар мэдээ, мэдээлэл цуглуулах ажилд оролцдог үндэсний статистикийн болон бусад байгууллагуудын ажилтнуудыг энэ ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай сургалтад хамруулах
- Олж авсан мэдээлэлд хийсэн дүн шинжилгээ дүгнэлтийг олон нийтэд мэдээлж, цаашдын арга хэмжээнд ашиглах
- Мэдээлэл цуглуулахдаа эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэр, илрэлийн байдал, хэмжээ, далайцыг тогтоох, олон улсад хэрэглэж болохуйц үзүүлэлтүүдийг сонгож авах. Ингэснээр эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх үүргээ улс орнууд хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих боломжтой болно.

385. Түүнчлэн:

- Эмэгтэй хүний эрх, хувийн нууцыг хүндэтгэх, эмэгтэй хүний аюулгүй байдалд хохирол учрахгүй байх талаар мэдээ, мэдээллийг цуглуулах
- Дэвшилттэй арга барилуудыг цаашид түгээн дэлгэрүүлэх зорилгоор мэдээнд үнэлгээ хийх
- Ядуурлыг бууруулах стратеги, хүний эрхийн хэрэгжилтийн хяналтын бодлогын төлөвлөлт, хэрэгжүүлэлттэй уялдуулж, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаарх мэдээ, мэдээллийг, үндэсний болон олон улсын хэмжээнд цуглуулах хүчин чармайлтанд нэгтгэх. Статистикийн газрууд энэ ажилд голлох үүргийг гүйцэтгэнэ.
- Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс хохирогчид, өрх, нийгэмд учирч буй эдийн засаг, хөгжлийн шинжтэй хохирлыг тооцоолох аргачлалыг цаашид хөгжүүлж боловсронгуй болгох шаардлагатай.

(д) Үндэсний, орон нутгийн зохицуулалттай салбар дундын стратегийг боловсруулж хэрэгжүүлэх нь

386. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг устгах ажил нь тусгай, нэг салбарын, нэг асуудалд хариу гаргах байдлаас чиг зорилго бүхий, байнгын ажиллагаатай, зохион байгуулалтын механизмаар зүй зохистой дэмжигдэж байдаг олон талт, системтэй, тогтвортой ажиллагаанд шилжих ёстой. Үүнд: хууль, эрүүл мэнд, боловсрол, батлан хамгаалах, санхүүжилт, гадаад харилцаа, ХАА, хөдөлмөрийн салбарыг хариуцсан төрийн байгууллагуудыг татан оролцуулах шаардлагатай. Хууль, эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээ, урьдчилан сэргийлэх ажлыг хүртээмжтэй байлган, хүчирхийллээс хохирсон эмэгтэйчүүдэд туслах ажилд янз бүрийн салбар, түвшний байгууллагуудын уялдаа холбоо нэн чухал.

387. Иймд улс орнуудад хандаж дараахь зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

- Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг устгах тогтвортой стратегийг бий болгох гол бүрдэл хэсэг болох төв, орон нутгийн төрийн байгууллагуудын уялдаа холбоог хангах
- Арга хэмжээ авах, уялдуулан зохицуулах, хяналт тавих, тайлагнах бүтцийн хүчирхэг механизмыг төв, бүс, орон нутгийн бүх түвшинд бүрдүүлэх
- Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, түүнийг багасгах үйл ажиллагааг ДОХ, нөхөн үржихүйн эрүүл мэнд, хот төлөвлөлт, цагаачлал, ядуурлыг бууруулах, хөгжлийн, мөргөлдөөн, мөргөлдөөний дараахь үеийн, дүрвэгсдийн болон хүмүүнлэгийн тусламжийн хөтөлбөрийн салбаруудын арга хэмжээтэй уялдуулж холбох
- Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн шалтгаан, хор хөнөөлийн талаарх олон талт ойлголтуудыг бүх түвшний боловсрол, сургалтын хөтөлбөр, түүний дотор эмнэлгийн ажилтнууд, багш, хуулийн болон нийгмийн ажилтнуудын мэргэжлийн сургалтын хөтөлбөрт тусгах

(е) Хөрөнгө нөөцийг оновчтой хуваарилах нь

388. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл хувь хүн, гэр бүл, иргэд, улс орныг үгүйрүүлэн хоосруулж байдаг. Энэ байдал цааш үргэлжилбэл нийгэм, улс төр, эдийн засгийн асар их хохирол авчрах тул эмэгтэйчүүдийн аюулгүй байдлын

асуудалд зохих хөрөнгө оруулалт хийх шаардлагатайг харуулж байна. Энэ ажилд одоо зарцуулж байгаагаас хавьгүй их хэмжээний санхүү, хүний нөөцийн хүчин чармайлтыг гаргах улс төрийн хүсэл зориг шаардагдана.

389. Иймд улс орнуудад хандаж дараахь зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

- Хохирогчдод зүй зохистой үйлчилгээ үзүүлэх, тэдэнд хуулийн шударга ёсыг хүргэх, хохирлыг нөхөн барагдуулах ажилд зарцуулах санхүүжилтийг нэмэгдүүлэх
- Үндэсний болон орон нутгийн төсөвт жендерийн байр суурьнаас дүгнэлт өгөх, ялгаварлан гадуурхах ба эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг устгах ажилд зохих нөөцийг хуваарилах
- Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх ажилд улсын төсвөөс санхүүжилт хийх
- Буурай хөгжилтэй болон мөргөлдөөний дараахь байдалд байгаа улс орнуудын эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх хөтөлбөрт зориулж тусгай сан хандивлагчдын нэмэлт нөөцийг гаргуулах

390. Төр, хандивлагч, олон улсын байгууллагууд:

- Эмэгтэйчүүдийн эсрэг ялгаварлан гадуурхалт устгах, жендерийн тэгш байдлыг дэмжих, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэр, илрэлээс урьдчилан сэргийлж, түүний хор уршгийг арилгах чиглэлээр ихээхэн нөөцийг хуваарилах
- Төр, ТББ-ын шинэлэг хөтөлбөрүүдэд үнэлгээ өгөх, хяналт тавихад зориулан нөөц гаргах, ирээдүйтэй практик туршилтын төслүүдийг цаашид шат дараатай өргөжүүлэхийг дэмжих шаардлагатай.

2. Олон улсын хэмжээнд хэрэгжүүлэх зөвлөмж

391. Дэлхийн эмэгтэйчүүдийн 4 дүгээр бага хурлаас хойш Засгийн газар хоорондын болон шинжээчийн байгууллагууд, НҮБ-ын системийн нийт байгууллагуудын хэмжээнд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх асуудалд тавих анхаарал өсөн нэмэгдэж ирлээ.

392. Энэ ажилд илүү иж бүрэн, системтэй, уялдаа холбоо, нөөц бололцоогоо дайчлан хандах ёстой. Одоогоор улс орнуудын үүрэг, хариуцлага, хэм хэмжээг биелүүлэх явдал хязгаарлагдмал байна. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл бусад асуудалтай холбогдох байдал, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн шинэ хэлбэрүүд, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлд хүргэдэг шинэ нөхцөлүүдийн талаар бий болж байгаа санаа зовоосон зүйлүүдийг шийдвэрлэх шаардлагатай. Тодорхой салбарт эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлд чиглэсэн анхаарал тавигдаж байгаа хэдий ч эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх ажил бүх бодлого, хөтөлбөр, үйл ажиллагааны нэгдмэл нэгэн хэсэг болж чадаагүй байна.

393. Үүнээс үүдээд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх ажилд дорвитой өөрчлөлт гаргахад шаардагдах өөрийн онцлог, дүр төрхийг олоогүй байна. Энэ судалгаанд дурдсан стратегийн 6 чиглэлийн зөвлөмжүүдэд заасан асуудлуудыг шийдвэрлэхэд нэгдмэл, стратегийн хандлага шаардлагатай. Ийм хандлагыг бий болгоход Засгийн газрууд, олон улсын хамтын нийгэмлэг, иргэний нийгмийн байгууллагуудыг оролцуулсан бүх сонирхогч талуудын илүү эрчимтэй хамтын ажиллагаа зайлшгүй юм.

394. Энэ хэсэгт эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх ажилд НҮБ-ын тогтолцоонд илүү системтэй тал бүрийн анхаарал чиглүүлэх шаардлагын талаар авч үзэв. Энэхүү судалгааг явуулах болсон Ерөнхий Ассамблейн чухал санаачлагыг эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлж, түүнийг устгах талаар бүх түвшинд, тодорхой үйл ажлаар шийдвэртэй дэмжих ёстой.

395. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх хэм хэмжээ бодлогын хэрэгжилтийг сайжруулах талаар улс төрийн хүсэл зориг, тогтвортой үйл ажиллагаа, дорвитой нөөцийг хуваарилах хандлагаар илрэн гарах Засгийн газар хоорондын болон НҮБ-ын системийн хүчирхэг, байнгын, харагдахуйц үүрэг шаардлагатай байна.

(а) Засгийн газар хоорондын хэмжээнд хэрэгжүүлэх зөвлөмжүүд

396. Засгийн газар хоорондын байгууллагуудад эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн эсрэг арга хэмжээ авах үүрэг, хариуцлагаа дээшлүүлж ажиллахыг зөвлөмж болгож байна. Эдгээр байгууллагуудад эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаарх хүлээсэн үүрэг, хэм хэмжээг үндэстэн, бүс нутаг, олон улсын түвшинд хэрэгжүүлэх ажлаа эрчимжүүлэхийг зөвлөв.

397. Үүний дотор:

- ЕНБД-ын тайланд үндэслэн эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаарх асуудлыг Ерөнхий Ассамблейгаас жил бүр хэлэлцэж байх. Энэ хэлэлцүүлэг нь засгийн газар хоорондын бусад байгууллагуудын эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх талаар авч хэрэгжүүлсэн зорилгот болон тухайн салбарын үйл ажиллагаанд үндэслэх ба тэдгээрийг үргэлжлүүлэх зорилготой.

Ерөнхий Ассамблейгаас эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн асуудлыг иж бүрнээр нь авч үзэхдээ эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл нь ДОХ, ядуурлыг бууруулах, хүнсний аюулгүй байдал, энх тайван, аюулгүй байдал, хүмүүнлэгийн ажил, эрүүл мэнд, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зэрэг асуудлуудтай хэрхэн уялдаж байгаа зэрэг шинэ болон шинээр гарч ирж буй асуудлуудад онцгой анхаарах ёстой.

- Аюулгүйн зөвлөлөөс эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх хүчин чармайлтыг эрчимжүүлж, Эмэгтэйчүүд, энх тайван, аюулгүй байдлын талаархи Аюулгүйн зөвлөлийн 1325 (2000) дугаар тогтоолыг хэрэгжүүлэх талаар авч буй арга хэмжээнд байнгын хяналт тавьдаг. Түүнчлэн, зэвсэгт мөргөлдөөний үед эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэгддэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, учирсан хохирлыг барагдуулах талаар Зөвлөлийн оруулж байгаа хүчин чармайлтын үр нөлөөг дээшлүүлэх, хяналтын механизмыг тогтоох талаар Аюулгүйн Зөвлөл хэлэлцэх ёстой юм.

- Энх тайван тогтоох комисс, Хүний эрхийн зөвлөл, Эдийн засаг нийгмийн зөвлөл болон түүний бүтцийн комиссууд, Эмэгтэйчүүдийн статусын талаархи комисс, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ба эрүүгийн хууль, статистикийн комисс гэх мэт Засгийн газар хоорондын байгууллагууд 2008 он гэхэд өөрийн бүрэн эрхийн хүрээнд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэр, илрэлийн талаар хэлэлцэж, цаашдын хүчин чармайлт, ажлын хөтөлбөртөө энэ асуудлыг шийдвэрлэх тэргүүлэх чиглэлүүдийг тогтоож өгөх юм. Засгийн газар хоорондын байгууллагууд өөрийн үүрэгт ажлын хүрээнд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх олон улсын бодлого, хэм хэмжээнд байгаа цоорхойг олж тогтоох, түүнийг шийдвэрлэх үйл ажиллагаа явуула.

- Хүний эрхийн зөвлөлөөс Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, түүний шалтгаан үр дагаврыг судлах тусгай судлаачийн бүрэн эрхийг дахин баталж өгөв. Энэ нь Бээжингийн тунхаглал болон Үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх Засгийн газар хоорондын төв байгууллагын үүргийн хувьд Тусгай судлаач эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх ажлаа өргөтгөх, Эмэгтэйчүүдийн статусын тухай комисстой хамтран Хүний эрхийн комисс, Эмэгтэйчүүдийн статусын тухай комисст жил бүр ажлаа тайлагнахад маш чухал ач холбогдолтой юм.

- Ерөнхий Ассамблейгаас олон улс, бүс нутгийн түвшинд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг устгах үйл ажиллагааны ил тодорхой байдлыг нэмэгдүүлэх, уялдаа холбоо, зөвлөгөө, сурталчилгааны ажлыг сайжруулах механизм болох ЕНБД-ын Жендерийн асуудал ба эмэгтэйчүүдийг хөгжүүлэх асуудлаарх тусгай зөвлөхийн албыг бэхжүүлэн ажиллаж байна. Эдгээр хүчин чармайлт нь улс орны түвшинг хамруулан нийт системийн уялдаа, холбоог сайжруулахад тухайлан чиглэгдэнэ. Уялдаа холбоогоор хангах ажлыг Зохицуулалтын асуудал хариуцсан гүйцэтгэх зөвлөл хариуцна.

(б) НҮБ-ын системийн байгууллагын хэмжээнд хэрэгжүүлэх зөвлөмжүүд **НҮБ-ын системийн байгууллагын хоорондын уялдаа холбоо ба зохион байгуулалтын дэмжлэг**

398. Одоогийн бүтэц, нөөцийг дээд хэмжээнд үр дүнтэй ашиглаж, уялдаа холбоотой ажиллахын тулд дор дурдсан арга хэмжээг авахыг зөвлөмж болгож байна. Үүнд:

- НҮБ-ын системийн байгууллагууд бүрэн эрхээ үр дүнтэй хэрэгжүүлэхэд нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл ямар сөрөг нөлөө үзүүлж буйг тодорхойлон, түүнтэй хийх тэмцлийг чангатгах. Тэдгээр байгууллагууд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн олон талт шинж байдалд хариу арга хэмжээ авах ажлаа сайжруулан, өөрсдийн хүчин чармайлтыг ДОХ, ядуурлыг бууруулах, хүнсний аюулгүй байдал, энх тайван аюулгүй байдал, хүмүүнлэгийн ажил, эрүүл мэнд, боловсрол, хууль эрх зүйн шинэчлэл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх асуудлаар хийж байгаа ажлуудтай уялдуулж холбох.

- ЕНБД-ын Жендер эмэгтэйчүүдийг хөгжүүлэх асуудал эрхэлсэн тусгай зөвлөх нь Эмэгтэйчүүд, Жендерийн тэгш байдлын талаарх агентлаг хоорондын сүлжээгээр дамжуулан, харагдахуйц, тогтмол, үр нөлөөтэй үйл ажиллагаа явуулах, үйл ажиллагаанд хяналт тавьж эдгээр асуудлаар Хөтөлбөр менежментийн дээд түвшний хороод, Зохицуулалтын удирдах зөвлөлд тайлагнахын тулд системийг хамарсан уялдаа, холбоог сайжруулах ажлыг удирдана. Тусгай зөвлөхийн ажлыг Сүлжээний байгуулсан Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаарх ажлын хэсэг дэмжин ажиллана.

- ЕНБД-ын Жендер эмэгтэйчүүдийг хөгжүүлэх асуудал эрхэлсэн тусгай зөвлөх, ЮНИФЕМ, Итгэлцлийн сангийн менежер, Эмэгтэйчүүд жендерийн тэгш байдлын талаархагентлагхоорондынсүлжээнийЭмэгтэйчүүдийнэсрэгхүчирхийллийнталаарх ажлын хэсгээс НҮБ-ын Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг устгах итгэлцдэлийн санг эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх НҮБ-ын системийг хамарсан механизм бөгөөд дэмжиж хэрэгжүүлдэг төслүүдээс гарч буй сургамжтай зүйлүүдийг эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаарх нийт системийн бодлого, ажлын хэм хэмжээнд тусгаж ажилладаг байгууллагынх нь хувьд үйл ажиллагааны үр нөлөөг нь дээшлүүлэх арга зам, хэрэгслийг судалж үзнэ.

Мэдээ, мэдээлэл цуглуулах, судалгаа хийх

399. Эрэгтэйчүүдээс эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэж байгаа хүчирхийллийн талаар мэдээ, мэдээлэл цуглуулах, боловсруулах, нийтэд мэдээлэх болон мэдээллийг үндэслэн хууль, бодлого, хөтөлбөр боловсруулах чиглэлд улс орны чадавхи, бололцоог бэхжүүлэхэд НҮБ-ын систем тун чухал үүрэг гүйцэтгэнэ.

400. НҮБ-ын системээс тэргүүлэх чиглэл болгон доорх ажлыг гүйцэтгэнэ. Үүнд:

- Мэдээ цуглуулах ажил одоогийн стандартын шаардлага хангахуйц байх тал дээр улс орнуудад техникийн туслалцаа үзүүлэх, дэвшилтэт арга барил, туршлагыг танилцуулах
- Баримтжуулагдаагүй байгаа эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрийн талаар мэдээ цуглуулахдаа баримтлах ижил арга барил, стандартыг боловсруулах
- Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах ажиллагааны нөлөөллийн талаар судалгаа дүн шинжилгээ хийхийг дэмжих
- Төр олон улсын гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлж байгааг дүгнэх, хяналт тавих нийтлэг үзүүлэлтүүдийг боловсруулах
- Үндэсний статистикийн газрууд, эмэгтэйчүүдийн байгууллагууд, олон улсын болон үндэсний судалгааны байгууллагууд, ТББ-ын чадавхийг бэхжүүлж, тэдний хоорондын харилцааг бэхжүүлэх
- Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаар мэдээ цуглуулах ажлыг ядуурлыг бууруулах, хүний эрхийн хэрэгжилтийн хяналтын төлөвлөлтийн үйл явцад зориулан хийгдэж байгаа гэх мэт өөр мэдээ цуглуулах ажилтай уялдуулан холбож өгөх
- Эдийн засаг, нийгмийн газарт зохицуулалт бүхий, мэдээ авахад хялбар мэдээллийн санг байгуулах. Энэ ажлыг хийхэд Эдийн засаг, нийгмийн газрын Статистикийн хэлтэс, бүсийн комиссууд болон НҮБ-ын систем дэх статистик, хууль зүй, сургалт, шинэ арга барил, ёс зүй болон эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэр илрэлтэй тэмцэх нөөцийг татан оруулах.
- Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн хэмжээ далайц, гаралт, тохиолдлуудад дүн шинжилгээ хийх, хүчирхийлэлтэй тэмцэх ажлын ахицад хяналт тавих, өөр өөр арга хэмжээ, оролцооны нөлөөлөлд үнэлгээ хийх олон улсын үзүүлэлтийн багцыг боловсруулж санал болгох НҮБ-ын ажлын хэсгийг байгуулах. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн үзүүлэлтүүдийн талаар гарсан санал, Хүний эрхийн комиссын 2004/46 дугаар Тогтоолд заасан Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаарх тусгай судлаачийн санал болгосон үзүүлэлтэнд үндэслэн энэ ажлыг хийнэ.

Хүмүүнлэгийн тусламж, энхийг сахиулах ажиллагааны хүрээг хамруулан, тухайн улс орны түвшинд гүйцэтгэх үйл ажиллагаа

401. Дараахь арга хэмжээг авахыг зөвлөмж болгож байна. Үүнд:

- Үндэсний түвшинд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх үр нөлөөтэй, олон талт арга хэмжээ авах талаар зөвлөх, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, түүнийг устгах талаар төрийн ба бусад байгууллагын үйл ажиллагааг системтэйгээр дэмжихэд НҮБ-ын Байнгын төлөөлөгчид манлайлах үүрэг гүйцэтгэнэ.
- НҮБ-ын тухайн улсад ажилладаг багууд үндэсний хэмжээнд олон нийтэд ойлголт өгөх компаниаг ажлуудыг оролцуулсан эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хэмжээний үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж бүрэн

хэрэгжүүлэхийг дэмжинэ. Түүнчилэн, хүн амын эрхийн талаарх мэдлэгийг сайжруулах, үйлчилгээг хүртээмжтэй байлгах, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг бий болгон өөгшүүлж байдаг хүйсийн талаарх уламжлалт ойлголт, хандлага хэм хэмжээг өөрчлөхөд онцгой анхаарал тавина.

- НҮБ-ын тухайн улсад ажилладаг багууд хөтөлбөр боловсруулах чиглэлд нийт системийг хамарсан уялдаа холбоотой байх хандлагыг баримтлах, эмэгтэйчүүдийн бүлэг, иргэний нийгэмтэй хамтран ажиллах байдлаар эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлж түүнтэй тэмцэхэд тэргүүлэх ач холбогдол өгч ажиллана.

- Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн асуудлаар ажилладаг НҮБ-ын тухайн улс дахь багийн чадавхийг сургалт, бусад арга хэрэгслээр бэхжүүлнэ.

- НҮБ-ын ЕНБ Даргын Тусгай төлөөлөгч энхийг сахиулах, энх тайвныг тогтоох үйл ажиллагааны бүрэн эрхийнхээ хүрээнд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн асуудалд тэргүүн зэргийн анхаарал тавьж ажиллана.

402. Дараахь арга хэмжээг авахыг зөвлөмж болгож байна. Үүнд:

- НҮБ-ын нийт системд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх асуудалд хуваарилах нөөцийг ихээхэн нэмэгдүүлэх

- Улс орнууд, ялангуяа, буурай хөгжилтэй, мөргөлдөөний дараахь үеийн улс орнуудад эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, түүнийг устгахад чиглэсэн үндэсний иж бүрдэл үйл ажиллагааны төлөвлөгөөгөө хэрэгжүүлэхэд нь зориулж НҮБ-ын системийн байгууллагууд, бусад хандивлагчдын зүгээс нөөц гаргахыг нэмэгдүүлэх

- Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, түүнийг устгах ба эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлд нөлөөлөх олон хүчин зүйлийн уулзварыг таньж мэдэх, түүнтэй тэмцэх тухайлсан зорилготойгоор ядуурлыг бууруулах, ДОХ, энхийг сахиулах асуудалд зориулан НҮБ-ын системийн байгууллагуудаас хуваарилж байгаа нөөцийг нэмэгдүүлэх.

- Төр, хандивлагч, ОУБ-ын зүгээс НҮБ-ын агентлаг хөтөлбөрүүд, түүний дотор НҮБ-ын эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг устгах итгэлцлийн санг санхүүгийн талаар дэмжих дэмжлэгээ дорвитой нэмэгдүүлэх зэрэг болно.

Хавсралт

Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн хохирол: хохирлын мөнгөн тооцоог гаргасан түүвэр судалгаа

<i>Зохиогч, хэвлэсэн он, улс</i>	<i>Зардал (нэг жилээр тооцоолсон)</i>	<i>Ашигласан тэдээ (жишиг хэмжээг оруулан)</i>	<i>Зардлын утга</i>
Leonard and Cox, Distaff Assoc. ; 1991; Австрали	1.5 тэрбум австрали доллар	– Цагдаагийн дуудлага – Үйлчилгээний байгууллагын бүртгэл – Үйлчилгээний байгууллагуудаас мэдээ байхгүй үед ашиглах хэргийн судалгааны загвар бий болгох судалгаа Нэгжийн хохирол яаж гаргасан нь тодорхойгүй.	– Үхэл – Ажлын чадвар алдах – Байр, хууль, эмнэлэг, алдсан орлого, алдсан ажлын цаг –Эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээ, байр, орлого, цагдаа, шүүх, нөхөн олговор, орчуулагч
Blumel ; 1993; Австрали	620 сая австрали доллар	–50 эмэгтэйг судалсан. 10 нь бие махбодийн хувьд, 40 нь хүчин болон бэлгийн халдлагын хохирогч	–Хууль зүйн зөвлөгөө, байр, шүүх, түргэн тусламж, цагдаа, эрүүл мэнд, зөвлөгөө, унаа болон хувийн зардал, алдсан орлого
Mansingh & Ramphal ; 1993; Ямайка	1.1 тэрбум ам доллар	– Ахуйн хүчирхийллээс хохирсон 640 хүнээс Кингстоны эмнэлэгт авсан судалгаа	– Эмнэлгийн шууд зардал
KRMG ; 1994; Австрали	40 эмэгтэйд 4 сая австрали доллар (17.67 саяыг Тасмани мужаас, гэвч жишиг төлөөлөл болж чадахуйц жишээ биш)	– 40 хүнээс авсан судалгаа – Нэгж зардал гаргадаг нутгийн иргэдийн байгууллагаас авсан судалгаа	– Өмч хөрөнгө алдах, эмнэлгийн чөлөө, өрөө төлж чадахгүй болох, сургуулиа солих, аюулгүй байдлын арга хэмжээ, хууль зүйн холбоотой зардлууд – Зөвлөгөө өгөх утсанд хандах, цагдаа, хоргодох байр, түргэн тусламж, хямралыг дэмжих үйлчилгээ, зуучилсан үйлчилгээ, байрлуулсан үйлчилгээ

<i>Зохиогч, хэвлэсэн он, улс</i>	<i>Зардал (нэг жилээр тооцоолсон)</i>	<i>Ашигласан тэдээ (жишиг хэмжээг оруулан)</i>	<i>Зарцуулсан зардал</i>
Snively; 1994; Шинэ Зеланд	1.2-оос 1.4 тэрбум Шинэ Зеланд доллар	<ul style="list-style-type: none"> - Үйлчилгээ үзүүлэгч байгууллагын судалгаа - Үйлчилгээний талаархи анкет - Хэргийн гаралт цагдаа дуудсан тоотой тэнцүү гэж үзсэн баримжаа тооцоо - 5 дахин үржүүлэх баримжаа тооцоо - Алдагдсан орлогын баримжаа тооцоо - Хүүхэд хохирсон гэр бүлийн хүчирхийллийг оруулж тооцсон - Төрийн мэдээлэл - Өмнөх судалгаа 	<ul style="list-style-type: none"> - Эмнэлгийн зардал, эм, дүрвэх, шилжиж нүүх, хууль зүйн үйлчилгээний зардал, шүдний эмчийн зардал, алдсан орлого - Нас баралт - Нийгмийн халамж, хоргодох байр, хямралын байгууллага, орлогын дэмжлэг, цагдаа, шүүх
Day; 1995; Канад	1.5 тэрбум канад доллар	<ul style="list-style-type: none"> - Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн судалгаа - Статистикийн товхимол - ЗГ төсөв - Орон нутгийн эрүүл мэндийн судалгаа - Улсын хэмжээний гэмт хэргийн хохирогчийн судалгаа - Бусад судалгаа 	<ul style="list-style-type: none"> - Эмнэлэг, шүдний эмч, цалингаа авсан буюу аваагүй алдсан цаг, сэтгэл зүйч, мансуурах бодис, архи хэтрүүлэн хэрэглэх, хоргодох байр, тусламжийн утас, сайн дурынхны цаг, төрийн дэмжлэгийн үйлчилгээ
Greaves et al.; 1995; Канад	4.2 тэрбум канад доллар	<ul style="list-style-type: none"> - Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн судалгаа 12300 хүнээс - ЗГ статистик - Өмнөх судалгаа - Шинжээчийн дүгнэлт 	<ul style="list-style-type: none"> - Алдсан орлого, төлөгдөөгүй ажлын цаг, байр, нүүх, бие хамгаалах, - Нас баралт - ЗГ-аас алдаж буй татварын орлого, шүүх, хорих, цагдаа, хуулийн туслалцаа, хохирлыг төлүүлэх, эмнэлэг, хоргодох байр, зөвлөгөө, олон нийтэд сурталчлан таниулах, судалгаа, сайн дурынхны зарцуулсан цаг

<i>Зохиогч, хэвлэсэн он, улс</i>	<i>Зардал (нэг жилээр тооцоолсон)</i>	<i>Ашигласан мэдээ (жишиг хэмжээг оруулан)</i>	<i>Зарцуулсан зардал</i>
Kerr and M c L e a n ; 1996; Канад	385 сая канад доллар	– Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн судалгаа – Муж улсын яамны төсөв – Улсын хэмжээний гэмт хэргийн хохирогчийн судалгаа	– Цагдаа, засан хүмүүжүүлэх, нөхөн олговор, хохирогч буруутай этгээдэд зориулсан нийгмийн хөтөлбөр, сэтгэцийн эрүүл мэнд, архидалт, мансуурлын эсрэг эмчилгээ, хоргодох байр – Төлөгдсөн болон төлөгдөөгүй ажлын цагийн алдагдал
Miller et al.; 1996; АНУ	105 тэрбум ам доллар бодитгоор, 450 тэрбум ам доллар бодит бусаар (нийт хэргийн хохирол)	– ХМБ товчооны Цагдаагийн үйлдсэн гэмт хэргийн тайлан – Улсын хэмжээний гэмт хэргийн хохирогчийн судалгаа – Үндэсний хэмжээнд хийгддэг бусад жишиг судалгаа – Өмнөх судалгаа	– Өмчийн хохирол алдагдал, эмнэлгийн тусламж, даатгал, хохирогчид зориулсан үйлчилгээ, орлогын болон ар гэрийн ажлын алдагдал – Өвчин, шаналал, нас баралт (зөвхөн эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл бус бусад бүх гэмт хэргийг хамруулсан)
Korf et al.; 1997; Нидерланд	1 тэрбум канад доллар	– Гэр бүлийн хүчирхийллийн эмэгтэй хохирогч	– Цагдаа, хуулийн байгууллага, эмнэлэг, сэтгэл зүйч, хөдөлмөр эрхлэлт, аюулгүй байдал
Stanko et al.; 1998; Хэгни, Лондон хотууд Британи	Хэкнид 7.5 сая фунт, Лондонд 278 сая фунт	– Үйлчилгээ хийдэг 107 байгууллагаас авсан судалгаа – 26 хэрэг дээр хийсэн судалгаа – Хүчирхийллээс үүссэн ажлын ачааллын хувийг тогтоох талаар байгууллагын бичиг хэргээс авсан мэдээлэл – Эмнэлэгт хандаж ирсэн 129 эмэгтэйгээс авсан судалгаа – Бусад судалгаа	– Цагдаа, шүүх, хуулийн зөвлөгөө, салалт, хувийн байгууллагаас гаргасан орон сууц, хоргодох байр, нийгмийн ажилтан, эмч, түргэн тусламж, эмнэлэг

<i>Зохиогч, хэвлэсэн он, улс</i>	<i>Зардал (нэг жилээр тооцоолсон)</i>	<i>Ашигласан мэдээ (жишиг хэлжээг оруулан)</i>	<i>Зарцуулсан зардал</i>
Faley et al.; 1999; АНУ — АНУ-ын арми	250 сая ам доллар (х а м г и й н багаар, 1994 оны доллараар)	– Зөвхөн ажлын байран дахь бэлгийн халдлага – Эрэгтэй эмэгтэй 2,079 хүнээс авсан судалгаа – АНУ-ын армийн төсвийн баримт бичиг	– Ажлын байран дахь бэлгийн дарамтын улмаас учирсан хохирол: Ажлын чадвар алдах, идэвхигүй байдал үүсэх, салалт, ажлаас өөрчлөгдөх, шилжих болон бусад
Godenzi and Yodanis; 1999; Швейцари	60 сая евро	– Олон судалгаа	– Эмнэлэг, цагдаа, хуулийн байгууллага, дэмжлэг, хорогдох байр, зөвлөгөө, төрийн зардал, хохирогчид үзүүлэх дэмжлэг, судалгаа
Morrison and Orlando; 1999; Ч и л и , Никарагуа	Чилид: 1.56 тэрбумын орлого бууралт Ам долллараар Никарагуад: 29.5 тэрбумын орлого бууралт	–310, 378 эмэгтэйгээс тус тус авсан судалгаа	– Ажил эрхлэлт, эрүүл мэндийн үйлчилгээ, хүүхдийн сурлагын амжилт
Henderson and Associates; 2 0 0 0 ; Австрали	1.5 тэрбум австрали доллар	– Зөвхөн бизнесийн салбарт – Австралийн болон олон улсын судалгааны үр дүнгээс авсан иштэл – Холбогдох байгууллагахувьхүнтэй хийсэн зөвлөгөө – Өмнөх судалгааны үр дүн	– Бизнесийн салбарын зардал, идэвхигүй байдалд орох, хөрөнгийн эргэлт, хөдөлмөрийн бүтээмж алдагдах – Бусад зардал, холбогдох төрийн үйлчилгээний татварт ноогдох хувь, алдагдсан ашиг, хохирогч, буруутай этгээд болон бусад хүмүүсийн зардалд гарсан өөрчлөлт

Зохиогч, хэвлэсэн он, улс	Зардал (нэг жилээр тооцоолсон)	Ашигласан тэдээ (жишиг хэмжээг оруулан)	Зарцуулсан зардал
Heiskanen and Piipasa; 2001; Финланд	Шууд хохирол 50 сая евро, шууд бус 56 сая	<ul style="list-style-type: none"> - 7000 эмэгтэйгээс авсан зохиогчийн өмнө нь хийсэн судалгаа - Бусад зохиогчийн өмнөх судалгааны үр дүн - ЗГ-ийн мэдээллийн сан, агентлагуудын төсөв, үйл ажиллагааны тайлангаас авсан тоо баримт - Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн хохирогчид үзүүлсэн үйлчилгээний талаар мэргэжилтнүүдтэй хийсэн ярилцлага - 2 хэрэг дээр хийсэн судалгаа 	<ul style="list-style-type: none"> - Эмчид үзүүлэх, эмнэлгийн үйлчилгээ болон эм - Хоргодох байр, хямралын эсрэг үйлчилгээ, нийгмийн ажил, эмчилгээ, цагдаа, шүүх, шорон - Нас баралт
Deloitte and Touche, Almenara Estudios Economicos y Sociales; 2002; Андалуз муж, Испани	2.4 тэрбум евро	<ul style="list-style-type: none"> - Хамтран амьдрагчаас салж улсын хоргодох байранд очсон 300 эмэгтэй 	<ul style="list-style-type: none"> - Нийгэм, эрүүл мэнд, хууль, цагдаагийн салбар, бие сэтгэлийн хохирол, ажил эрхлэлт, эдийн засагт учрах хохирол - Бодит бус хохирлыг оруулан
Health Canada; 2002; Канад	1.5 тэрбум канад доллар	<ul style="list-style-type: none"> - Цагдаа: бүртгэгдсэн болон хүн амины хэргийн талаарх мэдээлэл - 1999 оны нийгмийн ерөнхий судалгаа, бусад эх үүсвэр 	<ul style="list-style-type: none"> - Эмнэлгийн шууд зардал
Гэмтлээс урьдчилан сэргийлэх хянах үндэсний төв; 2003; АНУ	5.8 тэрбум ам доллар	<ul style="list-style-type: none"> - Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаарх үндэсний судалгаа 8000 хүнээс (зөвхөн гэмтсэн эмэгтэйчүүдийг авч үзсэн) - Эмнэлгийн зардал, судалгаа - Эмнэлгийн үйлчилгээний бүртгэл 	<ul style="list-style-type: none"> - Зөвхөн гэмтлийн үед үзүүлсэн эмчилгээний зардал - Цалин хөлс авсан, авч чадаагүй ажлын цаг - Нас баралт

Зохиогч, хэвлэсэн он, улс	Зардал (нэг жилээр тооцоолсон)	Ашигласан тэдээ (жишиг хэтжээг оруулан)	Зарцуулсан зардал
Bowlus et al.; 2003; Канад	15.7 тэрбум канад доллар (хүүхдийн эсрэг хүчирхийллийн тооцоо)	– Муж улсын эрүүл мэндийн судалгаа – ЗГ тоо баримт ба агентлагийн тайлан – Өмнөх судалгаа	– Цагдаа, хуулийн байгууллага, торгууль, тэнсэн, хохирол барагдуулалт, тусгай боловсрол, эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээ, алдсан орлого хувийн зардал
Access Economics; 2004 ; Австрали	8.1 тэрбум австрали доллар	– Эмэгтэйчүүдийн аюулгүй байдлын судалгаа – Эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн Австралийн уртрагийн дагуу хийдэг судалгаа (мэдээнд хохирогчдыг тусад нь салгадаггүй учраас гэр бүлийн хүчирхийллийн орчин нөхцлийн талаар загвар үүсгэсэн) – Өмнөх судалгааны дүн	– Хохирогч ба буруутай этгээдийн хүйсийг үл харгалзан бүх гэр бүлийн хүчирхийллийг оруулсан судалгаа – Өвчин шаналал, нас баралт болон томчуудын хүчирхийллийг хүүхэд гэрчилсний зардлыг оруулсан – ЗГ-ын: эрүүл мэнд, хууль хяналт, боловсрол, иргэдийн төлөө үйлчилгээ, байр, – Хувийн зардал: өмч шилжүүлэх, өр төлөх чадваргүй болох, цалин хөлсөө авсан болон авч чадалгүй алдсан цаг – Бүтээмж алдагдах, эрж хайх ба хүн хөлсөлснөөс үүдсэн бизнесийн зардал – Өрхийн эдийн засгийн алдагдал
Walby; 2004; Британи	5.8 тэрбум фунтын шууд ба шууд бус хохирол, өвдөлт шаналалыг оруулан 23 тэрбум фунт	Үйлчилгээний байгууллагуудын тайлан, өмнөх судалгааны дүн	– Шүүх, эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээ, орон байр болон иргэний хуулийн зардал – Бүтээмж алдагдах, ажил олгогч ба ажиллагчийн орлогын алдагдал – Өвчин, шаналал

